

НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ

Курукшетрын тулалдааны талбар дээр хуралдсан цэргийн хүчнүүдийг ажиглан харахуйд

ШҮЛЭГ 1

дхритараштра увача
дхарма-кшетра куру-кшетре самавета юютсавах
мамаках пандавааш чайва ким акурвата саньжая

дхритараштрах- Дритараштра хаан, *увача-* хэлсэн, *дхарма-кшетра-* тахилга мөргөлийн талбарт, *куру-шетре* – Курукшетра гэж нэрлэгддэг газарт, *самавета-* цугларан байгаа, *юютсавах* – тулалдахаар улангассан, *мамаках-* миний тал (миний хөвгүүд), *пандавааш-* Пандугийн хөвгүүд, *ча-* болон, *эва-* гарцаагүй, *ким-* юу, *акурвата-* хийцгээж байна, *саньжая-* ай Саньжая минь.

Дхритараштра хэлсэн нь, ай Саньжая минь ээ, Курукшетрын тахилга мөргөлийн ариун газар оронд улангасан тулалдахаар цугларсан миний хөвгүүд болон Пандугийн хөвгүүд юу хийцгээж байна?

ТАЙЛБАР: Бхагавад Гита бол шашны эрдэм ухааны өргөнөөр уншигддаг ном билээ. Түүнийг “Гитагийн магтаал” буюу Гита-махатмьяд хураангуйлан тоймлосон байдаг бөгөөд тэнд өгүүлсэнчлэн, Бхагавад Гитаг Шри Кришнагийн чин бишрэлтэн-номын багшийн тусламжтайгаар нарийн судлах ёстой бөгөөд түүнийг хувийн санаа бодол бүхий тайлбараас ангид ойлгохыг хичээн чармайх хэрэгтэй. Энэхүү номлол сургаалыг зөв ойлгосон хүний жишээг Бхагавад Гитагаас өөрөөс нь олж болно. Энэ бол Гитаг Бурханаас Өөрөөс нь шууд сонсон хүртэж байгаа Аржуна билээ. Бхагавад Гитаг багш шавийн барилдлагааны энэ сүлжээ хэлхээгээр, өөрийн санаа бодлыг оруулсан тайлбаргүйгээр ойлгож хүртэх зол завшаан тохиосон хэн бүхэн ертөнцийн бүхий л судрууд хийгээд ведэд агуулагдах мэдлэгээс илүү дээд мэдлэгийг олж авна. Уншигч нь бусад судруудад агуулагдсан бүхнийг Бхагавад Гитад олж болохын зэрэгцээ өөр хаана ч байхгүй зүйлийг ч мөн үзэж болно. Энэ бол Гитагийн онцгой гайхамшиг юм. Түүнийг Бурханы Дээд Бодгаль, Шри Кришна шууд Өөрөө айлдсан учраас тэрээр төгс төгөлдөр шашны эрдэм ухаан юм.

Махабхаратад өгүүлсэн байдаг Дхритараштра болон Саньжая хоёрын хоорондын яриа нь энэхүү гайхамшигт гүн ухааны үндэс суурь болдог. Гэхдээ урд өмнө өгүүлсэнчлэн, энэхүү гүн ухаан нь анх эхлээд ведийн соёлд өнө эртийн цагаас эхлэн дээдлэн хүндлэгдэж ирсэн мөргөлийн ариун дагшин газруудын нэг болох Курукшетрын тулааны талбар дээр нээн хүртээгдсэн билээ. Айлдагч нь хүн төрөлхтнийг үнэнд хүрэх зам руу залан чиглүүлэхээр газар дэлхий дээр морилон бууж ирсэн Шри Кришна Өөрөө байлаа.

Дхарма-кшетра (шашны зан үйлийг үйлддэг газар орон) гэдэг үг нь чухал ач холбогдолтой. Учир нь, энэхүү тулаан болох Курукшетрын талбарт Бурханы Дээд Бодгаль Өөрөө залран Аржунагийн талд байлаа. Куручуудын эцэг Дхритараштра өөрийн хөвгүүдийг тулаанд ялна гэдэгт маш ихээр эргэлзэж байсан ба иймээс ч тэрээр түшмэл Саньжаягаас “Тэд нар юу хийцгээж байна вэ?” гэж асууж байна. Тэрээр, өөрийн нь хөвгүүд болон мөн дүү Пандугийн хөвгүүд Курукшетрын талбарт энэхүү тулааныг шийдвэр төгс хийхээр цугларсан гэдгийг ойлгож байлаа. Гэхдээ л түүний энэ асуулт учир холбогдолтой. Тэрээр, үеэл ах дүү нарыг харилцан буулт хийж хоорондоо зохицохыг хүсэхгүй байсан учраас тэр тулааны талбар дээр байгаа өөрийн хөвгүүдийн хувь заяаны талаар тодорхой мэдэхийг хүсэж байв. Ведэд, тэр бүү хэл тэнгэрийн гаригуудын оршин суугчдын хувьд ч мөргөл бишрэлийн талбар гэж нэрлэгддэг газар оронд тулалдахаар тохиролцсон байсан учраас энэхүү ариун дагшин газар орон тулалдааны үр дүнд нөлөөлж болох юм гэж Дхритараштра эмээж байв. Түүнчлэн Аржуна болон Пандугийн бусад хөвгүүдийн цэвэр ариун мөн чанар нь тэдний талд сайнаар нөлөөлнө гэдгийг тэр сайн мэдэж байв. Саньжая нь Вьясагийн шавь байсан учраас тэр хэдийгээр Дхритараштра хааны оронд байсан ч номын багшийнхаа өршөөл нигүүлслээр Курукшетрын тулааны талбарыг далдаас харж хүлээж авах чадвартай байлаа. Иймээс Дхритараштра түүнээс тулалдааны талбар дээрх байдлын талаар асууж байна.

Пандугийн хөвгүүд болон Дхритараштрын хөвгүүд нь нэгэн гэр бүлд хамаарагддаг ч энд Дхритараштрын далд санаа харагдаж байна. Тэрээр зөвхөн өөрийн хөвгүүдийг л Куручууд мөн гэж үзсэнээр Пандугийн хөвгүүдийг гэр бүлийн өвөөс хасан гаргасан. Дхритараштрын, өөрийн ач нар болох Пандугийн хөвгүүдэд хандаж байгаа хандлага дахь онцгой байр суурийг ийм байдлаар ойлгож болно. Тариалангийн талбайд ургасан ямар ч хэрэггүй зэрлэг ургамлыг зулгаан хаяхтай адилаар, энэхүү айлдварын бүр эхэн одооноос л шашин номын эцэг Шри Кришнагийн залран байгаа Курукшетрын бишрэл мөргөлийн талбай дээр Дхритараштрын хүү Дурьодхана болон бусад хүмүүс шиг үл хүсүүштэй ургамлууд устгагдах болон Юдхистхира тэргүүтэй үнэнхүү бишрэл шүтлэг бүхий хүмүүст Бурхан эрх мэдлийг шилжүүлэн өгнө гэдгийг хүлээж болно. Түүхийн болон ведийн үүднээс авч үзвэл *дхарма-кшетре* болон *куру-кшетре* гэдэг үгүүдийн утга учир ийм бөлгөө.

ШҮЛЭГ 2

саньжая увача
дриштва ту пандаваникам вьюдхам дурьодханас тада
ачарьям упасангамья ража вачанам абравит

саньжая увача- Саньжая хэлсэн, *дриштва-* тэр харсаны дараа, *ту-* гэвч, *пандаваникам-* Пандавчуудын цэргийг, *вьюдхам-* байлдааны байрлалаа эзэлсэн байдалд, *дурьодханах-* Дурьодхана хаан, *тада-* энэ цаг үед, *ачарьям-* багшид, *упасангамья-* ойртон, *ража-* хаан, *вачанам-* үгээ, *абравит-* өгүүлсэн.

Саньжая хэлсэн нь: Ай хаантан минь ээ, байлдахаар зохион байгуулагдсан Пандугийн хөвгүүдийн цэргийн хүчийг харсаны дараагаар Дурьодхана хаан өөрийн багшийн зүгт очин, түүнд дараахь үгүүдийг хэллээ.

ТАЙЛБАР: Дхритараштра төрөлхийн сохор байсан бөгөөд мөн харамсалтай нь түүнд бурханлаг хараа ч дутагдаж байлаа. Тэрээр өөрийнх нь хөвгүүд шашин номын асуудалд мөн адил сохор хийгээд тэд төрөлхийн зөв шудрага байсан Пандугийнхантай хэзээ ч санаа нэгдэн тохиролцож чадахгүй гэдгийг сайн мэдэж байв. Гэхдээ тэр мөргөлийн ариун газар орны нөлөөллийн тухай бодох үед төрсөн эргэлзээнээсээ салж чадахгүй байсан бөгөөд ямар учраас тулааны цагийн байдлын талаар асуусныг Саньяя ойлгож байв. Иймээс тэр зүрхшээн байгаа хааныгаа зоригжуулахыг хүсэн, түүний хөвгүүд нь ариун дагшин газар орны нөлөөлөлд орон ямар нэгэн буулт зохицол хийх талаар бодохгүй гэдгийг түүнд батлан хэлж байна. Саньяя хаанд цааш үргэлжлүүлэн, түүний хүү Дурьодхана Пандугийнханы цэргийн хүчийг ажиглаж харсны дараагаар тулалдааны талбар дээрх цагийн байдлын талаар мэдээлэхээр өөрийн цэргийн ерөнхий жанжин Дроначарьягийн зүгт шууд очив гэж хэлж байна. Энд Дурьодханаг хэдийгээр хаан гэж нэрлэж байгаа ч цагийн байдал ноцтой байгаагаас болж тэр өөрөө жанжин дээрээ очиж байна. Эндээс үзэхэд тэр сайн улс төрч гэдэг нь илт байна. Гэсэн ч Дурьодханы гадна өнгөн талдаа харуулах дипломатч байдал нь Пандугийнхны цэргийн зохион байгуулалтыг хараад бий болсон түүний айдас хүйдсийг нуун далдалж чадахгүй байлаа.

ШҮЛЭГ 3

*пашьяйтам панду-путранам ачарья махатим чамум
вьюдхам друпата-путрена тава шишьена дхимата*

пашья- ажигла, *этам-* үүнийг, *панду-путранам-* Пандугийн хөвгүүдийн, *ачарья-* ай багш минь ээ, *махатим-* аугаа, *чамум-* зэвсэгт хүчин, *вьюдхам-* байрлуулсан, *друпата-путрена-* Друпадын хүүгээр, *тава-* Таны, *шишьена-* шавь, *дхи-мата-* маш ухаалаг.

Ай багш минь ээ, Таны ухаалаг шавь болох Друпадын хүүгийн уран дадамгайгаар байрлуулсан Пандугийн хөвгүүдийн хүчирхэг армийг ажиглаж харна уу.

ТАЙЛБАР: Эв дүйтэй аугаа дипломатч болох Дурьодхана цэргийн аугаа жанжин бөгөөд брахмана Дроначарьягийн алдааг анхааруулахыг хүсэж байна. Дроначарья нь Аржунагийн гэргий Драупадын эцэг Друпада хаантай улс төрийн шалтгаанаас болж муудалцсан байлаа. Энэхүү сөргөлдөөнөөс болж Друпада том хэмжээний тахилга үйлдсэн бөгөөд үүний ачаар тэр Дроначарьяг хөнөөж чадах хүүтэй болох адислалыг хүртсэн. Дроначарья үүнийг маш сайн мэдэж байсан ч Друпадагийн хүү Дхриштадьюмнаг цэрэг зэвсгийн боловсролтой болохоор хүрч ирэхэд нь уужим ухаантай брахмана мөн болохын хувьд тэрээр түүнд өөрийн цэргийн эрдмийн бүхий л нууцыг нээхээс татгалзаагүй. Курукшетрын тулааны талбарт Дхриштадьюмна Пандугийнхны талд байсан бөгөөд чухамдаа тэр л Дроначарьягаас сурсан эрдмээрээ тэдний цэргийн хүчийг байлдааны журамд тархаан байрлуулж зохион байгуулсан. Дурьодхана Дроначарьяг тулалдааны үед сонор сэрэмжтэй бөгөөд хатуу чанга байгаасай гэсэн үүднээс энэ алдааг түүнд анхааруулж байна. Түүнээс гадна тэр, Дроначарьяг мөн л өөрийн нь гарамгай шавь нар байсан Пандугийнхны эсрэг тулаанд зөөлөн байх ёсгүй гэдгийг онцгойлон анхааруулж байна. Ялангуяа Аржуна бол түүний хамгийн хайртай бөгөөд хамгийн гарамгай шавь нь байлаа. Дээрх шалтгаанаас болж өршөөнгүй хандвал тулалдаанд ялагдахад хүргэж мэдэх учраас Дурьодхана эдгээрийн тухай анхааруулж байна.

ШҮЛЭГ 4

*атра шура махешв-аса бхимаржуна-сама юдхи
ююдхано вираташ ча друпаташ ча маха-ратхах*

атра- энд, *шурах-* баатрууд, *маха-ишу-асах-* мэргэн харваачид, *бхима-аржуна-* Бхима болон Аржуна, *самах-* хүч тэнцүү, *юдхи-* тулаанд, *ююдханах-* Ююдхана, *виратах-* Вирата, *ча-* мөн түүнчлэн, *друпатах-* Друпада, *ча-* мөн, *маха-ратхах-* аугаа дайчид.

Бхима болон Аржуна нараас дутахааргүй, аугаа дайчин Ююдхана, Вирата, Друпада шиг мэргэн харваачид тэдний дунд олон байна.

ТАЙЛБАР: Тулааныг удирдан явуулах урлагт гарамгай чадварлаг Дроначарьягийн хувьд Дхриштадьюмна бол тийм ч том саад тотгор биш байсан ч тэнд байгаа өөр бусад олон дайчид түүний айдас болгоомжлолыг төрүүлэх учир шалтгаан болж байлаа. Тэдгээрийн хэн нь ч Бхима болон Аржунагийн нэгэн адил айдас, болгоомжлол төрүүлж байсан учир Дурьодхана тэднийг ялалтанд хүрэх зам дээрх том саад тотгор гэж нэрлэж байна. Тэр Бхима болон Аржунаг ямар хүч чадалтайг мэдэж байсан учир бусдыг нь тэдэнтэй харьцуулж байна.

ШҮЛЭГ 5

*дхриштaketуш чекитанах каширажаш ча вирьяван
пуружит кунтибхожаш ча шайбьяш ча нара-пунгавах*

дхриштaketуш- Дхриштaketу, *чекитанах-* Чекитана, *каширажах-* Кашиража, *ча-* мөн, *вирьяван-* маш хүчирхэг, *пуружит-* Пуружит, *кунтибхожах-* Кунтибхожа, *ча-* болон, *шайбьях-* Шайбья, *ча-* мөн, *нара-пунгавах-* хүмүүсийн дундах баатрууд.

Мөн эдний дунд Дхриштaketу, Чекитана, Кашиража, Пуружит, Кунтибхожа, Шайбья зэрэг аугаа, баатарлаг бөгөөд хүчирхэг дайчид байна.

ШҮЛЭГ 6

*юдхаманьяюш ча викранта уттамаужаш ча вирьяван
саубхадро драупадьяш ча сарва эва маха-ратхах*

юдхаманьяюх- Юдхаманью, *ча*- мөн, *викрантах*- хүчирхэг, *уттамаужах*- Уттамаужа, *ча*- мөн, *вирья-ван*- үлэмж хүчит, *саубхадрах*- Субхадрагийн хүү, *драупадьях*- Драупадагийн хөвгүүд, *ча*- мөн, *сарве*- бүгд, *эва*- нөхцөлгүй, *маха-ратхах*- тэргэн дээрээс гарамгай тулалдагчид.

Мөн хүчирхэг Юдхаманью, Субхадрагийн хүү үлэмж хүчтэй Уттамаужа болон Драупадагийн хөвгүүд тэдэнтэй байна. Эдгээр дайчид бүгд л байлдааны тэргэн дээр тулалдахдаа маш чадварлаг билээ.

ШҮЛЭГ 7

*асмакам ту вишишта йе тан нибодха движоттама
наяка мама сайньяся самгьяртхам тан бравими те*

асмакам- манай, *ту*- харин, *вишиштах*- онцгой хүчирхэг, *йе*- тэд, *тан*-тэдэнд, *нибодха*- мэдэж ав, *движа-уттама*- брахмануудын шилдэг нь минь, *наяках*- гол хүмүүс, *мама*- миний, *сайньяся*- дайчдын, *самгья-артхам*- мэдээлэл болгон, *тан*- тэдэнд, *бравими*- би хэлж байна, *те*- Танд.

Ай брахмануудын шилдэг нь минь ээ, би Танд мэдээлэл болгон манай цэргийн хүчинд ямар хүчирхэг жанжингууд байгааг мөн хэлье.

ШҮЛЭГ 8

*бхаван бхишмаш ча карнаш ча крипаш ча самитим-жаях
ашваттхама викарнаш ча саумадаттис татхайва ча*

бхаван- Та өөрөө, *бхишмах*- ахмад настай Бхишма, *ча*- мөн, *карнах*- Карна, *ча*- мөн, *крипах*- Крипа, *ча*- мөн, *самитим-жаях*- тулаанд үргэлж ялагч, *ашваттхама*- Ашваттхама, *викарнах*- Викарна, *ча*-мөн, *саумадаттих*- Сомадаттын хүү, *татха*- шиг, *эва*- гарцаагүй, *ча*-мөн.

Тантай адил хүч чадалтай Бхишма, Карна, Крипа, Ашваттхама, Викарна болон тулалдаанд хэзээ ч ялагдаж үзээгүй баатар Бхуришрава гэж алдаршсан Сомадаттын хүү гэх зэрэг баатрууд байна.

ТАЙЛБАР: Дурьодхана тулалдаанд үргэлж ялж байсан ялгуулсан баатруудын нэрсийг дурьдаж байна. Викарна нь Дурьодханын дүү, Ашваттхама нь Дроначарьягийн хүү, харин Бхуришрава гэж нэрлэгддэг Саумадатти бол Бахликаас хааны хүү билээ. Карна бол Аржунагийн эх нэгтэй ах билээ. Кунти Панду хаантай гэрлэхээсээ өмнө түүнийг төрүүлсэн ажээ. Крипачарьягийн ихрийн өрөөсөн нь Дроначарьягийн эхнэр байлаа.

ШҮЛЭГ 9

*анье ча бахавах шура мад-артхе тьякта-живитах
нана-шастра-прахаранах сарве юддха-вишарадах*

анье-бусад, *ча*-мөн, *бахавах*- олон тоогоор, *шура*- баатрууд, *мад-артхе*- миний төлөө, *тьякта-живитах*- амьдралаа эрсдүүлэхэд бэлэн, *нана*- олон, *шастра*- зэр зэвсэг, *прахаранах*- агссан, зэвсэглэсэн, *сарве*- тэд бүгд, *юддха-вишарадах*-цэрэг дайны үйлд гарамгай.

Мөн өөр олон баатрууд миний төлөө амь насаа зориулахад ч бэлэн байна. Тэд бүгд янз бүрийн зэр зэвсгээ агссан байгаа бөгөөд мөн бүгдээрээ л цэрэг дайны эрдэм ухаанд гарамгай дайчид билээ.

ТАЙЛБАР: Жаядратха, Критаварма болон Шалья зэрэг өөр бусад дайчдын хувьд тэд бүгдээрээ л Дурьодханын төлөө өөрсдийн амьдралаа золиослоход бэлэн байцгаалаа. Өөрөөр хэлбэл, тэд нүгэлт Дурьодханын талд орсон байсан учир бүгд л Курукшетрын тулалдаанд үхнэ гэдэг нь хэдийнээ урьдаас тогтоогдчихсон зүйл байв. Дурьодханын хувьд гэвэл дээр дурьдсан өөрийн найз нөхдийн нэгдсэн хүчинд түшиглэж тулгуурлан ялна гэдэгтээ мэдээж хэрэг итгэлтэй байсан.

ШҮЛЭГ 10

*апарьяптам тад асмакам балам бхишмабхиракшिताм
парьяптам те идам этешам балам бхимабхиракшिताм*

апарьяптам- хэмжиж болшгүй, *тад*- энэхүү, *асмакам*- бидний, *балам*- хүч, *бхишма*- өвөг эцэг Бхишмагаар, *абхиракшिताм*- баттай хамгаалагдсан, *парьяптам*- хязгаарлагдсан, *те*- гэвч, *идам*- энэ бүхэн, *этешам*- Пандавчууд, *балам*- хүч, *бхима*- Бхимагаар, *абхиракшिताм*- нягт нямбай, сайтар хамгаалагдсан.

Манай хүч бол хэмжээлшгүй бөгөөд өвөг эцэг Бхишмагаар баттай хамгаалагдсан байхад Бхимагийн хичээнгүйлэн хамгаалж байгаа Пандугийн хөвгүүдийн хүчин хэмжээ хязгаартай билээ.

ТАЙЛБАР: Дурьодхана энд хоёр талын хүчнийг харьцуулан дүгнэж байна. Тэрээр, өөрийн талын цэргийн хүчин чадал ялангуяа бүх жанжингуудаас хамгийн туршлагатай нь болох өвөг эцэг Бхишма тэднийг хамгаалж байгаа учраас хязгааргүй юм хэмээн итгэж байна. Нөгөө талаас, Пандугийн хөвгүүдийн цэргийн хүчин нь төдийлөн туршлагатай бус жанжин хийгээд Бхишматай харьцуулахад одой хүн лугаа өчүүхэн төдий мэт Бхишмагийн хамгаалалт доор байх учир хязгаарлагдмал хэмээн үзэж байна. Дурьодхана өөрийгөө хэзээ нэгэн цагт амь эрсдэх болвоос түүнийг зөвхөн Бхишма л хөнөөх болно гэдгийг маш сайн мэдэж байсан учраас түүнийг үргэлж үзэн яддаг байлаа. Гэсэн ч, үүний зэрэгцээ тэрээр Бхишмаас хавьгүй илүү жанжин Бхишмаг байгаа болохоор өөрийн ялалтанд итгэлтэй байлаа. Тулаанаас ялагч болон гарна гэсэн түүний дүгнэлт нь ийнхүү огт үндэслэлгүй зүйл биш байлаа.

ШҮЛЭГ 11

*аянешу ча сарвешу ятха-бхагам авастхитах
бхишмам эвабхиракшанту бхавантах сарва эва хи*

аянешу- стратегийн цэгүүдэд, *ча-* мөн, *сарвешу-* хаа сайгүй, *ятха-бхагам-* тэднийг хэрхэн янз бүрийн байдлаар байрлуулсан, *авастхитах-* буй, *бхишмам-* өвөг эцэг Бхишма, *эва-* баттай, *абхиракшанту-* дэмжлэг үзүүлэх ёстой, *бхавантах-* та нар, *сарва-* бүгд, *эва хи-* заавал.

Одоо та бүхэн байлдааны журам дахь стратегийн чухал байрлалуудаа эзлээд бүгдээрээ өвөг эцэг Бхишмад бүрэн дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

ТАЙЛБАР: Дурьодхана Бхишмагийн эр зоригийг магтсаны дараагаар бусад нь өөрсдийгөө төдийлөн чухал биш хэмээн үнэлж байна гэж үзэж магадгүй хэмээн бодсоноор тэр өөрийн заншсан дипломат зангаар дээрх үгүүдээр нөхцөл байдлыг зохицуулж байна. Бхишмадева нь аугаа баатар мөн гэдэг нь эргэлзээгүй ч нас өндөр болсон тул түүнийг тал бүрээс нь хамгаалан дэмжихийг хүн бүр анхаарах ёстой гэж тэр онцлон хэлж байна. Бхишма тулаанд маш ихээр хутгалдан орж байрлалаа байнга солин сүлжиж байх нь сайн талтай бөгөөд хэрвээ тэр нэг л жигүүрт тулалдан байх аваас дайсан энэ нөхцөл байдлыг ашиглаж мэдэх юм. Иймээс бусад баатрууд өөрсдийн стратегийн байрлалуудаа орхилгүй эзлэн байх нь маш чухал бөгөөд эс тэгвээс дайсанд байлдааны журам, эгнээгээ эвдүүлэх боломжийг олгох болно. Куручуудын ялалт нь Бхишмадевагийн байгаа эсэхээс хамаарна гэдгийг Дурьодхана маш сайн мэдэрч байлаа. Бхишмадева болон Дроначарья нар нь тулалдаанд түүнийг бүрэн дэмжинэ гэдэг нь тодорхой байлаа. Учир нь аугаа жанжингуудын хуралдаан дээр Аржунагийн гэргий Драупадаг хүчээр нүцгэлэх гэж оролдох үед, хөөрхийлөлтэй байдалд ороод байсан Драупада тэдэнд хандан шудрага ёсыг баримтлахыг мөргөн гуйхад тэд ганц ч үг хэлээгүй билээ. Энэ хоёр жанжин Пандугийнханд тодорхой хэмжээгээр дотносон татагдаж байгаа гэдгийг Дурьодхана мэдэж байсан ч одоо тэд тэдэнд дотносох энэ хандлагаа дээрх аз сорьсон тоглоом болсон хуралдааны үед байсан шигээ бүрмөсөн орхих болно гэж найдаж байв.

ШҮЛЭГ 12

*тасья саньжанаян харшам куру-вриддхак питамахах
симха-надам винадьоччайх шанкхам дадхмау пратапаван*

тасья- түүний, *саньжанаян-* нэмэгдсэнээр, *харшам-* баяр хөөр, *куру-вриддхак-* Куру удмын өвөг дээд, *питамахах-* өвөг эцэг, *симха-надам-* арслангийн хүрхрэх адил дүнгэнээ, *винадья-* цуурайтан, *уччайх-* маш чанга, *шанкхам* – дун, *дадхмау-* үлээв, *пратапаван-* баатарлаг.

Тэгтэл дайчдын өвөг эцэг, Куру удмын аугаа баатарлаг өвөг Бхишма өөрийн дунгаа чангаар үлээлээ. Түүний дуу нь арслан хүрхрэх лугаа дүнгэнэн цуурайтахуйд Дурьодхана баяр хөөрөөр дүүрэв.

ТАЙЛБАР: Куру-удмын өвөг өөрийн ач Дурьодханын зүрхэнд юу болж байгааг сайн мэдэж байсан ба түүнд урам хайрлахаар жам ёсны өрөвдөж хайрлах мэдрэмжээрээ дунгаа маш чангаар үлээсэн нь түүний арслан лугаа байр сууринд зохицож нийцсэн хэрэг байлаа. Дунгаа үлээх байдлаараа тэр урам нь хугарч санаа нь зовиурлан байгаа ачдаа, Бүхний Дээд Бурхан, Шри Кришна нөгөө талд байгаа учир тулалдаанд ялах ямар ч боломжгүй гэдгийг түүнд шууд бус байдлаар ойлгуулж байна. Тэгсэн хэдий ч тулааныг явуулах нь түүний үүрэг байсан бөгөөд үүний тулд түүнд ямар ч зүтгэл чармайлт гаргах шаардлагагүй байлаа.

ШҮЛЭГ 13

*татах шанкхаш ча бхерьяш ча панаванака-гомукхах
сахасайвабхьяханьянта са шабдас тумуло бхават*

татах- дараа нь, *шанкхаш-* дун бүрээнүүд, *ча-* мөн, *бхерьяш-* том бөмбөрүүд, *ча-* мөн, *панава-анака-* жижиг бөмбөрүүд болон хэнгэрэг, *го-мукхах-* эвэр бүрээнүүд, *сахаса-* гэнэт, *эва-* яг, *абхьяханьянта-* нэгэн зэрэг дуугарсан, *сах-* тэр, *шабдас-* нэгдэж нийлсэн дуу авиа, *тумулах-* аянга ниргэх мэт, *абхават-* болсон.

Үүний дараагаар гэнэт бүхий л дун, их бага бөмбөр, хэнгэрэг, дохионы бүрээ болон нарийн бүрээнүүд нэгэн зэрэг дуугарцгаасан ба тэд бүгдийн дуу нийлээд аянга ниргэх мэт аймшигт чимээ шуугианыг үүсгэв.

ШҮЛЭГ 14

*татах шветаир хаяйр юкте махати съяндане стхитау
мадхавах пандаваш чайва дивьяу шанкхау прададхматух*

татах- дараа нь, *шветаир*- цагаан, *хаяйр*- морьдоор, *юкте*- хөллөсөн, *махати*- аврага том, *съяндане*- байлдааны тэрэг, *стхитау*- байрласан, *мадхавах*- Кришна (аз жаргалын охин тэнгэрийн нөхөр), *пандавааш*- Аржуна (Пандугийн хүү), *ча*- мөн, *эва*- гарцаагүй, *дивьяу*- трансценденталь, *шанкхау*- дун бүрээнүүд, *прададхматух*- цууриатуулсан.

Нөгөө талд цагаан морьд хөллөсөн байлдааны том тэргэн дээр зогссон Шри Кришна болон Аржуна нар өөрсдийн трансценденталь дунгуудаа цуурайтууллаа.

ТАЙЛБАР: Бхишмадевагийн үлээсэн дун бүрээний эсрэгээр Кришна болон Аржуна нарын гарт байгаа дунгуудыг трансценденталь гэж нэрлэж байна. Эдгээр трансценденталь дунгуудын цуурайтуулах дуу нь Кришна Пандугийнхны талд байгаа учраас нөгөө тал ялах ямар ч найдлагагүй гэдгийг битүү сануулж байна. *Жаяс ту панду-путранам ешам пакше жанарданах*. Пандугийн хөвгүүд шиг чин бишрэлтэнгүүдийн талд Кришна байдаг учраас тэд үргэлж ялж байдаг. Аз хийморийн охин тэнгэр өөрийн Нөхрөөс хэзээ ч салан холддоггүй учир Бурхан хэзээ болон хаана заларч байна тэнд мөн аз жаргалын охин тэнгэр үргэлж хамт байдаг. Иймээс Вишну буюу Шри Кришнагийн дун бүрээнээс цуурайтах трансценденталь дуу авианы битүү сануулж байгаачлан, Аржунаг ялалт болон аз жаргал хүлээж байлаа. Түүнээс гадна, хоёр найзын хөлөглөсөн байлдааны тэрэг нь галын тэнгэр Агнигийн Аржунад хайрласан бэлэг байсан бөгөөд түүнийг хөлөглөн байгаа хэн бүхэн гурван ертөнцийн хаана ч тэнгэрийн бүхий л зүгийг эзэлж чадах болой.

ШҮЛЭГ 15

*паньчажаньям хришикешо девадаттам дхананьяжаях
паундрам дадхмау маха-шанкхам бхима-карма врикодарах*

паньчажаньям- Паньчажанья нэртэй дун, *хришикешах*- Хришикеша (Кришна, чин бишрэлтэнгийн мэдрэхүйг удирдан залагч Бурхан), *девадаттам*- Девадатта нэртэй дун, *дхананьяжаях*- Дхананьяжая (Аржуна, баялгийг эзлэгч), *паундрам*- Паундра нэртэй дун, *дадхмау*- үлээсэн, *маха-шанкхам*- айдас төрүүлэм дун, *бхима-карма*- баатарлаг үйл үйлдэгч, *врикодарах*- идээд цадаж ханадаггүй (Бхима).

Шри Кришна Өөрийн Паньчажанья нэртэй дун бүрээгээ цуурайтуулав. Аржуна өөрийн Девадатта, харин баатарлаг ялалтуудаараа алдаршсан, цадаж ханадаггүй Бхима Паундра нэртэй дунгаа үлээцгээв.

ТАЙЛБАР: Шри Кришна бүхий л мэдрэхүйн эзэн учраас Түүнийг энэ шүлэгт Хришикеша гэж нэрлэж байна. Амьд оршнолууд нь Түүний өчүүхэн жижиг бүрэлдэхүүн хэсгүүд учраас тэдний мэдрэхүй нь мөн л Түүний мэдрэхүйн хэсгүүд байдаг билээ. Бодьгал бусыг баримтлагчид нь амьд оршнол мэдрэхүйтэй байдаг тухайд хангалттай тайлбарыг өгөх чадваргүй байдаг тул тэд амьд оршнол нь бодьгал бусын зэрэгцээ мэдрэхүйгүй байдаг гэж батлахыг ямагт хичээж байдаг. Амьд оршнол бүрийн зүрхнээ залрах Бурхан тэдний мэдрэхүйг залан чиглүүлж байдаг. Гэхдээ Тэр тэдний бишрэлийн зэрэг түвшингээс нь хамааруулан залж чиглүүлдэг. Цэвэр чин бишрэлтэнгийн хувьд Бурхан түүний мэдрэхүйг шууд залан жолоодож байдаг. Энд, Курукшетрын тулааны талбар дээр Бурхан Аржунагийн трансценденталь мэдрэхүйг шууд Өөрөө залан жолоодож байгаа бөгөөд энэ нь, Түүнийг энэ шүлэгт Хришикеша гэж нэрлэж байгаагийн тайлбар болно. Бурхан Өөрийн үйлүүдэд зохицож нийцсэн янз бүрийн нэр алдартай байдаг. Тухайлбал: Тэр Мадху демоныг устган дарсан тул Мадхусудана гэж нэрлэгддэг. Мөн Тэр үнээд хийгээд мэдрэхүүд баяр баясгаланг бэлэглэж байдаг учир Говинда, Васудевагийн хүү болон заларсан учир Васудева, Девакийг ээжээ болгосон учир Деваки-нандана, Вриндаванад Өөрийн хүүхэд ахуйн зугаа наадмаар Яшодаг баясгаж байсан учир Яшода-нандана, Өөрийн найз Аржунын тэргийг залж жолоодож байсан учраас Партха-саратхи гэж нэрлэгддэг билээ. Үүний нэгэн адил Тэр Курукшетрын тулааны талбар дээр Аржунаг удирдан чиглүүлж байсан учир Хришикеша гэж нэрлэгдэж байна.

Аржуна, янз бүрийн тахилга өргөлийг элбэг дэлбэг байдалтайгаар үйлдэхийг хүссэн өөрийн ах Юдхистхира хаанд баялаг цуглуулахад нь тусалж байсан учраас тэрээр энэ шүлэгт Дхананьяжая гэж нэрлэгдэж байна. Бхимагийн хувьд гэвэл учиргүй их иддэг байсан нь Хидимба демоныг дарсан зэрэг түүний баатарлаг ялалтуудын нэгэн адил гайхалтай байсан учир тэрээр Врикодара гэж нэрлэгдэж байна. Ийнхүү Бурханы дунгаар эхэлсэн Пандугийн хөвгүүдийн талынхны үлээсэн дунгуудын хадаасан дуу тулалдаанд бэлэн болсон дайчдыг маш ихээр зоригжуулж байв. Эсрэг талд баярлаж хөөрөх ийм ивээл байхгүй байлаа, тэдэнд дээдийн дээд залагч Шри Кришнагийн, мөн аз жаргалын охин тэнгэрийн ивээл байхгүй байлаа. Иймд Куручууд тулаанд ялагдах нь урьдаас тогтоогдсон байсан бөгөөд дунгуудын цуурайтуулах дуу авиа бол энэ тухай зарласан дохио мэдээ байв.

ШҮЛЭГ 16-18

*анантавижаям ража кунти-путро юдхистхирах
накулах сахадевааш ча сугхоша-манипушкау*

*кашьяш ча парамешв-асах шикханди ча маха-ратхах
дхриштадьюмно вираташ ча сатьякиш чапаражитах*

*друпадо драупадеш ча сарвашах притхиви-пате
саубхадраш ча маха-бахух шанкхан дадхмух притхак притхак*

ананта-вижаям- Анантавижая нэртэй дун, *ража*- хаан, *кунти-путрах*- Кунтийн хүү, *юдхистхирах*- Юдхистхира, *накулах*- Накула, *сахадевах*- Сахадева, *ча*- ба, *сугхоша-манипушкау*- Сугхоша болон Манипушка нэртэй дунгууд, *кашьях*- Каши хаан, *ча*- мөн, *парама-ишу-асах*- аугаа мэргэн харваачид, *шикханди*- Шикханди, *ча*- мөн, *маха-ратхат*-

мянга мянгын эсрэг ганцаар тулалдагч, *дхриштадьюмнах*- Дхриштадьюмна (Друпада хааны хүү), *виратах*- Вирата (Пандугийн хөвгүүдийг нуугдах ёстой байсан үед тэднийг ивээлдээ авсан хаан) *ча*- мөн, *сатьяких*- Сатьяки (мөн Ююдхана гэж нэрлэгддэг, Шри Кришнагийн тэрэгний хөтөч), *ча*- мөн, *апаражитах*- урьд өмнө хэзээ ч ялагдаж байгаагүй хүмүүс, *друпадах*- Друпада, Паньчалын хаан, *драупадях*- Драупадын хөвгүүд, *ча*- мөн, *сарваших*- хаа сайгүй, *притхиви-пате*- ай хаантан минь, *саубхадрах*- Абхиманью, Субхадрагийн хүү, *ча*- мөн, *маха-бахух*- хүчит гарт, *шанкхан*- дунгууд, *дадхмух*- үлээсэн, *притхак притхак*- өөр өөрсдөө.

Кунтийн хүү Юдхитхира хаан өөрийн дун Анантавижаягаа үлээн цуурайтуулсан бол Накула болон Сахадева нар Сугхоша болон Манипушпакугаа тус тус үлээв. Аугаа харваач Каши хаан, аугаа дайчин Шхиканди, Дхриштадьюмна, Вирата, үл ялагдагч Сатьяки, Друпада, Драупадын хөвгүүд болон Субхадрагийн хүчит гарт хүү зэрэг бусад дайчин баатрууд, ай хаантан минь ээ, мөн л өөр өөрсдийн дунгуудаа цуурайтуулаа.

ТАЙЛБАР: Пандугийн хөвгүүдийг залилан мэхэлж өөрийн хөвгүүдээ хаан ширээнд суулгахыг хичээн оролдох түүний ухаангүй бодлого нь магтууштай зүйл биш байсан гэдгийг Дхритараштра хаанд Саньжая маш ая дантай байдлаар ойлгуулсан. Олон тооны шинж тэмдгүүд энэхүү аугаа тулалдаанд Куругийн удмынхан бүхэлдээ хөнөөгдөнө гэдгийг бүр одооноос эхлэн тодорхой зааж байна. Хамгийн ахмад Бхишмагаас эхлэн Абхиманью зэрэг ач нар хүртэл болон дэлхийн олон улс гүрнүүдийн хаадуудыг оролцуулаад - тэнд цугларсан байгаа бүгдэд мөхөл сүйрэл нүүрлэж байв. Бүх аюул сүйрэл нь өөрийн хөвгүүдийнхээ төлөвлөгөөг дэмжиж байсан Дхритараштра хааны буруугаас болсон байлаа.

ШҮЛЭГ 19

*са гхоша дхартараштранам хридаяни вьядаряят
набхаш ча притхивим чайва тумуло бхянунадаян*

сах- энэхүү, *гхошах*- дуу авианы чичиргээ, *дхартараштранам*- Дхритараштрын хөвгүүдийн, *хридаяни*- зүрхийг, *вьядаряят*- зүсэх, *набхах*- тэнгэр, *ча*- мөн, *притхивим*- газрын гадаргуу, *ча*- мөн, *эва*- гарцаагүй, *тумулах*- аянга мэт хүчтэй, *авхянунадаян*- цуурайтан.

Дунгуудын дуу маш хүчтэй, газар тэнгэрээр нэг цуурайтаж байсан учир Дхритараштрын хөвгүүдийн зүрхийг нь зүсэв.

ТАЙЛБАР: Бхишма болон Дурьодханын талын дайчдыг дун бүрэнүүдээ дуугаргахад Пандугийнхны зүрхэнд айдас огтхон ч төрөөгүй билээ. Ингэсэн тухай хаана ч дурьдаагүй байдаг, харин ч эсрэгээр, яг энэхүү шүлэгт өгүүлсэнчлэн, Пандугийнхны талын цуурайтуулсан дууг сонсоод Дхритараштрын хөвгүүдийн зүрх нь урагдаж байв. Үүний учир шалтгаан нь Пандугийнхны Шри Кришнад итгэж байгаа итгэл билээ. Бурханы Дээд Бодгалиас аврал ивээл эрж хайх хэн бүхэн хамгийн хүнд бэрх гай зовлонгийн дунд орсон ч юунаас ч айдаггүй.

ШҮЛЭГ 20

*атха вьявастхитан дриштва
дхартараштран капи-дхважах
правритте шастра-сампате
дханур удьямья пандавах
хиршикешам тада вакьям
идам аха махи-пате*

атха- тэгээд, *вьявастхитан*- жагссан, *дриштва*- харснаа, *дхартараштран*- Дхритараштрын хөвгүүдийг, *капи-дхважах*- Хануманы дүр бүхий далбаатай тэр, *правритте*- бэлэн болсон байхад, *шастра-сампате* сумаа харвахаар, *дханух*- нум, *удьямья*- аван, *пандавах*- Пандугийн хүү (Аржуна), *хиршикешам*- Шри Кришнад, *тада*- энэ цаг үед, *вакьям*- үгүүд, *идам*- энэ, *аха*- хэлсэн, *махи-пате*- ай хаантан минь.

Энэ үед Хануманы дүр бүхий далбаагаа байлдааны тэргэн дээрээ залсан Пандугийн хүү Аржуна нумаа авч сумаа харвахад бэлэн болсон. Тэрээр Дхритараштрын хөвгүүдийн цэргийн эгнээг хараад, ай хаантан минь ээ, Шри Кришнад дараахь үгүүдийг айлтгав.

ТАЙЛБАР: Тулаан юу юугүй эхлэхэд бэлэн болсон байлаа. Дээр өгүүлснээс үзэхэд Дхритараштрын хөвгүүд нь Шри Кришнагийн шууд сургаал зааврыг удирдлага болгож байсан Пандугийнхны цэргийн хүчнээс, хүлээж байгаагүй тийм гэнэтийн зохион байгуулалтыг хараад их бага боловч ямар нэгэн хэмжээгээр зориг алдарсан. Хануман нь Рама, Равана хоёрыг тулалдахад Шри Рамагийн талд байсан ба эцэст нь Шри Рама ялсан учраас Аржунагийн далбаан дээрх түүний дүртэй эмблем нь ялалтын бас нэгэн тэмдэг болж байв. Одоо бол Рама ч тэр мөн Хануман ч тэр, хоёулаа Аржунаг дэмжихээр түүний байлдааны тэргэн дээр залран байлаа. Шри Кришна бол Өөрөө Рама бөгөөд Шри Рама хаана заларч байна тэнд Түүний мөнхийн албат Хануман болон Түүний мөнхийн гэргий, аз жаргалын охин тэнгэр Сита нар мөн бараа болон заларч байдаг билээ. Ийм учраас Аржунагийн хувьд ямар ч дайснаас айж эмээх үндэс байхгүй байв. Түүнээс гадна хамгийн гол нь, мэдрэхүйн эзэн Шри Кришна түүнд заавар өгөхөөр Өөрөө залран байлаа. Тулалдаан явуулахын тухайд гэвэл ийнхүү бүхий л сайн заавар, зөвлөмжүүд Аржунагийн мэдэлд байв. Бурханаас Өөрийн мөнхийн чин бишрэлтэнд зориулан бүрдүүлсэн ийм таатай нөхцөл байдлууд нь баталгаатай ялахын тэмдэг болж байдаг.

ШҮЛЭГ 21-22

аржуна увача
сенайор убхайор мадхье ратхам стхапая ме `чьюта
явад этан нирикше `хам йоддоху-каман авастхитан
кайр майа саха йоддохавьям асмин рана-самудьяме

аржуна увача- Аржуна айлтгасан, *сенайох*- цэргийн хүчнүүдийн, *убхайох*- хоёр талын, *мадхье*- тэдний дунд, *ратхам*- байлдааны тэргээ, *стхапая*- чиглүүл, *ме*- миний, *ачьюта*- алдаа эндэгдэл үл гаргагч минь, *яват*- хүртэл, *этан*-энэ бүхэн, *нирикше*-ажиглахад минь, *ахам*- би, *йоддоху-каман*- тэмцэн тулалдахаар улангассан, *авастхитан*- тулааны талбарт байрлалаа эзэлсэн, *кайха*- хэнтэй, *майа*- надаар, *саха*- хамт, *йоддохавьям*- тулалдах ёстой, *асмин*- энэ, *рана*- тулалдаанд, *самудьяме*- оролдлогод.

Аржуна айлтгасан нь: Ай алдаа эндэгдэл үл гаргагч минь ээ, бид энэхүү аугаа тулаанд хэний эсрэг өөрсдийн зэр зэвсгээ чиглүүлэх ёстой болоод байна гэдгийг болон энд улангасан тулалдахаар хэн хэн цугларсныг бүгдийг нь хармаар байна. Иймд миний тэргийг хоёр талын цэргийн хүчний дунд талруу аваачна уу.

ТАЙЛБАР: Шри Кришна Бурханы Дээд Бодгаль мөн хэдий ч учир шалтгаангүй өршөөл нигүүлслээрээ Тэр Өөрийн найзын албанд зүтгэж байна. Тэрээр Өөрийн чин бишрэлтэнгүүддээ дотно хандахдаа хэзээ ч алдаа эндэгдэл гаргадаггүй бөгөөд иймээс Түүнийг энд алдаа эндэгдэл үл гаргагч хэмээн нэрлэж байна. Тэргийг нь жолоодон залагч болохын хувьд Тэр Аржунагийн тушаалыг гүйцэтгэх ёстой бөгөөд Тэрээр үүнийг гүйцэтгэхээс үл татгалзаж байгаа учраас алдаа эндэгдэл үл гаргагч гэж нэрлэгдэж байна. Тэр хэдийгээр Өөрийн чин бишрэлтэнгийн тэрэгний хөтчийн үүргийг гүйцэтгэж байгаа ч Дээдийн Дээд байдаг Түүний байр суурь ямар ч асуултгүй хэрэг билээ. Тэр бол ямар ч нөхцөл байдлаас үл хамааран Бурханы Дээд Бодгаль, Хришикеша, бүхий л мэдрэхүйн эзэн байдаг билээ. Бурхан болон Түүний албат үйлчлэгчийн хоорондын харьцаа маш ялдам дотно бөгөөд трансценденталь байдаг. Бурханы албат нь Түүнд үйлчлэн зүтгэхэд хэзээд бэлэн байдаг ба мөн үүний нэгэн адил Бурхан Өөрийн чин бишрэлтэнд ямар нэгэн ач тус үзүүлэх боломж далимыг үргэлж эрж байдаг. Бурхан Өөрөө зарлиг лүндэн буулгаж байснаас цэвэр чин бишрэлтэн нь Өөрт нь тушаал заавар өгч байдаг илүү дээд байр суурийг эзэлж байх нь Түүнийг маш ихээр цэнгүүлдэг. Тэр Бурхан учраас Түүний зарлиг лүндэнг хэн бүхэн дагах ёстой, Түүнд тушаал заавар өгч чадахаар Түүнээс илүү дээр хэн ч байдаггүй. Гэсэн ч цэвэр чин бишрэлтэн нь Түүнд тушаал зааж байхыг хараад Тэр хэдийгээр ямар ч нөхцөл байдалд байсан алдаа эндэгдэл үл гаргах Бурхан мөн ч трансценденталь баяр цэнгэлийг мэдэрч амталж байдаг.

Бурханы цэвэр чин бишрэлтэн мөн болохын хувьд Аржуна үеэлүүд болон ах дүү нартайгаа тулалдах шаардлага байгаагүй ч, эвлэрэн найрамдах гэсэн аль ч саналыг нь огтхон ч хүлээн зөвшөөрөөгүй Дурьодханы гөжүүд зөрүүд зангаас болж тулааны талбарт ирэхээс өөр аргагүй болсон. Ийм учраас тэр тулааны талбарт цугларсан удирдагчид хэн хэн болохыг харахыг маш ихээр хичээж байв. Хэдийгээр тулааны талбар дээр эвлэрэн найрамдахаар хичээл зүтгэл гаргах тухай асуудал байж болохгүй ч тэрээр тэднийг дахин харах болон тэд энэхүү үл хүсүүштэй тулааныг явуулахыг хир ихээр шавдан шаардаж байгааг мэдэхийг хүсэж байлаа.

ШҮЛЭГ 23

йотсьяманан авекше `хам я эте `тра самагатах
дхартараштрасья дурбуддхер ююдхе прия-чикиршавах

йотсьяманан- тулалдах гэж байгаа тэднийг, *авекше*- харуул, *ахам*- би, *я*- тэд, *эте*- тэд, *атра*- энд, *самагатах*- хуран цугларсан, *дхартараштрасья*- Дхритараштрын хүүг, *дурбуддхер*- муу санаат, *ююдхе*- тулалдаанд, *прия*- сайн, *чикиршавах*- хүссэн.

Дхритараштрын санаа муут хүүг баярлуулан тулалдаанд оролцохоор энд ирэгсдийг надад харуулаач.

ТАЙЛБАР: Дурьодхана өөрийн эцэг Дхритараштратай хамтран хорт муу нууц явуулгаар Пандугийнхны улс гүрнийг өөрсдөдөө булаан авахыг хүссэн нь нууц биш юм. Иймээс Дурьодханы талд орогсод нь бүгдээрээ адил санаа бодолтой байсан хэрэг. Аржуна тулалдааны талбар дээр тулаан эхлэхээс өмнө тэднийг хэн болохыг нь мэдэх гэж л харахыг хүссэн болохоос тэдэнтэй энхийн хэлэлцээр хийх санал тавих санаа бодол өвөрлөөгүй байлаа. Түүнээс гадна, Кришна өөрийнх нь талд байсан болохоор тэрээр ялалтандаа бүрэн итгэлтэй байсан ч өөртэй нь тулгарах гэж байгаа хүчний багцааг авах үүднээс мөн тэднийг харахыг хүссэн хэрэг.

ШҮЛЭГ 24

саньжая увача
эвам укто хришикешо гудакешена бхарата
сенайор убхайор мадхье стхапайтва ратхоттамам

саньжах увача- Саньжая хэлсэн, *эвам*- ингэж, *укто*- хандсан, *хришикешах*- Шри Кришна, *гудакешена*- Аржунагийн, *бхарата*- Бхаратын үр удам минь, *сенайох*- цэргийн хүчнүүдийн, *убхайох*- хоёр талын, *мадхье*- гол дунд, *стхапайтва*- залж байрлуулан, *ратхоттамам*- гайхамшигтай байлдааны тэрэг.

Саньжая хэлсэн нь: Ай Бхаратын үр удам минь ээ, Аржунаг ингэж хэлэхэд Шри Кришна гайхамшигт сайхан байлдааны тэргийг нь хоёр талын цэргийн хүчний дундуур чиглүүлэн заллаа.

ТАЙЛБАР: Энэ шүлэгт Аржунаг Гудакеша гэж нэрлэж байна. *Гудака* гэдэг нь “нойр” гэсэн үг, харин нойроо ялж дийлсэн хэн бүхнийг *гудакеша* гэж нэрлэдэг. Нойр нь мөн мунхаг гэсэн утгатай бөгөөд иймд Аржуна нь Кришнатай нөхөрлөсний ач тусаар нойрыг ч тэр, мөн мунхгийг ч тэр ялан дийлсэн байлаа. Аугаа чин бишрэлтэн болохын хувьд тэр Кришнаг хоромхон зуурт ч мартдаггүй. Учир нь энэ бол чин бишрэлтэнгийн мөн чанар билээ. Чин бишрэлтэн нь унтаж байхдаа ч тэр, мөн сэрүүн байхдаа ч тэр Кришнагийн нэр алдар, дүр төрх, шинж чанар болон зугаа наадмуудын талаарх бодлоо хэзээ ч зогсоодоггүй. Кришнагийн чин бишрэлтэн нь ингэж л Кришнаг тасралтгүй бодсоноор нойрыг ч тэр, мунхгийг ч тэр ялан дийлдэг. Үүнийг Кришнагийн ухамсар буюу *самадхи* гэж нэрлэдэг. Амьд оршнол бүрийн ухаан хийгээд мэдрэхүйг залан жолоодогч Хришикеша болохын хувьд Кришна Аржунагийн байлдааны тэргээ хоёр талын цэргийн дундуур залахыг Түүнд тушаах үеийн бодол санааг нь ойлгосон. Тэрээр энэ тушаалыг гүйцэтгэсэн бөгөөд дараа нь дараахь үгүүдийг айлдсан.

ШҮЛЭГ 25

*бхишма-дрона-прамукхатах сарвешам ча махи-кшитам
увача партха пашьяитан самаветан курун ити*

бхишма- өвөг эцэг *Бхишмагийн, дрона*- багш *Дронагийн, прамукхатах*- өмнө нь, *сарвешам*- бүхнийг, *ча*- мөн, *махи-кшитам*- дэлхий хаад, *увача*- хэлсэн, *партха*- Притхын хүү минь, *пашья*- зөвхөн хар, *этан*- тэд бүгдийг, *самаветан*- цугларсан, *курун*- Куру удмынхныг, *ити*- ийнхүү.

Бхишма, Дрона болон дэлхийн бусад бүхий л хаадыг хараад Бурхан айлдсан нь: Ай Партха минь ээ, энд цугларсан зөвхөн бүх Куругийнхныг л хар даа.

ТАЙЛБАР: Шри Кришна бүх амьд оршнолуудын Дээд Сүнс учраас Аржунагийн ухаанд юу болж байгааг ойлгосон байв. Үүнтэй холбогдуулан Хришикеша гэдэг үгийг энд хэрэглэж байгаа нь Тэр бүхнийг мэдсэн гэдгийг зааж байна. Энд Аржунад Кунтийн буюу Притхийн хүү гэсэн утга бүхий Партха минь гэж хандаж байгаа нь мөн л учиртай. Найз нөхөр болохын хувьд Кришна Аржунад, тэр Түүний эцэг Васудевагийн дүү Притхын хүү байсан учраас л түүний тэрэгний хөтөч болохыг зөвшөөрсөн гэдгийг ойлгуулж байна. Харин Тэр “зөвхөн бүх Куручуудыг хар л даа” гэж айлдах үедээ юу бодож байсан бэ? Аржуна одоо, өөрийн санаа бодлоо өөрчлөн тулалдаанд оролцохоос татгалзахыг хүснэ гэж үү? Кришна Өөрийн авга эгчийн хүүгээс иймэрхүү зүйл огтхон ч хүлээж байсангүй. Энэ бол Аржунагийн ухаан бодлыг урьдчилан айлдсан Бурханы нөхөрсөг, хошигнол хэлбэртэй сануулга байлаа.

ШҮЛЭГ 26

*матрапашьят стхитан партхах питрин атха питамахан
ачарьян матулан бхратрин путран паутран сакхимс татха
швашуран сухридаш чайва сенайор убхайор апи*

матра- тэнд, *апашьят*- олж харав, *стхитан*- зогсож байгаа, *партхах*- Притхын хүү минь, *питрин*- эцгүүд, *атха*- мөн, *питамахан*- өвөг эцгүүд, *ачарьян*- багш нар, *матулан*- нагац ах нар, *бхратрин*- ах нар, *путран*- хөвгүүд, *паутран*- ач нар, *сакхимс*- найз нөхдүүд, *татха*- мөн, *швашуран*- хадам аавууд, *сухридах*- сайныг ерөөгчид, *ча*- мөн, *эва*- гарцаагүй, *сенайох*- цэргийн хүчнүүдийн, *убхайох*- хоёр талын, *апи*- тэрчлэн.

Хоёр талын цэргийн хүчний хооронд ирж зогссон Аржуна өөрийн эцгүүд, өвөг эцгүүд, багш нар, нагац ах нар, ах дүү нар, хөвгүүдээ, ач нараа, найз нөхдөө, хадам эцгүүдээ болон өөрийг нь хүндэтгэн байдаг хүмүүсээ олж харлаа.

ТАЙЛБАР: Тулааны талбар дээр Аржуна өөрийн бүхий л төрөл төрөгсдөө харсан. Тэр эцгийнх нь үе чацуутан байсан Бхуришраву зэрэг хүмүүс, мөн өөрийн өвөг эцгүүд Бхишма болон Сомадатту, Дроначария болон Крипачария шиг багш нар, Шалья болон Шакуни зэрэг нагац ах нар, Дурьодхана зэрэг ах дүү нар, Лакшмана зэрэг хөвгүүдээ, Ашваттхама зэрэг найз нөхдөө, Критаварма зэрэг сайн сайхныг ерөөгчид болон бусад олон хүмүүсийн байгааг таньсан. Мөн түүнчлэн тэр хоёр талын цэргийн хүчинд өөрийн нь олон найз нөхөд байхыг харж таньсан.

ШҮЛЭГ 27

*тан самикшья са каунтеях сарван бандхун авастхитан
крипая параявишто вишиданн идам абратив*

тан- тэд бүгдийг, *самикшья*- харан, *сах*- тэр, *каунтеях*- Кунтийн хүү, *сарван*- бүхий л төрлийн, *бандхун*- төрөл төрөгсөд, *авастхитан*- оршин, *крипая*- энэрэл өрөвдөлөөр, *парая*- ихэд, *авиштах*- дүүрэн, *вишидан*- харамссан, *идам*- ингэж, *абратив*-хэлсэн.

Кунтийн хүү Аржуна энэ бүх найз нөхөд болон төрөл төрөгсөдөө харснаа энэрэл өрөвдөлд автан дараахь үгүүдийг айлтгалаа.

ШҮЛЭГ 28

*аржуна увача
дриштвемам сва-жанам кришна юютсум самупастхитам
сиданти мама гатрани мукхам ча паришушьяти*

аржунах- Аржуна, увача- хэлсэн, дриштва- харсаны дараа, имам- энэ бүхнийг, сва-жанам- төрөл төрөгсөдөө, кришна- Кришна минь, юютсум- бүгд тулалдахаар улангассан, самупастхитам- цугларан, сиданти- чичрэх, мама- миний, гатрани- биеийн хэсгүүд, мукхам- ам, ча- мөн, паришушьяти- хуурайшин хатаж байна.

Аржуна айлтгасан нь: Ай эрхэм Кришна минь ээ, улангасан тулалдахаар ийнхүү хуран цугларсан төрөл төрөгсөд болон найз нөхдөө хараад бүхий л бие минь дагжин чичирч, ам маань хуурайшин хатаж байна.

ТАЙЛБАР: Бурханыг жинхэнэ чин бишрэх хэн бүхэн ариун гэгээн хүмүүс болон сахиулсан тэнгэрүүдэд байх бүхий л сайн шинж чанаруудыг өөртөө агуулж байдаг байхад чин бишрэлтэн бус хүн боловсрол болон соёлоороо материаллаг хөгжлийн ихээхэн өндөр түвшинд хүрсэн байж болох ч бурханлаг шинж чанаруудтай байдаггүй. Иймээс Аржуна, бие биенийхээ эсрэг тулалдахаар шийдэн тулалдааны талбар дээр цугларсан байсан өөрийн төрөл төрөгсөд болон найз нөхдөө хармагц шууд л энэрэл өрөвдөлд дийлдэн автаж байна. Бүр эхнээсээ л түүний дотор өөрийн талын дайчдыг өрөвдөх бодол төрж байсан бол одоо тэр эсрэг талынхаа цэргүүдийг зайлшгүй үхэхийг урьдчилан харсан тул тэднийг хүртэл өрөвдөж байна. Энэ байдлаасаа болж түүний бүхий л бие нь чичирч эхэлсэн бөгөөд мөн ам нь ч хуурайшин арган хатсан. Тэдний ийнхүү тулалдахаар бүрэн улангассан байхыг харсан нь чухамдаа түүнийг гайхшруулсан хэрэг. Бараг л удам угсаагаараа бүхэлдээ, өөрөөр хэлбэл Аржунагийн цусан төрлийнхөн бүгдээрээ түүний эсрэг тулалдахаар ирсэн байлаа. Энэ явдал л Аржуна шиг сайхан санаатай чин бишрэлтэн ялж дийлсэн хэрэг. Хэдийгээр энд дурьдаагүй боловч Аржуна зөвхөн чичирч, ам нь хуурайшин арган хатсан төдийгүй мөн тэр өрөвдөл энэрэлээсээ болж үйлж байсан гэдгийг хялбархан төсөөлж болно. Аржунагийн энэ байдал нь түүний сул доройгоос биш харин цэвэр чин бишрэлтэнгийн нэгэн шинж чанар болох өр нимгэнтэйгээс болсон хэрэг. Иймээс:

*ясьясти бхактир бхагаватй акиньчана
сарвайр гунайс татра самасате сурах
харав абхактасья кутто махад-гуна
мано-ратхенасати дхавато бахих*

“Бурханы Дээд Бодгальд хэлбэрэлт гуйвалтгүйгээр чин бишрэлтэй байх хэн бүхэн сахиулсан тэнгэрүүдийн бүхий л сайн шинж чанаруудыг агуулж байдаг. Харин Бурханы чин бишрэлтэн бус хэн бүхэн үнэ цэнээр багахан зөвхөн материаллаг чадваруудыг л эзэмшсэн байдаг. Тэрээр ухааны түвшинд үйл хөдлөлөө хийдэг болон гялтганан гялбалзах материаллаг эрчимд мансууран байдаг нь эргэлзээгүй учраас ийм байдаг.” гэж Шримад Бхагаватамын (5.12.18)-д өгүүлсэн байдаг.

ШҮЛЭГ 29

*вепатхуш ча шарире ме рома-харшаш ча жаяте
гандивам срамсате хастат твак чайва паридахьяте*

вепатхух- биеийн чичрэлт, ча- мөн, шарире- бие махбодь дээр, ме- миний, рома-харшах- үс өрвийн босож байна, ча- мөн, жаяте- болсон, гандивам- Аржунагийн нум, срамсате- алдран, хастат- гараас, твак- арьс, ча- мөн, эва- гарцаагүй, паридахьяте- халуу шатаж байна.

Миний бүхий л бие чичирч, үс минь өрвийн босож байна. Миний Гандива нум гараас минь алдран мултарч байна. Миний арьс халуу шатаж байх шиг байна.

ТАЙЛБАР: Бие махбодь салганан чичирч эхлэх болон үс өрвийн босох үзэгдэл нь нэг бол их бурханлаг хөөрөлд (экстаз) ороход эсвэл материаллаг нөхцөл байдлын доор ихээр айсан гэсэн хоёр тодорхой тохиолдолд л бий болдог. Трансценденталь танин мэдэхүйн үйл явцад ямар ч айдас хүйдэс гэж байдаггүй. Энд, Аржунад илэрч байгаа шинж тэмдэг нь материаллаг айдас хүйдэснээс, тухайлбал амьдралаа алдах нь гэж эмээснээс үүсэн гарсан. Энэ нь мөн өөр шинж тэмдгүүдээр ч илэрч байна. Тэрээр түүний алдартай нум Гандива нь гараас нь гулсан мулттрахаар тийм ихээр мэгдэн сандарсан байв. Мөн дотоодод нь, зүрх нь шатаж байсан учраас тэр арьс нь шатаж байгааг мэдэрч байлаа. Энэ бүхэн нь материаллаг амьдралын үзэл бодлоос шалтгаалан гардаг.

ШҮЛЭГ 30

*на ча шакномй авастхатум бхраматива ча ме манах
нимиттани ча пашьями випаритан кешева*

на- үгүй, ча- мөн, шакноми- чадна, авастхатум- хэвээр үлдэх, бхрамати- мартан, ива- шиг, ча- мөн, ме- миний, манах-ухаан, нимиттани- учир шалтгаан, ча- мөн, пашьями- би харж байна, випаритан- шууд эсрэг тал, кешева- Кешу демоныг дарагч минь.

Би энд илүү удаан зогсож байж чадахгүй нь. Миний ухаан самуурч, толгой минь эргэж байна. Ай Кришна минь ээ, ай Кешу демоныг дарагч минь ээ, би зөвхөн гай зовлонгийн шалтгааныг л олж харж байна.

ТАЙЛБАР: Мэгдэж сандарсны улмаас Аржуна тулааны талбарт удаан байх боломжгүй болсон бөгөөд энэхүү дотоод үлбэгэр сул дорой байдлаасаа болж тэрээр маш их сандарч самуурсан байв. Ийнхүү сандарч тэдсэн байдалд орох нь материаллаг зүйлд хэт ихээр татагдсантай холбоотой байдаг. Бхаям двитиябхинивешатах сьят (Шримад Бхагаватам,

11.2.37): Иймэрхүү айдас хүйдэст автах болон ухааны тэнцвэртэй байдлаа алдах явдал нь материаллаг нөхцөл байдлын нөлөөлөлд маш ихээр орсон хүмүүст л тохиолддог. Аржуна энэхүү тулалдаан зөвхөн зовлон гасланг л авчирна гэдгийг урьдчилан харсан бөгөөд тэр дайснаа ялсан байлаа ч аз жаргалтай байж чадахааргүй байлаа. *Нимитта, випаритани* гэдэг үгүүд нь чухал ач холбогдолтой. Хэрвээ хэн нэгэн хүн өөрийн хүсэн хүлээж байгаа зүйлдээ горьдлого тасрах аваас “Би чухам яах гэж энд байгаа билээ” гэж боддог. Хэн бүхэн өөрийнхөө болон өөрийн хувийн сайн сайхан байдлын тухай л анхаарал сонирхол тавьж байдаг. Хэн ч Дээд Сүнсний тухайд анхаарч сонирхдоггүй. Кришнагийн тааллын дагуу л Аржуна энд мөн өөрийн жинхэнэ сонирхлын тухай үл мэдэх байдалд оршин байгааг харуулж байна. Жинхэнэ өөрийн сонирхол бол Вишну буюу Кришнад зүтгэхэд оршдог боловч болзолт сүнс нь үүнийг мартаж умартсны улмаас материаллаг зовлон шаналыг эдэлж байдаг. Аржуна, тулалдаанд ялсан байлаа ч энэ нь түүний хувьд зөвхөн зовлон шаналал авчрахын нэг үндэс болно гэж бодож байлаа.

ШҮЛЭГ 31

*на ча шрейо `нупашьями хатва сва-жанам ахаве
на канкше вижяам кришна на ча ражьям сукхани ча*

на- үгүй, ча- мөн, шрейо- сайн, анулашьями- би урьдчилан харж байна, хатва- хөнөөснөөр, сва-жанам- өөрийн төрөл төрөгсдөө, ахаве- тулаанд, на- үгүй, канкше- би хүсэж байна, вижяам- ялалт, кришна- Кришна минь, на- үгүй, ча- мөн, ражьям- эзэнт гүрэн, сукхани- ингэж олсон сайн сайхан, ча-мөн.

Би энэ тулалдаанд өөрийн төрөл төрөгсдөө хөнөөснөөр ямар сайн юм болохыг харахгүй байна. Ай эрхэм Кришна минь ээ, энэхүү аллага хөнөөлийн үр дагавар болох ялалт, улс гүрнээ эзэмшилдээ авах эсвэл аз жаргал зэрэг нь миний хүслэн болсон чухал зүйл биш.

ТАЙЛБАР: Болзолт сүнснүүд нь өөрсдийн нь сонирхох ёстой жинхэнэ сонирхол бол Вишну (Кришна) байдаг гэдгийг мэдэлгүй бие махбодийн харьцаануудадаа татагддаг ба тэд ингэж л байж аз жаргалтай болно хэмээн найдаж байдаг. Харалган байдалд орсноор тэд материаллаг аз жаргалын учир шалтгаан юу байдгийг ч мартдаг. Аржуна ч гэсэн *киатрия* хүний мөрдөх ёстой ёс суртахууны хуулиудыг мартсан байдалтай байна. Кришнагийн шууд удирдлага зааврын дагуу тулалдаж байгаад тулалдааны талбар дээр амь эрсэдсэн *киатрия* болон бурханлаг зам мөрөөр замнахад өөрийгөө бүрнээ зориулсан огоорохуйн амьдралаар амьдрагч зэрэг хоёр төрлийн хүмүүс хамгийн хүчирхэг бөгөөд нүд гялбам нарны гариг дээр дээшлэн хүрч очдог гэж ярьдаг. Аржуна төрөл төрөгсдөө бүү хэл дайснаа хөнөөхийг ч эсэргүүцэж байна. Төрөл төрөгсдөө хөнөөх аваас түүний амьдрал ямар ч аз жаргалгүй болно гэж бодсоноос тэр өлсөөгүй байгаа хүн хоол хийхийг хүсдэггүйтэй адилаар тулалдахыг хүсэхгүй байна. Тэгээд тэр ойд очин хүнгүй зэлүүд газарт уйтгартай ганцаардмал амьдралаар амьдрахаар шийдэж байлаа. *Киаатрия* мөн болохын хувьд оршин байхын тулд түүнд улс гүрэн хэрэгтэй билээ. Учир нь *киатрия* хүнд өөр бусад үйл эрхлэх нь зохилдохгүй. Харин Аржунад улс гүрэн байсангүй. Түүний улс гүрэнгүй болох цорын ганц боломж бол өөрийн үеэлүүд болон ах дүү нарын эсрэг тулалдан эцгээсээ өвлөсөн улс гүрнээ буцааж эргүүлэн авах явдал байв. Гэтэл тэр үүнийг хийхийг хүсэхгүй байлаа. Ийм учраас тэр уйтгартай, ганцаардмал, холдож хөндийрсөн амьдралаар амьдрахаар ой руу явах нь хамгийн дээр гэж үзэж байна.

ШҮЛЭГ 32-35

*ким но ражьена говинда ким бхогайр живитена ва
ешам артхе канкшитам но ражьям бхогах сукхани ча*

*та име вастхита юддхе пранамс тьяктва дханани ча
ачарьях питарах путрас татхайва ча питамахах*

*матулах швашурах паутрах шьялах самбандхинас татха
этан на хантум иччхами гхнато `пи мадхусудана*

*апи трайлокья-ражьясья хетох ким ну махи-крите
нихатья дхартараштран нах ка притих сьяз жанардана*

ким- ямар ач тус, нах- бидэнд, ражьена- эзэнт гүрэн, говинда- Кришна минь, ким- юу, бхогайр- таашаал ханамж, живитена- амьдарсанаар, ва- эсвэл, ешам- тэдний хувьд, артхе- төлөө, канкшитам- хүсэж байгаа, нах- биднээр, ражьям- эзэнт гүрэн, бхогах- материаллаг таашаал ханамж, сукхани- бүхий л аз жаргал, ча- мөн, те- тэд бүгд, име- эдгээр, авастхита- оршиж байгаа, юддхе- тулалдааны энэ талбар дээр, пранан- амьдрал, тьяктва- орхин, дханани- баялаг, ча- мөн, ачарьях- багш нар, питарах- эцгүүд, путрах- хөвгүүд, татха- мөн тэрчлэн, сва- гарцаагүй, ча- мөн, питамахах- өвөг эцгүүд, матулах- нагац ах нар, швашурах- хадам эцгүүд, паутрах- ач нар, шьялах- хүргэд, самбандхинах- төрөл төрөгсөд, татха- мөн тэрчлэн, этан- энэ бүхэн, на- хэзээ ч үгүй, хантум- хөнөөхөөр, иччхами- би хүсэж байна, гхнатах- хөнөөгдсөнөөр, апи- ч, мадхусудана- Мадху демоныг хөнөөгч (Кришна) минь, апи- хэдий ч, трайлокья- гурван ертөнцөд, ражьясья- эзэнт гүрний төлөө, хетох- зорилготой, ким- хөнөөгдсөнөөр, ну- ч, махи- крите- газар дэлхийн төлөө, нихатья – хөнөөснөөр, дхартараштран- Дхритараштрын хөвгүүдийг, нах- бидний, ка- ямар, притих- баяр хөөр, сьязт- болно, жанардана- бүх амьд оршнолыг тэтгэгч минь.

Ай Говинда минь ээ, улс гүрэн, аз жаргал эсвэл амьдралыг өөрийг нь хүртэл тэдний төлөө л хүсэж байхад тэд бүгдээрээ одоо тулалдааны талбар дээр эгнээ хүрээгээрээ бидний эсрэг зогсож байхад энэ бүхэн нь бидэнд ямар хэрэгтэй гэж? Ай Мадхусудана минь ээ, хэрвээ багш нар, эцгүүд, хөвгүүд, өвөг эцгүүд, нагац ах нар, хадам

эцгүүд, ач нар, хүргэд нар болон бусад төрөл төрөгсөд минь амь амьдрал болоод эд баялгаа эрсдүүлэхэд ч бэлэн байдалтай миний өмнө зогсоцгоож байхад- хэрвээ би тэднийг эс хөнөөх аваас, тэд намайг хөнөөх гэж байгаа ч би тэднийг хөнөөхийг хүсэж яахин чадах билээ дээ. Ай амьдралыг тэтгэгч минь ээ, тулалдах аваас надад энэхүү газар дэлхийг бүү хэл гурван ертөнцийг бүхэлд нь өгье гэсэн байлаа ч би тэдэнтэй тулалдахад бэлэн биш байна. Бид Дхритараштрын хөвгүүдийг хөнөөчихөөд яаж баяр баясгалантай байж чадах билээ дээ.

ТАЙЛБАР: Кришна бол үнээд хийгээд мэдрэхүйд бүхий л баяр баясгаланг хайрладаг учраас Аржуна Түүнийг Говинда гэж нэрлэн хандаж байна. Энэхүү учир утга бүхий нэрийг хэрэглэснээрээ тэр Кришнад, Тэр түүний мэдрэхүйд таашаал ханамж өгөх талаар санаа тавих хэрэгтэй гэдгийг ойлгуулж байна. Гэвч Говинда бол бидний мэдрэхүйн таашаал ханамжийн төлөө санаа тавихаар байдаг юм биш. Харин бид эсрэгээр, Говиндагийн мэдрэхүйд таашаал ханамж өгч Түүнийг цэнгүүлэхийг хичээх аваас бидний мэдрэхүй нь аяндаа л мөн ханамжтай болно. Материаллаг ухамсарт орших хэн бүхэн мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийг хийгээд Бурхан энэхүү таашаал ханамжийг эдлүүлэгч, өгөгч байх ёстой гэдгийг хүсэж байдаг. Бурхан амьд оршнолуудын мэдрэхүйд тэдний хүртэх ёстой гавъяаны хэмжээнд нь тохируулан таашаал ханамж эдлүүлдэг болохоос тэдний шунаж шаардахын хэмжээгээр биш. Гэхдээ хүн эсрэг чиглэлээр нь замнах аваас, өөрөөр хэлбэл, хүн өөрийн мэдрэхүйд таашаал ханамж эдлүүлэхийг эрмэлзэлгүйгээр зөвхөн Говиндагийн мэдрэхүйг баясган Түүнийг цэнгүүлэх аваас Түүний өршөөлөөр амьд оршнолын бүхий л хүсэл нь биелэгдэнэ. Аржуна өөрийн найз нөхөд, багш нар болон төрөл төрөгсөдөө ихээр татагдан байгаа гэдэг нь энд зарим талаар, тэр тэдний төлөө өөрийн жам ёсны өрөвдөл энэрэлээсээ болж тулалдахад бэлэн бус байгаагаар харагдаж байна. Хүн бүр л найз нөхөд болон төрөл төрөгсөдөө өөрийн эд баялгаа харуулахыг хүсэж байдаг, иймд Аржуна түүний найз нөхөд, төрөл төрөгсөд нь бүгдээрээ тулааны талбар дээр хөнөөгдөх болно, ялсны дараагаар тэр эд баялгаа тэдэнтэй хувааж чадахгүй нь гэж айж байна. Энэ бол материаллаг амьдрал дахь нийтлэг хэв шинжит бодол билээ. Харин трансценденталь амьдрал бол өөр. Чин бишрэлтэн нь Бурханы таалалд нийцүүлэхийг хүсэж байдаг учраас тэр хэрвээ Бурхан таалах аваас бүхий л төрлийн эд баялгийг авдаг бөгөөд тэдгээрийг тэр Түүний албанд хэрэглэж зориулдаг, хэрвээ Бурхан таалахгүй байх аваас тэр өчүүхэн багыг ч авах ёсгүй. Аржуна төрөл төрөгсдөө хөнөөхийг хүсэхгүй байсан бөгөөд хэрвээ ямар нэгэн шалтгаанаар тэд хөнөөгдөх шаардлагатай юм бол Кришна Өөрөө тэднийг хөнөөхийг тэр хүсэж байлаа. Кришна тэднийг тулалдааны талбарт ирэхээс өмнө хэдийнээ хөнөөчихсөн байсан бөгөөд Аржуна зөвхөн Түүнийг багаж зэвсэг л болох ёстой гэдгийг тэр үед тэрээр хараахан мэдээгүй байлаа. Энэ учир байдал хойшхи бүлгүүдэд тайлагдан нээгдэх болно. Бурханы цэвэр чин бишрэлтэн мөн болохын хувьд Аржуна өөрийн жигшүүрт үеэлүүд болон ах дүү нараасаа өшөөгөө авахыг хүсээгүй билээ. Гэсэн ч тэд бүгдээрээ хөнөөгдөх ёстой гэдэг нь Бурханы таалал байлаа. Бурханы чин бишрэлтэн нь муу үйл үйлдэгчдэд өширхдөггүй билээ. Гэсэн ч Бурхан жигшүүрт хүмүүсийн зүгээс Өөрийнх нь чин бишрэлтэнд учруулж буй буруу хэргийг хүлцэн өнгөрөөдөггүй. Хэрвээ хэн нэгэн Өөрт нь ийм үйл хийх аваас Тэрээр түүнийг уучлах нь юман чинээ зүйл биш, харин чин бишрэлтэнд нь зовлон учруулах хэнийг ч Тэр уучилдаггүй. Иймээс, Аржуна тэднийг уучилж өршөөхийг хүссэн ч Бурхан бурхангүйчүүдийг хөнөөхөөр шийдчихсэн байлаа.

ШҮЛЭГ 36

*папам эвашраед асман хатвайтан ататайнах
тасман нарха ваям хантум дхартараштран са-бандхаван
сва-жанам хи катхам хатва сукхинах съяма мадхава*

папам- нүглүүд, *эва-* гарцаагүй, *ашрает-* болно, *асман-* бидэнд, *хатва-* бид хөнөөснөөр, *етан-* энэ бүхнийг, *ататайнах-* дайран довтлогчид, *тасмат-* иймээс, *на-* хэзээ ч үгүй, *архах-* ёстой, *ваям-* бид, *хантум-* хөнөөснөөр, *дхартараштран-* Дхритараштрын хөвгүүдийг, *са-бандхаван-* найз нөхөдтэй хамт, *сва-жанам-* төрөл төрөгсөд, *хи-* тодорхой, *катхам-* яаж, *хатва-* хөнөөн, *сукхинах-* аз жаргалтай, *съяма-* бид байж болох, *мадхава-* Кришна, аз жаргалын охин тэнгэрийн эр нөхөр минь.

Хэрвээ бид иймэрхүү түрэмгийлэгчдийг хөнөөх аваас нүгэл нь бидэн дээр л буух болно. Иймээс өөрийн нөхдөө болон Дхритараштрын хөвгүүдийг хөнөөх нь бидний хувьд зохисгүй хэрэг. Бид төрөл төрөгсдөө хөнөөснөөр яаж аз жаргалтай байж чадах билээ дээ, ай аз жаргалын охин тэнгэрийн хань, Кришна минь ээ, бид мөн юугаа ч хожих билээ дээ.

ТАЙЛБАР: Ведэд зааснаар бол (1) хор өгөгч, (2) галдан шатаагч, (3) үхлийн аюултай зэвсэг хэрэглэн халдагч, (4) бусдын эд хөрөнгийг тонон дээрэмдэгч, (5) бусдын газар нутгийг эзлэгч болон (6) бусдын эхнэрийг булаагч гэсэн зургаан төрлийн халдан түрэмгийлэгчид байдаг. Иймэрхүү халдан түрэмгийлэгчдийг даруйхан устгах хэрэгтэй байдаг бөгөөд тэднийг хөнөөснөөр хүн ямар ч нүгэл хураадаггүй байлаа. Эгэл жирийн хүмүүсийн хувьд иймэрхүү халдан түрэмгийлэгчдийг хөнөөх нь зүй ёсны хэрэг байсан. Гэтэл Аржуна эгэл жирийн бус хүн байв. Тэрээр ариун гэгээн хүний шинж чанарыг агуулж байсан учраас тэдний эсрэг тийм л байдлаар хандахыг хүсэж байлаа. Гэвч ариун гэгээн байхын иймэрхүү төрөл *киатрия* хүнд зориулагдсан зүйл биш билээ. Улс гүрний удирдлагад байгаа хүн ариун гэгээн шинж чанартай байх шаардлагатай хэдий ч аймхай хулчгар байх ёсгүй. Жишээ нь, Шри Рама нь өнөөдрийг хүртэл хүмүүс Рамагийн хаант улс (Рама-ражья)-д амьдрахыг хүсэн тэмүүлж байдаг тийм л ариун шудрага байсан юм. Шри Рама нь аймхай хулчгар байдлын өчүүхэн төдий ч шинж тэмдэг харуулаагүй билээ. Шри Рамагийн эхнэр Ситаг хулгайлсан Равана бол Түүний хувьд нэгэн халдан түрэмгийлэгч мөн байсан ч Тэрээр дэлхийн түүхэнд энэ талаар харьцуулшгүй тийм хангалттай номлолыг түүнд хүртээж сургасан. Харин энд Аржунагийн өөрийн нь өвөг эцэг, өөрийн нь багш, өөрийн нь найз нөхөд, өөрийн нь хөвгүүд, ач нарын зэрэгцээ өөрт нь хамаатай өөр бусад хүмүүсийн тухай яригдаж байгаа болохоор түүний хувьд энэ бол онцгой хэлбэрийн халдан түрэмгийлэл байна гэж үзэх ёстой. Тэдний улмаас л Аржуна ердийн халдан түрэмгийлэгчдийн эсрэг авах шаардлагатай байдаг тийм хатуу чанга арга хэмжээнүүдийг явуулж болохгүй гэж бодож байна. Түүнээс гадна ариун гэгээн хүмүүст уучилж хэлтрүүлж байхыг сургасан байдаг. Энэ сургаал бол тэдний хувьд төрийн ямар ч явцуу шахадмал байдалд байхаас ч илүү чухал байдаг. Аржуна өөрийн төрөл төрөгсдөө улч төрийн бодлогын улмаас хөнөөснөөс шашин номын учир шалтгааны үндэслэлээр өршөөн, ариун гэгээн

байдлаа хадгалан үлдэх нь илүү дээр гэсэн бодолтой байлаа. Иймээс тэр, зөвхөн цаг зуурын бие махбодийн аз жаргалын төлөөх иймэрхүү аллага хядлага нь ямар ч ач тус авчрахгүй гэж үзэж байна. Эцсийн эцэст, улс гүрэн болон иймэрхүү байдлаар олж авсан өөр бусад материаллаг баяр баясгалан нь байнгын зүйлс биш билээ. Төрөл төрөгсдөө хөнөөснөөр тэр өөрийн амьдрал хийгээд өөрийн мөнхийн аврагдал чөлөөлөгдлөө эрсдэлд яагаад оруулах гэж? Аржуна Кришнад Мадхава буюу аз жаргалын охин тэнгэрийн эр нөхөр гэж хандаж байгаа нь үүнтэй холбогдон мөн л гүн утгыг агуулах билээ. Тэр үүгээрээ Кришна аз жаргалын охин тэнгэрийн эр нөхөр болохын хувьд түүнийг эцэстээ зөвхөн аз жаргалгүй байдал буюу гай зовлон авчрах тийм зүйл рүү бүү ятгаж уруу татаасай гэж хэлэхийг хүсэж байлаа. Гэхдээ Кришна хэнд ч, ялангуяа Өөрийн чин бишрэлтэнгүүддээ гай зовлон авчирдаггүй билээ.

ШҮЛЭГ 37-38

*ядй апи эте на пашьянти лобхопахата-четасах
кула-кшая-критам дошам митра-дрохе ча патакам*

*катхам на гьям асмабхих папад асман нивартитум
кула-кшая критам дошам прапашьядбхир жанардана*

яди- хэрвээ, *апи*- ч, *эте*- тэд, *на*- үгүй, *пашьянти*- харж байна, *лобхо*- шуналдаа, *упахата*- дийлдэж, *четасах*- өөрсдийн зүрхээ, *кула-кшая*- гэр бүлээ хөнөөснөөр, *критам*- үйлдэгдсэн, *дошам*- алдаа, *митра-дрохе*- найз нөхөдтэйгөө муудалцан, *ча*- мөн, *патакам*- нүгэлт үр дагавар, *катхам*- яагаад, *на*- ёсгүй, *гьям*- ил байх ёстой, *асмабхих*- бидэнд, *папат*- нүглээс, *асмат*- эдгээр, *нивартитум*- болих, *кула-кшая*- нэгэн удмынхны устал мөхөлд, *критам*- хийсэн, *дошам*- гэмт хэрэг, *прапашьядбхих*- харж байгаа хэн бүхнээр, *жанардана*- Кришна минь.

Ай Жанардана минь ээ, зүрх нь шуналын сэтгэлд автсан эдгээр эрчүүд өөрсдийн гэр бүлээ хөнөөх эсвэл найз нөхдийнхөө эсрэг тулан тэмцэлдэх явдалдаа ямар ч алдаа нүглийг олж харахгүй байж болно. Харин гэр бүлээ хөнөөн устгах нь ямар гэмт хэрэг болохыг мэдэж байгаа бид яах гэж иймэрхүү нүгэлт үйлийг хүсэх гэж?

ТАЙЛБАР: Өрсөлдөгч тал нь *киатрияг* тулаанд эсвэл аз сорьсон тоглоомд уриалан дуудаж байх аваас тэрээр түүнд оролцохоос татгалзаж болдоггүй. Дурьодханы тал Аржунаг уриалан дуудсан учраас тэр энэхүү үүргийнхээ дагуу тулалдахаас татгалзаж болохгүй билээ. Нөгөө тал иймэрхүү уриа дуудлагын нөлөө, үр дагаврыг ухаараагүй байсан байж болох юм гэж Аржуна бодож байна. Харин тэгэхэд Аржуна аймшигт үр дагаврыг нь урьдчилан харж байсан ба иймээс тэр тэдний уриа дуудлагыг хүлээн авахыг хүсэхгүй байв. Гарах үр дагавар, үйлчлэл нь эерэг сайн байх тийм л үүргийг хүн заавал биелүүлэх хэрэгтэй. Харин гарах үйлчлэл, үр дагавар нь өөр хэлбэртэй байх аваас ямар ч уриа дуудлагыг даган биелүүлэх үүрэг хэнд ч байхгүй. Аржуна ийнхүү “Тийм үү”, “Үгүй юү” гэдэг талаар эргэцүүлэн бодож үзээд тулалдахгүй байхаар шийдвэрлэсэн.

ШҮЛЭГ 39

*кула-кшае пранашьянти кула дхармах санатанах
дхарме наште кулам критснам адхармо `бхибхаватй ута*

кула-кшае- гэр бүлийн устал мөхлөөр, *пранашьянти*- сүйрэгдэнэ, *кула-дхармах*- гэр бүлийн уламжлал, *санатанах*- мөнх, *дхарме*- шашин, *наште*- устан мөхсөнөөр, *кулам*- гэр бүл, *критснам*- нийт, *адхармо*- шашин бус, *абхибхавати*- хувирдаг, *ута*- хэлдэг.

Удам угсаа сүйрснээр гэр бүлийн мөнхийн уламжлал устан үгүй болох бөгөөд ингэснээр гэр бүлийнхний амьд үлдсэн хэсэг нь шашингүйн замаар орох болно шүү дээ.

ТАЙЛБАР: *Варнашрама* системд гэр бүлийн гишүүдийг зөв өсгөх болон бурханлаг үнэ цэнэтэй шинж чанаруудыг тэдэнд хөгжүүлэхэд нь туслах ёстой шашин номын уламжлалын олон зарчмууд байдаг. Ариусах үйл явц нь төрөхөөс эхлэн үхэх цаг мөч хүртэл үргэлжилдэг бөгөөд энэхүү ёслолуудыг гэр бүлийн хүрээнд явуулж байхыг ахмад гишүүд нь хариуцаж байдаг. Харин гэр бүлийн ахмад гишүүд нас барах аваас иймэрхүү уламжлалт ариусгах ёслолууд нь зогсон тасарч, гэр бүлийн ард үлдэж хоцорсон залуу гишүүд шашин номын бус дадал заншлуудыг хөгжүүлэн, улмаар бурханлаг аврагдал чөлөөлөгдөлд хүрэх боломжоо алдах явдал гарч болох юм. Иймээс гэр бүлийн ахмад гишүүдийг ямар ч тохиолдолд хөнөөж болдоггүй.

ШҮЛЭГ 40

*адхармабхибхават кришна прадушьянти кула-стриях
стришу душтасу варшняя жаяте варна-санкарах*

адхарма- шүтлэг бишрэлгүй байдал, *абхибхават*- ноёрхох аваас, *кришна*- Кришна минь ээ, *прадушьянти*- бузар болно, *кула-стриях*- гэр бүлийн эмэгтэйчүүд, *стришу*- эмэгтэйчүүд, *душтасу*- ийм байдлаар бузардтаг, *варшняя*- Вришнигийн үр удам минь, *жаяте*- үүсэх болох, *варна-санкарах*- үл хүсүүштэй үр удам.

Хэрвээ гэр бүлд шашингүйн үзэл ноёрхох аваас, ай Кришна минь ээ, гэр бүлийн эмэгтэйчүүд цэвэр ариун байдлаа гээх болно. Хэрвээ эмэгтэйчүүдийн ёс суртахуун ийнхүү доройтох аваас, ай Вришнигийн үр удам минь ээ, хүсээгүй үр удам үүсэн бий болох билээ.

ТАЙЛБАР: Хүн ам нь сайн байна гэдэг бол хүний нийгэм дэх бурханлаг хөгжил дэвшлийн болон сайн сайхан, амгалан тайван байхын үндсэн зарчим байдаг билээ. *Варнашрама*-шашны үндсэн зарчмууд нь хүн амын зонхилох хэсэг нь сайн байхаар зохицуулагдан байгуулагдсан байдаг ба нийгмийн болон улс гүрний ерөнхий бурханлаг хөгжил дэвшлийг ингэж хамгаалдаг байжээ. Хүн ам нь ийм сайн байх эсэх нь эмэгтэйчүүдийн үнэнч болон цэвэр ариун байхаас хамаардаг. Хүүхдүүдийг амархан уруу татаж болдогтой адил эмэгтэйчүүдийн толгойг ч мөн хялбархан эргүүлж болдог. Иймээс хүүхдүүд ч тэр, эмэгтэйчүүд ч тэр гэр бүлийн ахмад гишүүдийн хамгаалалт доор байх ёстой байдаг. Эмэгтэйчүүд шашны янз бүрийн үүргүүдийг биелүүлж байх аваас гэр бүл салалтанд хүргэх аюул тэдэнд учрахгүй. Чанака Пандитын өгүүлсний дагуу бол эмэгтэйчүүд нь ерөнхийдөө маш их оюунлаг биш байдаг учир тэдэнд итгэхэд хэцүү. Иймд эмэгтэйчүүд нь гэр бүлийн уламжлалын хүрээнд шашны үүрэг даалгавруудыг биелүүлж байх ёстой байдаг бөгөөд тэгсэн цагт тэдний цэвэр ариун байдал хийгээд чин бишрэл нь *варнашрама*-системд оролцоход нийцэж зохицсон сайн үр удам буюу хүн амыг төрүүлдэг. Хэрвээ энэхүү *варнашрама-дхарма* цаашид хэргэлжлэн оршин тогтнохоо боливоос эмэгтэйчүүд нь өөрсдийн дураар үйлдэх эрх чөлөөтэй болон эрчүүдтэй хутгалдаж эхлэх ба энэ нь гэр бүлийн салалт болон үл хүсүүштэй хүн ам бий болгоход хүргэдэг. Мөн хариуцлагагүй эрчүүд нийгэмд гэр бүл салалтыг ихэсгэдэг ба ингэснээр хүний нийгэм нь дайн байлдаан хийгээд тахал, хижиг мэт аюулыг төрүүлэх хүсээгүй хүүхдүүдээр дүүрдэг.

ШҮЛЭГ 41

*санкаро наракаяйва кула-гхнанам куласья ча
патанти питаро хй эшам лупта-пиндодака-криях*

санкарах- иймэрхүү хүсээгүй хүүхдүүд, *наракая*- тамд унах, *эва*- гарцаагүй, *кула-гхнанам*- гэр бүлээ мөхөл сүйрэлд хүргэгчдийн хувьд, *куласья*- гэр бүлийн хувьд, *ча*- мөн, *патанти*- уналт доройтолд ордог, *питарах*- өвөг дээдэс, *хитодорхой*, *эшам*- тэднээс, *лупта*- зогсдог, *пинда*- зоог өргөл, *удака*- болон ус, *криях*- өргөх.

Хүсээгүй хүн ам өсөн нэмэгдэх аваас энэ нь гэр бүлийнхний хувьд ч, мөн гэр бүлийн уламжлалын эвдэн сүйтгэгчдийн хувьд ч тамд унахын учир шалтгаан болдог. Иймэрхүү гажуудаж буруудсан гэр бүлд өвөг дээдэстээ зоог болон усаар өргөл өргөдөг ёслол бүрмөсөн зогсдог учир тэд уналтанд ордог.

ТАЙЛБАР: Үр дагавар дагуулах үйлд зориулсан журам дүрмийн дагуу бол гэр бүлийн өвөг дээдэстээ үе үехэн зоог болон ус өргөж байх хэрэгтэй байдаг. Вишнуд өргөсөн зоогийн үлдэгдлийг хүртсэнээр хүн нүгэлт үйлийн бүхий л хэлбэрийн үр дагавруудаасаа ангижирдаг учраас Вишнуд бишрэл хүндэтгэлээ илэрхийлснээр л энэ өргөл мөн үйлдэгддэг. Зарим үед, өвөг дээдсүүд маань янз бүрийн төрлийн нүгэлт үр дагавруудаасаа болж зовж шаналж байдаг ба тэдний зарим нь бүр бүдүүн материаллаг бие махбодийг ч авч чадахгүй нарийн биендээ хий үзэгдэл байдлаар амьдрахаас өөр аргагүй байдалд орсон байдаг. Иймээс үр удам нь өвөг дээдэстээ *прасадам*-зоогийн илүү гарч үлдсэнээс өргөх аваас тэд хий үзэгдлийн амьдрал эсвэл өөр зовлон шаналал дүүрэн байх нөхцөл байдлаас ангижирдаг. Өвөг дээдэстээ ийм байдлаар туслах нь гэр бүлийн уламжлал байдаг бөгөөд Бурханд өөрийгөө үл зориулах хэн бүхэн ийм зан үйлийг үйлдэж байх хэрэгтэй. Харин Бурханд чин бишрэлээр зүтгэж байгаа хэн бүхний хувьд иймэрхүү үйлүүдийг үйлдэх хэрэггүй байдаг. Бурханы чин бишрэлийн албанд зүтгэсэнээр л хүн зуу зуун, мянга мянган өвөг дээдсээ зовлон шаналал, гай гамшгаас ангижруулдаг болно. Бхагаватамын (11.5.4)-д өгүүлсэнчлэн:

*девариш бхутапта-нринам питринам
на кинкаро наям рини ча ражан
сарватмана ях шаранам шараньям
гато мукундам парихритья картам*

“Бүхий л материаллаг үүргүүдээ орхин ангижралыг хайрлагч Мукундагийн бадам лянхуа өлмийд аврал ивээлийг эрсэн хийгээд энэ зам мөрөөр ул суурьтай, нухацтайгаар замнах хэн бүхэн сахиулсан тэнгэрүүдийн ч, цэцэд мэргэдийн ч, бусад амьд оршнолуудын ч, өөрийн гэр бүлийнхний ч, хүн төрөлхтний ч мөн өвөг дээдсийнхээ ч өмнө үүрэг хүлээдэггүй буюу буруутдаггүй.”

Бурханы Дээд Бодгалийн чин бишрэлийн албанд зүтгэн байгаа хүний хувьд иймэрхүү үүргүүд нь аяндаа өөрөө биелэгддэг.

ШҮЛЭГ 42

*дошайр этайх кула-гхнанам варна-санкара-каракайх
утсадьянте жати-дхармах кула-дхармах ча шашватах*

дошайх- эдгээр нүгэлт үйлүүдээр, *этайх*- энэ бүхэн, *кула-гхнанам*- гэр бүлийг устган хөнөөгч, *варна-санкара*- үл хүсүүштэй хүүхдүүд, *каракайх*- учир шалтгаанууд, *утсадьянте*- зогсдог, *жати-дхармах*- нийгмийн төлөөх үүргийн дагуух үйл, *кула-дхармах*- гэр бүлийн уламжлал, *ча*- мөн, *шашватах*- мөнх.

Гэр бүлийн уламжлалыг эвдэн сүйтгэгч болон хүсээгүй хүүхдүүд төрөх явдал өсөн нэмэгдэх шалтгаан бологч тэдний хорт муу үйлээр, нийгмийн сайн сайхны төлөөх бүхий үйлүүд болон гэр бүлийн элбэг хангалуун байдалд чиглэсэн үйл хэргүүд устгагдан сүүддэг.

ТАЙЛБАР: *Санатана-дхарма* буюу *варнашрама-дхарма* системд тогтоогдсон байдаг гэр бүлийн сайн сайхны төлөөх үйлүүд, мөн тэрчлэн хүний нийгмийн дөрвөн ангийн үүргийн дагуу заавал үйлдэх ёстой үйлүүд нь хүнийг ангижралд бүрмөсөн хүрэхийг боломжтой болгох ёстой байдаг. Иймд нийгмийн хариуцлагагүй удирдагчид *санатана-дхармын* уламжлалыг эвдэн сүйтгэх аваас энэ нийгэмд эмх замбараагүй байдал үүсэн бий болох бөгөөд үүний уршгаар амьдралын зорилго бол Вишну гэдгийг хүмүүс мартдаг. Иймэрхүү удирдагчид нь харалган сохор байдаг бөгөөд тэднийг дагах хүмүүс эмх замбараагүй байдалд орох нь гарцаагүй.

ШҮЛЭГ 43

*утсанна-кула-дхарманам манушьянам жанардана
нараке ниятам васо бхаватити анушушрума*

утсанна- сүйрч мөхсөн, кула-дхарманам- гэр бүлийн уламжлалыг дагагч, манушьянам- иймэрхүү хүмүүсийн, жанардана- Кришна минь, нараке- тамд, ниятам- үргэлж, васах- оршин суугаа газар, бхавати- болно, ити- ингэж, анушушрума- би багш шавийн барилдлагаагаар сонссон.

Хүмүүн нарыг тэтгэгч Кришна минь ээ, гэр бүлийн уламжлалыг сүйтгэгч хэн бүхэн тамд мөнхөд зовон тарчлах болно гэж багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээгээр дамжуулан сонссон билээ.

ТАЙЛБАР: Аржуна яагаад татгалзаж эсэргүүцэж байгаа гэдгээ өөрийн хувийн мэдлэг туршлага дээрээ биш, харин эх сурвалжуудаас сонссон зүйл дээрээ түшиглэж тулгуурлан тайлбарлаж байна. Энэ бол жинхэнэ мэдлэг хүртэх зам мөн билээ. Жинхэнэ мэдлэгийг хэдийнээ хүртэж эзэмшсэн зөв хүнээс туслалцаа авалгүйгээр энэхүү мэдлэгийг хүртэж чадахгүй. Хүн үхэхийнхээ өмнө үйлдсэн нүглээсээ ангижрахын тулд тодорхой ёслолыг үйлдэх хэрэгтэй гэдгийг заасан журам *варнашрама-системд* байдаг. Байнгад нүгэлт үйлтэй зууралдан хутгалдаж байсан хүн наманчлалын энэ үйл (*прайшчитта*)-г үйлдэх хэрэгтэй. Энэхүү бололцоог алдсан хүн үйлдсэн нүгэлт үйлүүдийнхээ үр дагавар болсон тарчлал зовлонгоор дүүрэн амьдралыг туулахаар тамын гаригуудад хүргэгдэх нь гарцаагүй болой.

ШҮЛЭГ 44

*ахо бата махат-папам картум вьявасита ваям
яд ражья-сукха-лобхена хантум сва-жанам удьятах*

ахо- өө, бата- ямар хачин жигтэй юм бэ, махат- аугаа, папам- нүгэл, картум- үйлдэх, вьяваситах- шийдсэн, ваям- бид, ят- яагаад гэвэл, ражья-сукха-лобхена- эзэнт гүрнээр таашаал ханамж эдлэх хүсэлдээ хөтлөгдөн, хантум- хөнөөх, сва-жанам- төрөл төрөгсөдөө, удьятах- оролдон.

Ай хөөрхий, бид маш хүнд нүгэл үйлдэхээр зэхэж байгаа нь ямар хачин жигтэй хэрэг вэ? Улс гүрний хаан байж, цэнгэн жаргах хүсэлдээ хөтлөгдсөн бид өөрсдийн төрөл төрөгсдөө хөнөөх гэж чармайж байна шүү дээ.

ТАЙЛБАР: Хүн амиа бодсон учир шалтгаанд хөтлөгдөн амьдрах аваас ах дүү, эцэг эсвэл эхээ хөнөөх шиг тийм хүнд бэрх аймшигт нүглүүдийг үйлдэхэд бэлэн байдаг. Дэлхийн түүхэнд энэ талын жишээ олон байдаг билээ. Гэсэн ч Бурханы ариун гэгээн чин бишрэлтэн мөн болохын хувьд Аржуна ёс суртахууны үндсэн зарчмуудыг үргэлж ухаарч байсан ба иймээс ч иймэрхүү үйлүүдээс зайлсхийхийг хичээж байна.

ШҮЛЭГ 45

*яди мам апрафикарам ашастрам шастра-панаях
дхартараштра ране ханьюс тан ме кшема тарам бхавет*

яди- хэрвээ, мам- намайг, апрафикарам- эсэргүүцэл үзүүлэлгүй, ашастрам- зэвсэггүй хоосон гараараа, шастра- панаях- гартаа зэвсэг бүхий тэр, дхартараштрах- Дхритараштрын хөвгүүд, ране- тулааны талбар дээр, ханьюх- хөнөөх болог, тан- энэ, ме- миний хувьд, кшема-тарам- илүү дээр, бхавет- байх болно.

Тулалдааны талбарт өөрөө зэвсэг агсалгүйгээр хоосон байж байгаад, ямар ч эсэргүүцэл үзүүлэлгүйгээр зэвсэг агссан Дхритараштрын хөвгүүдийн гарт амь алдах нь надад илүү дээр.

ТАЙЛБАР: *Кшатрия-гуудын* тулааны журмаар бол зэвсэг бариагүй бөгөөд тулалдахыг хүсэхгүй байгаа эсрэг этгээд рүүгээ довтолхгүй байх ёс байдаг. Гэсэн ч Аржуна дайсан нь түүнийг тийм хөөрхийлөлттэй байдалд ороод байхад нь ч довтолсон байсан ч тулалдахгүйгээр шийдсэн. Эсрэг тал нь тулаанд хичнээн ихээр шахаж шаардаж байсан ч түүнд огтхон ч хамаагүй болсон. Энэ бүх шинж тэмдгүүд нь Бурханы аугаа чин бишрэлтэн Аржунагийн өр нимгэнтэйгээс шалтгаалсан нь лавтай.

ШҮЛЭГ 46

*саньжая увача
звам уктваржунах санкхье ратхопастха упавишат
висрижья са шарам чапам шока-самвигна-манасах*

саньжаях увача- Саньжая хэлсэн, звам- ингэж, уктава- хэлэнгээ, аржунах- Аржуна, санкхье- тулааны талбар дээр, ратха- байлдааны тэрэгний, упастхе- суудал дээр, упавишат- дахин доош суув, висрижья- хажуу тийш нь тавин, са- шарам- сумтайгаа хамт, чапам- нумаа, шока- зовлон шаналалаар, самвигна- тарчлан, манасах- ухаандаа.

Санъжая хэлсэн нь: Тулалдааны талбар дээр Аржуна эдгээр үгүүдийг айлтгасны дараагаар өөрийн нум сумаа хажуу тийш шидээд, ухаан санаа нь уйтгар гунигт автан, тэргэн дээрээ лагхийтэл суулаа.

ТАЙЛБАР: Аржуна дайснуудаа ажиглан харж байх үедээ байлдааны тэргэн дээрээ цэх шулуун зогсож байсан бол харин одоо тэр уй гашуудаа дийлдэн нум сумаа хажуу тийш хаян, дахин доош сууж байна. Бурханы чин бишрэлийн албанд зүтгэж байгаа ийм эелдэг ялдам бөгөөд өр нимгэн хүн нь бурханлаг мэдлэгийг хүртэхэд зохистой бүлгээ.

Шримад Бхагавад Гитагийн “Курукшетрын тулалдааны талбар дээр хуралдсан цэргийн хүчин” нэртэй нэг дүгээр бүлэгт Бхактиведантын өгсөн тайлбар ийнхүү өндөрлөлөө.

ХОЁР ДУГААР БҮЛЭГ Бхагавад Гитагийн хураангуй тойм

ШҮЛЭГ 1

*санъжая увача
там татха крипаявиштам аиру-пурнакулекшанам
вишидантам идам вакьям увача мадхусуданах*

санъжаях увача- Санъжая хэлсэн нь, *там-* Аржунад, *татха-* ийм байдлаар, *крипая-* өрөвдөл энэрэлээс, *авиштам-* дийлэгдсэн, *аиру-пурна-акула-* нулимс дүүрэн, *икшанам-* нүд, *вишидантам-* зовиурласан, *идам-* эдгээр, *вакьям-* үгүүдийг, *увача-* хэлсэн, *мадхусуданах-* Мадхуг хөнөөгч.

Санъжая хэлсэн нь: Өрөвдөл энэрэлд автан, ухаан санаа нь самууран, нүд дүүрэн нулимс мэлтрүүлэн байгаа Аржунаг хараад Мадхусудана, Кришна ийн айлдав.

ТАЙЛБАР: Материаллаг энэрэл өрөвдөл, зовлон шаналал, уй гашуу болон нулимс эд бүгд нь өөрийн жинхэнэ “Би”-г таньж мэдээгүйн илрэл юм. Харин мөнхийн сүнсний төлөө зовж байна гэдэг бол өөрийгөө бүрэн нээж таньж мэдэж байгаа хэрэг юм. Мадхусудана гэдэг үг нь энэ шүлэгт гүнзгий утгыг агуулж байна. Шри Кришна урьд нь Мадху нэртэй нэгэн демоныг хөнөөсөн билээ. Харин одоо Аржуна, Кришнаг өөрийг нь эзэмдэн үүргээ биелүүлэхэд нь саад болж байгаа буруу ойлголтын демоныг устгаж өгөхийг хүсэж байна. Юуны төлөө санаа зовох ёстойгоо хэн ч мэддэггүй. Живж буй хүний өмссөн хувцасны төлөө зовж шаналах ямар учир утга байх билээ. Харанхуй мунхгийн далайд унасан хүнийг зөвхөн түүний гадуур өмсгөл болох бүдүүн материаллаг бие махбодийг нь аварснаар түүнийг аварч чадахгүй билээ. Үүнийг үл мэдэн зөвхөн гадуур өмсгөлийн төлөө зовж шаналан гашуудах хүнийг *шудра* буюу хий дэмий хоосон шаналан гашуудагч гэж нэрлэдэг. Аржуна *киатрия* байсан тул түүний хувьд ингэх нь байж болшгүй зүйл билээ. Гэхдээ Шри Кришна харанхуй мунхаг хүний зовлон шаналлыг үлдэн хөөж чадах бөгөөд энэ л зорилгоор Тэр Бхагавад Гитаг айлдсан билээ. Энэ бүлэгт, дээдийн дээд эх сурвалж болох Шри Кришна материаллаг бие махбодь болон бурханлаг сүнсийг задлан шинжлэх замаар өөрийгөө хэрхэн бүрэн нээж танин мэдэж болох талаар тайлбарлана. Энэхүү танин мэдэхүүд зөвхөн, өөрийн ажил үйлийнхээ үр дагаварт үл дурлан татагдах хийгээд өөрийн жинхэнэ “Би”-гийн талаар гүн бат мэдэж ойлгосон хүн л хүрнэ.

ШҮЛЭГ 2

*ири бхагаван увача
кутас тва кашмалам идам вишаме самупастхитам
анарья-жуштам асваргьям акирти-карам аржуна*

ири бхагаван увача- Бурханы Дээд Бодгаль айлдсан, *кутах-* хаанаас, *тва-* чамд, *кашмалам-* бузар, *идам-* энэхүү зовиур, *вишаме-* энэ шийдвэрлэх хүнд цаг үед, *самупастхитам-* ирсэн, *анарья-* амьдралын үнэ цэнийг таньж мэдэхгүй хүмүүс, *жуштам-* хэрэгжүүлэх, *асваргьям-* дээд гаригуудад үл хүргэх зүйл, *акирти-* гутамшиг, *карам-* учир шалтгаан, *аржуна-* Аржуна.

Бурханы Дээд Бодгаль айлдсан нь: Ай Аржуна минь ээ, ийм бузар бодол чамд яахин төрнө вэ? Амьдралын утга учрыг мэдэх чам шиг хүний хувьд энэ нь зохисгүй хэрэг билээ. Энэ нь дээд гаригст үл хүргэх ба харин гутамшигт байдалд л хүргэх болно.

ТАЙЛБАР: Кришна бол Бурханы Дээд Бодгаль. Иймээс бүхий л Гитагийн туршид, бүр эхнээс нь аваад дуусан дуустал Түүнийг Бхагаван гэж нэрлэдэг. Бхагаван бол Үнэмлэхүй Үнэний дээдийн дээд төлөв. Үнэмлэхүй Үнэнийг танин мэдэх Брахман буюу бодгаль бус, бүхэнд нэвчих бурханлаг эрчим; амьд оршнол бүрийн зүрхнээ залран байх төлөв- Параматма болон Бурханы Дээд Бодгаль Шри Кришна буюу Бхагаван гэсэн гурван төлөв байдаг. Шримад Бхагаватамын (1.2.11)-д Үнэмлэхүй Үнэний тухай энэ ойлголтыг дараах байдлаар тайлбарласан байдаг:

*ваданти тат таттва-видас
таттвам яж гьянам адваям
брахмети параматмети*

“Үнэмлэхүй Үнэнийг таньж мэдсэн хэн бүхэн Түүнд өөр хоорондоо ялгаагүй байх гурван төлвөөр хүрдэг. Үнэмлэхүй Үнэний эдгээр төлвүүдийг Брахман, Параматма болон Бхагаван гэж нэрлэдэг.”

Энэхүү бурханлаг гурван төлөв байдлыг мөн гурван янзын төлөв байдал буюу нарны гэрэл, нарны цагираг, нарны гаригийг өөртөө агуулах нараар жишээ болгон тайлбарлаж болно. Зөвхөн нарны гэрлийн цацрагийг судалж буй хүн бол хамгийн доод түвшинд байгаа суралцагч, нарны гадаргуугийн талаар ойлгох түвшинд байгаа нь илүү ахиц дэвшилд хүрсэн, харин нарны гаригийн дотоодыг судлагч нь хамгийн дээд түвшинд хүрсэн хэрэг. Нарны гэрлийн цацрагийг ойлгосондоо буюу түүний орчлон даяар тархах тархалт болон түүний бодьгал бус байгалийн нүд гялбам цацралын талаар ойлгосон мэдлэгтээ хангалуун байх хүнийг Үнэмлэхүй Үнэний зөвхөн Брахманы төлвийг таньж мэдсэн хүнтэй, харин түүнээс гадна нарны цагирагийн талаар судалж мэдэн илүү ахиц дэвшилд хүрсэн хүнийг Үнэмлэхүй Үнэний Параматма төлвийг таньж мэдсэн хүнтэй зүйрлүүлж болохуйц юм. Харин нарны гаригийн зүрхэнд нэвтрэн орсон хүнийг Үнэмлэхүй Үнэний бодгаль төлвийг таньж мэдсэн хүнтэй зүйрлүүлж болно. Иймээс тэд хэдийгээр бүгд Үнэмлэхүй Үнэнд хүрэх үйлэнд өөрсдийгөө зориулан, нэг ижил сэдвийг судлан байгаа боловч *бхакта* нар буюу Үнэмлэхүй Үнэний Бхагаван төлвийг таньж мэдсэн трансценденталистууд нь хамгийн дээд трансценденталистууд мөн билээ. Нарны цацраг, нарны цагираг болон наран гариг дээр болж буй үйл явцыг бие биенээс нь салангид тусад нь авч үзэх аргагүй ч энэхүү гурван өөр төлөв байдлыг судалж буй хүмүүсийг нэг ижил зэрэглэл, түвшинд хамааруулж болохгүй юм.

Бхагаван гэдэг санскрит үгийг Вьясадевагийн эцэг, аугаа их эх сурвалж болох Парашара Муни дараах байдлаар тайлбарласан байдаг. Бүхий л эд баялаг, бүхий л хүч чадал, бүхий л алдар цуу, бүхий л гоо сайхан, бүхий л мэдлэг болон бүхий л огоорохуйг Өөртөө агуулан байх Дээдийн Дээд Бодгалийг Бхагаван гэж нэрлэдэг. Маш их баян, маш их хүч чадалтай, маш их үзэсгэлэн гоо, маш их алдар нэртэй, маш их эрдэм мэдлэгтэй болон огоорохуйн маш өндөр түвшинд хүрсэн хүмүүс олон байдаг ч хэн нь ч өөрийгөө бүхий л баялаг, бүхий л хүч чадал болон бусдыг бүрэн дүүрэн агуулдаг гэж батлан хэлж чадахгүй билээ. Кришна бол Бурханы Дээд Бодгаль мөн учраас зөвхөн Тэр л Өөрийн тухай ийнхүү гунхаглан айлдаж чадах юм. Ямар ч амьд оршнол, тэр бүү хэл Брахма, Шива эсвэл Нараяна хүртэл энэ бүхнийг Кришнагаар адил тийм бүрэн дүүрэн хэмжээгээр агуулдаггүй. Ийм учраас, Брахма самхитад Брахма өөрөө, Кришна бол Бурханы Дээд Бодгаль гэж батлан өгүүлдэг. Хэн ч Түүнтэй эн зэрэгцэхгүй, хэн ч Түүнээс дээш гарахгүй. Тэр бол анхдагч Бурхан, Бхагаван бөгөөд Говинда гэж нэрлэгддэг. Тэр бол бүх учир шалтгаануудын эх учир шалтгаан.

*шиварах парамах кришнах
сач-чид-ананда-виграха
анадир адир говиндах
сарва-карана-каранам*

“Бхагаваны шинж чанарыг агуулсан олон бодгалиуд оршин байдаг ч Кришна бол хамгийн дээд нь. Учир нь Түүнийг хэн ч даван илүү гарч чадашгүй билээ. Тэр бол Дээдийн Дээд Бодгаль. Түүний бие мөнх бөгөөд мэдлэг болон цэнгэл жаргалаар дүүрэн байдаг. Тэр бол хамгийн анхдагч Бурхан, Говинда бөгөөд Тэрээр бүх учир шалтгааны учир шалтгаан.” (Брахма самхита, 5.1)

Шримад Бхагаватамд Бурханы Дээд Бодгалийн олон хувилгаан дүрүүдийн жагсаалт байдаг ба тэнд мөн Кришнаг Бурханы хамгийн анхдагч Бодгаль бөгөөд Түүнээс олон олон хувилгаан дүрүүд хийгээд Бурханы Бодгалиуд гаралтай гэж өгүүлсэн байдаг:

*эте чамша-калах пумсах кришнас ту бхагаван-сваям
индрари-вьякулам локам мридаянти юге юге*

“Энд дурьдагдсан байгаа Бурханы хувилгаанууд нь нэг бол Бүхний Дээд Бурханы бүрэн хувилгаан дүрүүд эсвэл бүрэн хувилгаан дүрүүдийн хэсэгчилсэн дүрүүд юм. Харин Кришна бол Бурханы Дээд Бодгаль Өөрөө билээ. (Шримад Бхагаватам, 1.3.28)

Иймд Кришна бол Бурханы анхдагч Дээд Бодгаль, Үнэмлэхүй Үнэн бөгөөд Параматмын ч, мөн бодгаль бус Брахманы ч эх булаг болох билээ.

Бурханы Дээд Бодгалийн залран байхуйд Аржунагийн өөрийн төрөл төрөгсдийн талаар гашуудан шаналах нь мэдээж зохимжгүй хэрэг бөгөөд иймээс ч Шри Кришна гайхашралаа илэрхийлэх үүднээс *кутас* буюу “хаанаас” гэдэг үгийг хэрэглэж байна. Хүн төрөлхтний соёл иргэншил бүхий хэсэг болох *ария* гэж нэрлэгдэх бүлэгт хамаарагдах хүнээс ийм зохисгүй, ариун бус зүйл хүлээнэ гэдэг төсөөлшгүй хэрэг. *Ария* гэдэг үг нь амьдралын үнэ цэнийг таньж мэддэг болон бурханлаг мэдлэгт тулгуурласан соёл иргэншил бүхий хүмүүст хамааралтай юм. Амьдралын материаллаг үзэл бодолд хөтлөгдсөн хүмүүс нь амьдралын зорилго бол Үнэмлэхүй Үнэнийг танин мэдэх буюу өөрөөр хэлбэл Вишну буюу Бхагаваныг танин мэдэх явдал гэдгийг мэддэггүй. Тэд материаллаг ертөнцийн гадаад өнгөн талын үзэгдэл, илрэлүүдэд уягдан хүлэгдсэн байдгийн улмаас ангижрал гэж юу болохыг мэддэггүй. Материаллаг боолчлолын савраас ангижрах гэж юу болох тухай ойлголтгүй хүмүүсийг *ария* бус хүмүүс гэж нэрлэдэг. Аржуна *кишатрия* мөн хэдий ч байлдан тулалдахаас татгалзаж байгаа нь тэр өөрт оноогдсон үүргээ биелүүлэхээс зайлсхийж байна гэсэн үг юм. Иймэрхүү хулчгар зан байдал нь *ария* хүмүүст хэзээ ч зохихгүй шинж билээ. Өөрт оноогдсон үүргээ биелүүлэхээс ийм байдлаар зайлсхийх нь бурханлаг амьдралдаа хөгжил дэвшил гаргахад нь хэнд ч тус нэмэр болохгүйн зэрэгцээ энэхүү ертөнцөд ч алдар цуу олох боломжийг нь ч мөн үгүйсгэнэ. Шри Кришна Аржунаг өөрийн төрөл садан, ойр дотныхноо иймэрхүү байдлаар энэрч өрөвдөхийг сайшаахгүй байна.

ШҮЛЭГ 3

*клайбьям ма сма гамах партха найтат твайи упанадьяте
киудрам хридая-даурбальям тьяктвоттиштха парантана*

клайбьям- хүч чадалгүй байдал, *ма сма*- үгүй, *гамаха*- ав, *партха*- Притхын хүү минь, *на*- хэзээч үгүй, *этак*- энэхүү, *твайи*- чамд, *упанадьяте*- зохистой, *киудрам*- өчүүхэн ч, *хридая*- зүрхний, *даурбальям*- сул дорой байдал, *тьякта*- орхих, татгалзах, *уттиштха*- дээш бос, *парам-тана*- дайснаа дарагч минь.

Ай Притхын хүү минь ээ, ингэж зүрх алдан шалдаа бууж болохгүй. Ингэх нь чамд зохимжгүй байна. Энэхүү олхиогүй, сул дорой байдлаа зүрхнээсээ авч хаян дээшээ босогтун, дайснаа дарагч минь ээ,

ТАЙЛБАР: Шри Кришна Аржунад Притхын хүү минь ээ хэмээн хандаж байгаа нь тэд хоорондоо цусан төрлийн ах дүү нар болохыг илтгэж байна. Учир нь Притха бол Түүний эцэг Васудевагийн охин дүү билээ. *Киатрийн* хүү тулалдан гэмцэлдэхээс татгалзан зайлсхийх аваас *брахманы* хүү үйлийг бурханлаг бусаар үйлдсэнээр зөвхөн нэрийн хувьд л *брахмана* байдгийн нэгэн адил нэр төдий л *киатрия* байна. Иймэрхүү нэр төдий *киатрия* болон *брахманууд* нь эцгүүдийнхээ хувьд зохисгүй хөвгүүд болдог билээ. Аржуна Кришнагийн хамгийн дотнын анд нөхөр тул Тэр байлдааны тэргэн дээр нь хамт байж түүнийг шууд удирдан чиглүүлж байгаа учраас түүнийг *киатрийн* ийм зохисгүй хүү байхыг хүсэхгүй байна. Хэдийгээр Аржунад энэ бүх давуу талууд байсан ч хэрвээ тэр тулалдааны талбарыг орхин одох аваас энэ нь түүнд гутамшигт байдлыг л авчрах билээ. Иймээс иймэрхүү явдал гаргах нь Аржуна лугаа бодьгалд зохисгүй гэж Шри Кришна айлдаж байна. Аржуна өөрийн гүнээ хүндэтгэдэг Бхишма болон төрөл төрөгсдөдөө өршөөнгүй хандсанаар тулалдахаас татгалзаж байж болох ч Шри Кришна өршөөнгүй хандахын иймэрхүү хэлбэрийг зүгээр л зүрх алдан шалдаа буусан аймхай хулчгар байдал гэж нэрлэж байна. Иймэрхүү буруу өршөөнгүй байдлыг ямар ч эх сурвалж сайшаан үздэггүй билээ. Иймээс Шри Кришнагийн шууд удирдлагын доор байх Аржунатай адил төстэй хүмүүс иймэрхүү хэлбэрийн өршөөл нигүүлсэл буюу хүч үл хэрэглэн энэрэн нигүүлсэх гэж нэрлэгдэх зүйлсээс татгалзах нь зүйтэй.

ШҮЛЭГ 4

аржуна увача
катхам бхишмам ахам санкхе дронам ча мадхусудана
ишубхих пратийотсыями пужархав ари-судана

аржуна увача- Аржуна айлтгасан нь, *катхам*- яаж, *бхишмам*- Бхишма, *ахам*- би, *санкхе*- тулалдаанд, *дронам*- Дрона, *ча*- мөн, тэрчлэн, *мадху-судана*- Мадхуг хөнөөгч минь, *ишубхих*- сумаар, *пратийотсыями*- тэмцэх ёстой, *пужа-рхау*- хүндэтгэж байвал зохистой тэд, *ари-судана*- дайснаа хөнөөгч минь.

Аржуна айлтгасан нь: Ай дайснаа дарагч минь ээ, ай Мадхуг хөнөөгч минь ээ, би өөрийн хүндэтгэн дээдэлж явдаг Дрона болон Бхишма зэрэг хүмүүсийн эсрэг сумаа хэрхэн тавих билээ?

ТАЙЛБАР: Өвөг эцэг Бхишма болон багш Дроначарья зэрэг ихэс дээдсийг байнгад хүндэтгэж байвал зохистой билээ. Тэр бүү хэл тэдний зүгээс дайралт хийсэн ч эсэргүүцэн тэмцэх ёсгүй. Нийтийн ёс журмын хувьд бол ахмад, дээгүүр зиндааны хүмүүстэй үг сөргөлдөх ч ёсон байдаггүй. Тэднийг хааяа бүдүүлэг зан авир гаргахад ч гэсэн түүний хариуд бүдүүлэг муухай байдлаар харьцах ёсгүй. Тэгэхээр Аржуна тэдний эсрэг хэрхэн яаж дайран довтлох болж байна вэ? Хэзээ нэгэн цагт Кришна Өөрийн өвөг эцэг Уграсен эсвэл багш Сандипани Мунигийн эсрэг ийн халдах байсан гэж үү? Ийнхүү Аржуна Кришнад хандан өөрийн татгалзах учир шалтгаануудаасаа өгүүлж байна.

ШҮЛЭГ 5

гурун ахатва хи маханубхаван
шрейо бхоктум бхайкиьям апиша локе
хатвартха-камамс ту гурун ихайва
бхуньясия бхоган рудриха-прадигдхан

гурун- дээд байр сууринд оршигчид, *ахатва*- хөнөөж болохгүй, *хи*- тодорхой, *маха-анубхаван*- аугаа сүнснүүд, *шрейо*- энэ бол илүү дээр, *бхоктум*- амьдралыг таашаах, *бхайкиьям*- гуйлгаар, *апи*- ч, *иха*- энэхүү амьдралдаа, *локе*- энэ дэлхий дээр, *хатва*- хөнөөх, *артха*- ялалт, *камамс*- шунасанаар, *ту*- гэсэн ч, *гурун*- дээд байр суурь эзлэгсэд, *иха*- энэ дэлхий дээр, *эва*- гарцаагүй, *бхуньясия*- жаргаж цэнгэх хэрэгтэй, *бхоган*- тааламжтай зүйлс, *рудриха*- цус, *прадигдхан*- будагдсан.

Багш нар маань болсон аугаа сүнснүүдийн амьдралыг золиослон амьдарснаас гуйлгачилж явсан минь хавьгүй дээр. Хэдийгээр тэднийг материаллаг ашиг хонжоо түлхэж хатгасан байвч тэд миний хувьд эрхэм хүндэт хэвээрээ л байх болно. Хэрвээ тэд амь эрсдэх аваас бидний хойшид эдлэх баяр баясгалангаас цус амтагдан ханхлах болно шүү дээ.

ТАЙЛБАР: Судруудад заасны дагуу бол сайн мууг ялгаж салгах чадваргүй болсон хийгээд жигшүүрт бузар хэрэг үйлдэх аливаа багшаас татгалзах ёстой. Бхишма болон Дрона нар нь Дурьодханы зүгээс тэдэнд үзүүлсэн санхүүгийн дэмжлэг тусламжинд автан түүний талд орсон бөгөөд тэд ингэж зөвхөн хөрөнгө мөнгөний бодлоор өөрсдийгөө ийм байдалд оруулах ёсгүй байсан билээ. Энэ учир шалтгаанаас болж тэд өөрсдийн багш хэмээх эрхэм нэр хүндийг алдсан. Гэсэн ч Аржуна тэднийг урьдын адил хүндэтгэн үзэхийн сацуу тэднийг хөнөөсний дараа эзлэх материаллаг эд баялгаас цус амтагдах болно гэж бодож байна.

ШҮЛЭГ 6

на чайтад видмах катаран но гарийо
яд ва жаема яди ва но жаеюх
ян эва хатва на жиживишамас
те `вастхитах прамукхе дхартараи трах

на- үгүй, *ча*- мөн, *эат*- энэ, *видмах*- бид мэддэг, *катарат*- юу, *нах*- бидний хувьд, *гариях*- илүү дээр, *ят ва*- гэж үү, *жаема*- бид ялах, *яди*- хэрвээ, *ва*- эсвэл, *нах*- биднийг, *жаеюх*- тэд ялах, *ян*- тэд, *эва*- гарцаагүй, *хатва*- хөнөөснөөр, *на*- хэзээ ч үгүй, *живишамас*- бид амьдрахыг хүснэ, *те*- тэд бүгд, *авастхитах*- орших, *прамукхе*- өмнө, *дхартараитраха*- Дхритараштрын хөвгүүд.

Ялах эсвэл тэдэнд ялагдахын аль нь илүү болохыг бид мэдэхгүй. Хэрвээ бид Дхритараштрын хөвгүүдийг даран хөнөөх аваас бидний цаашдын амьдрал ямар ч учир утгагүй болох юм шиг. Гэвч тэд яг одоо тулалдааны талбар дээр бидний өмнө зогсоцгоож байна.

ТАЙЛБАР: Тулалдах нь хэдийгээр *киштрия* хүний үүрэг мөн ч Аржуна хий дэмий хүч хэрэглэн амь өрсөн тулалдах уу эсвэл тулалдахаас зайлсхийн гуйлгачлан амьдрах уу гэдгээ шийдэж ядан эргэлзэн тээнгэлзэж байна. Хэрвээ тэр дайснаа ялан дийлэхгүй л бол гуйлга гуйх нь түүний амьдралаа залгуулах цорын ганц арга зам болох билээ. Аль ч тал тулалдаанд ялалт байгуулж болохоор байсан учир мөн түүний хувьд ялах нь бүрэн баталгаатай биш байв. Хэрвээ тэд ялахаар байсан байлаа ч (тэд шудрага үйл хэргийн төлөө байв) уг тулалдааны явцад амь эрсдэх Дхритараштрын хөвгүүдгүйгээр амьдрах нь маш хэцүү юм шиг байлаа. Ийм байдлаар ирэх ялалт нь нэг ёсондоо ялагдлын өөр нэг хэлбэр мэт баймаар санагдаж байв. Аржунагийн ийнхүү эргэцүүлэн бодож байгаа байдал нь түүнийг зөвхөн Бурханы аугаа их чин бишрэлтэн төдийгүй мөн бурханлаг мэдлэгт ихэд гэгээрсний зэрэгцээ өөрийн ухаан болон мэдрэхүйгээ бүрэн эзэмдэн захирч чаддагийг тодорхой батлан харуулж байна. Хааны гэр бүлд төрсөн ч гуйлга гуйх байдлаар амьдралаа залгуулах гэсэн түүний хүсэл нь огоорохуйн бас нэг шинж тэмдэг юм. Эдгээр чанарууд нь түүний номын багш Шри Кришнагийн сургаалд итгэх итгэлтэй хослон Аржунаг жинхэнэ цэвэр ариун болохыг илтгэж байна. Үүнээс үзэхэд Аржуна ангижралыг олоход бүрэн нийцэж зохицсон нь илт байна. Мэдрэхүйгээ эзэмдэн захирч чадаагүй байсан цагт жинхэнэ мэдлэг хүртэх түвшинд дээшлэн хүрэх боломжгүй бөгөөд мэдлэг болон чин бишрэлгүйгээр ангижралд хүрдэггүй. Аржуна нь материаллаг талын гарамгай чадваруудынхаа зэрэгцээ мөн энэ бүх шинж чанаруудыг агуулсан байлаа.

ШҮЛЭГ 7

*карпатья-дошопахата-свабхавах
приччхами твам дхарма-саммудха-четах
яч чхреях сьян нишчитам брухи тан ме
ишишьяс те `хам шадхи мам твам прапаннам*

карпатья- хахир харамч байдлаасаа, *доша-* сул доройгоос, *упахата-* нөлөөлөлд *сва-бхавах-* шинж тэмдэг, *приччхам-* би асууж байна, *твам-* Танаас, *дхарма-* шашин, *саммудха-* төөрөлдсөн, *четах-* зүрхэндээ, *ят-* юу, *чхреях-* аль талаараа сайн, *съят-* байж болох, *нишчитам-* итгэлтэй, *брухи-* хэлэх, *тат-* энэнийг, *ме-* надад, *ишишьяс-* шавь, *те-* Таны, *ахам-* би бол, *шадхи-* сургаалаа хайрлаач, *мам-* намайг, *твам-* Танд, *прапаннам-* даатгах.

Би бүр төөрөлдөж самуураад өөрийн үүргээ юу болохыг ч мэдэхээ байлаа. Үлбэгэр сул дорой байдлаасаа болж биеэ барьж ч чадахаа болилоо. Ийм нөхцөл байдалд ороод байгаа миний хувьд хамгийн чухал нь юу болохыг айлдаж хайрлахыг Танаас гуйя. Одоо бол би Таны шавь, Танд өөрийгөө даатгасан сүнс бөлгөө. Та надад сургаалаа хайрлаач.

ТАЙЛБАР: Материаллаг үйлийн бүхий л систем нь хэн бүхэнд аливаа төөрөгдөл самуурлын эх үүсвэр болж байдаг нь энэ ертөнцийн мөн чанар юм. Төөрөгдөл самуурал нь алхам тутамд тохиолдож байдаг. Иймээс амьдралын зорилгод хүрэх замыг зааж өгч чадах жинхэнэ номын багшид хандах хэрэгтэй бөгөөд ингэснээр хүн амьдралынхаа утга учрыг биелүүлж чадах болно. Ведийн бүхий л судруудад, хүсээгүй байсан ч тохиолдож байдаг амьдралын төөрөгдөл самуурлаас ангижрахын тулд жинхэнэ номын багшид хандахыг зөвлөсөн байдаг. Энэхүү хүндрэл бэрхшээлтэй байдлыг хэн ч гал тавиагүй байхад дүрэлзэн асдаг ойн түймэртэй зүйрлүүлж болно. Үүнтэй нэгэн адил, амьдралын бэрхшээл хүндрэлүүд бидний хүслээс үл хамааран өөрөө бий болж байхаар энэ ертөнц бүтээгдсэн. Хэн ч түймэр асаж байхыг хүсдэггүй билээ. Гэсэн ч гал гарсаар, мөн бид төөрөгдөл самуурал, хүндрэл бэрхшээлтэй байдалд орсоор байдаг. Амьдралд тохиолдох хүндрэл бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, мөн энэхүү шийдвэрт хүргэдэг эрдэм ухааныг ойлгож хүртэхийн тулд багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээнд хамаарагдах номын багшид хандахыг ведийн мэдлэг ухаан зөвлөдөг. Жинхэнэ номын багшийн шавь хүнийг бүгдийг мэддэг гэж үздэг учраас материаллаг амьдралаас төрөн гарах хүндрэл бэрхшээлүүдэд автан байхын оронд номын багшид хандах нь зүйтэй. Энэхүү шүлгийн гол утга санаа нь энэ болой.

Ямар хүн материаллаг төөрөгдөл самууралд нэрвэгддэг вэ? Амьдралын жинхэнэ асуудлыг ойлгодоггүй тийм хүн л. Брихад-араньяка Упанишадын (3.8.10)-т төөрөлдөж самуурсан хүнийг дараах байдлаар тодорхойлон өгүүлсэн байдаг: *йо ва этад акшарам гарги авидитвасмал локат прайти са крипанах* буюу хүний амьдралын төрөлдөө амьдралынхаа асуудлыг шийдвэрлэж чаддаггүй хүнийг өөрт байгаа баялгаа ашиглаж чаддаггүй хахир харамч нарийн хэн нэгэнтэй адилтган үздэг бөгөөд тэрээр өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн эрдэм ухааныг ойлголгүй муур нохой мэт байсаар энэхүү дэлхийгээс талийн оддог.

Хүний амьдралын хэлбэрийг л амьдралын асуудлыг шийдвэрлэхэд ашиглаж болох учир амьд оршнолуудын хувьд хүний биеийг олон төрнө гэдэг үнэхээрийн онцгой үнэ цэнэтэй хэрэг байдаг бөгөөд энэхүү боломжийг үл ашиглаж чадах хэн бүхэн нь өөрт байгаа баялгийг ашиглаж чаддаггүй хахир харамч нарийн нэгэн болох билээ. Харин тэгэхэд *брахмана* буюу хангалттай оюунлаг хүн нь бие махбодио амьдралын бүхий л асуудлаа шийдвэрлэхэд зохих ёсоор ашиглаж чаддаг билээ. *Я этад акшарам гарги видитвасмал локат прайти са брахманах.*

Крипана буюу хахир харамч нарийн хүмүүс нь гэр бүл, нийгэм, улс орон гэх зэргээр материаллаг амьдралын үзэл бодолдоо хэт их автанаар цагаа хий дэмий үрж байдаг. Материаллаг амьдралын үзэл бодолтой ийм хүмүүс нь гэр бүл, эхнэр хүүхдүүд болон бусад төрөл төрөгсдөдөө үргэлж татагдаж байдаг бөгөөд энэ бүхний үндэс нь “арьсны өвчин” (өөрийгөө болон бусдыг материаллаг бие махбодтой адилтгах гэсэн утгаар. Орчуулагч) байдаг билээ. *Крипана* нь өөрийн гэр бүлийн гишүүдийг үхлээс аварч чадна гэж итгэх юм уу эсвэл гэр бүл, нийгэм нь түүнийг үхлийн савраас хэлтрүүлж чадна хэмээн бодож байдаг. Гэр бүлийн иймэрхүү дотногол харьцааг нялх үр төлийнхөө төлөө санаа тавьж буй доод адгуусан амьтдын дундаас ч олж харж болно. Аржуна оюунлаг хүн байсан учир төрөл төрөгсдөө хайрлах хайр болон тэднийг үхлээс авран хамгаалах гэсэн хүсэл нь түүний төөрөгдөл самуурлын учир шалтгаан байсан гэдгийг ухаарсан. Тэр хэдийгээр тулалдах нь түүний үүрэг мөн гэдгийг ойлгож байсан ч дээр өгүүлэх сул талаасаа болж өөрийн үүргийг биелүүлж чадахгүйд хүрч байна. Иймээс тэр дээдийн дээд номын багш Шри Кришнаг эцсийн шийдвэрийг гаргахыг хүсэж байна. Тэр Шри Кришнагийн шавь болон Түүнд өөрийгөө даатгаж найз, нөхөр журмын бүхий л харьцаагаа эцэс болгон дуусгахыг хүсэж байна. Багш шавь хоёрын хоорондын харьцаа нь үргэлж нухацтай байдаг бөгөөд одоо Аржуна өөрийн хүлээн зөвшөөрсөн номын багштайгаа нухацтай ярилцахыг хүсэж байна. Иймээс Шри Кришна бол Бхагавад Гитагийн мэдлэг ухааныг номлож буй анхдагч номын багш, харин Аржуна Гитаг хүртэж буй анхны шавь болж байна. Аржунагийн Бхагавад Гитаг хэрхэн ойлгож хүртэж байгаа тухай Гитад өөрт нь өгүүлдэг. Гэхдээ ойрхон бодолтой материаллист

философчид нь Кришнад Бодгаль хэлбэр дүрээр нь биш, харин Түүний “төрөөгүй” төлөв хэлбэрт нь өөрийгөө даатгах шаардлагатай гэж тайлбарлаж байдаг. Шри Кришнагийн дотоод болон гадаад мөн чанарт ялгаа байдаггүй. Энэхүү үнэнийг ойлгож ухаарах чадваргүй мөртөө Бхагавад Гитагийн учир утгад нэвтрэхийг оролдогч хэн бүхэн бол хамгийн тэнэг мангуу нэгэн юм.

ШҮЛЭГ 8

*на хи прапашьями мамапанудьяд
яч чхокам уччошанам индриянам
авапья бхумав асапатнам риддхам
ражсьям суранам апи чадхипатьям*

на- үгүй, хи- тодорхой, прапашьями- би харж байна, мама- миний, апанудьяд- хөөн зайлуулж чадах, ят- энэ, чхокам- зовиур, уччошанам- аргааж хатааснаар, индриянам- мэдрэхүй, авапья- хүрсэнээр, бхумау- дэлхий дээр, асапатнам- өрсөлдөгчгүй, риддхам- цэцэглэн мандаж байгаа, ражсьям- эзэнт гүрэн, суранам- сахиулсан тэнгэрүүдийн, апи- тэр ч бүү хэл, ча- мөн, адхипатьям- дээд засаглал.

Мэдрэхүйнүүдийг минь аргаан хатаах энэ гаслан зовлонг арилгах арга замыг би мэдэхгүй байна. Энэ газар дэлхий дээр цэцэглэн мандаж байгаа, эгнэшгүй сайхан улс гүрнийг захирсан ч, тэнгэрийн оронд сахиулсан тэнгэрүүдийн адил эрх дарх эдэлсэн ч үүнээс ангижирч чадахгүй байх.

ТАЙЛБАР: Аржуна татгалзаж байгаа тухайгаа шашны болон ёс суртахууны үндсэн зарчмуудын мэдлэг дээр үндэслэн олон баримтаар өгүүлж байгаа ч өөрийн жинхэнэ асуудлаа номын багш Шри Кришнагийн тусламжгүйгээр шийдвэрлэж чадахгүй нь илт байна. Түүний оршихуйг гандуулж байгаа хүндрэл бэрхшээлээс ангижрахад иймэрхүү мэдлэг ухаан тус болохгүй нь гэдгийг болон Шри Кришнаатай адил номын багшийн тусламж дэмжлэггүйгээр, энэ төөрөгдөл самуурлаас гарах нь боломжгүй юм гэдгийг тэр ойлгосон байв. Материаллаг боловсрол, гүн гүнзгий мэдлэг, өндөр байр суурь гэх мэт нь амьдралын асуудлыг шийдвэрлэх тал дээр огтхон ч нэмэр болохгүй. Зөвхөн Кришнаатай адил номын багш л тусалж чадна. Иймээс, Кришнаг бүрнээ ухамсарласан номын багш л амьдралын бүхий л асуудлуудыг шийдвэрлэж чадах тул жинхэнэ номын багш мөн гэсэн дүгнэлт хийж болно. Шри Чайтаньягийн айлдсанаар, Кришнагийн ухамсрын эрдэм ухаанд нэвтэрхий хэн бүхэн нийгмийн ямар ч байр сууринд байхаас үл хамааран жинхэнэ бурханлаг номын багш билээ:

*киба випра киба шудра кене ная
ей кришна-таттва-ветта сей гуру хая*

“Хэн нэгэн нь випра (ведийн мэдлэгт нэвтэрхий нэгэн) ч бай, доод язгуур гаралтай гэр бүлд төрсөн ч бай эсвэл огоорохуйн амьдралын хэвшилд амьдрагч ч бай, хэн ч байсан ялгаагүй гагцхүү Кришнагийн тухай эрдэм ухаанд л нэвтэрхий сайн байх аваас тэрээр төгс төгөлдөр бөгөөд жинхэнэ бурханлаг номын багш болно.” (Чайтанья-чаритамрита, Мадхья, 8.128). Өөрөөр хэлбэл, Кришнагийн ухамсрын эрдэм ухаанд нэвтэрхий гаргууд байх хэн бүхнийг жинхэнэ бурханлаг номын багш гэж нэрлэж болно. Ведийн судруудад мөн өгүүлэхдээ:

*шат-карма-нипуна випро мантра-тантра-вишарадах
вайшнаво гуру на сьяд вайшнавах свапачо гурух*

“Ведийн бүхий л салбарын талаар гүнзгий мэдлэг бүхий эрдэм мэдлэг төгс брахмана байсан ч вайшнава л биш буюу Кришнагийн ухамсрын эрдэм ухааныг үл мэдэгч л бол бурханлаг номын багш болж таарахгүй. Харин доод ангийн гэр бүлээс гаралтай байсан ч Кришнаг ухамсарласан буюу вайшнава л мөн байх хүн бурханлаг номын багш байж болно.” (Падма Пурана)

Материаллаг оршихуйн асуудлууд болох төрөлт, хөгшрөлт, өвчлөл, үхлийг эд баялаг хуримтлуулах болон эдийн засгийн хөгжил дэвшилээр сөрөн зогсож чадахгүй. Энэ дэлхийн олон газарт амьдралын бүхий л таатай нөхцлүүд бүрдсэн маш баян бөгөөд эдийн засгийн хөгжил дэвшлийн өндөр түвшинд хүрсэн улс орнууд байдаг ч тэнд мөн л материаллаг оршихуйн асуудлуудтай тэмцэх явдал байсаар байдаг. Эдгээр улс гүрнүүд энх тайван, амар амгаланд хүрэхээр олон янзын арга замаар хичээн оролдож байгаа боловч жинхэнэ аз жаргалтай амьдралд тэд зөвхөн Кришнагийн жинхэнэ элч төлөөлөгч буюу өөрөөр хэлбэл Кришнаг бүрэн ухамсарласан хүний удирдлагын доор сургаал заавар хүртэхээр Кришнад буюу Кришнагийн тухай эрдэм ухааныг агуулах Бхагавад Гита болон Шримад Бхагаватамд хандсан цагт л хүрэх болно.

Эдийн засгийн хөгжил дэвшил болон материаллаг тав тухтай нөхцөл нь хүнийг гэр бүлийн, нийгмийн, улс үндэстний болон олон улсын хуурмаг үзэгдлийн төлөөх түгшүүр зовиураас нь ангижруулж чаддаг байсан бол энэ газар дэлхий дээр өөр хаана ч байхгүй аугаа улс гүрэн эсвэл тэнгэрийн гаригуудад эзлэх сахиулсан тэнгэрүүдийнхтэй зүйрлэхүйц тийм хүчирхэг байр суурь ч түүний зовлонг арилгаж чадахгүй гэж Аржуна хэлэхгүй байхсан билээ. Иймээс тэр Кришнагийн ухамсраас аврал эрж байгаа бөгөөд энэ нь амгалан тайван, эв найрамдалд хүргэх зөв зам билээ. Эдийн засгийн хөгжил дэвшил, дэлхий дахиныг ноёрхсон ноёрхол нь материаллаг байгалийн эрс хувиралтаар хоромхон зуурт дуусгавар болж болно. Жишээлбэл, одоо үеийн хүмүүсийн хүрэхээр тэмүүлж байгаа сар зэрэг дээд гаригуудад дээрх амьдрал ганц цохилтоор л эцэс болж болно. Бхагавад Гитад энэ тухай *кишине пуње мартья-локам вишанти* буюу “зөв шудрага үйлийн нь үр барагдаж дуусмагц хүн аз жаргалын дээд оргилоос амьдралын хамгийн доод шат руу буцан унадаг.” хэмээн батлан өгүүлсэн байдаг. Энэ дэлхийн олон улс төрчид иймэрхүү уналтыг өөрсөд дээрээ амсаж эдэлцгээсэн бөгөөд ингэснээр тэдний ахих дэвших зам нь эмгэнэлтэйгээр төгсгөл болсон.

Иймээс, бид өөрсдийн зовлон бэрхшээлийг нэг мөр бүрмөсөн төгсгөл болгоё гэвэл Аржунагийн хүрэхийг хэрхэн хичээж байгаа үлгэр жишээг даган Кришнагаас аврал ивээл эрэх хэрэгтэй. Аржуна Кришнагаас өөрт учирч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудлыг бүрмөсөн шийдвэрлэж өгөхийг гуйж хүсэж байгаа нь Кришнагийн ухамсрын зам мөр болой.

ШҮЛЭГ 9

*саньжяя увача
эвам уктава хришикешам гудакешах парантанах
на йотьяса ити говиндам уктава тушним бабхува ха*

*саньжася*х увача- Саньжая хэлсэн нь, *эвам*- ингэж, *уктва*- хэлснээр, *хришикешам*- мэдрэхүйн эзэн Кришнад, *гудакешах*- харанхуй мунхагийг ялан дийлэгч Аржуна, *парантанах*- дайснаа дарагч, *на йотья*- би тулалдахгүй, *ити*-ингэж, *говиндам*- мэдрэхүйд баяр хөөр хайрлагч Кришнад, *уктва*- хэлснээр, *тушим*- чимээгүй, *ббхува*- болсон, *ха*- тодорхой.

Саньжая хэлсэн нь: Дайснаа дарагч Аржуна ийнхүү айлтгасныхаа дараагаар Кришнад хандан: Ай Говинда минь ээ, би тулалдаанд оролцохгүй гээд дуугаа хураав.

ТАЙЛБАР: Аржунаг тулалдахаа больж байлдааны талбарыг орхин гуйлгачин болох бодолтой байгааг Дхритараштра сонсоод маш ихээр баярласан нь лавтай. Гэхдээ Саньжая Аржунаг *парантанах* буюу дайснаа дарах чадвартай гэж хэлсэн нь түүний урмыг дахин хугалахад хүрэв. Хэдийгээр Аржуна төрөл төрөгсдөө энэрэх хуурмаг байдалд түр зуур автсан байсан ч тэрээр дээдийн дээд номын багш Шри Кришнад шавийн ёсоор өөрийгөө даатгаж байна. Энэ нь тэрээр гэр бүлийнхэндээ дотносон татагдсанаас үүдэн гарах хуурмаг зовлонгоос удахгүй салан ангижрахын шинж тэмдэг бөгөөд Кришнагийн ухамсрын буюу өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн төгс төгөлдөр мэдлэгийг хүртэн гэгээрснээр тулалдаанд орох нь гарцаагүй. Кришнагийн сургаалын ачаар гэгээрийг олох Аржуна эцсээ хүртэл тулалдан тэмцэх учир Дхритараштрын энэхүү баяр хөөр удаан үргэлжлэхгүй нь мэдээж.

ШҮЛЭГ 10

*там увача хришикешах прахасанн ива бхарата
сенайор убхайор мадхье вишидантам идам вачах*

там- түүнд, *увача*- хэлсэн, *хришикешах*- мэдрэхүйн эзэн, *прахасанн*- инээнгээ, *ива*- ингэж, *бхарата*- ай Дхритараштра, Бхаратын үр удам минь ээ, *сенайох*- цэргийн хүчнүүд, *убхайох*- хоёр талын, *мадхье*-хооронд, *вишидантам*- зовж шаналагч-д, *идам*- дараах, *вачах*- үгүүдийг.

Ай Бхаратын үр удам минь ээ, тулалдагч хоёр талын дунд зогсон буй Кришна, инээмсэглэн, дараахь айлдварыг зовлон шаналлаар дүүрэн буй Аржунад хандан өгүүлсэн нь.

ТАЙЛБАР: Энэ яриа хүүрнэл дотнын найз нөхдийн, Хришикеша болон Гудакеша хоёрын дунд өрнөсөн билээ. Анд нөхөд мөн болохын хувьд тэд хоёул нэг ижил түвшинд оршин байсан ч нэг нь сайн дураараа Нөгөөгийнхөө шавь болсон. Шри Кришнагийн инээвхийлсний учир гэвэл Түүний найз Өөрийнх нь шавь болохоор шийдсэнд оршино. Бурхан бүхний дээд эзэн учир дээдийн дээд байр сууринд байнгад заларч байдаг ч Өөрийн нь чин бишрэлтэн Түүнийг найз нөхрийн, хүүгийн эсвэл амраг хайртын дүрээр харахыг хүсвэл Тэрээр хүссэн тэр л дүрд нь илэрч тодроход бэлэн байдаг. Аржуна Түүнийг өөрийн номын багшаа болгохыг хүсмэгц Тэрээр энэ үүргийг Өөртөө шууд хүлээн авч шавьтайгаа багшийн ёсоор, тэр л нөхцөл байдалд зохицож нийцсэн нухацтай байдлаар харьцаж эхэлсэн. Багш шавь хоёрын яриа тулалдахаар зэхсэн хоёр талуудын өмнө, нээлттэй өрнөснөөрөө тэнд байгсад бүгд түүнээс ач тусыг олж чадсан. Иймээс Бхагавад Гитад өрнөх яриа хүүрнэл нь зөвхөн тодорхой нэгэн бие хүн, бүлэглэл эсвэл нийгэмд хамаатай биш бөгөөд түүнийг нөхөр, дайсан гэж ялгалгүйгээр бүгд сонсох эрхтэй болой.

ШҮЛЭГ 11

*ири бхагаван увача
аиочьян анваиочас твам прагья-вадами ча бхашасе
гатаасун агатаасуми ча нануиочанти пандитах*

ири бхагаван увача- Бурханы Дээд Бодгаль айлдсан, *аиочьян*- зовж шаналаад байх үнэ цэнэгүй зүйл, *анваиочах*- чи харамсан гашуудаг байна, *твам*- чи, *прагья-вадами*-гүн мэдлэгтний үгүүдийг, *ча*- мөн, *бхашасе*- ярьснаар, *гата*- алдсан, *асун*- амьдрал, *агата*- өнгөрсөн, *асун*- амьдрал, *ча*- мөн, *на*- хэзээ ч үгүй, *ануиочанти*-харамсан гашуудах, *пандитах*- номч, эрдэмтэн.

Бурханы Дээд Бодгаль айлдсан нь: Чи эрдэм төгс мэдлэгтэн мэт ярих атлаа огтхон ч санаа зовох хэрэггүй зүйлийн төлөө шаналан гашуудах юм. Жинхэнэ мэргэд нь амьдын тухайд ч тэр, үхсэний талаар ч тэр харамсан гашууддаггүй билээ.

ТАЙЛБАР: Бурхан, номын багшийн байр сууриа эзлэмэгцээ шавна шууд бус байдлаар тэнэг мангуу хэмээн нэрлэж буруушаан зэмлэж байна. Бурхан: Чи эрдэм төгс хүн мэт ярих боловч бие махбодь гэж юу болох, сүнс гэж юу болохыг таньж мэдсэн жинхэнэ мэдлэг ухаантай хүн бие махбодь үхмэл ч бай, амьд ч бай ямар ч үед харамсан гашууддаггүй гэдгийг мэдэхгүй байна.” хэмээн айлдаж байна. Эрдэм мэдлэг бол матери болон сүнс, мөн тэдгээрийг удирдан залагчийг таньж мэдэх явдал юм гэдэг нь дараагийн бүлгүүдээс тодорхой болно. Аржуна шашны зарчмуудыг улс төрийн болон нийгмийн үйл хэргүүдээс илүү чухалд авч үзэх хэрэгтэй гэдгийг илэрхийлж байгаа ч матери, сүнс, мөн Дээдийн Дээдийн тухай мэдлэг нь шашны сургаал номлолоос ч бүр илүү дээд гэдгийг мэдэхгүй байна. Энэ талын эрдэм мэдлэгээр хомс байж Аржуна аугаа эрдэмтэн мэргэн мэт байдал гаргах хэрэггүй байсан билээ. Тэр үнэхээрийн хангалттай мэдлэггүй байсан учраас л санаа зовнирлах шаардлагагүй зүйлсийн хойноос зовон шаналж байна. Бие махбодь бол төрдөг учраас эрт орой хэзээ нэгэн цагт үрэх үрэгдэх тавилантай; иймээс бие махбодь бол сүнс шиг тийм чухал биш юм. Хэн үүнийг мэдэж байнам тэр үнэхээрийн эрдэм мэдлэг бүхий хүн мөн болох бөгөөд түүний хувьд материаллаг бие махбодь ямар ч нөхцөл байдалд байсан түүний төлөө шаналан зовох шалтгаан байдаггүй.

ШҮЛЭГ 12

*на тв эвахам жату насам на твам неме жанадхитах
на чайва на бхавишьямах сарве ваям атах парам*

на- хэзээ ч үгүй, *тв*- гэвч, *эва*- гарцаагүй, *ахам*- Би, *жату*- хэзээ нэгэн цагт, *на*- үгүй, *асам*- оршиж байсан, *на*-үгүй, *твам*- чи өөрөө, *на*- үгүй, *име*- энэ бүх, *жана-адхипах*- хаад, *на*- хэзээ ч үгүй, *ча*- мөн, *эва*- гарцаагүй, *на*- үгүй, *бхавишьямах*- оршин байх, *сарве ваям*- бид бүгд, *атах парам*- ирээдүйд.

Би, чи болон энэ бүх хаадууд эс оршин байсан цаг үе гэж хэзээ ч байгаагүй. Мөн ирээдүйд бидний хэн нэгэн нь эс оршино гэх явдал үгүй билээ.

ТАЙЛБАР: Ведэд, Катха Упанишадад мөн Шветашватара Упанишадад өгүүлсэнчлэн, Бурханы Дээд Бодгаль нь тоо томшгүй олон амьд оршнолуудыг тогтоон барьж байдаг ба тэднийг бие даан үйлдэх үйл болон эдгээр үйлийн үр дагавраас шалтгаалан орших амьдралын янз бүрийн нөхцөл байдалд нь тохируулан тэтгэж байдаг. Мөн Бурханы Дээд Бодгаль нь амьд оршнол бүрийн зүрхэнд Өөрийн бүрэн хэсэгчилсэн хувилгаан дүрээр залран байдаг. Бүх зүйлсийн дотоодод ч тэр, гадна нь ч тэр нэг л Бүхний Дээд Бурханыг харах чадвартай гэгээн хүмүүс л төгс төгөлдөр, мөнхийн тайван амгаланд үнэхээрийн хүрч чадна.

*нитьо нитьянам четанаши четананам
эко бахунам йо видадхати камам
там атма-стхам е `нупашьянти дхирас
тешам шантих шаивати нетарешам*
(Катха Упанишад, 2.2.13)

Аржунад нээн хүртээж байгаа ведийн үнэн нь өөрийгөө эрдэм төгс хэмээн өргөмжлөн бодох боловч үнэн хэрэгтээ өчүүхэн төдий л мэдлэгийг агуулах энэ дэлхийн бүх хүмүүст зориулагдсан. Бурхан Өөрөө, Аржуна мөн тулалдааны талбарт хуран цугласан бусад бүх хаадууд бүгд л мөнхийн бие даасан оршнолууд бөгөөд Бурхан эдгээр бие даасан амьд оршнолуудыг болзолт байдалд ч тэр, мөн ангижирсан үед нь ч тэр мөнхөд тэтгэн, тогтоон барьж байдаг гэж айлдаж байна. Бурханы Дээд Бодгаль бол дээдийн дээд бие даасан Бодгаль бөгөөд Бурханы мөнхийн дагуул болох Аржуна болон тэнд хуралдсан бүх хаадууд мөн л бие даасан мөнхийн бодьгалууд юм. Тэд өнгөрсөн цаг үед бие даасан байдалтай оршиж байгаагүй, мөн энэхүү бие даан оршнох байдлаа мөнхөд хадгалдаггүй гэж бодох нь буруу юм. Тэдний бие даасан байдал өнгөрсөн үед ч оршин байсан мөн ирээдүйд ч тасралтгүйгээр үргэлжлэн оршоор байх болно. Иймээс хэнд ч харамсан гашуудах учир шалтгаан байхгүй.

Дээдийн дээд эх сурвалж Шри Кришна, сүнс нь зөвхөн *майа-гийн* буюу хий хуурмагийн бүрхүүдээр бүрхэгдсэн үедээ л бие даасан байдалтай орших бөгөөд ангижралыг олсны дараагаар бодьгал бус Брахманд уусан нийлснээр өөрийн бие даасан оршнолоо алддаг хэмээн номлох *майавадийн* онолыг үгүйсгэж байна. Мөн, бие даасан байдал нь болзолт нөхцөл байдалд байгаа бидний хийсвэрлэх сэтгэлгээний бүтээгдэхүүн юм гэсэн онол ч дэмжигдэхгүй байна. Кришна энд, Түүний болон бусад бүх амьд оршнолуудын бие даасан байдал нь Упанишадуудад батлан өгүүлсэн шигээр ирээдүйд ч мөнхөд орших болно гэж салаа утгагүйгээр тодорхой айлдаж байна. Шри Кришна хий хуурмагийн нөлөөлөлд үл өртөх учраас Түүний энэ айлдвар бол шийдвэрлэх тайлбар болох билээ. Бие даасан байдал нь бодитой биш байсансан бол Шри Кришна энэ тухай, тэр бүү хэл ирээдүйд ч хэмээн онцлон дурдахгүй байсан билээ. *Майавадууд* Кришнагийн айлдаж байгаа энэхүү бие даасан байдал нь бурханлаг бус харин материаллаг юм хэмээн үл хүлээн зөвшөөрсөн байдал гаргаж магадгүй юм. Гэхдээ бие даасан байдал нь материаллаг юм гэсний учир шалтгаан нь үнэн байх аваас Шри Кришнагийн бие даасан байдлыг юу гэж ойлгох вэ? Шри Кришна Өөрөө өнгөрсөн үед ч бие даасан бодьгал байсан, ирээдүйд ч мөн ийм л байдалтай үргэлжлэн оршоор байх болно гэж батлан айлдаж байна. Тэр Өөрийн бие даасан байдлаа олон арга замаар нотлохын зэрэгцээ бодьгал бус Брахман нь Түүнд захирагддаг гэдгийг тайлбарласан. Өөрөөр хэлбэл Шри Кришна Өөрийн бурханлаг бие даасан байдлаа үргэлж хадгалж байдаг. Зарим хүмүүсийн итгэж байдагчлан, Түүнийг бие даасан ухамсар бүхий эгэл жирийн болзолт сүнс хэмээн үзэх аваас Бхагавад Гита нь эх сурвалж судар болох үнэ цэнээ алдах болно. Төгс төгөлдөр бус байдлын дөрвөн дутагдал бүхий эгэл жирийн хүн нь сонсоход үнэ цэнэ бүхий зүйлийг бусаддаа зохих ёсоор сургах чадваргүй байдаг. Гита бол иймэрхүү бүтээлүүдээс дээгүүрт тавигддаг. Материаллаг ямар ч номыг Бхагавад Гитатай харьцуулшгүй. Хэрвээ Шри Кришнаг эгэл жирийн хүн гэж үзэх аваас Гита өөрийн бүхий л утга учраа алдана. *Майавадууд* энэ шүлэгт дурьдагдсан олон талт байдлыг уламжлалт заншмал утгаар нь ойлгох ёстой бөгөөд тэдгээр нь бие махбодид л хамаарагддаг хэмээн нотлохыг оролддог. Бие махбодтой холбогдсон иймэрхүү үзэл бодлыг үүний гүүрүүчийн шүлэгт няцаасан билээ. Амьд оршнолын бие махбодийн үзэл бодлыг буруушаан зэмлэсний дараа Шри Кришна энэ онолыг дахин дэвшүүлэн тавина гэж үү? Бие даасан байдал нь бурханлаг байдалд ч хадгалагддаг гэдгийг Шри Раманужа зэрэг аугаа *ачарья* нар ч батлан өгүүлсэн. Энэхүү бурханлаг бие даасан байдлыг зөвхөн Бурханы чин бишрэлтэнүүд л ойлгоно гэж Гитад олонтаа тодорхой өгүүлдэг. Бурханы Дээд Бодьгал Кришнадад атаархалтайгаар хандах хэн бүхэн энэхүү аугаа бүтээлийн жинхэнэ утга учрыг ойлгох чадваргүй байдаг. Бхагавад Гитагийн номлол сургаалыг судлахыг хүсэж буй чин бишрэлтэн бус хүнийг дотроо бал агуулах савыг гаднаас нь амтлах гэж оролдож буй зөгийтэй адилтгахуйц. Савны тагийг нээлгүйгээр балыг амтлах аргагүй билээ. Үүний нэгэн адил, Бхагавад Гитагийн ид шидэгт утга учрыг зөвхөн чин бишрэлтэнүүд л ойлгож хүртэхээс биш дөрөв дүгээр бүлэгт өгүүлсэнчлэн, өөр хэн ч түүний амтыг мэдэрч чадахгүй. Түүнээс гадна Бурханы оршнолыг эс хүлээн зөвшөөрөх хэн бүхэнд Гита нь тайлагдашгүй. Иймээс Гитад өгсөн *майавадийн* тайлбарууд нь үнэнийг дээд зэргээр гажуудуулан гуйвуулсан байдаг юм. Шри Чайтанья биднийг *майавадийн* тайлбарыг уншихыг хориглосон бөгөөд *майавадийн* философид хандагчид нь Гитагийн жинхэнэ нууцыг ойлгох чадвараа алддаг гэж сэрэмжлүүлсэн. Бие даасан байдал нь эмпирик орчлонд л хамааралтай байсансан бол Бурханы сургаал нь илүүдэл зүйл байхсан билээ. Бурханы болон бие даасан сүнсний олон талт байдал нь мөнхийн зүйл бөгөөд, дээр өгүүлсэнчлэн, Ведэд үүнийг баталдаг.

ШҮЛЭГ 13

*дехино `смин ятха дехе каумарам яванам жара
татха дехантара-праптир дхирас татра на мухьяти*

дехинах- бие махбодид төрсөн, *асмин*- энэ, *ятха*- шиг, *дехе*- бие махбодид, *каумарам*- нялх үе, *яванам*- идар залуу, *жара*- нас, *татха*- үүнтэй адилаар, *деха-антара*- бие махбодио солихын, *праптих*- олж авах, *дхирах*- нухацтай, *татра*- түүний учраас, *на*- хэзээ ч үгүй, *мухьяти*- төөрөгдөлд орсон.

Бие махбодид төрсөн сүнс нь энэхүү бие махбодио нялх балчраас эхлэн идэр залуу дараа нь өтөл буурал болтол хувирч өөрчлөгдөхийг дамжин өнгөрдөг ба үхлийн дараагаар тэрээр өөр бие махбодид шилжин ордог. Нухацтай, бодлоготой хүн иймэрхүү шилжилтэнд төөрөлдөж самуурдаггүй.

ТАЙЛБАР: Амьд оршнол бүр нь бие даасан сүнс болох учир бие махбодио байнгад агшин бүрт өөрчилж байдаг ба ийнхүү тэрээр зарим үед нялх балчир, зарим үед идэр залуу, зарим үед өтөл буурал байдалтай болж байдаг. Гэхдээ бие махбодийн өөрчлөлт хувиралтын энэ үйл явцын үед тухайн бие махбодид орших уг сүнс нь өөрчлөлт хувиралтанд огтхон ч өртдөггүй. Энэхүү бие даасан сүнс нь тухайн бие махбодийг үхэх үед нь бүрмөсөн орхиж өөр бие махбодид шилжин ордог. Тэрээр дараа төрөлдөө баталгаатай өөр бие махбодид буюу нэг бол материаллаг, үгүй бол бурханлаг биед орох учир Аржунагийн маш ихээр зовж шаналаад байсан Бхишма болон Дрона нарын үхэлд харамсаад байх шалтгаан байхгүй. Түүний оронд тэднийг хуучин бие махбодио орхин шинэ биед орсноороо шинэ эрч хүчтэй болох болсонд баярлах хэрэгтэй байсан билээ. Шинэ бие махбодийг авснаараа бид өөрсдийн урьд амьдралдаа үйлдсэн үйлээсээ хамааран янз бүрийн байдлаар таашаал ханамж болоод зовлон шаналалыг амсаж эдлэх болдог. Бхишма болон Дрона нар нь ховор сүнснүүд байсан болохын хувьд дараагийн амьдралдаа нэг бол бурханлаг бие, үгүй ядахдаа наад зах нь тэнгэрийн гаригуудад амьдралыг олж материаллаг оршнолын илүү дээд таашаал ханамжийг эдлэх нь дамжиггүй. Аль ч тохиолдол нь байсан харамсаж гуних шалтгаан байхгүй.

Бие даасан сүнс болон Дээд Сүнс, мөн материаллаг болон бурханлаг мөн чанарын талаар төгс төгөлдөр мэдлэг бүхий хүнийг *дхира* буюу хамгийн эрүүл саруулаар сэтгэдэг хүн гэж нэрлэдэг. Ийм хүн бие махбодийн солигдох явдалд огтхон ч төөрөлдөж будилдаггүй.

Бурханлаг сүнсний жижиг хэсгүүдэд хуваагдашгүй байдал нь бүх бурханлаг сүнсүүд нэг байдаг гэсэн *майвадийн* онолыг үгүйсгэж байна. Дээдийн Дээд нь олон янзын бие даасан сүнснүүдэд хуваагддаг гэж үзэх аваас Тэрээр хуваагддаг, хувирч өөрчлөгддөг болж таарах бөгөөд энэ нь Дээд Сүнс бол хуваагдашгүй буюу өөрчлөгдөж хувирдаггүй гэсэн зарчимтай зөрчилдөх болно. Гитад батлан өгүүлсэнчлэн, Дээдийн Дээдийн салангид тусдаа хэсгүүд нь мөнхөд (*санатана*) орших бөгөөд *кишара* гэж нэрлэгддэг нь тэдгээрийг доош буюу материаллаг мөн чанар тийш унах дур хүсэлтэй байдаг гэсэн утгыг илэрхийлдэг. Эдгээр хэсгүүд нь мөнхөд ийн салангид тусдаа оршин байх бөгөөд бие даасан сүнс нь ангижралыг олсны дараа ч тэр л салангид тусдаа хэсэг хэвээрээ байдаг. Харин тэр ангижралыг нэгэнтээ олсон л бол Бурханы Дээд Бодгалийн хүрээлэлд мэдлэг болоод цэнгэл жаргалаар дүүрэн мөнхийн амьдралдаа хүрдэг. Параматма гэж нэрлэгдэх Дээд Сүнс нь бие даан орших бие махбодь бүрт залран байдаг. Дээд Сүнс болон бие даасан сүнс хоёр нь нэгэн бие махбодид хамт орших боловч тэдгээр нь бие биенээсээ ялгаатай. Үүнийг дараахь жишээн дээр тайлбарлаж болно. Усанд тольдон тусах тэнгэрийн дүрсэнд нар, сар мөн од гаригууд харагддаг. Олдыг амьд оршнолуудтай, харин нарыг эсвэл сарыг Бүхний Дээд Бурхантай зүйрлүүлж болно. Бие даасан, өчүүхэн жижиг бурханлаг сүнснийг Аржунагаар төлөөлүүлж болно. Параматма бол Бурханы Дээд Бодгаль Шри Кришна. Тэд өөр өөр түвшинд оршигтоодог ба энэ тухай дөрөв дүгээр бүлгийн эхэнд тодорхой өгүүлэх болно. Хэрвээ Аржуна Кришнагай нэгэн ижил түвшинд оршин, Кришна түүнээс илүү дээд байр суурь эзэлдэггүй байсан бол тэдний багш шавийн харьцаа ямар ч учир утга, ач холбогдолгүй байх байсан билээ. Тэд хоёулаа хий хуурмаг (*майя*)-гийн эрчимд хууртан төөрөлдсөн байх аваас нэг нь багш, нөгөө нь шавь байгаад яах ч билээ? Хий хуурмагийн эрхшээл нөлөөн доор байгаа хэн ч жинхэнэ эх сурвалж номын багш болж чадаагүй учраас ийм хүний сургаал номлол ямар ч ач тус болохгүй. Гэхдээ энд, хий хуурмагт төөрөлдөн самуурсан мартамхай сүнс болох амьд оршнол Аржунаас илүү дээд байр сууринд орших Шри Кришнаг Бүхний Дээд Бурхан мөн гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

ШҮҮЛЭГ 14

*матра-спаршас ту каунтея шитошина-сукха-духкха-дах
агамтайино нитьяс тамс тимикшасва бхарата*

матра-спаршах- мэдрэхүйн ойлгоц, *ту-* зөвхөн, *каунтея-* Кунтийн хүү минь, *шита-* өвөл, *ушина-* зун, *сукха-* аз жаргал, *духкха-* зовлон шаналал, *дах-* өгсөнөөр, *агама-* илэрсэнээр, *апайинах-* зайлан хөндсоноор, *анитьях-* байнгын бус, *тан-* тэд бүгд, *тимикшасва-* тэвчихийг л оролд, *бхарата-* Бхаратын удам минь.

Ай Кунтийн хүү минь ээ, цаг зуурхны аз жаргал болоод зовлон гуниг нь өвөл зун ирж буцахтай адил бөлгөө. Тэдгээр нь мэдрэхүйн хүртцээс л үүсэн бий болдог юм шүү дээ. Ай Бхаратын үр удам минь ээ, төөрөлдөж самууралгүйгээр тэдгээрийг тэсвэрлэж сурах хэрэгтэй.

ТАЙЛБАР: Өөрт оноогдсон үүргээ зохих ёсоор нь биелүүлэхийн тулд цэнгэл жаргал, зовлон шаналлын цаг зуурын илрэлд тэсвэртэй байж сурах хэрэгтэй. Ведийн сургаалын дагуу бол хүн *магха* (нэг, хоёр дугаар сарууд) сарын үед ч өглөөний угаалаа үйлдэж байх ёстой. Энэ цаг үед маш хүйтэн байдаг хэдий ч шашин номын зарчмуудыг даган мөрдөж байгаа хүн угаал үйлдэхээсээ огтхон ч тээнгэлздэггүй. Мөн зуны хамгийн халуун үе болох тав болон зургаа дугаар саруудад эмэгтэйчүүд ямар ч хойргошол тээнгэлздэггүйгээр гал зууханд хоол ундаа бэлтгэж байдаг. Цаг агаарын таатай бус нөхцөл байдалд ч өөрт оноогдсон үүргээ биелүүлэх л ёстой. Үүний нэгэн адил *кишатрия* хүний дагаж мөрдөх шашин номын зарчим нь тулалдах явдал байдаг бөгөөд, хэдийгээр тэр өөрийн найз нөхөд, төрөл төрөгсдийн эсрэг тулалдах байсан байлаа ч өөрт оноогдсон үүргээ биелүүлэхээс зайлсхийж болохгүй. Зөвхөн мэдлэг хийгээд чин бишрэлийн тусламжтайгаар л *майя-гийн* буюу хий хуурмагийн савраас ангижирч чадна. Иймээс төгс төгөлдөр мэдлэгийг хүртэх түвшинд дээшлэн хүрэхийн тулд шашин номын зарчмуудын заавар, дүрэм, журмыг даган мөрдөх ёстой.

Шри Кришна энд Аржунаг зүгээр л нэг хоёр өөр нэрээр нэрлэж, хандаагүй. Түүнд, Кунтийн хүү минь ээ гэж хандаж байгаа нь түүний эхийн талын алдартай удмыг, харин Бхаратын үр удам минь ээ хэмээн хандсан нь түүний эцгийн талын аугаа ихийг онцолсон хэрэг юм. Иймээс Аржунагийн эцгийн болоод эхийн талын өвөг дээдсүүд нь аугаа хүмүүс байсан байна. Ийм аугаа язгуур гарал нь өөрт оноогдсон үүргийг ягштал зөв биелүүлж байх хариуцлагыг давхар агуулж байдаг. Тиймээс тэр тулалдаанд оролцохоос зайлсхийж болохгүй юм.

ШҮҮЛЭГ 15

ям хи на вьатхаянти эте нурушам нурушаршабха

сама-дурхха-сукхам дхирам со `мритатвая калпате

ям- түүнд, хи- тодорхой, на- хэзээ ч үгүй, *вьятахаянти*- зовлон шаналын эрхшээлд орох, *эте*- энэ бүгд, *пурушам*- хүнд, *пуруша-ришаба*- хүмүүсийн дундах хамгийн шилдэг минь, *сама*-өөрчлөгдөггүй, *дурхха*- зовлонд, *сукхам*- аз жаргал, *дхирам*- тэсвэртэй, *сах*- тэр, *амритатвая*- ангижралын хувьд, *калпате*- дөхөмтэй гэж тооцогддог.

Ай хүмүүсийн дундаас хамгийн шилдэг нь минь ээ (Аржуна), баяр хөөр болоод зовлон гунигийн аль нь ч тохиолдсон үл ажрах, үргэлжид тайван амгалан байх хүн л ангижралд хүрэхэд тохирмуй.

ТАЙЛБАР: Бурханлаг танин мэдэхүйн дээд түвшинд хүрэх санаа зорилгодоо шийдвэр төгс байхын зэрэгцээ гуниг зовлонтой болоод баяр хөөртэй байдлыг ажралгүй тэсвэрлэж чадах хүн л ангижирлыг олоход дөхөмтэй гэдэг нь эргэлзээгүй юм. *Варнашрама* систем дахь амьдралын дөрөв дэх үе шат буюу огоорохуйн амьдрал (*санньяса*) нь хамгийн их хичээл чармайлт шаарддаг. Гэхдээ амьдралаа төгөлдөржүүлэхийг үнэхээрийн шийдвэр төгс хүсэж байгаа хүн л хүндрэл бэрхшээлтэй тал олон байсан ч эргэлзээ тээнэгэлзээгүйгээр амьдралын энэ хэлбэрт ордог. Гол хүндрэл бэрхшээл нь гэр бүлээсээ буюу өөрөөр хэлбэл эхнэр хүүхдүүдтэйгээ холбогдсон харьцаагаа орхихтой холбогдон гардаг. Гэхдээ иймэрхүү хүндрэл бэрхшээлүүдийг даван гарах чадвартай хүний бурханлаг танин мэдэхүүд хүрэхээр зорьсон зам нь төгс төгөлдөр байх нь дамжиггүй. Үүний нэгэн адил, өөрийн ойр дотнын хүмүүс болон гэр бүлийн гишүүдийн эсрэг тулалдан тэмцэх нь Аржунад хэдийгээр хүнд хэцүү байсан ч *киштрия* хүний үүргээ биелүүлэх тэсвэр хатуужилтай, тууштай байхыг түүнд зөвлөж байна. Шри Чайтанья хориндөрвөн насандаа *санньясын* амьдралд ороход Түүний асрамж хамгаалалд байсан залуу эхнэр, настай эх хоёр нь ямар ч түшиг тулгуургүй үлдсэн. Гэсэн ч Тэрээр илүү дээд үйлийн төлөө *санньясын* амьдралд орж Өөрийн илүү дээд үүргийг тууштайгаар биелүүлсэн. Материаллаг боолчлолын савраас ангижрах зам ийм л байдаг.

ШҮҮЛЭГ 16

*насато видьяте бхаво набхаво видьяте сатах
убхайор апи дришто `нтас тв анайос таттва-даршибхих*

на- хэзээ ч үгүй, *асатах*- амьд бус, *видьяте*- байдаг, *бхавах*- тогтвор, на- хэзээ ч үгүй, *абхавах*- өөрчлөгдөх шинж чанарууд, *видьяте*- байдаг, *сатах*- мөнх байдлын, *убхайох*- хоёулангийн, *апи*- үнэндээ, *дриштах*- ажиглаж байгаа, *антах*- дүгнэлт, *ту*- үнэхээр, *анайох*- тэднээс, *таттва*- үнэний, *даршибхих*-харж байгаа тэднээр.

Үнэнийг харагч хүмүүс нь амьд бус (материаллаг бие махбодь) нь түр зуурын, харин мөнхөд оршигч (сүнс) нь өөрчлөгдөж хувирдаггүй гэдгийг таньж мэдсэн байдаг. Тэд энэ хоёрын аль алиных нь мөн чанарыг судалж үзээд ийм дүгнэлтэнд хүрдэг билээ.

ТАЙЛБАР: Өөрчлөгдөж хувирч байдаг бие махбодь нь түр зуурынх. Янз бүрийн эсийн үйлдэл, үр дагаврын улмаас бие махбодь нь агшин тутамд өөрчлөгдөж байдгийг орчин үеийн анагаах ухаан нотолсон. Иймээс л бие махбодид өсөлт торнилт, өтлөлт хөгшрөлт явагдаж байдаг. Харин бурханлаг сүнс бол бие махбодь болон ухааны түвшинд бүхий л өөрчлөлтүүд явагдаж байсан ч тэр л хэвээрээ байдаг. Үүнд л матери болон бурханлаг мөн чанар хоёрын ялгаа оршдог. Бие махбодь нь өөрийн мөн чанарын улмаас байнгад өөрчлөгдөж хувирч байдаг бол сүнс мөнхөд хэвээр байдаг. Энэ бол чухамхүү үнэнийг харж байгаа бодьгал бусын болон бодьгалын талыг баримтлагч мэргэдийн аль алины нь дүгнэлт юм. Вишну Пуранад, Вишну болон Түүний гаригууд нь бүгд өөрөөсөө гэрэлтэгч бурханлаг оршнолууд буюу *жьотимши вишнур бхуванани вишнух* гэж өгүүлсэн байдаг. Амьд болон амьд бус оршнол гэдэг үгнүүд нь гагцхүү сүнс болон материд хамаарагддаг. Үнэнийг харсан бүхий л мэргэдийн үзэл бодол ийм байдаг билээ.

Харанхуй мунхгийн нөлөөнд төөрөлдөж будилсан амьд оршнолуудад хандсан Бурханы айлдвар сургаал нь эндээс ингэж эхэлж байна. Харанхуй мунхгийг арилган хөөж зайлуулна гэдэг нь шүтэн бишрэгч болон шүтэн бишрүүлэгч Тэр хоёрын хоорондын мөнхийн харьцааг сэргээн улмаар Бурханы Дээд Бодгаль болон Түүний салангид тусдаа өчүүхэн жижиг хэсэг болох амьд оршнол хоёрын хоорондын ялгааг ойлгож мэдэхийг хэлдэг. Аливаа нэгэн жижиг хэсэг өөрийн бүрэн бүтэнтэй ямар нэгэн байдлаар харилцан холбоотой байдаг шиг хүн Дээдийн Дээдтэй холбогдсон холбоо харьцаагаа ойлгож ухаарсны үндсэн дээр өөрийгөө гүн гүнзгий судалж мэдсэнээр л Түүний мөн чанарыг таньж мэдэж болно. Веданта судруудад болон Шримад Бхагаватамд Дээдийн Дээд нь бүх цацралын (эрчмийн) эх үүсвэр юм гэж үздэг. Энэ цацралууд нь дээд болон доод мөн чанартай гэсэн хоёр хэлбэрээр илэрдэг. Амьд оршнол нь дээд мөн чанарт хамаарагддаг болох нь долоо дугаар бүлгээс тодорхой болно. Хэдийгээр эрчим болон эрчмийн эх үүсвэр хоёрын хооронд ялгаа байдаггүй ч, эх үүсвэр нь Дээдийн Дээд хийгээд эрчим буюу мөн чанарыг өөрийн эх үүсвэр болох Түүнд захирагдсан байр суурьтай байдаг гэдэг. Зарц үйлчлэгч нь эзэндээ, шавь нь багшдаа захирагддагийн адил амьд оршнол нь иймээс Дээдийн Дээдийн захиргаанд байнгад оршиж байдаг. Харанхуй мунхагийн эрхшээлд оршин байгаа нөхцөлд энэхүү цэвэр тунгалаг мэдлэгийг ойлгож хүртэх боломжгүй учир Бурхан Бхагавад Гитаг бүх цаг үеийн бүхий л амьд оршнолуудыг гэгээрүүлэн мунхгийн харанхуйг үлдэн хөөхийн тулд айлдсан.

ШҮҮЛЭГ 17

*авинаши ту тад виддхи ена сарвам идам татам
винашам авьяясыя на каичит картум архати*

авинаши- мөнхийн, *ту*- гэвч, *тад*- тэр, *виддхи*- үүнийг мэд, *ена*- түүгээр, *сарвам*- бүхий л бие махбодь, *идам*- энэ, *татам*- нэвчих, *винашам*- устал сүйрэл, *авьяясыя*- мөнх байдлын, *асья*- энэний, *на каичит*- хэнд ч үгүй, *картум*- хийх, *архати*- чадвартай.

Бүхий л бие махбодид нэвчин тархах тэр зүйл бол устаж сүйрдэггүй гэдгийг мэдэж ав. Үхэшгүй мөнх сүнснийг хэн ч устгаж чадахгүй.

ТАЙЛБАР. Энэ шүлэгт бүхий л бие махбодиор тархах сүнсний жинхэнэ мөн чанарын тухай илүү тодорхой тайлбарлаж байна. Бие махбодиор тархах зүйл бол юу вэ? гэдгийг хүн бүр мэддэг. Энэ бол ухамсар. Өвдөж байгаа эсвэл баяр хөөр болж байгаа хүн түүнийгээ биеийн аль нэгэн хэсэгт эсвэл бүхэл бие махбодиороо шууд мэдэрч байдаг. Ухамсарын ийнхүү тархах хүүрээ нь зөвхөн тухайн нэг л бие махбодиор хязгаарлагддаг. Нэг бие махбодийн өвдөж зовох, баярлаж хөөрөх нь бусад бие махбодид мэдрэгддэггүй. Иймээс бие махбодь бүрд нэг л бие даасан сүнс оршин байдаг. Сүнсний оршин байгаагийн шинж тэмдэг нь бие махбодид бие даасан ухамсар байдгаар илэрдэг. Сүнсний овор хэмжээг үсний үзүүрийг 10 000 хуваасны нэгтэй жишихүйц жижиг гэж үздэг. Шветашватара Упанишадын (5.9)-д үүнийг батлан өгүүлсэн байдаг:

*балагра-шата-бхагасья шатадха калпитасья ча
бхаго живах са вигьяях са чанантьяя калпате*

“Үсний үзүүрийг 100 хуваагаад гарах нэг хэсгийг дахин 100 хуваахад гарах хэсгийн нэг нь сүнсний овор хэмжээтэй дүйнэ.” Мөн энэ талаар өөр нэг шүлэгт батлан өгүүлсэн байдаг:

*кешагра-шата-бхагасья шатамиах садришатмаках
живах сукима-сварупо `ям санкхьятито хи чит-канах*

“Тоо томшгүй олон бурханлаг хэсгүүд оршин байдаг бөгөөд тэдний нэг бүр нь үсний үзүүрийг 10 000 хуваасны нэгтэй дүйхүүц овор хэмжээтэй байдаг.”

Тэгэхээр бурханлаг сүнснийг дүрслэх бие даасан жижиг хэсэг нь нэг бурханлаг атом бөгөөд энэ нь материаллаг атомаас ч жижиг бөгөөд ийм бурханлаг атомууд нь тоолохын аргагүй олон байдаг байна. Энэхүү бурханлаг өчүүхэн жижиг оч нь материаллаг бие махбодийн хөдөлгөгч хүч буюу үндэс болдог бөгөөд эмийн анагаах хүчний үйлчлэл бие махбодийн бүх хэсэгт мэдрэгддэгийн адил энэхүү бурханлаг жижиг очийн нөлөөлөл нь бүхий л бие махбодиор тархдаг. Сүнсний энэхүү цацралт нь бие махбодийн бүхий л хэсэгт ухамсар байдлаар мэдрэгддэг бөгөөд энэ нь сүнсний оршин байгаагийн баталгаа болдог. Эгэл жирийн хүн бүр ухамсар байхгүй материаллаг бие махбодь нь үхмэл юм, материаллаг ямар ч арга замаар бие махбодид ухамсарыг сэргээн бий болгож болохгүй гэдгийг ойлгоно. Иймээс ухамсар нь янз бүрийн материаллаг элементүүдийн нэгдэж холбогдсоны үр дүнд бий болдог биш, харин сүнс оршин байгаагийн илрэл юм. Мундака Упанишадын (3.1.9)-д өчүүхэн жижиг бурханлаг сүнсний овор хэмжээний тухай мөн тайлбарласан байдаг:

*эшо `нур атма четаса ведитавьо
ясмин пранах паньчадха самвивеша
пранайш читтам сарвам отам пражанам
ясмин вишуддхе вибхаватй эша атма*

“Сүнс нь овор хэмжээний хувьд атом мэт жижиг бөгөөд түүнийг төгс төгөлдөр оюун ухаанаар мэдэрч хүлээн авч болно. Энэхүү өчүүхэн жижиг сүнс нь хийн таван урсгалд хөвж байдаг (*прана, апана, вьяна, самана, болон удана*). Тэрээр зүрхэнд оршин байх бөгөөд өөрийн нөлөөллөө амьд оршнолын бие махбодийн бүхий л хэсгээр тархааж байдаг. Сүнс нь таван төрлийн материаллаг хийн нөлөөллийн бузраас ариуссан цагт л түүний бурханлаг хүчин чадал нь хөгжин дэлгэрч эхэлдэг.”

Хатха-йогын зорилго нь ариун сүнснийг тойрон хүрээлэх хийн урсгалын таван төрлийг суудлын янз бүрийн байрлалын тусламжтайгаар удирдахад чиглэгддэг бөгөөд гэхдээ энэ нь ямар нэгэн материаллаг ашиг сонирхлын үүднээс биш, харин энэхүү өчүүхэн жижиг сүнснийг материаллаг тушаа хүлээнээс ангижруулахад л зориулагддаг.

Иймд Ведийн бүхий л судрууд нь сүнс бол мөн чанарын хувьд өчүүхэн жижиг гэдэгт нэгдмэл байдаг бөгөөд үүнийг эрүүл саруулаар сэтгэх хэн бүхэн өөрийн дадлага туршлагаар ойлгож болно. Зөвхөн ухаан солиотой хүн л энэхүү бурханлаг өчүүхэн жижиг очийг бүхэнд нэвчих *вишну-таттва-тай* адилтган үзэж магадгүй.

Өчүүхэн жижиг сүнсний нөлөө нь өөрийн оршин байх тэр бие махбодийн бүхий л хэсэгт нэвчин тархдаг. Мундака Упанишадад өгүүлсэнчлэн, энэ өчүүхэн жижиг сүнс нь амьд бие махбодийн зүрхэнд оршдог бөгөөд түүнийг хэмжих явдал нь материаллаг эрдэмтэдийн чадварын хязгаарын чанадад байх тул тэдний зарим нэгэн нь мунхаг байдлаар, ямар ч сүнс байдаггүй хэмээн батлахыг оролдож байдаг. Бие даасан өчүүхэн жижиг сүнс нь Дээд Сүнсний хамт зүрхэнд оршин байдаг нь ямар ч эргэлзээгүй бөгөөд иймээс ч бие махбодийг үйл, хөдлөлд оруулахад шаардагддаг бүхий л эрчим зүрх байрлах энэ л хэсгээс ирдэг. Уушигнаас хүчилтөрөгчийг зөөдөг цусны улаан бөөмүүд нь эрчмээ сүнснээс авдаг. Сүнс бие махбодийг орхимогц цусны шинэчлэн сэргээгдэх бүхий л үйл явц, эргэлт зогсдог. Анагаах ухаан нь цусны улаан бөөмийг чухал гэдгийг хүлээн зөвшөөрдөг боловч амьдралын эрчмийн эх булаг нь сүнс юм гэдгийг тогтоож чаддаггүй. Гэхдээ бие махбодийн бүхий л эрчим нь зүрхнээс эх авдаг гэдэгтэй анагаах ухаан санал нэг байдаг.

Бурханлаг Бүрэн Бүтэний өчүүхэн жижиг хэсгүүдийг нарны цацрагийг бүрдүүлэгч гэрэлтэн гялалзах хязгааргүй олон жижиг хэсгүүдтэй зүйрлүүлдэг. Үүний нэгэн адил Бүхний Дээд Бурханы салангид тусдаа жижиг хэсгүүд нь *пребха* буюу дээд эрчим гэж нэрлэгддэг Түүний цацралын өчүүхэн жижиг очнууд юм. Ведийн сургаалыг дагасан ч, эсвэл орчин үеийн шинжлэх ухааны талыг баримталсан ч, аль ч тохиолдолд ялгаагүй бие махбодид орших сүнсний оршнолыг үгүйсгэх аргагүй юм. Сүнсний тухай эрдэм ухааны талаар Бурханы Дээд Бодгаль Өөрөө Бхагавад Гитад тодорхой тайлбарладаг.

ШҮЛЭГ 18

*антаванта име деха нитьясьокобах шаририних
анашино `прамеяся тасмад юдхьясва бхарата*

анта-вантах- түр зуурын, *име*- энэ бүгд, *деха*- материаллаг бие махбодид, *нитьясья*- мөнх оршихуйн, *уктаха*- гэж яригддаг, *шаририних*- бие махбодид төрсөн сүнс, *анашинах*- хэзээ ч устгагдашгүй, *апрамеясья*- хэмжих аргагүй, *тасмат*- иймээс, *юдхьясва*- тулалд, *бхарата*- Бхаратын үр удам минь.

Үл устаж сөнөх, хэмжихийн аргагүй, мөнхийн сүнсний бие махбодь нь үхэх тавилантай байдаг билээ. Иймээс, ай Бхаратын үр удам минь ээ, тулалдан байлдагтун.

ТАЙЛБАР: Материаллаг бие махбодь нь мөн чанарын хувьд удаан оршин тогтнохоор заяагдаагүй. Тэрээр тэр дороо юм уу, эсвэл 100 жилийн дараа ч үхэж болно. Энэ бол зөвхөн цаг хугацааны асуудал. Түүнийг хязгааргүй удаан хугацааны туршид амьд байлгах боломжгүй. Харин сүнс бол маш өчүүхэн жижиг бөгөөд ямар ч дайсан түүнийг устгаж сөнөөх нь байтугай харж ч чадахгүй. Өмнөх шүлэгт өгүүлсэнчлэн, түүний овор хэмжээг нь хэмжих талаар ч төсөөлөхийн аргагүй тийм жижиг. Амьд оршинол нь устаж сөнөшгүй, мөн материаллаг бие махбодийг тодорхой цаг хугацаанаас илүү удаанаар тогтоон барьж болохгүй, урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээнүүдийг аваад ч мөнхөд хамгаалан байж чадахгүй учир аль ч тохиолдолд харамсан гашуудах учир шалтгаан байхгүй. Бурханлаг Бүрэн Бүтэний өчүүхэн жижиг хэсэг нь өөрийн үйлээс хамааран материаллаг бие махбодийг авдаг тул хүн бүр амьдралын туршдаа шашин номын зарчмуудыг дагаж мөрдөж байх ёстой юм. Веданта сударт амьд оршнолыг “гэрэл” гэж тодорхойлон өгүүлсэн байдгийн учир нь тэрээр дээд гэрлийн салшгүй хэсэг мөн болоход оршино. Нарны гэрэл нь бүхий л орчлонг тэтгэж тогтоон барьж байдгийн адил сүнсний гэрэл нь материаллаг бие махбодийг тэтгэн тогтоон барьж байдаг. Бурханлаг сүнс материаллаг бие махбодийг орхимогц тухайн бие махбодь нь задран ялзарч эхэлдгээс үзэхэд чухамхүү сүнс л материаллаг бие махбодийг тогтоон барьж байдаг нь тодорхой. Бие махбодь өөрөө бол чухал биш. Иймээс л Аржунад, материаллаг бие махбодид анхаарал хандуулснаас болж шашин номын үндсэн зарчмуудыг хөсөрдүүлэлгүйгээр тулалдаанд орохыг сургаж байна.

ШҮЛЭГ 19

*я энам ветти хантарам яши чайнам маньяте хатам
убхау тау на вижанито наям ханти на ханьяте*

яx- хэн нэгэн, энам- үүнийг, ветти- мэдэж байгаа, хантарам-хөнөөгч, яx- хэн нэгэн, ча- мөн, энам- үүнийг, маньяте- бодож байгаа, хатам- хөнөөсөн, убхау- хоёул, тау- тэд, на- хэзээ ч үгүй, вижанитах- мэдэцгээдэг, на- хэзээ ч үгүй, аям- энэ, ханти- хөнөөж устгах, на- үгүй, ханьяте-хөнөөгдөх.

Амьд оршнолыг устгаж болно, эсвэл амьд оршинол нь устдаг гэж бодож байгаа хүн нь огтын мэдлэггүй харанхуй юм. Учир нь сүнснийг устгаж болохгүй бөгөөд тэрээр огт устдаггүй юм.

ТАЙЛБАР: Амьд бие махбодь нь үхлийн аюулд хүргэх зэвсэгт өртсөн байсан ч түүний дотор орших амьд оршинол нь устдаг гэж бодож болохгүй. Бурханлаг сүнс бол ямарч материаллаг зэвсгийн хүчээр устгах аргагүй тийм жижиг гэдэг нь дараагийн шүлгээс тодорхой болно. Амьд оршинол нь өөрийн бурханлаг мөн чанарын улмаас ерөөсөө усташгүй юм. Харин устдаг буюу устгагддаг нь бол зөвхөн бие махбодь билээ. Гэхдээ энэ нь бие махбодийг устгаж хөнөөхийг уриалж байгаа хэрэг огтхон ч биш. Ведэд: *ма химсьят сарва-бхутани* буюу “Хэзээ ч хэнд ч хүч хэрэглэж болохгүй.” гэж сургасан байдаг. Мөн түүнчлэн амьд оршинол нь усташгүй юм гэдгээс үндэслэн амьтныг хүртэл хэзээ ч алж нядалж болохгүй. Ямар ч эрх мэдэлгүй байж аливаа нэгэн амьд амьтныг алж хөнөөнө гэдэг нь жигшүүртэй бузар хэрэг мөн бөгөөд ийм хэрэг үйлдсэн хэн бүхэн төр засгийн хуулиар ч, мөн Бүхний Дээд Бурханы хуулиар ч гэгсгээл шийтгэл хүлээх л болно. Гэхдээ Аржуна энд өөрийн хувийн санаа зоргоороо биш, шашин номын зарчмуудыг авран хамгаалах үүднээс тулалдаанд орж эсрэг талаа дарж устгах ёстой болоод байгаа билээ.

ШҮЛЭГ 20

*на жаяте мрияте ва кадачин
наям бхутва бхавита ва на бхуях
ажо нитьях шашвата ям пурано
на ханьяте ханьямане шарира*

на- хэзээ ч үгүй, жаяте- төрөгддөг, мрияте- үхдэг, ва- эсвэл, кадачит- аль нэгэн цагт (өнгөрсөн, одоо эсвэл ирээдүйд) на- хэзээ ч үгүй, аям- энэ, бхутва-үүссэнээр, бхавита- үүсэн бий болно, ва- эсвэл, на- үгүй, бхуях- эсвэл дахин бий болно, ажах- үл төрдөг, нитьяха- мөнх, шашватах- байнгын, аям- энэ, пуранах- хамгийн ахмад, на- хэзээ ч үгүй, ханьяте- хөнөөгдөх, ханьямане- хэрвээ хөнөөгддөг бол, шарира- бие махбодь.

Сүнсний хувьд төрөлт, мөн үхэл гэж хэзээ ч байдаггүй. Тэр хэзээ ч үүсэж бий болоогүй, хэзээ ч үүсэж бий болдоггүй, хэзээ ч үүсэн бий болохгүй. Тэр төрдөггүй, мөнхийн байнга оршин байдаг, анхдагч. Бие махбодь үхэж үрэгдэхэд тэр үхэж үрэгддэггүй.

ТАЙЛБАР: Бурханлаг сүнс нь Дээд Сүнсний өчүүхэн жижиг салангид тусдаа хэсэг учир Дээдийн Дээдтэй нэгэн адил шинж чанартай байдаг. Тэрээр бие махбодь лугаа хувирч өөрчлөгддөггүй. Заримдаа сүнснийг *кута-стха* буюу үл хувирч өөрчлөгдөгч гэж нэрлэдэг. Харин бие махбодь нь зургаан төрлийн хувиралт өөрчлөлтөнд өртдөг. Тэр эхийн хэвлийгээс төрөн тодорхой хугацааны турш оршин тогтноно, өсөж торнино, үр төлөө төрүүлнэ, аажмаар доройтон мөхнө, эцэст нь үгүй болон мартагдана. Харин сүнс бол иймэрхүү хувиралт өөрчлөлтийг туулдаггүй. Сүнс нь төрдөггүй бөгөөд харин тэрээр материаллаг бие махбодь авсан учраас л тэр бие махбодь нь төрдөг. Сүнсний хувьд энэ нь төрөлт биш бөгөөд мөн түүнд үхэл гэж байхгүй. Төрж байгаа бүхэн үхдэг жамтай. Сүнс нь төрдөггүй учир түүнд өнгөрсөн, одоо, ирээдүй үе гэж байдаггүй. Тэрээр мөнхийн, байнга оршин байдаг бөгөөд анхдагч, өөрөөр хэлбэл материаллаг бие махбодийн оршнолын үзэл баримтлалын нөлөөнд орсон бид, сүнс бол түүхийн явцад хэзээ нэгэн цагт төрсөн гэх мэтээр бодох боловч хичнээн чармайн оролдсон ч сүнсний гарал үүслийн тухай түүхийн үл мөрийг олж тогтоож чадахгүй юм. Мөн, бие махбодиос ялгаатай нь сүнс хэзээ ч хөгширдөггүй. Тиймээс өгөлж хөгширсөн харагдах хүн ч өөрийгөө хүүхэд ахуй эсвэл залуу цаг үеийнх шигээ тэр байдлаар мэдэрч байдаг. Бие махбодийн өөрчлөлт хувирал нь сүнсэнд нөлөөлдөггүй. Сүнс мэдү шиг, ер нь аливаа нэгэн материаллаг зүйл мэт гандаж, өмхөрч, өгөрч мууддаггүй. Түүнчлэн сүнс нь өөрийн дагалдах бүтээгдэхүүнүүдийг бий

болгодоггүй. Бие махбодийн дагалдах бүтээгдэхүүн болох хүүхдүүд нь мөн л бие даан орших янз бүрийн сүнснүүд бөгөөд зөвхөн бие махбодийн үүднээс авч үзвэл тэдгээр нь хэн нэгэн хүний хүүхдүүд болж харагддаг. Сүнс оршин байгаа учраас л бие махбодь өсөж торниж байдаг ч, сүнсэнд үр удам, өөрчлөлт хувирал гэж байдаггүй. Иймээс сүнс нь бие махбодийн зургаан өөрчлөлт хувиралгаас ангид байдаг.

Катха Упанишадын (1.2.18)-д үүнтэй төстэй шүлэг байдаг:

*на жаяте мрияте ва випашичин
наям куташичин на бабхува кашичит
ажо нитьяях шашивато `ям пурано
на ханьяте ханьямане шарире*

Энэ шүлгийн утга санаа нь Бхагавад Гитагийнхтай ижил боловч нэгэн онцгой чухал үгийг агуулдаг. Энэ нь *випашичит* буюу “гүн мэдлэгтэй” буюу “мэдлэг хүртсэн” гэсэн утгатай үг юм.

Сүнс нь мэдлэгээр дүүрэн байдаг. Өөрөөр хэлбэл тэрээр байнгад бүрэн дүүрэн ухамсрыг агуулж байдаг. Иймд ухамсар нь сүнсний шинж тэмдэг. Хүн хэдийгээр сүнснийг өөрийн зүрхэнд оршин байгааг харж чадахгүй ч ухамсар байгаа учир сүнс оршин байгаа гэдгийг ойлгож байдаг. Заримдаа бид нарыг үүлний цаагуур орсны улмаас юмуу эсвэл өөр ямар нэгэн шалтгаанаас болж харж чадахгүй болдог ч түүний гэрэл байгаагаар нь одоо өдөр байна гэдгийг мэдэж байдаг билээ. Өглөө эрт тэнгэрийн хаяа гэрэлтэн туяарахад удалгүй нар мандах нь гэж ойлгодог. Үүний нэгэн адил хүний ч бай, эсвэл амьтны ч бай ялгаагүй аль ч бие махбодид ухамсар байдгаас сүнс оршин байна гэж бид ойлгож мэдэж байдаг билээ. Гэхдээ сүнсний ухамсар нь Дээдийн Дээдийн ухамсраас ялгаатай. Учир нь Дээдийн Дээдийн ухамсар нь бүхэнд нэвчин түгдэг мэдлэг учраас өнгөрсөн, одоо болон ирээдүйг агуулж байдаг. Бие даасан сүнс нь мартамхай шинжтэй. Өөрийн үнэн мөн чанарыг мартсан сүнс нь Кришнагийн эрхэм дээд сургаалаас боловсрол гэгээрлийг хүртэж болно. Харин Кришнаг мартамхай сүнснүүдтэй адилтган үзэж болохгүй. Хэрвээ тийм байсан бол Түүний Бхагавад Гитад айлдах сургаал номлол нь ямар ч ач тусгүй зүйл байхсан билээ.

Сүнсний хоёр төрөл байдаг: нэг нь өчүүхэн жижиг сүнс (*ану-атма*) нөгөө нь Дээд Сүнс (*вибху-атма*). Энэ тухай Катха Упанишадын (1.2.20)-д дараахь байдлаар батлан өгүүлсэн байдаг:

*анор аниан махато махиян
атмасья жантор нихито гухаям
там акратух нашьяти вита-шоко
дхатух прасадан махиманам атманах*

“Дээд Сүнс (Параматма), бие даасан сүнс (*живатма*) хоёр нь хоёул бие махбодийн нэгэн модон дээр буюу амьд оршнолын зүрхэнд оршиж байдаг ба бүхий л материалаг хүсэл болон зовлон шаналалаасаа ангижирсан зөвхөн тэр л Бурханы өршөөл нигүүлслээр сүнсний гайхамшигт сайхныг ойлгож чадна.”

Кришна бол мөн Парамтамын эх булаг (энэ талаар дараагийн бүлгүүдэд тодорхой болно) юм. Харин Аржуна нь өөрийн үнэн мөн чанарыг мартсаны улмаас Кришнагаас эсвэл Түүний жинхэнэ элч төлөөлөгчөөс (номын багш) гэгээрлийг олох хэрэгтэй байгаа өчүүхэн жижиг сүнс билээ.

ШҮҮЛЭГ 21

*ведавинашинам нитьям я энам ажсам авьяям
катхам са пурушах партха кам гхатаяти ханти кам*

веда- мэддэг, *авинашинам-* усташгүй, *нитьям-* үргэлж оршигч, *ях-* тэр нэгэн, *энам-* энэ (сүнс), *ажсам-* төрдөггүй, *авьяям-* өөрчлөгдөж хувирдаггүй, *катхам-* яаж, *сах-* тэр, *пурушах-* бодьгал, *партха-* Притхын хүү минь, *кам-* хэнийг, *гхатаяти-* зовлон учруулах, *ханти-* устгадаг, *кам-* хэнийг.

Ай Притхын хүү минь ээ, сүнс болбоос устаж үгүй болшгүй, мөнхийн, төрдөггүй, өөрчлөгдөж хувирдаггүй гэдгийг мэдэх хүн хэрхэн, хэн нэгнийг хөнөөх эсвэл хөнөөлгөх гэх билээ дээ?

ТАЙЛБАР: Бүх зүйлс тодорхой ач тустай байдаг. Төгс төгөлдөр мэдлэгт тулгуурлах хүн л юуг хаана, яаж зохих ёсоор нь зөв хэрэглэхийг мэддэг. Үүний нэгэн адил хүч хэрэглэх нь ч гэсэн өөрийн гэсэн ач тустай байдаг ч түүнийг зөв хэрэглэж чадах эсэх нь мэдлэг эзэмшиж хүртсэн хүний шийдвэрээс хамаардаг. Хүн амины хэрэг үйлдсэн хэрэгтэнд цаазаар авах ял оноож байгаа шүүгчийг буруутгах аргагүй. Учир нь тэр хуулийн зүйл ангид нийцүүлэн хэрэгтний эсрэг хүч хэрэглэж байна. Хүн төрөлхтний хуулийн эмхтгэл болсон Ману-самхитад алуурчинг үйлдсэн энэ их том нүглийнхээ үр дагаврыг дараагийн амьдралдаа эдлэн зовоохгүйн тулд цаазлахыг зөвшөөрсөн байдаг. Иймээс алуурчинг цаазын тавцанд дүүжлэх зарлиг буулгаж байгаа хаан бол чухамдаа түүнд адислал хүртээж байгаа хэрэг. Хэрвээ Кришна тулалдахыг шаардаж байвал энэхүү хүч хэрэглэх үйл нь илүү дээд шудрага ёсны төлөө чиглэгдэж байна хэмээн ойлгох хэрэгтэй. Иймээс ч хүн, нарийндаа яривал сүнс устаж сөнөдөггүй учраас Кришнагийн төлөө тулалдаанд хүч хэрэглэх нь хүч хэрэглэх явдал огтхон ч биш гэдгийг ойлгоод Аржуна Түүний таалалд нийцүүлэн тэмцэл тулаанд орох хэрэгтэй юм. Шудрага ёсыг хангахын тулд ийнхүү хүч хэрэглэхийг зөвшөөрдөг. Мэс заслын хагалгааг өвчтөнийг хөнөөх гэж биш, харин анагаах гэж хийдэг. Иймээс Аржуна нь төгс төгөлдөр мэдлэгийг хүртэн Кришнагийн тааллын дагуу тулалдаанд орох бөгөөд ингэснээр ямар ч нүгэлт үр дагавар бий болон дагалдахгүй.

ШҮҮЛЭГ 22

*васамси жирнани ятха вихая
навани гриснати наро `парани
татха шарирани вихая жирнанй*

аньяни самьяти навани дехи

васамси- хувцас, *жирнани-* хуучирсан, *ятха-* яг түүн шиг, *вихая-* орхиод, *навани-* шинэ хувцас, *грихнати-* авдаг, *нараха-* хүн, *апарани-* өөр, *татха-* түүнчлэн, *ширирани-* бие махбодь, *вихая-* орхиод, *жирнани-* хуучин хэрэггүй, *аньяни-* өөр төрлийн, *самьяти-* үнэхээр авдаг, *навани-* шинэ, *дехи-* бие махбодид төрсөн.

Хүн хуучирч муудсан хувцсаа тайлж хаяад шинийг өмсдгийн адил сүнс нь хэрэггүй болсон хуучин бие махбодио орхин шинэ материаллаг бие махбодийг авдаг.

ТАЙЛБАР: Хэмжихийн аргагүй өчүүхэн жижиг бие даасан сүнсний бие махбодио сольдог нь хүлээн зөвшөөрөгдсөн зүйл. Хэдийгээр сүнсний оршин байхуйд итгэдэггүй ч зүрхэн дэх эрчмийн эх үүсвэрийн тухай тайлбарлаж чадахгүй байгаа орчин үеийн эрдэмтэд нь хүүхэд ахуй наснаас залуу нас, залуу наснаас идэр нас, идэр наснаас өтөл нас хүртэл явагдах бие махбодийн байнгын шилжилтийг хүлээн зөвшөөрөх л хэрэгтэй. Бие махбодь нь өтлөлт хөгшрөлтийн хамгийн сүүлийн үе шатанд хүрмэгц энэ өөрчлөлт, шилжилт нь өөр шинэ бие махбодид үргэлжлэн явагдана. Энэ тухай урьд өмнөх шүлгүүдийн нэгэнд (2.13) тайлбарласан билээ.

Бие даасан сүнсний шинэ бие махбодид шилжих шилжилт нь Дээд Сүнсний буюу Параматмын өршөөлөөр л явагддаг. Нэг найз нь нөгөө найзын хүсэлтийг биелүүлдгийн адил Параматма нь өчүүхэн жижиг сүнсний хүсэлтийг биелүүлдэг. Ведэд, тухайлбал Мундака Упанишад болон Шветашватара Упанишадад бие даасан сүнс, Дээд Сүнс хоёрыг нэг модон дээр сууж буй найз хоёр шувуутай зүйрлүүлсэн байдаг. Хоёр шувууны нэг (бие даасан өчүүхэн жижиг сүнс) уг модны үр жимсийг тоншин идэж байхад нөгөө шувуу (Кришна) нь зөвхөн Өөрийн найзаа ажиглан харж сууж байдаг. Хэдийгээр энэ хоёр шувууд шинж чанарын хувьд адил ч нэг нь материаллаг модны үр жимсэнд дур булаагдан татагдаж байхад нөгөө шувуу Өөрийн найзын үйлийг л ажиглаж суудаг. Кришна-ажиглагч шувуу, Аржуна-идэж байгаа шувуу. Тэр хоёр найз нөхөд хэдий ч нэг нь дээд Эзэн нь, нөгөө нь Түүний албат. Өчүүхэн жижиг сүнс нь энэхүү холбоо, харилцаагаа мартсан л бол түүнд нэг модноос өөр мод руу нисэн очих буюу өөрөөр хэлбэл, бие махбодио солих шаардлага гарна. Материаллаг бие махбодийн модон дээр суугаа *жива* нь маш хүнд хэцүү зовлон бэрхшээлийн туулан эдлэх бөгөөд хэзээ нөгөө шувуугаа —Аржуна сургаал номлолыг хүртэж дагахын тулд өөрийгөө Шри Кришнад сайн дураараа хэрхэн даатгасны адилаар— бүхний дээд номын багш хэмээн хүлээн зөвшөөрөн түүний сургаалыг дагасан цагт л бүх зовлон бэрхшээлээсээ мөдхөн ангижрах болно. Мундака Упанишадын (3.12)-д болон Шветашватара Упанишадын (4.7)-д энэ талаар:

*самане врикше пурушо нимагно
`нишяя шочати мухьяманах
жуштам яда пашьяти аньям ишам
асья махинамам ити вита-шоках*

“Хэдийгээр хоёр шувуу хамтдаа нэг модон дээр сууж байгаа боловч нэг нь уг модны үр жимсийг тоншин идэж амтлах гэж хүсэж байгаа тул айдас хүйдэс болон ханамжтай бус байдалд автан зовж шаналж байдаг. Харин ямар нэгэн байдлаар найздаа буюу Бүхний Дээд Бурханд хандан, Түүний гайхамшигт сайхныг таньж мэдэх аваас тэрхүү зовж шаналан байгаа шувуу мөдхөн л бүхий л зовлон шаналлаасаа салан ангижрах болно.” гэж батлан өгүүлсэн байдаг.

Аржуна одоо өөрийн мөнхийн анд Шри Кришнад хандан Түүний амнаас Бхагавад Гитагийн цэцэн мэргэн мэдлэгийг сонсон хүртэж байна. Тэрээр Бурханы айлдварыг сонссоноор Түүний эрхэм дээд гайхамшигтайг нь ойгож ухааран бүх зовлон гунигаасаа ангижрах болно.

Аржуна энд, өвөг эцэг болон багшийнхаа бие махбодио солих явдалд зовж шаналах хэрэггүй тухай Бурханы сургаалыг сонсож байна. Харин ч тэр удалгүй тэдний бие махбодийг шудрага тулаанд ялан дийлж хөнөөснөөр тэднийг бие махбодийн бүхий л үйлийн үр дагавраас нь ариусгах боломжтой болсондоо баярлах ёстой билээ. Өөрийн амьдралаа тахилгын талбар дээр буюу шудрага тулаанд алдаж байгаа хэн бүхэн тэр даруйдаа бие махбодийн бүхий л үйлийн үр дагавруудаас ангижран амьдралын илүү дээд түвшинд дээшлэн хүрдэг. Иймээс Аржунагийн хувьд зовж шаналах үндэс байхгүй юм.

ШҮҮЛЭГ 23

*найнам чхинданнти шастрани найнам дахати наваках
на чайнам кледаянти апо на шошяати марутах*

на- хэзээ ч үгүй, *энам-* энэ сүнс, *чхинданнти-* хэрчиж болох, *шастрани-* зэвсэг, *на-* хэзээ ч үгүй, *энам-* энэ сүнс, *дахати-* шатдаг, *навакаха-* гал, *на-* хэзээ ч үгүй, *ча-* мөн, *энам-* энэ сүнс, *кледаянти-* нордог, *апаха-* ус, *на-* хэзээ ч үгүй, *шошяати-* хатдаг, *марутах-* салхи.

Сүнсийг ямар ч зэвсгээр огтлон хэрчиж болдоггүй ба галд ч шатдаггүй, усанд ч норж уусдаггүй, мөн салхинд ч гандаж өгөрдөггүй.

ТАЙЛБАР: Илд, сэлэм, галт зэвсэг, бороон зэвсэг, хуй салхин зэвсэг гэх мэт болон ер нь ямар ч зэвсэг хэрэглэсэн сүнснийг устгаж хөнөөж чадахгүй. Эрт дээр үеийн тэр цагт одоогийн галт зэвсгийн зэрэгцээ мөн ус, шороо, агаар, огторгуй гэх мэт болон бусад зүйлээс бүтээгдсэн янз бүрийн төрөл хэлбэрийн зэр зэвсэг байжээ. Одоо цаг үеийн цөмийн зэвсэг нь галт зэвсэгт тооцогддог ч эрт цагт бусад бүх төрлийн материаллаг мах бодинаас зэр зэвсэг бүтээж байсан. Галт зэвсгийн эсрэг, одоогийн шинжлэх ухаанд огт үл мэдэгдэх усан зэвсгээр тэмцдэг байжээ. Түүнээс гадна орчин үеийн эрдэмтэд хуй салхин зэвсгийн талаар ч мэдэхгүй билээ. Тэглээ ч гэсэн шинжлэх ухааны ямар ч ололт, нээлтээс үл хамааран ямар ч зэвсэг хэрэглэсэн сүнснийг огтолож хэрчиж, жижиглэх эсвэл устгаж үл чадна.

Бие даасан сүнс нь зөвхөн харанхуй мунхгийн улмаас яаж үүсэж бий болсон байх ёстой хийгээд үүний улмаас хий хуурмагийн эрчмээр хэрхэн хүчигдсэн болохыг *майавадууд* тайлбарлаж чаддаггүй. Мөн түүнчлэн бие даасан сүнс анхдагч Дээд Сүнснээс хэзээ нэгэн цагт салан тусгаарлагдсан байх боломжгүй юм. Бие даасан сүнснүүд нь харин ч эсрэгээр, Дээд

Сүнсний мөнхийн салангид тусдаа хэсгүүд байдаг. Гэхдээ амьд оршнолууд нь мөнхийн (*санатана*) өчүүхэн жижиг бие даан орших сүнснүүд болох учраас хууран мэхлэх эрчмээр бүрхэгдэн хучигдах дур сонирхолтой байдаг ба ингэснээрээ тэд, галтай ижил шинж чанартай ч галаас салан холдсоноор бөхөн унтардаг очтой адил Бүхний Дээд Бурханы хүрээллээс холдон оддог. Вараха Пуранад амьд оршнолуудыг Дээдийн Дээдийн салангад тусдаа байх өчүүхэн жижиг бүрэлдэхүүн хэсгүүд гэж тодорхойлон өгүүлсэн байдаг бөгөөд тэдгээр нь мөн Бхагавад Гитад батлан өгүүлсэнчлэн, мөнх билээ. Бурханы Аржунад хандан айлдаж буй сургаалаас үзэхэд, амьд оршнол нь хий хуурмагаас ангижирсаны дараагаар ч өөрийн бие даасан байдлаа хадгалдаг гэдэг нь тодорхой. Аржуна Кришнагаас хүртсэн мэдлэгийн ач тусаар ангижралд хүрсэн ч тэрээр хэзээ ч Кришнатай нэг болоогүй.

ШҮҮЛЭГ 24

*аччхедьо `ям адахьо `ям акледьо `шошья эва ча
нитьях сарва-гатах стханур ачало `ям санатанах*

аччхедьях- эвдэрч бутаршгүй, *аям-* энэ сүнс, *адахьях-* шаташгүй, *аям-* энэ сүнс, *акледьях-* уусашгүй, *ашошьях-* хатааж гандааж болшгүй, *эва-* гарцаагүй, *ча-* мөн, *нитьях-* байнгад, *сарва-гатах-* хаа сайгүй оршигч, *стханух-* өөрчлөгдөж хувиршгүй, *ачалах-* хөдөлшгүй, *аям-* энэ сүнс, *санатанах-* мөнх тэр байдлаараа.

Бие даасан сүнс нь эвдэрч бутаршгүй ба түүнийг норгож уусгаж, шатааж, хатааж болдоггүй. Тэр байнгад, хаа сайгүй, өөрчлөлт хувиралтгүй, хөдөлшгүй оршдог бөгөөд мөнхөд ийм л байдаг.

ТАЙЛБАР: Өчүүхэн жижиг сүнсний энэ бүх шинжүүд нь бие даасан сүнс нь бурханлаг Бүрэн Бүтэний мөнхийн өчүүхэн жижиг хэсэг болох хийгээд ямар ч өөрчлөлтгүйгээр мөнхөд тэр л хэвээр байдаг гэдгийг тодорхой баталж байна. Үүнээс үзэхэд бие даасан сүнс нь бурханлаг Бүрэн Бүтэнтэй нэг хийгээд адил болдог гэдэг нь хэзээ ч байж болшгүй учир монизмын онолыг хүлээн зөвшөөрөхийн аргагүй юм. Материаллаг бузраас ангижирсаны дараагаар өчүүхэн жижиг сүнс нь Бурханы Дээд Бодьгалын гэрэлтэн туяарах цацрагт бурханлаг оч байдлаар үлдэхийг эрхэмлэн үзэж болох ч илүү оюунлаг сүнснүүд нь Бурханы Дээд Бодьгалтай хамт байхын тулд бурханлаг гаригуудад дээшлэн хүрч очдог.

Бурханы бүтээлийн хаа сайгүй амьд оршнолууд оршин байдаг нь ямар ч эргэлзээгүй учир *сарва-гата* (бүхэнд нэвчмэл) гэдэг үг нь онцгой ач холбогдолтой юм. Тэд хуурай газарт, усанд, агаарт, шороонд, мөн тэр бүү хэл галд ч оршин байдаг. Сүнс галд шатдаггүй гэж энд тодорхой өгүүлсэнээс үзэхэд тэднийг галаар устгаж болно гэсэн үзэл бодлыг хүлээн зөвшөөрөхийн аргагүй юм. Иймээс ч амьд оршнолууд тохирсон тодорхой бие махбодийг аван мөн наран дээр оршин байдаг нь эргэлзээгүй юм. Хэрвээ наран дээр амьд оршнол байдаггүйсэн бол *сарва-гата* буюу хаа сайгүй оршдог гэдэг үг утгаа алдах байсан билээ.

ШҮҮЛЭГ 25

*авьякто `ям ачинтьо `ям авикарьо `ям учьяте
тасмад эвам видитвайнам нанушочитум архаси*

авьяктах- харагдашгүй, *аям-* энэ сүнс, *ачинтьях-* ойлгож хүртэхийн аргагүй, *аям-* энэ сүнс, *авикарьях-* өөрчлөгдөж хувирдаггүй, *аям-* энэ сүнс, *учьяте-* нэрлэгддэг, *тасмат-* иймээс, *эвам-* үүн шиг, *видитва-* сайн мэдсэнээр, *энам-* энэ сүнс, *на-* үгүй, *анушочитум-* гашуудах, *архаси-* чи болно.

Сүнс нь үзэгдэж харагдашгүй, ойлгож ухаарахын аргагүй бөгөөд мөн хувирч өөрчлөгддөггүй юм. Чи энэ тухай мэдсэн тул бие махбодийн төлөө гашуудан гуниглах хэрэггүй

ТАЙЛБАР: Урьд өмнө өгүүлсэнчлэн, сүнс нь бидний материаллаг хэмжээсний хувьд хамгийн хүчтэй микроскопоор ч харах аргагүй маш өчүүхэн жижиг учир түүнийг үзэгдэж харагдашгүй гэж нэрлэж байна. Сүнсний оршин байдгийг туршилтын журмаар тогтоож болохгүй бөгөөд түүний оршин байдгийн цорын ганц баталгаа бол *шрути* буюу ведийн цэцэн мэргэн мэдлэг юм. Сүнсний оршин байгаа нь бидний хүлээн авч мэдэрч буй шинж тэмдгүүдийн үндсэн дээр маргашгүй хэдий ч түүний оршин байгааг нотлох мэдлэгийн өөр эх сурвалж байхгүй учир бид *шрутийн* баталгааг л үнэн гэж хүлээн авах хэрэгтэй. Зөвхөн дээд эх сурвалж дээр үндэслэж тулгуурлан хүлээн авахаас өөр аргагүй зүйл олон байдаг. Жишээ нь: Бид зөвхөн эхийнхээ үгэнд л итгэж эцгээ хэн болохыг мэддэг. Өөрөөр хэлбэл эх бол бидний эцгийг хэн болохыг хэлж чадах цорын ганц эх сурвалж юм. Иймээс сүнсний тухай мэдлэгийн цорын ганц эх сурвалж нь Вед, өөрөөр хэлбэл сүнсийг хүний хийсэн туршилтын мэдлэгт үндэслэж тулгуурлан таньж мэдэх боломжгүй юм. Ведэд сүнс бол ухамсар буюу сүнс нь ухамсартай гэж өгүүлсэн байдаг бөгөөд бид үүнийг үнэн гэж хүлээж авах л хэрэгтэй. Хувирч өөрчлөгдөж байдаг бие махбодиос сүнс нь хувиралт өөрчлөлтөнд үл өртдөгөөрөө ялгаатай. Хэзээ ч хувирч өөрчлөгддөггүй сүнс нь хязгааргүй байх Бүхний Дээд Сүнтэй харьцуулахад үргэлж хязгааргүй жижиг байдаг. Дээд Сүнс нь хязгааргүй том бөгөөд өчүүхэн жижиг сүнс нь хязгааргүй жижиг. Хязгааргүй жижиг сүнс нь хувирч өөрчлөгддөггүй учир тэрээр хязгааргүй том Сүнс буюу Бурханы Дээд Бодьгалтай хэзээ ч эн зэрэгцэхгүй. Сүнсний тухай ойлголтыг улам батжуулахын тулд энэхүү санааг Ведэд янз бүрийн хувилбараар олонтаа давтан өгүүлсэн байдаг. Олон дахин давтах нь ямар нэгэн утга санааг гүн гүнзний бөгөөд алдаа мадаггүй ойлгоход тустай.

ШҮҮЛЭГ 26

*атха чайнам нитья-жатам нитьям ва маньясе мритам
татхани твам маха-бахо найнам шочутим архаси*

атха- хэрвээ, ча- мөн, энам- энэ сүнс, нитья-жатам- үргэлж төрдөг, нитьям- бүр мөсөн, ва- эсвэл, маньясе- бидний бодож байгаа шиг, мритам- үхмэл, татха-ани- гэхдээ, твам- чи, маха-бахо- ай хүчит гарт минь, на- хэзээ ч, энам- сүнсний тухай, шочитум- гашуудах, архаси- болох.

Хэрвээ чи сүнс (буюу амьдралын шинж тэмдэг) байнга л төрж байдаг, тэгээд дараа нь бүрмөсөн үхэж үгүй болдог гэж итгэдэг байсан ч чамд гуньж гутаад байх шалтгаан алга байна шүү дээ, ай хүчит гарт минь ээ.

ТАЙЛБАР: Сүнс нь бие махбодиос ангид тусдаа оршин байдаггүй хэмээн буддистуудын нэгэн адил итгэж байдаг философчдын тодорхой бүлгүүд байнга байж байдаг. Шри Кришна Бхагавад Гитаг айлдаж байх үед ч иймэрхүү үзэл бодолтой *локаятики* болон *вайбхашики* зэргийн философчууд байсан. Эдгээр философчуудын үзэл баримтлалаар бол материаллаг элементүүдийн тодорхой нэгдэл холбооны хөгжиж боловсорсон үе шатанд амьдралын шинж тэмдэг бий болдог байх нь. Орчин үеийн материалист эрдэмтэд болон материалист философичид ч энэ үзэл бодлыг баримталдаг. Тэдний бодлоор бол бие махбодь нь материаллаг элементүүдийн нэгдэл холбоо бөгөөд физик болон химийн элементүүдийн харилцан үйлчлэлийн үр дүнд тодорхой үе шатанд амьдралын шинж тэмдэг хөгжин бий болдог байна. Хүн судлалын шинжлэх ухаан ч энэ философи дээр үндэслэдэг. Одоо үед, Америкт моодонд ороод байгаа олон хуурамч шашнууд мөн л энэ философийг дагадаг. Тухайлбал Бурханд чин бишрэлээр зүтгэхийг үгүйсгэгч нигиллистик буддист сект.

Аржуна нь *вайбхашикийн* философичдын нэгэн адил сүнсний оршнолд итгэдэггүй байсан байлаа ч түүний хувьд гашуудан шаналаад байх учир шалтгаан байхгүй байхсан билээ. Ямар ч хүн химийн бодисуудын хэсэгхэн бөөмнөрлийг алдсанаараа уй гашууд автан өөрт оноогдсон үүргээ биелүүлэхээс ухран татгалздаггүй. Орчин үеийн шинжлэх ухаанд болон дайны явцад дайснаа дарахын тулд химийн бодисуудыг тонн тонноор нь үрэн зарлагадаж байдаг. *Вайбхашикийн* философчоор бол энэхүү сүнс (*атма*) хэмээх зүйл нь бие махбодийн задралтай хамт үгүй болдог байна. Иймээс аль ч тохиолдолд, бие даасан сүнс нь оршин байдаг гэсэн Ведийн баримт нотолгоог хүлээн зөвшөөрсөн ч тэр, эсвэл сүнс нь үл оршдог гэдэгт итгэдэг байсан ч тэр, ялгаагүй Аржунагийн хувьд уйтгар гуниг, зовлон шаналалд автаад байх шалтгаан алга. *Вайбхашикийн* онолоор бол агшин тутамд л хязгааргүй олон амьд оршнолууд материас үүсэн бий болохын зэрэгцээ хязгааргүй олон амьд оршнолууд үхэн үгүй болж байх тул иймэрхүү үйл явдлын төлөө гашуудан гуниг хэрэг байхгүй билээ. Сүнс дахин төрдөггүй л юм бол Аржуна өөрийн өвөөгийн болон багшийнхаа амийг хөнөөснөөр үүсэн бий болох нүгэлт үр дагавраас айн эмээхийн хэрэг байхгүй байсан билээ. Кришна Аржунаг *маха-баху* буюу хүчит гарт минь хэмээн егөөдсөн байдлаар нэрлэж байгаа нь Тэр Ведийн цэцэн мэргэн мэдлэгт харшилдан зөрчилдөх *вайбхашикийн* онолыг огтхон ч хүлээн зөвшөөрөхгүй байгааг илтгэж байна. Аржуна нь *киатрия* мөн болохын хувьд ведийн соёлд хамаарагдах учраас түүний үүрэг нь ведийн зарчмуудыг цаашид дагаж мөрдөх явдал юм.

ШҮЛЭГ 27

жатасья хи дхруво мритьюр дхрувам жанма мритасья ча тасмад апарихарье ртхе на твам шочитум архаси

жатасья- төрсөн болгоны, хи- тодорхой, дхрувах- баримт, мритьюх- үхэл, дхрувам- энэ бол мөн бодит баримт, жанма- төрөлт, мритасья- үхэгсэдийн, ча- мөн, тасмат- иймээс, апарихарье- зайлахын аргагүй тэр зүйлээс, артхе- хэрэг явдалд, на- үгүй, твам- чи, шочитум- гашуудан зовох, архаси- болох.

Төрсөн болгон үхдэг бөгөөд үхсэний дараагаар дахин төрдөг бүлгээ. Иймээс өөрийн үүргээ гашуудаж зоволгүйгээр биелүүл.

ТАЙЛБАР: Хүний энэ амьдралын үйл ажиллагаа нь түүний дараагийн төрөлт, амьдралынх нь нөхцлийг тодорхойлж өгдөг. Хүн үйл ажиллагааныхаа нэгэн мөчлөгийг дуусгаад дахин төрөхөөр үхдэг. Ангижралыг л олохгүй бол төрөлт үхлийн хүрд нийм байдлаар дахин дахин эргэлдэж байдаг. Гэхдээ төрөлт үхлийн энэхүү хүрд буюу дахин давтагдах байдал нь ямар ч утга учиргүй алаан хядаан, бөөнөөр нь нядлах газар байгуулах болон дайн хийхийг цагаатган зөвтгөж байгаа хэрэг биш. Гэсэн хэдий ч хүний нийгэмд хууль дүрэм болон хэв журмыг зөв сахиулах үүднээс хүч хэрэглэх болон дайн хийх зайлшгүй тохиолдол гардаг.

Курукшетрын тулалдаан нь Дээдийн Дээдийн тааллаар болсон тул болох нь гарцаагүй байсан бөгөөд зөв шудрага хэргийн төлөө тэмцэх нь *киатрия* хүний үүрэг юм. Аржуна өөрт оноогдсон үүргээ л биелүүлж байгаа тул чухм яалаа гэж төрөл төрөгсдийгөө үхэхээс эмээж, тэдний талаар санаа зовох ёстой гэж? Тулалдаанд орсноороо Аржуна ямар ч хуулийг зөрчөөгүй бөгөөд иймээс тэр үр дагавраас нь маш ихээр айж эмээж байсан тийм нүгэлт үйлийг ч үйлдээгүй юм. Мөн тэр өөрийн жинхэнэ үүргийг биелүүлэхээс зайлсхийсэн байлаа ч өөрийн төрөл төрөгсдөө үхлээс зайлуулж чадахгүй байлаа. Харин энэхүү буруу үйлийнхээ үр дүнд хүрч болох цорын ганц зүйл бол түүний өөрийнх нь уналт доройтол байсан юм.

ШҮЛЭГ 28

авьяктадини бхутани вякта-мадхьяни бхарата авьякта-нидханани эва татра ка паридевана

авьякта-адини- эхэндээ үл илэрч тодордог, бхутани- бүтээгдсэн бүхэн, вякта- илэрч тодорсон, мадхьяни- завсрын үед, бхарата- Бхаратын үр удам минь, авьякта- үл илэрч тодорсон, нидханани- устгагдах үедээ, эва- бүгд ингэдэг, татра- иймээс, ка- юу, паридевана- зовлон шаналал.

Бүтээгдсэн бүх зүйлс эхэндээ илэрч тодроогүй төлөв байдалд оршиж байдаг. Харин дараа нь хэсэгхэн хугацаанд илэрч тодорсноо дахин илэрч тодроогүй төлөв байдалдаа шилжин ордог болохоор зовж шаналаад байхын хэрэг байна уу?

ТАЙЛБАР: Сүнс оршин байдагт итгэдэг болон сүнс оршин байдагт итгэдэггүй гэсэн философийн хоёр үзэл баримтлалыг авч үзсэн ч аль ч тохиолдолд уй гашуу болох шалтгаан байхгүй. Ведийн цэцэн мэргэн мэдлэгийн зарчмуудыг баримтлагчид нь

сүнс оршин байдаг гэдэгт үл итгэгчдийг атейстууд буюу бурхангүйн үзэлтэнгүүд гэж нэрлэдэг. Бид өөрсдийгөө бурхангүйн үзэл баримтлагчдын байр сууринд тавиад үзсэн ч ялгаагүй уй гашуу болох учир шалтгааныг олохгүй. Сүнс нь салангид тусдаа оршин байдаг гэдэг үүднээс аваад үзсэн ч материаллаг элементүүд нь бүтээл болохын өмнө илэрч тодроогүй төлөв байдалдаа байдаг. Эфирээс агаар, агаараас гал, галаас ус, уснаас шороо үүсдэг шиг үл илэрч тодорсон энэхүү нарийн төлөвөөс илэрч тодорсон төлөв байдал нь бий болдог. Шорооноос л янз бүрийн хэлбэрүүд бий болдог. Жишээ болгон тэнгэр баганадсан нэгэн өндөр байшинг авч үзье. Энэ байшин нь шорооноос л бүрдэх бөгөөд эвдэрч сүйдэн нурсаны дараагаар дахин илрээгүй төлөв байдалдаа шилжих бөгөөд эцсийн дүндээ зөвхөн атомууд л үлдэнэ. Энерги хадгалагдах хууль үргэлж хүчинтэй байдаг ба зөвхөн цаг хугацааны явцад юмс, зүйлүүд нь нэг илэрч тодорсоноо дараа нь дахин илэрч тодроогүй төлөвтөө ордог. Үүнд л ялгаа нь оршдог. Ямар учраас илэрч тодорсон эсвэл илэрч тодроогүй төлөв байдлын төлөө санаа зовох ёстой гэж? Илэрч тодроогүй төлөв байдалд ч чухамдаа юу ч бүр үгүй болдоггүй. Бүх материаллаг элементүүд эх, төгсгөл хоёртоо л илэрч тодроогүй төлөвтөө оршдог бөгөөд зөвхөн завсрын үе шатандаа л илрэлээ олддог бөгөөд энэ нь үнэндээ ямар ч материаллаг ялгаа биш.

Хэрвээ бид Бхагавад Гитад, материаллаг бие махбодь нь цаг хугацааны явцад үхэж үрэгддэг (*антаванта име дехах*), харин сүнс нь мөнх (*нитьясьоктах шаририних*) байдаг гэж өгүүлсэн байх ведийн баталгааг хүлээн зөвшөөрөх аваас бие махбодь бол өмссөн хувцастай адил юм гэдгийг байнгад санаж явах хэрэгтэй. Тэгвэл өмссөн хувцсаа солиход юундаа ч харамсан гашуудах билээ дээ? Материаллаг бие махбодийг мөнхийн орших сүнсгүй харьцуулах аваас үнэндээ оршин байдгүйтэй адил юм. Тэр бол ердөө зүүд мэт. Зүүдэндээ бид нэг бол тэнгэрт нисэж байна, эсвэл хаан болчихсон сүйх тэргэнд суугаад явж байна гэж хардаг боловч сэрмэгч л бид тэнгэрт ч биш, сүйх тэргэнд ч биш байгаагаа мэддэг билээ. Ведийн цэцэн мэргэн мэдлэг нь хүмүүсийг материаллаг бие махбодь бол үнэн хэрэгтээ үл оршдог юм гэдэг ойлголт дээр үндэслэн өөрийгөө бүрэн нээж танин мэдэхэд зоригжуулдаг. Иймээс сүнс оршин байдагт итгэдэг ч бай, итгэдэггүй ч бай, аль ч тохиолдол байсан ялгаагүй бие махбодио алдахад эмгэнэн гашуудах шалтгаан байхгүй.

ШҮҮЛЭГ 29

*ашчарья-ват паиьяти каишчид энам
ашчарья-вад вадати татхайва чаньях
ашчарья-вач чайнам аньях ириноти
шрутвапи энам веда на чайва каишчит*

ашчарья-ват- гайхамшигтай гэж, *паиьяти*- ажигладаг, *каишчит*- хэн нэгэн, *энам*- энэ сүнс, *ашчарья-ват*- гайхамшигтай гэж, *вадати*- тухай ярьдаг, *татха*- ийм байдлаар, *эва*- гарцаагүй, *ча*- мөн, *аньях*- өөр нэгэн, *ашчарья-ват*- гайхамшигтай гэж, *ча*- мөн, *энам*- энэ сүнс, *аньях*- өөр нэгэн, *ириноти*- тухай сонсдог, *шрутва*- сонссоноор, *апи*- тэр ч бүү хэл, *энам*- энэ сүнс, *веда*- мэддэг, *на*- хэзээ ч үгүй, *ча*- мөн, *эва*- гарцаагүй, *каишчит*- хэн нэгэн.

Зарим нь сүнснийг гайхамшигтай хэмээн үзэцгээнэ, зарим нь сүнснийг гайхамшигтай хэмээн ярьцгаана, мөн зарим нь сүнснийг гайхамшигтай хэмээхийг сонсоцгоож байхад зарим нь түүний тухай сонсоцгоох мөртөө юу ч эс ойлгоцгооно.

ТАЙЛБАР: Гитопанишад нь нилээд хэмжээгээр Упанишадын зарчмууд дээр үндэслэгдсэн байдаг учир Катха Упанишадад дараах шүлэг байх нь тийм ч гайхаад байх зүйл биш юм:

*шраванаяпи бахубхир йо на лабхьях
шринванто `пи бахава ям на видьяох
ашчарьо вакта кушало `ся лабдха
ашчарьо сья гьята кушаланушиштах*

Өчүүхэн жижиг сүнс нь үлэмж том бие махбодьтой амьтанд, аврага том баньян модонд төдийгүй сая саяараа нийлээд ч нэг шоо сантиметр эзлэхүүнтэй орон зайг ч дүүргэхгүй өчүүхэн жижиг бактериуд ч оршин байх нь үнэхээр гайхалтай. Мэдлэг ухаан хомстой болон өөрийн материаллаг хүслийг тэвчин барьж үл чадах хүмүүс бие даан орших өчүүхэн жижиг бурханлаг очны гайхамшигтай мөн чанарын талаар энэхүү орчлонгийн хамгийн анхны амьд оршнол болох Брахмад ч сургаалаа номлосон мэдлэгийн дээдийн дээд Эх сурвалжийг Өөрөө тайлбарласан ч ойлгохгүй. Амьдралын талаарх бүдүүн баараг-материаллаг ойлголтоосоо болж одоо цаг үеийн ихэнх хүмүүс энэхүү өчүүхэн жижиг хэсэг нь нэг бол ийм аврага том эсвэл ийм өчүүхэн жижиг болж байгааг төсөөлж ч чадахгүй юм. Иймээс тэд сүнсний мөн чанарыг таньж мэдэх болон эсвэл түүний талаар сонсмогч гайхашралд ордог. Өөрийгөө таньж мэдэлгүйгээр үйлдэх үйл нь эцсийн эцэст амьдрал оршнолын төлөөх тэмцэлд ямар ч амжилтгүй болно гэдэг нь тодорхой байдаг ч материаллаг эрчимд хууртагдан мэхлэгдсэн хүмүүс мэдрэхүйдээ таашаалыг ханамж эдлүүлэх үйлд гүн автсанаас болж өөрийгөө ухамсарлаж ойлгоход цаг заваар маш хомс болжээ. Материаллаг зовлон бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд сүнсний талаараа бодох хэрэгтэй гэдгийг эдгээр хүмүүс огтхон ч мэддэггүй байж болох юм.

Зарим хүмүүст сүнсний талаар сонсох нь сонирхолтой байдгаар барахгүй, бурханлаг хүмүүсийн хүрээлэлд ийм сэдэвтэй лекц, ярианд очиж суудаг ч харанхуй мунхагийнхаа харгайгаар тэд заримдаа төөрөлдөн, Дээд Сүнс болон бие даан орших өчүүхэн жижиг сүнс хоёр нь хоорондоо ялгаагүй юм хэмээн буруугаар бодож итгэх явдал гардаг. Дээд Сүнс болон бие даан орших сүнсний байр суурь, тэдгээрийн тус тусын үүрэг, харилцаа холбоо болон тэдгээртэй холбогдсон бусад бүх зүйлийг нэгд нэгэнгүй нарийн тодорхой ойлгож мэдсэн хүнийг олно гэдэг тун бэрх. Мөн сүнсний мэдлэг ухааны ач тусыг үнэхээрийн бүрэн дүүрэн гаргаж чадсан, түүний байр суурийн янз бүрийн төлөв байдлыг тодорхойлж чадах тийм хүнийг олно гэдэг бүр ч хэцүү. Хэн нэгэн нь сүнсний тухай мэдлэг ухааныг ямар нэгэн байдлаар ойлгож хүртэх чадвартай байх аваас түүний амьдрал урагштай болно.

Сүнсний тухай мэдлэг ухааныг ойлгож хүртэх хамгийн энгийн арга зам бол дээдийн дээд эх сурвалж болох Шри Кришнагийн айлдсан Бхагавад Гитагийн сургаал номлолыг анхаарлаа өөр бусад ямар ч онолд сарниулж будилуулалгүйгээр хүлээн авч хүртэх явдал юм. Шри Кришнаг Бурханы Дээд Бодгаль гэж хүлээн зөвшөөрөх чадвартай болохын тулд энэ амьдралдаа эсвэл өнгөрсөн амьдралууддаа үлэмж хэмжээний тахилга үйлдэж өргөл өргөн, огоорохуйн

амьдралыг туулсан байх шаардлагатай байдаг. Гэхдээ Кришнаг жинхэнээр нь зөвхөн цэвэр чин бишрэлтэнгийн учир шалтгаангүй өршөөл нигүүлслээр л таньж мэдэхээс өөр арга зам байдаггүй.

ШҮҮЛЭГ 30

*дехи нитьям авадхьо `ям дехе сарвасья бхарата
тасмат сарвани бхутани на твам шочитум архаси*

дехи- материаллаг бие махбодийн эзэн, *нитьям*- мөнх, *авадхьях*- устгаж болохгүй, *аям*- энэ сүнс, *дехе*- бие махбодид, *сарвасья*- хэн бүхний, *бхарата*- Бхаратын үр удам минь, *тасмат*- иймээс, *сарвани*- бүгд, *бхутани*- амьд оршнол (төрдөг), *на*- хэзээ ч үгүй, *твам*- чи, *шочитум*- зовон шаналах, *архаси*-болох.

Ай Бхаратын үр удам минь ээ, энэхүү бие махбодид оршин суугч нь хэзээ ч хөнөөгдөшгүй юм. Иймээс чи аль нэг амьд оршнолын төлөө гашуудан гунихын хэрэггүй билээ.

ТАЙЛБАР: Ийнхүү айлдсанаараа Шри Кришна хувирч өөрчлөгддөггүй бурханлаг сүнсний талаарх айлдвар сургаалаа өндөрлөж байна. Шри Кришна мөнхийн сүнсийг янз бүрийн байдлаар тайлбарласнаар сүнс нь үхэшгүй, бие махбодь нь түр зуурын гэдгийг харууллаа. Иймээс Аржуна нь *киатрия* хүн болохын хувьд өвөг эцэг Бхишма болон багш Дрона нарыг тулалдаанд амь эрсдэх нь хэмээн айж эмээсний улмаас өөрийн үүргээ биелүүлэхээс зайлсхийх ёсгүй. Шри Кришна бол эх сурвалж мөн гэдэг үүднээс бид бүхэн сүнс оршин байдаг болон энэхүү сүнс нь бие махбодиос ялгаатай гэдэгт итгэх хэрэгтэй. Сүнс гэж байдаггүй буюу амьдралын шинж тэмдэг нь химийн элементүүдийн харилцан үйлчлэлийн үр дүнд материаллаг хөгжлийн тодорхой нэг үе шатанд үүсэж бий болдог гэж үзэх хэрэггүй. Сүнс нь үхэшгүй байдаг ч хүч хэрэглэх явдлыг сайшаан дэмжиж уриалж болохгүй. Зөвхөн шаардлагатай үед л, тухайлбал дайны үед, гэхдээ өөрсдийн хувийн санаа зоргоор биш, зөвхөн Бурханы таалал соёрхлын дагуу.

ШҮҮЛЭГ 31

*сва-дхармам апи чавекшья на викампитум архаси
дхармьяд дхи юддхач чхрейо `нъят киатриясья на видьяте*

сва-дхармам- өөрийн шашны зарчмууд, *апи*- мөн, *ча*- үнэн хэрэгтээ, *авекшья*- бодож санан, *на*- хэзээ ч үгүй, *викампитум*- тээнгэлзэх, *архаси*- болно, *дхармьят*- шашны зарчмуудын төлөө, *хи*- үнэн хэрэгтээ, *юддхач*- тэмцэн тулалдахаас, *ирях*- илүү сайн үйл, *аньят*- өөр ямар нэгэн зүйл, *киатриясья*- кшатрийн, *на*- үгүй, *видьяте*- байдаг.

Кшатрия хүн болохын хувьд чиний онцгой үүрэг бол шашин номын зарчмуудад тулгуурлан тулалдахаас өөр илүү сайн үйл гэж үгүй гэдгийг мэдэх ёстой. Иймээс чамд тээнгэлзэх үндэс байхгүй.

ТАЙЛБАР: Дөрвөн ангит нийгмийн байгууллын хоёр дахь дахь буюу шашин номын хуулиудын үндсэн дээр улс гүрнээ зөв удирдан залах ангид хамаарах гишүүдийг *киатрия* гэж нэрлэдэг. *Киат*- гэдэг нь зөрчих, гэмтээх гэсэн утгатай үг. Ийм хор хөнөөл учрахаас хамгаалах хүнийг *киатрия* гэдэг (*тратя* гэдэг нь хамгаалах гэсэн утгатай). Эрт дээр цагт *киатрия* нь ойд очин бартай тулгаран түүний эсрэг зөвхөн сэлэм хэрэглэн ганцаарчлан тулалдах байдлаар байлдааны бэлтгэл сургуулилтаа хийдэг байжээ. Бар алагдсан тохиолдолд түүнийг хааны оршуулах ёслолын дагуу галд өргөн шатаадаг байжээ. Энэ уламжлалыг Жайпурын хаад-*киатрия* нар одоог хүртэл даган мөрддөг. Шашин номын хуулийн дагуу хүч хэрэглэхээс өөр аргагүй тохиолдол зарим үед гардаг учраас *киатрия* нь эсрэг талаа тулалдаанд хэрхэн урин дуудах болон ялан дийлэхэд тусгайлан суралцдаг. Иймээс *киатрия* нь *санньяса* буюу ертөнцөөс огоорохуйн амьдралын түвшинд шууд орох ёс огт байдаггүй. Хүч хэрэглэхээс татгалзах, зайлсхийх нь улс төрд дипломат сайн арга тактик байж болох ч хэзээ ч үндсэн зарчим болдоггүй. Шашны хуулийн эмхтгэлд өгүүлэхдээ:

*ахавешу митхо `ньоньям жигхамсанто махи-кишитах
юдаманах парам шактья сваргам янтй апаран-мухсах
ягьешу пашаво брахман ханьянте сататам движайх
самскритах кила мантрайш ча те `ни сваргам аваннуван*

“Хаан буюу *киатрия* нь тулалдааны талбарт өөрийнх нь эсрэг атаархан дайсангагч өөр нэгэн хаантай тулалдаж байгаад амь эрсдэх аваас тэрээр дээд гаригуудад очдог. Мөн тахилгын галд амьтнаар өргөл өргөсөн *брахмана* нь түүний нэгэн адил дээд гаригуудад хүрч очдог.”

Иймд шашин номын зарчмуудын дагуу тулалдааны талбарт тулалдаж байгаад амь эрсдэх эсвэл тахилгын галд амьтнаар өргөл өргөн амийг нь хөнөөхийг хүч хэрэглэсэн явдал гэж үздэггүй. Учир нь үүнтэй холбогдсон, шашин номын зарчмууд дээр үндэслэн үйлдсэн үйл нь хэн бүхэнд ач тусаа өгдөг. Тахилгын галд өргөл болгон өргөгдсөн амьтан нь амьдралын нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт шилжих хөгжлийн урт удаан хугацааны замыг туулалгүйгээр шууд хүний биенийг олж төрдөг. Тулалдаанд амь үрэгдсэн *киатрия* нь тахилга тахин өргөл өргөгч *брахманын* нэгэн адил дээд гаригуудад хүрч очдог.

Сва-дхарма буюу хүнд оноогдсон үүргийн хоёр төрөл байдаг. Материаллаг нөхцөлд оршин байгаа болзолт сүнс нь ангижралыг олохын тулд тухайн бие махбодид оноогдсон үүргээ шашин номын зарчмуудтай нийцүүлэн биелүүлж байх хэрэгтэй. Ангижралд хүрсэн хүний *сва-дхарма* буюу оноогдсон үүрэг нь бурханлаг болох бөгөөд энэ нь амьдралын тухай материаллаг бие махбодийн үзэл бодлын хүрээний чанадад гарсан байдаг. Амьдралын материаллаг бие махбодийн үзэл бодлын түвшинд оршин байгаа *брахмана* болон *киатрия* нарт тус бүрт нь оноогдсон тодорхой үүргүүд байдаг ба тэдгээрийг заавал биелүүлэх ёстой. *Сва-дхарма* Бурхан тогтоон өгсөн байдаг ба энэ талаар дөрвөн дүгээр бүлэгт тодорхой тайлбарлана. Материаллаг бие махбодийн түвшинд, *сва-дхарма*г *варнаширама-дхарма*, бурханлаг танин мэдэхүйд хүрэх үсрэлтийн тавцан гэж нэрлэдэг. Хүн төрөлхтний соёл иргэншил нь *варнаширама-дхармын* буюу тухайн бие махбодид

нөлөөллөө үзүүлж буй мөн чанарын гунуудаар тодорхойлогдох тодорхой үүргүүдийг биелүүлэх шатнаас эхэлдэг. Хүн үйл ажиллагааны ямар нэгэн салбарт өөрийн оноогдсон үүргээ илүү дээд эх сурвалжийн сургаал зааврын дагуу биелүүлж байх аваас энэ нь түүнийг амьдралын илүү дээд шатанд дээшлэн хүрэхэд туслана.

ШҮҮЛЭГ 32

*ядричхая чопаннам сварга-дварам апавритам
сукхинах киатриях партха лабханте юддхам идришам*

ядричхая- өөрт нь хамаагүй, *ча*- мөн, *улапаннам*- ирсэн, *сварга*- тэнгэрийн гаригуудын, *дварам*- үүд хаалга, *апавритам*- бүтэн нээлттэй, *сукхинах*- маш их аз жаргалтай, *киатриях*- хааны гэр бүлийн гишүүд, *партха*- Притхийн хүү минь, *лабханте*- хүрэх, *юддхам*- дайн, *идришам*- үүн шиг.

Ай Партха минь ээ, санаандгүй байж байхад нь тулалдах ийм боломж орж ирэх нь кшатрияг аз жаргалаар бялхуулдаг. Учир нь ингэснээр түүнд дээд гаригуудад хүрэх үүд хаалга нээгддэг билээ.

ТАЙЛБАР: Энэ ертөнцийн дээдийн дээд багш болохын хувьд Шри Кришна, “Би энэ тулалдаанаас сайн сайхан зүйл огтхон ч олж харахгүй байна. Тамын оронд мөнхөд байх тийм үр дагавар л дагуулах байхдаа.” хэмээн илэрхийлж байгаа Аржунагийн байр байдлыг буруушааж байна. Аржунагийн ийнхүү өгүүлэх нь түүний харанхуй мунхаг байдлаас болж байгаа хэрэг. Тэр өөрт оноогдсон үүргээ биелүүлэхдээ хүч хэрэглэхийг хүсэхгүй байна. Тулалдааны талбар дээр ирчихсэн мөртөө хүч үл хэрэглэх тухай ярина гэдэг бол зөвхөн тэнэгүүдийн гүн ухаан. Вьясадевагийн эцэг аугаа их мэргэн Парашарын бүтээсэн Парашара-смритид буюу шашин номын хуулинд:

*киатрио хи пражса ракиан шастра-паних прадандаян
ниржитья пара-сайньяди киштим дхармена палает*

“*Киатрийн* үүрэг нь албат иргэдээ тохиолдох бүхий л хүндрэл бэрхшээлээс хамгаалах явдал бөгөөд иймээс хууль журмыг сахин хамгаалах үүднээс зарим тохиолдолд хүч хэрэглэх хэрэгтэй. Иймд тэр газар дэлхийг шашин номын зарчмуудын дагуу залан захирахын тулд дайсагнагч хаадын цэргийн хүчийг ялан дийлэх үүрэгтэй байдаг.” гэж өгүүлсэн байдаг.

Энэ бүх үзэл бодлуудын үүднээс үзэхэд Аржунагийн хувьд тулалдахаас зайлсхийх ямар ч шалтгаан байхгүй байна. Хэрвээ тэр дайснаа дарчихвал улс гүрнээ эргүүлэн авч жаргал цэнгэлээ эдлэх болно. Харин тэр тулалдаанд амь эрсдэх аваас түүний хувьд хаалга үүд нь бүрэн нээлттэй байгаа тэнгэрийн гаригуудад дээшлэн очих болно. Тулалдах нь түүний хувьд аль ч тохиолдолд ач тустай байна.

ШҮҮЛЭГ 33

*атха чет твам имам дхармьям санграмам на каришьяси
татах сва-дхармам киртим ча хитва напам авасьяси*

атха- иймээс, *чет*- хэрвээ, *твам*- чи, *имам*- үүнийг, *дхармьям*- шашны үүрэг, *санграмам*- тэмцэл тулаан, *на*- үгүй, *каришьяси*- биелүүлэх, *татах*- тэгсэн цагт, *сва-дхармам*- чиний шашны үүрэг, *киртим*- алдар хүнд, *ча*- мөн, *хитва*- алдсанаар, *напам*- нүгэлт үр дагавар, *авасьяси*- хүлээн авна.

Хэрвээ чи шашин номын өөрт оноогдсон тулалдах үүргээ үл биелүүлэх аваас өөрт оноогдсон үүргийг эс тоомсорлосны нүглийг үүрэхийн зэрэгцээ дайчин эрийн алдар хүндээ алдах болно.

ТАЙЛБАР: Аржуна бол алдар цуутай дайчин эр байсан бөгөөд хүчирхэг олон сахиулсан тэнгэрүүдтэй, түүний дотор Шиватай хүртэл тулалдан асар их нэр хүндийг олсон байв. Тэрээр анчин маягаар хувцасласан Шиватай тулалдан дийлснээр түүний хүндэтгэлийг хүлээж *нашуната-астра* гэдэг зэвсгийг хөхүйлэл болгон авч байжээ. Түүнийг аугаа их баатарлаг дайчин эр гэдгийг хэн бүхэн мэддэг байв. Тэр ч бүү хэл, Дроначарья түүнд адислалаа хүртээж, багшийгаа хүртэл хөнөөж болох тийм онцгой зэвсгээ бэлэглэсэн билээ. Ийнхүү Аржуна маш олон аугаа нэр хүндтэй бодьгалуудаас, түүний дотор өөрийн төрсөн эцэг болох тэнгэрийн хаан Индра сахиулсан тэнгэрээс хүртэл цэргийн олон олон шагналуудыг хүртэж байжээ. Харин одоо тулалдааны талбарыг орхин одох аваас тэрээр *киатрия* хүний хувьд өөрт оноогдсон үүргээ үл ойшоон, эс тоомсорлосон хэрэг болохоор барахгүй, өөрийн бүхий л алдар цуу, нэр хүндээ алдан, тамд унах шууд замаа засаж бэлтгэсэн хэрэг болно. Өөрөөр хэлбэл, тэр тулалдсанаасаа болж биш, харин тулалдаанаас зайлж одсоноороо л тамд унах болно.

ШҮҮЛЭГ 34

*акиртим чапи бхутани катхайишьянти те `вьяям
самбхавитасья чакиртир маранат атиричьяте*

акиртим- гутамшиг, *ча*- мөн, *апи*- түүнээс гадна, *бхутани*- бүх хүмүүс, *катхайишьянти*- ярих болно, *те*- чиний тухай, *авьяям*- байнгад, *самбхавитасья*- эрхэм хүндэт хүний хувьд, *ча*- мөн, *акиртир*- гутамшиг, *маранат*- үхлээс, *атиричьяте*- илүү болно.

Хүмүүс чиний гутамшигт байдлын тухай цаг үргэлж ярьцгаах болно. Эрхэм хүндэтгэл хүлээсэн хүний хувьд алдар нэрээ гутаана гэдэг үхэхээс ч доор байдаг билээ.

ТАЙЛБАР: Шри Кришна зөвхөн Аржунагийн найз нөхөр төдийгүй мөн гүн ухаантан болохын хувьд түүний тулалдахаас татгалзаж байгаа талаар Өөрийн шийдвэрлэх айлдвараа айлдаж байна. Бурхан айлдахдаа: “Аржуна, хэрвээ чи байлдааны

талбарыг бүр тулалдаан эхлэхээс ч өмнө орхин зайлах аваас хүмүүс чамайг аймхай хулчгар гэж нэрлэх болно. Харин чи, хүмүүс чиний тухай юу гэж хэлэх нь хамаагүй, гагцхүү амиа аврахын тулд тулалдааны талбараас зугатах нь зөв гэж бодож байгаа бол Би чамд, тулалдаанд амь эрсдэх нь илүү дээр гэдгийг зөвлөх байна. Чам шиг ийм эрхэм хүндэтгэл хүлээсэн хүний хувьд гутамшиг гэдэг бол үхэхээс ч долоон дор. Иймээс чи өөрийн амьдралын төлөө айж зугатааж байснаас тулалдаж байгаад амь эрсдэх нь дээр. Ингэх нь чамайг, Миний найз нөхрийн холбоо харьцааг хортойгоор, зүй бусаар ашигласан гэдэг гутамшигт хүргэхээс хамгаалахаас гадна чи нийгмийн дундах нэр хүндээ алдахгүй.”

Аржунагийн талаарх Бурханы дээдийн дээд айлдвар бол тэр ийнхүү ухран зайлахын оронд тулалдаанд амь эрсдэх явдал.

ШҮҮЛЭГ 35

*бхаяд ранад упаратам мамсьянте твам маха-ратхах
ешам ча твам баху-мато бхутва ясьяси лагхавам*

бхаят- айснаас, *ранат*- тулалдааны талбараас, *упаратам*- орхих, *мамсьянте*- тэд бодох болно, *твам*- чи, *маха-ратхах*- аугаа жанжингууд, *ешам*- тэдний хувьд, *ча*- мөн, *твам*- чи, *баху-матах*- ихэд хүндэтгэлтэйгээр, *бхутва*- байдаг, *ясьяси*- чи явах болно, *лагхавам*- үнэ цэнээ алдсан.

Чиний нэр, алдрыг өндрөөр хүндэлж явдаг цэргийн аугаа жанжууд чамайг тулалдааны талбарыг зөвхөн айж сүрдсэнээсээ л болж орхин одлоо гэж бодон чамайг өчүүхэн амьтан хэмээн үзэх болно

ТАЙЛБАР: Шри Кришна Өөрийн тааллыг энд Аржунад үргэлжлүүлэн тайлбарлаж байна: Дурьодхана, Карна болон бусад аугаа их жанжууд чамайг өөрийн ах дүүс, өвөг эцгээ энэрч өрөвдсөнөөс болж тулалдааны талбарыг орхилоо хэмээн бодно гэж бүү сана. Тэд чамайг өөрийн амьдрал, амь насны төлөө айснаас л болж зугатаж одлоо гэж бодон чамайг эрхэмлэн хүндэтгэж явдгаа шууд болино.

ШҮҮЛЭГ 36

*авачья-вадами ча бахун вадишьянти тавахитах
ниндантас тава самартхьям тато духкхатарам ну ким*

авачья- таатай бус, *вадан*- бодож олсон үгүүд, *ча*- мөн, *бахун*- олон, их, *вадишьянти*- хэлэх болно, *тава*- чиний, *авитах*- дайснууд, *ниндантах*- чамайг шоолох үедээ, *тава*- чиний, *самартхьям*- чадварыг, *татах*- энэнээс, *духкха-тарам*- илүү хүндээр, *ну*- мэдээж хэрэг, *ким*- тэнд байснаас.

Дайснууд чинь чиний талаар муугаар хэлэхийн зэргэцээ чиний чадварыг элэглэн шоолох болно. Чиний хувьд үүнээс илүү гутамшигтай зүйл гэж байх уу?

ТАЙЛБАР: Эхэндээ Шри Кришна өөрийн зовж шаналж байгаа талаараа хэлсэн Аржунагийн зохимжгүй үгэнд гайхаж байсан бөгөөд Тэрээр иймэрхүү маягаар өрөвдөж энэрэх нь *ария-чуудад* зохихгүй гэдгийг айлдсан билээ. Шри Кришна өрөвдөж энэрсэнээсээ шаналан зовж байна гэх Аржунагийн байдлыг сайшаахгүй байна гэдгээ ийнхүү дэлгэрэнгүйгээр тайлбарлаж байна.

ШҮҮЛЭГ 37

*хато ва прасьяси сваргам житва ва бхокишьясе махим
тасмад уттишхта каунтея юддхая крита-нишчаях*

хатах- хөнөөлгөснөөр, *ва*- нэг бол, *прасьяси*- чи хүрнэ, *сваргам*- тэнгэрийн оронд, *житва*- ялснаар, *ва*- эсвэл, *бхокишьясе*- чи жарган цэнгэнэ, *махим*- дэлхий, *тасмат*- иймээс, *уттишхта*- дээшээ бос, *каунтея*- Кунтийн хүү минь, *юддхая*- тэмцэн тулалдахаар, *крита*- шийдэмгий, *нишчаях*- бат итгэлтэйгээр.

Ай Кунтийн хүү минь ээ, нэг бол чи тулалдааны талбарт амь эрсдэн тэнгэрийн гаригуудад дээшлэн очих, эсвэл ялалт байгуулан энэ газар дэлхийн улс гүрнээрээ цэнгэн жаргах болно. Иймээс дээшээ босож тэмцэл тулаандаа шийдвэртэйгээр ор.

ТАЙЛБАР: Аржунагийн тал ялах нь баталгаатай биш хэдий ч тэрээр тулалдах л хэрэгтэй байсан. Амь эрсдлээ гэхэд тэр тэнгэрийн гаригуудад дээшлэн хүрч очих болно.

ШҮҮЛЭГ 38

*сукха-духкхе саме критва лабхалабхау жаяжяяу
тато юддхая южьясва найвам папам авасьяси*

сукха- аз жаргал, *духкхе*- болон зовлон шаналал, *саме*- үл ажран, *критва*- ийн үйлдсэнээр, *лабха-алабхау*- гарз хохиролтой ч тэр мөн ашиг хожоотой ч тэр, *жая-ажаяу*- ялсан ч тэр мөн ялагдсан ч тэр, *татах*- энэ үеэс, *юддхая*- тулалдах ёстой гэдэг үүднээс, *южьясва*- тулалд, *на*- хэзээ ч үгүй, *эвам*- ингэснээр, *папам*- нүгэлт үр дагаврыг, *авасьяси*- авах болно.

Баяр хөөр, уйтгар гуниг, ялалт ялагдлыг үл хайхран тулалдах ёстой гэдэг үүднээс тулалд. Ийнхүү үйлдэх аваас чи өөртөө хэзээ ч нүгэл хураахгүй.

ТАЙЛБАР: Энэ тулалдаан нь Шри Кришнагийн тааллаар болж байгаа учраас Тэр Аржунад тулалдах ёстой гэдэг үүднээс тулалдах хэрэгтэй гэж шууд айлдаж байна. Кришнагийн ухамсарт үйлээ үйлдэх хүн нь баяр хөөр, уйтгар гуниг, ашиг алдагдал болон ялалт ялагдалд ч анхаарал хандуулдаггүй. Трансценденталь ухамсар гэдэг нь бүхнийг Шри Кришнагийн төлөө хийхийг хэлдэг. Ийнхүү үйлдэгдсэн материаллаг үйл нь ямар ч үр дагавар дагуулдаггүй. Өөрийнхөө мэдрэхүүд таашаал ханамж эдлүүлэхийн төлөө үйл үйлдэгч нь цэвэр ариуны болон хүсэл тачаалын гунауудын алинд ч байсан үйлийнхээ үр дагаврыг сайн ч бай муу ч бай ялгаагүй эрт орой хэзээ нэгэн цагт амсаж эдлэх л болно. Кришнагийн ухамсарын үйлэнд өөрийгөө бүрнээ зориулсан хүний, жирийн байдлаар ажил үйлээ хийж байгаа хүмүүсээс ялгарах онцлог нь тэрээр цаашид хэний ч өмнө үүрэг хүлээдэггүй болон хэний ч өмнө гэм буруутай болдоггүйд оршдог. Шримад Бхагаватамын (11.5.41)-д өгүүлэхдээ:

*девариши-бхутанта-принам питринам
на кинкаро наям рини ча ражан
сарватмана ях шаранам шараньям
гато мукундам парихритья картам*

“Кришна, Мукундад өөрийгөө бүрнээ зориулан бусад бүх үүргээ орхисон хэн бүхэн цаашдаа хэний ч өмнө- сахиулсан тэнгэрийн ч, цэцэд мэргэдийн ч ард түмний ч, төрөл төрөгсдийнхөө ч, хүн төрөлхтний ч, өвөг дээдсийнхээ ч өмнө- үүрэг хүлээдэггүйн зэрэгцээ хэний ч өмнө буруутан болдоггүй.” Энэ бол Шри Кришнагийн Аржунад шууд бус байдлаар өгч буй заавар зөвлөгөө билээ. Дараа дараагийн шүлгүүдэд энэ тухай бүр дэлгэрэнгүй тайлбарлана.

ШҮЛЭГ 39

*эша те `бхихита санкхе буддхир йоге тв имам шрину
буддхья юкто яя партха карма-бандхам прахасьяси*

эша- энэ бүхнийг, *те*- чамд, *абхихита*- тодорхойлсон, *санкхе*- задлан шинжлэлээр, *буддхих*- оюун ухаан, *йоге*- үр дагавар үл дагуулах үйлд, *ту*- харин, *имам*- үүнийг, *шрину*- зүгээр л сонс, *буддхья*- оюун ухаанаар, *юктах*- зохицуулж тааруулсан, *яя*- түүгээр, *партха*- Притхын хүү минь, *карма-бандхам*- үр дагаврын уяа хүлээнээс, *прахасьяси*- чи ангижран чөлөөлөгдөх болно.

Энэ хүртэл Би чамд энэхүү мэдлэгийг задлан шинжлэх аргаар тайлбарлалаа. Харин одоо, ямар ч үр дагавар үл дагуулах үйлийг үйлдэх замаар энэ мэдлэгт хэрхэн хүрдэгийг сонс. Ай Притхын хүү минь ээ, ийм мэдлэг ухааныг хүртэн түүний дагуу үйлээ үйлдэх аваас чи өөрийн үйлийн үр дагаврын уяа хүлээнээс ангижран салж чадах болно.

ТАЙЛБАР: Ведийн толь бичиг Нируктид өгүүлснээр *санкхья* гэдэг үг нь аливаа зүйлийг нэг бүрчлэн тодорхойлох тэр зүйл гэсэн утгыг агуулдаг бөгөөд *санкхья* нь сүнсний жинхэнэ мөн чанарын тухай өгүүлэх гүн ухаанд хамааралтай юм. *Йога* гэсэн ойлголтонд мэдрэхүйгээ эзэмдэн захирахуй мөн хамаарагддаг. Аржунагийн тулалдаанд оролцохгүй гэх шийдвэр нь өөрийн мэдрэхүйн таашаалыг хангах гэсэн түүний хүсэл эрмэлзлээс шалтгаалсан хэрэг. Аржуна Дхритараштрын хөвгүүд болох үезлүүдээ хөнөөн улс гүрнээ буцаан авснаас гэр бүлийнхэн болон төрөл төрөгсдөө амьд үлдээх нь илүү их аз жаргалыг авчрах болно хэмээн бодсон учраас өөрийн эн тэргүүнд тавих үүргээ умарган тулалдахгүй байхыг хүсэж байна. Аль ч тохиолдол нь байлаа гэсэн тэрээр өөрийн хувийн таашаал ханамж, санаа бодлоо гүйцэлдүүлэх гэсэн хүсэлдээ хөтлөгдсөн хэрэг. Төрөл төрөгсөдтэйгөө тулалдан тэднийг хөнөөснөөр эсвэл тэднийг амьд мэнд байлгаснаараа аз жаргалтай байж чадах эсэх тухайн Аржунагийн төсөөлөл нь түүний хувийн сонирхолд тулгуурлаж байна. Үүнийхээ төлөө тэр өөрийн цэцэн мэргэн байдал болон үүргээ золиослоход ч бэлэн байгаа түүний хувийн сонирхолд тулгуурлаж байна. Ийм учраас л Шри Кришна, тэр өвөг эцгийнхээ бие махбодийг хөнөөсөн ч түүний сүнснийг устгахгүй юм гэдгийг Аржунад тайлбарлахыг хүссэн бөгөөд Тэрээр түүнд Өөрийг нь оролцуулах бүхий л бие даасан бодьгалууд нь мөнхөд бие даан оршдог гэдгийг тодорхой болгож байна. Бид бүгдээрээ бие даасан сүнсүүд бөгөөд зөвхөн өөрсдийн бие махбодин өмсгөлөө л янз бүрийн байдлаар сольж байдаг учраас тэд бүгдээрээ өнгөрсөн үед ч бие даан оршоор байсан, одоо үед ч бие даан оршоор байна мөн ирээдүйд ч бие даасан оршнолоо хадгалсаар байх болно. Материаллаг өмсгөл бүрхүүлийн уяа хүлээнээс ангижирсаны дараа ч бид өөрсдийн бие даасан байдлыг хэвээр хадгалсаар байх болно. Шри Кришна, бие махбодийн болон сүнсний мөн чанарын талаар урьд өмнө задлан шинжлэх арга замаар дэлгэрэнгүй тайлбарласан. Сүнс болон бие махбодийг олон талаас нь өгүүлсэн энэхүү мэдлэгийг энд Нирукти толь бичигт тодорхойлсон утгаар *санкхья* гэж нэрлэж байна. Энэхүү *санкхья* нь атейст үзэлт Капилагийн *санкхья* философитой ямар ч хамаарал холбоогүй. Хууран мэхлэгч Капилаг өөрийн *санкхья* философийн онолыг дэвшүүлэхээс бүр эрт өмнө Шримад Бхагаватамд тодорхойлон өгүүлсэнчлэн, *санкхья* философийг Шри Кришнагийн хувилгаан дүр болох жинхэнэ Капила нь Өөрийн эх Девахутид тайлбарласан билээ. Энэ Капила Бурхан нь *пуруша* буюу Бүхний Дээд Бурхан бол идэвхитэй байдаг бөгөөд Тэрээр *пракрити* тийш харцаа илгээх төдийд л материаллаг ертөнцийг бүтээн бий болгодог гэж тодорхой тайлбарласан. Ведэд болон Гитад энэхүү баримтыг хүлээн зөвшөөрдөг. Ведэд тодорхойлон өгүүлснээр бол Бурхан материаллаг мөн чанар буюу *пракрити* тийш хармагц түүнд өчүүхэн жижиг бие даасан сүнсүүд орж үр тогтдог. Энэ бүх бие даан орших сүнсүүд нь материаллаг ертөнцөд өөрсдийн мэдрэхүйн таашаалыг хангах үйлтэй зууралдан байдаг бөгөөд материаллаг эрчимд илбэдүүлснээр тэд өөрсдийгөө цэнгэн жаргагч гэж бодоцгоодог. Ухаан бодлын иймэрхүү байдлын дээд цэг нь ангижралд хүрэх гэсэн тэдний хүсэл буюу Дээдний Дээдтэй нэг болох гэсэн хүсэлд л илрэлээ олдог. Энэ нь *майя* буюу мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн хий хуурмагийн сүүлчийн урхи болох бөгөөд амьд оршилоо иймэрхүү мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийг эрмэлзэн олон олон амьдралыг туулж өнгөрүүлсний дараа өөрийгөө аугаа сүнс Васудева, Кришнад даатгаснаар л дээдийн дээд Үнэнийг хайсан түүний эрэл төгсгөлөө олно.

Аржуна өөрийгөө Кришнад бүрэн даатгаснаараа Түүнийг номын багшаа болгон шавь орж байна: *шишьяс те `хам шадхи мам твам прапаннам*. Ингэснээр Шри Кришна түүнд *буддхи-йога* буюу *карма-йогын* үйлийн талаар, өөрөөр хэлбэл, Бурханы таалалд нийцүүлэхийн тулд Түүнд чин бишрэлээр хэрхэн зүтгэх талаар номлох болно. Арав дугаар бүлгийн арав дугаар шүлэгт өгүүлснээр *буддхи-йога* гэж өөрийн зүрхнээ Параматма байдлаар залрах Бурхантай шууд холбогдохыг хэлдэг. Энэхүү холбоо харьцаа нь чин бишрэлийн зүтгэлгүйгээр хэзээ ч биелээ олохгүй. Бурханы чин бишрэл дүүрэн, трансценденталь хайрын албанд буюу өөрөөр хэлбэл Кришнагийн ухамсарт автан байгаа хэн бүхэн Бурханы онцгой өршөөл

соёрхлоор *буддхи-йогийн* энэхүү түвшинд хүрдэг. Иймээс Бурханы чин бишрэлийн албанд трансценденталь хайрын улмаас байнгад зүтгэн байгаа хүнд л хайрын чин бишрэлийн цэвэр ариун мэдлэгийг Тэр бэлэг болгон хүртээдэг гэж айлдаж байна. Чин бишрэлтэн нь ийм байдлаар л Өөрийн мөнхийн цэнгэл жаргалаар дүүрэн бялхах орондоо залран байгаа Бурханд амархан хүрдэг болно.

Энэхүү шүлэгт дурьдагдаж байгаа *буддхи-йога* нь иймд Бурханы чин бишрэлийн алба үйлтэй холбоотой бөгөөд мөн энд яригдсан *санкхья* нь хууран мэхлэгч Капилагийн гаргасан атейст *санкхья-йога-той* ямар ч хамаагүй юм. Иймээс энд дурьдагдаж байгаа *санкхья-йогыг* ямар ч нөхцөл байдалд байсан атейст *санкхья-тай* андуурч, хольж хутгах ёсгүй. Энэ дашрамд өгүүлэхэд, Курукшетрын тулалдаан болсон тухайн цаг үед энэхүү атейст философи нь ямар ч нөлөөлөлгүй байсан ба Шри Кришна ч иймэрхүү бурхангүйн үзэлтэй философийн цэцэрхийллийг дурьдах оролдлого хийгээгүй юм. Жинхэнэ *санкхья*-философийг Шри Капила Шримад Бхагаватамд тодорхойлон өгүүлсэн байдаг бөгөөд энэхүү *санкхья* нь ч бидний энд авч үзэж буй сэдэвтэй холбоогүй. Энэ шүлэгт *санкхья* нь бие махбодь болон сүнсийг задлан шинжлэх замаар тодорхойлон өгүүлэхийг л хэлж байна. Зөвхөн Аржунаг *буддхи-йогын* буюу *бхакти-йогын* түвшинд хүргэхийн тулд л Шри Кришна сүнсийн задлан шинжилсэн тодорхойлолтыг өгч байна. Энэ утгаараа Шри Кришнагийн *санкхья* болон Шримад Бхагаватамд өгүүлдэг Шри Капилагийн *санкхья* нь нэг зүйлийг л илэрхийлдэг. Аль аль нь *бхакти-йога*. Энэ учраас л Шри Кришна зөвхөн оюунлаг бус хүмүүс л *санкхья-йога* *бхакти-йога* хоёр ялгаатай хэмээн үздэг гэж айлдсан: *санкхья-йогау притхга балах праваданти на пандитах.*

Мэдээж хэрэг атейст *санкхья-йога* нь *бхакти-йогатай* ямар ч хамаагүй, гэхдээ иймэрхүү мулгуу тэнэг хүмүүс нь Бхагавад Гитад чухамхүү энэ атейст *санкхья-йогын* тухай л өгүүлдэг хэмээн батлахыг оролддог.

Иймээс *буддхи-йогаг* Бурханы чин бишрэл дүүрэн албаны мэдлэг болон цэнгэл жаргал бялхан байх, Кришнагийн ухамсар дахь үйл ажиллагаа юм гэж ойлгох хэрэгтэй. Гагцхүү Бурханы таалалд нийцүүлэхийн тулд чармайн байгаа хэн бүхэн ажил үйл нь хичнээн хүнд байсан ч үл ажран *буддхи-йогын* зарчмуудын дагуу хийж үйлддэг ба бурханлаг цэнгэл жаргалын далайд үргэлж умбаж байдаг. Ийм трансценденталь үйлэнд зүтгэснээр хүн Бурханы өршөөл нигүүлслийн ачаар бүхий л трансценденталь мэдлэгийг аяндаа хөгжүүлдэг ба мэдлэг ухаан хүртэх гэж онцгой их хүчин чармайлт гаргалгүйгээр бүрэн төгс ангижралд хүрдэг. Кришнагийн ухамсар дахь үйл болон үр дагавар дагуулах ажил үйл буюу гэр бүлийн хийгээд материаллаг аз жаргалын хэлбэрт байх мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн төлөө үйлдэж буй ажил үйлийн хооронд маш том ялгаа байдаг. Иймд *буддхи-йога* нь бидний үйлдэж байх ёстой трансценденталь үйл юм.

ШҮҮЛЭГ 40

*нехабхикрама –нашо `сти пратьявайо на видьяте
св-аллам апи асья дхармасья траяте махато бхаят*

на- байдаггүй, *иха-* энэ иогт, *абхикрама-* тэмүүлэлд, *нашах-* гарз хохирол, *асти-* байдаг, *пратьяваях-* доройтол бууралт, *на-* хэзээ ч үгүй, *видьяте-* байдаг, *су-аллам-* бага зэрэг, *апи-* хэдий ч, *асья-* үүнээс, *дхармасья-* үйл, *траяте-* ангижирдаг, *махатах-* маш ихээс, *бхаят-* аюул.

Энэхүү зам мөрөөр замнагчид ямар ч гарз, хохирол гардаггүй бөгөөд харин ч энэ зам мөр дээр гаргасан өчүүхэн бага хөгжил дэвшил нь хүнийг хамгийн том аюул заналаас хамгаалж байдаг.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсарт зүтгэх буюу өөрөөр хэлбэл, өөрөө мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийг хүсэн хүлээлгүйгээр дан ганц Кришнагийн тааллын дагуу үйлдэх үйл нь трансценденталь үйлийн дээдийн дээд төрөл юм. Энэхүү зам мөрөөр замнаж эхлэхэд ямар ч саад тогтвор байхгүй бөгөөд эхлэлийн үеийн бага зэргийн хичээл чармайлт ч гэсэн ямар ч түвшинд алдагдан үгүй болдоггүй. Материаллаг түвшинд эхлэсэн аливаа ажил бүрийг бүрмөсөн дуусгахгүй л бол түүний төлөө гаргасан бүхий л хүчин чармайлт ямар ч хэрэгцээгүй болдог. Харин Кришнагийн ухамсарт эхэлсэн үйл төгсгөлийн шатандаа ороогүй байсан ч байнгад эерэг нөлөө үйлчлэл үзүүлж байдаг. Кришнагийн ухамсарт аливаа үйлийг бүрэн төгс дуусгаж чадаагүй байлаа ч уг үйлийг үйлдэгч нь ямар ч алдагдал хохиролд ордоггүй. Хүн бүхий л үйлийнхээ зөвхөн нэг хувийг Кришнагийн ухамсарт зориулсан байсан ч түүний үр дагавар нь үгүй бололгүйгээр дараа эхлэхэд хоёр дахь хувиас буюу энэ хүрсэн түвшингээсээ цааш үргэлжлүүлэн хийх боломжийг өгдөг байхад аливаа материаллаг үйлийг зуун хувь, амжилттай хийж дуусгахгүй л бол ямар ч ашиг тус өгдөггүй. Жишээлбэл Ажамила нь Кришнагийн ухамсарт өөрийн үүргийг зөвхөн их биш хувиар биелүүлсэн байсан ч хожим нь Бурханы өршөөл нигүүлслээр зуун хувийн амжилтанд хүрсэн билээ. Энэ талаар Шримад Бхагаватамын (1.5.17)-д нэгэн гайхамшигтай сайхан шүлэг байдаг:

*тъякта сва-дхармам чаранамбхужам харер
бхажани апакво `тха патет тато яди
ятра ква вабхадрам абхуд амушья ким
ко вартха апто `бхажатам сва-дхарматах*

“Өөрийгөө Кришнагийн ухамсарт бүрнээ зориулахын тулд нийгмийн үүргээ орхисон хүн энэ зам мөрийнхөө төгсгөлд нь хүртэл замнаж чадалгүй уналтанд өртсөн ч юугаа алдаж гээх юм бэ? Нөгөө талаас, хүн материаллаг үйл ажиллагаагаа бүрэн төгс байдлаар хийж гүйцэтгэж байлаа ч юу хожих билээ дээ?” Эсвэл Христэд итгэгчдийн ярьдагчлан: “Өөрийн мөнхийн сүнсэндээ хор хохирол учруулах юм бол бүх дэлхийг эзэгнээд ч ямар ач тус гарах билээ?”

Материаллаг үйл хийгээд түүний үр дүн нь бие махбодтой хамт эцэс болдог. Харин Кришнагийн ухамсарт үйлдсэн үйл нь хүнийг одоогийн бие махбодио орхисны дараа ч Кришнагийн ухамсарт дахин авчирна. Дор хаяж түүнд дараагийн амьдралдаа хүн болон нэг бол мэдлэг ухаанд маш ихээр боловсорсон *брахманы* гэр бүлд, үгүй бол баян язгууртны гэр бүлд төрөх боломж олгодог учир түүний бурханлаг төгс төгөлдөрт дээшлэн хүрэх цаашдын нөхцлийг бүрдүүлж өгдөг. Кришнагийн ухамсарт үйлдсэн аливаа үйл нь ийм хосгүй шинж чанартай.

ШҮҮЛЭГ 41

вьавасаятмика буддхир эхека куру-нандана

баху-шакха хй ананташ ча буддхайо `вьявасайнама

вьявасая-атмика- Кришнагийн ухамсарт шийдвэртэй, *буддхих-* оюун ухаан, *эка-* зөвхөн ганц, *иха-* энэ ертөнцөд, *куру-нандана-* Куругийн хайртай хүү минь, *баху-шаксах-* олон салаа байдаг, *хи-* үнэн хэрэгтээ, *анантах-* хязгааргүй, *ча-* мөн, *буддхаях-* оюун ухаан, *авьявасайнама-* Кришнаг ухамсарлаагүй хэн нэгний.

Энэ зам мөрөөр замнах хүн өөрийн санаа бодолдоо эрс шийдвэртэй байдаг бөгөөд тэр зөвхөн ганц зорилгын төлөө явдаг. Ай Куручуудын хайртай хүү минь ээ, шийдмэг бус байгчийн оюун ухаан нь олон салаа байдаг юм.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсрын зам мөрөөр замнаснаар амьдралын дээдийн дээд төгс төгөлдөрт хүрнэ гэсэн хатуу итгэлийг *вьявасаятмика-*оюун ухаан гэж нэрлэдэг. Чайтанья-чаритамритагийн (Мадхья, 22.62)-д өгүүлсэнчлэн:

*`шраддха`-шабде-вишваса кахе судридха нишчая
кришине бхакти кайле сарва-карма крита хая*

Итгэл бишрэлтэй байна гэж ямар нэгэн эрхэм дээд зүйлд хэлбэрэлт гуйвалтгүйгээр найдахыг хэлдэг. Кришнагийн ухамсарт үүргээ биелүүлж байгаа хэн бүхэн материаллаг ертөнцөд гэр бүл, улс үндэстэн болон хүн төрөлхтөнд хамааралтай бүх үүргээ биелүүлэхийн хойноос явах хэрэггүй болдог. Үр дагавар авчирдаг аливаа үйл нь бидний өнгөрсөн цаг үеийн сайн болон муу үр дагавруудаас урган гардаг үйл юм. Гэхдээ Кришнагийн ухамсар нь сэрсэн хүн, цаашид өөрийн үйлээрээ сайн үр дагаварт хүрэхийг ч эрмэлзэх хэрэггүй болдог. Кришнагийн ухамсарт оршин байх хүн сайн хийгээд муу гэх мэтийн хоёрдмол байдлын эрхшээлээс гарсан байдаг учир түүний үйлдэх аливаа үйл бүр нь үнэмлэхүй түвшинд үйлдэгдэж байдаг. Кришнагийн ухамсарын дээдийн дээд төгс төгөлдөр бол материаллаг амьдралын үзэл бодлоос огоорохуй юм. Кришнагийн ухамсарыг өөртөө хөгжүүлэн ахиц дэвшил гаргаж байгаа хүн энэ түвшинд аяндаа хүрдэг.

Кришнагийн ухамсарт орших хүний хэлбэрэлт гуйвалтгүй шийдвэр төгс байдал нь мэдлэгт тулгуурласан байдаг. *Васудевах сарвама ити са махатма судурлабхах-* Кришнаг ухамсарласан хийгээд Васудева, Кришна бол илэрч тодорсон бүх учир шалтгаануудын үндэс гэдгийг бүрэн төгс ухаарсан хүн нь маш ховор, аугаа сүнс юм. Модны үндсийг усалснаар л түүний бүхий л мөчир, навчсыг ундаалдагтай адил Кришнагийн ухамсарт үйл үйлдэх хэн бүхэн өөртөө ч, гэр бүлдээ ч, нийгэмдээ ч, улс орондоо ч, хүн төрөлхтөнд ч болон бусад бүгдэд дээдийн дээд ач тусыг хүргэж байдаг. Бидний үйл Кришнагийн таалалд нийцэх аваас бид бүхэн бүгдээрээ ханамжтай болох болно.

Кришнагийн ухамсар дахь албанд Кришнагийн жинхэнэ төлөөлөгч бөгөөд өөрийн сурагчийн шинж чанарыг сайн мэдэх, түүний үйлийг Кришнагийн ухамсрын жинхэнэ зам мөрөөр чиглүүлэн залж чадах чадварлаг номын багшийн удирдлага доор зүтгэх нь хамгийн чухал. Иймээс Кришнагийн ухамсарт үнэхээр урагшлан дэвшихийн тулд эрс шийдвэртэй байхын зэрэгцээ Кришнагийн төлөөлөгчийн удирдлаганд байж үгийг нь дагах шаардлагатай. бөгөөд жинхэнэ номын багшийн сургаал зааврыг өөрийн амьдралын даалгавар, гол зорилго хэмээн үзэж биелүүлэх ёстой. Шрила Вишванатха Чакраварти Тхакура номын багшдаа хандсан алдарт залбирлаараа бидэнд дараахь сургаалыг хайрласан билээ:

*ясья прасадад бхагават-прасадо
ясья прасадан на гатих куто `пи
дхьяян стувамс тасья яшас три-сандхьям
ванде гурах ири- чаранаравиндам*

“Номын багш ханамжтай байх аваас Бурханы Дээд Бодгаль мөн ханамжтай байдаг. Номын багшийн таалалд үл нийцэх аваас бид Кришнагийн ухамсрын түвшинд дээшлэн хүрэх боломжгүй. Иймээс би өдөр бүр наад зах нь гурван удаа номын багшийнхаа тухай бясалгах болон надад өршөөл нийгүүлснээ хайрлах болтугай гэж залбирах ёстой билээ. Номын багш таны бадам лянхуа өлмийд сөгдөн мөргөж бишрэл хүндэтгэлээ илэрхийлье.”

Энэ бүх үйл явдал нь хүн бие махбодноос ангид орших сүнсний тухай төгс төгөлдөр мэдлэгийг, гэхдээ мэдрэхүүдээ таашаал ханамж эдлүүлэх зорилго бүхий аливаа үйлд төгсгөл тавих боломжийг олгодог зөвхөн онолын төдийгүй мөн практик мэдлэгийг агуулдаг эсэхээс хамаардаг. Ухаанаа үнэхээрийн батжуулан бэхжүүлж чадаагүй хэн бүхэн янз бүрийн үр дагавар дагуулах үйлүүдэд хөтлөгдөх болно.

ШҮҮЛЭГ 42-43

*ям имам пушпитам вачам праваданти авипаичитах
веда-вада-ратах партха наньяд астити вадинах
каматманах сварга-пара жанма-карма-пхала-прадам
крия-вишеша-бахулам бхогайшварья-гатим прати*

ям имам- энэ бүх, *пушпитам-* цэцэг мэт, *вачам-* үгүүд, *праваданти-* хэлэх, *авипаичитах-* мэдлэгээр хомс хүмүүс, *веда-вада-ратах-* Ведийг хуурмагаар дагагсад, *партха-* Притхын хүү минь, *на-* хэзээ ч үгүй, *аньят-* арай өөр, *асти-* байдаг, *ити-* энэ, *вадинах-* хамгаалагчид, *кама-* атманах- мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийг хүсэгч, *сварга-парах-* диваажингийн гаригуудад хүрэх зорилго агуулагч, *жанма-карма-пхала-прадам-* сайн төрөл олох болон бусад материаллаг эд баялагтай болох үр дагавар бүхий, *крия-вишеша-* сүртэй ёслол, *бахулам-* янз бүрийн төрлийн, *бхога-* мэдрэхүйн таашаал ханамж, *айшварья-* баялаг, *гатим-* хөгжил дэвшил, *прати-* хандлагатайгаар.

Мэдлэг хомс хүмүүс нь эрх мэдэл, сайн төрөл олж авах эсвэл тэнгэрийн гаригуудад төрөхийн тулд янз бүрийн кармын үйлүүд үйлдэхийг зөвлөсөн байдаг Ведийн цэцэг мэт үгнүүдэд маш ихээр татагддаг. Тэд мэдрэхүйн таашаал ханамж эдлэх хийгээд баян чинээлэг амьдрахын хойноос шунаж байдаг учир түүнээс илүү зүйл үгүй гэж ярьцгаадаг.

ТАЙЛБАР: Ихэнх хүмүүс тийм ч оюунлаг бус байдаг бөгөөд харанхуй мунхгийнхаа улмаас тэд Ведийн *карма-канда* гэж нэрлэгдэх хэсэгт зөвлөсөн байдаг үр дагавар дагуулах үйлүүдэд маш ихээр татагдаж байдаг. Тэд дарс, хүүхэн хийгээд

материаллаг баялаг хаа сайгүй элбэг дүүрэн байх тэнгэрийн гаригуудад хүрч очин мэдрэхүйн таашаал ханамж эдлэх боломжоос өөр юуг ч үл хүснэ. Энэ л зорилгод хүрэхийн тулд олон төрлийн тахилга өргөл, түүний дотор юуны өмнө *жьэотишотома* тахилга өргөлийг өргөхийг Ведэд зөвлөсөн байдаг. Тиймээ тэнд, тэнгэрийн гаригуудад хүрч очихыг хүсэж байгаа хэн бүхэн эдгээр тахилга өргөлүүдийг өргөх хэрэгтэй гэж байдаг ч мэдлэг хомс хүмүүс ведийн цэцэн мэргэн мэдлэг нь бүхэлдээ зөвхөн үүнд л зориулагдсан байдаг хэмээн итгэж байдаг. Иймэрхүү юм мэддэггүй хүмүүсийн хувьд Кришнагийн ухамсар дахь шийдвэр төгс үйлийг өөрийн болгоно гэдэг маш хүнд бэрх. Мөн тэнэг мангуу хүмүүс урган гарах үр дагаврыг нь төсөөлж ч чадахгүй байж хортой модны үр жимсэнд дурлан татагдахтай адилаар ахиц дэвшилд сайн хүрээгүй хүмүүс тэнгэрийн гаригуудын эд баялаг болон түүнтэй холбогдсон мэдрэхүйн таашаал ханамжинд хууртан мансуурч байдаг.

Ведийн *карма-канда* хэсэгт хэлсэн байдагчлан: *апама сомам амрита абхума* болон *акшайям ха вай чатурмасья-яжинах сукритам бхавати*. Өөрөөр хэлбэл, дөрвөн сарын турш тэвчил, наманчлал үйлдсэн хүн үхэшгүй мөнхийн амьдрал болон байнгын аз жаргалыг бэлэглэдэг *сома-раса* ундааг уух эрх авдаг. Энэ газар дэлхий дээр байхдаа хүртэл зарим хүмүүс эрүүл энх, хүч чадалтай байж мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн тулд *сома-раса* ундааг уухыг эрмэлзэж байдаг. Иймэрхүү хүмүүс материаллаг боолчлолын уяа хүлээнснээ ангижрах явдалд итгэдэггүй бөгөөд ведийн тахилга өргөл өргөх сүр бадруулсан ёслол үйлэнд маш ихээр татагддаг. Энэ хүмүүс ерөнхийдөө өөрсдийн мэдрэхүйн боол болсон байдаг бөгөөд амьдралдаа тэнгэрийн таагаал ханамжаас өөр юуг ч үл хүснэ. Тэнгэрийн гаригуудад сахиулсан тэнгэртэй адил үзэсгэлэнт бүсгүйчүүдтэй хамт зугаацан *сома-раса* дарс хангалттай ууж болох *нандана-канана* гэж нэрлэгдэх цэцэрлэгт хүрээлэнгүүд байдаг гэж өгүүлдэг. Бие махбодийн иймэрхүү таашаал ханамж эдлэх нь мэдээжийн хэрэг мэдрэхүйн шинжтэй. Иймээс тэнд “материаллаг ертөнцийн эзэн” байдлаар материаллаг цаг зуурын аз жаргалд бүрнээ автан татагдагсадтай л уулзалдах болно.

ШҮҮЛЭГ 44

*бхогайшварья-прасактанам таянахрита-четасам
вьавасаятмика буддхих самадхау на видияте*

бхога- материаллаг жаргал цэнгэлд, *айшварья-* болон эд баялагт, *прасактанам-* татагдагсадын хувьд, *тая-* иймэрхүү зүйлсээр, *апахрита-четасам-* ухаан нь төөрөлдөж самуурсан, *вьавасая-атмика-* бат шийдвэртэй, *буддхих-* Бурханд чин бишрэл дүүрэн зүтгэх алба, *самадхау-* эзэмдэн захирсан ухаанд, *на-* хэзээ ч үгүй, *видияте-* болдог.

Ухаан санаа нь мэдрэхүйн таашаал ханамж эдлэхэд болон материаллаг эд баялагт хэт автан төөрөлдөж хууртсан хүмүүс Бүхний Дээд Бурханы чин бишрэлийн алба үйлэнд зүтгэх бат хатуу шийдвэрт хүрч чаддаггүй.

ТАЙЛБАР: *Самадхи* нь “бат бэх автан умбасан ухаан” гэсэн утгатай үг юм. Ведийн толь бичиг Нируктид *самьяг адхияте`сминн атма-таттва-ятхатмьям* буюу “Өөрийгөө танин мэдэхэд ухаан нь бүрэн чиглэгдэж, батжин бэхжсэн байхыг *самадхи* гэж нэрлэдэг.” хэмээн өгүүлсэн байдаг. *Самадхи* нь материаллаг мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийг сонирхон хүсэгчид болон мөн иймэрхүү түр зуурын зүйлд төөрөлдөж самуурсан хүмүүсийн хувьд огтын боломжгүй зүйл юм. Материаллаг эрчмийн үйлчлэл нөлөөлөл тэдэнд их бага ямар нэгэн хэмжээгээр саад тотгор учруулдаг.

ШҮҮЛЭГ 45

*трай-гунья-вишая веда нистрай-гуньо бхаваржуна
нирдвандво нитья-саттва-стхо нирьога-кшема атмаван*

трай-гунья- материаллаг байгалийн гурван гунуудад хамаарал бүхий, *вишаях* сэдвийн талаар, *ведах-* ведийн судрууд, *нистрай-гуньях-* материаллаг байгалийн гурван гунад трансценденталь, *бхава-* байх, *аржуна-* Аржуна минь, *нирдвандвах-* хоёрдмол байдалгүй, *нитья-саттва-стхах-* бурханлаг оршихуйн ариун байдалд, *нирьога-кшемах-* аврал хамгаалал болон олз ашигтай байх бодлоос ангид, *атмаван-* өөрийн “Би”-д автсан.

Ведэд голчлон материаллаг байгалийн гурван гунуудын талаар өгүүлдэг. Ай Аржуна минь ээ, энэхүү гурван гунуудын чанадад бай. Бүхий л хоёрдмол байдал хийгээд олз ашиг олох болон аюулгүй байдалдаа санаа зовохоос ангид бай. Өөрийн “Би”-дээ авт.

ТАЙЛБАР: Бүхий л материаллаг үйл ажиллагаа нь материаллаг байгалийн гурван гунуудын нөлөөн доор үйлдэгдсэн үйлдлүүд болон тэдгээрийн үр дагаврууд юм. Эдгээр үйлүүд нь материаллаг үр дагаварт хүрэх санаа бодолтойгоор үйлдэгддэг бөгөөд энэ нь бидний материаллаг ертөнцөд уягдаж хүлэгдэхийн учир шалтгаан болж байдаг. Хүмүүсийг мэдрэхүйн таашаал ханамж эдлэх түвшингээс трансценденталь түвшинд аажим аажмаар дээшлэн хүрэхэд туслахын тулд Ведэд үр дагавар дагуулах ийм үйлүүдийн янз бүрийн хэлбэрийн талаар голчлон өгүүлдэг. Аржуна Шри Кришнагийн шавь хийгээд анд нөхөр болохын хувьд, эхэнд нь дээдийн дээд Трансцендент буюу *брахма-жигьаса-ын* тухай асуултууд тавигддаг Веданта философийн трансценденталь түвшинд дээшлэн хүрэхийн тулд Түүнээс зөвлөгөө авч байна. Материаллаг ертөнц дэх бүх амьд оршнолууд нь амьдрал оршнолынхоо төлөө хүнд бэрх тэмцлийг өрнүүлж байдаг. Материаллаг ертөнцийг бүтээсний дараагаар Бурхан тэдэнд материаллаг хүлээнснээ ангижрахын тулд хэрхэн яаж амьдрах тухай сургадаг ведийн цэцэн мэргэн мэдлэгийг өгсөн. *Карма-канда* бүлэгт өгүүлсэн мэдрэхүйн таашаал ханамж эдлэхэд чиглэгдсэн үйлээ эцэс болгон орхисон цагт л хүн Упанишадуудын хэлбэрээр өгөгдсөн бурханлаг мэдлэгийг хүртэх боломжтой болно. Бхагавад Гита нь тав дахь Вед болох Махабхаратагийн бүрэлдхүүн хэсэг болж байдагтай нэгэн адил трансценденталь амьдралын эхлэлийг тодорхойлон өгүүлдэг Упанишадууд нь янз бүрийн Ведүүдийн хэсгүүд болж байдаг.

Материаллаг бие махбодь оршин байсан цагт материаллаг байгалийн гунууд дахь үйлдэл болон үр дагавар мөн байх л болно. Хүмүүс баяр хөөр болон уйтгар гуниг, халуун болон хүйтэн гэх мэтийн хоёрдмол байдлуудыг тэсвэрлэж сурах хэрэгтэй бөгөөд тэдгээрийг ийнхүү тэсвэрлэж чадсанаар олз ашиг болон гарз хохирлоос үүдэн гарах аливаа зүйлд санаа зовохоос ангижрана. Кришнаг бүрнээ ухамсарласан бөгөөд өөрийгөө Кришнагийн ивээллээс бүрнээ хамааруулж чадсан хүн л энэхүү трансценденталь түвшинд хүрч чадна.

*яван артха удапане сарватах самплутадаке
таван сарвешу ведешу брахманасья вижанатах*

яван- энэ бүх, *артхах-* зориулагдсан, *уда-пане-* худагт, *сарватах-* аль ч талаараа *самплута-удаке-* том ай савд, *таван-* үүнтэй адил байдлаар, *сарвешу-* бүхий л, *ведешу-* ведийн судруудад, *брахманасья-* Бүхний Дээд Брахманыг таньж мэдэх хүний, *вижанатах-* бүрэн төгс мэдлэгийг агуулдаг.

Жижигхэн худгийн гүйцэтгэх бүхий л үүрэг зориулалтыг усны том ай сав аль ч талаараа мөн л бүрэн биелүүлж чаддагтай адил Ведийн цаад далдын зорилгыг мэдэж байгаа хүн түүний бүхий л зорилгуудад хүрч чадна.

ТАЙЛБАР: Ведийн *карма-канда* хэсэгт дурьдсан байдаг тахилга өргөл болон зан үйлийн ёслолууд нь хүнийг аажим аажмаар өөрийгөө бүрэн нээж танин мэдэхэд хүрэхэд зоригжуулдаг. Өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн зорилгыг Бхагавад Гитагийн арвантав дугаар бүлгийн (15.15)-д тодорхой өгүүлдэг: Ведийг судлахын зорилго нь бүх зүйлсийн анхдагч учир шалтгаан болох Шри Кришнаг таньж мэдэхэд оршдог. Өөрийгөө бүрэн нээж танин мэднэ гэдэг нь иймд Кришнаг болон Түүнтэй холбогдсон өөрийн мөнхийн холбоо харьцаагаа ойлгож ухаарахыг хэлдэг. Амьд оршнолын Кришнагай холбогдсон мөнхийн харьцааны талаар мөн Бхагавад Гитагийн арвантав дугаар бүлэгт (15.7) өгүүлдэг. Амьд оршнолууд нь Кришнагийн салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд мөн юм. Ийм учраас бие даан орших амьд оршнол өөрийн Кришнагийн ухамсарыг сэргээн хөгжүүлэх аваас энэ нь ведийн мэдлэгийн дээдийн дээд төгс төгөлдөр болно. Энэ тухай Шримад Бхагаватамын (3.33.7)-д батлан өгүүлэхдээ:

*ахо бата шва-пачо `то гариян
яж-жихвагре вартате нама тубхьям
тепус тапас те жухувух саснур арья
брахманучур нама гринанти е те*

“Ай Бурхан минь ээ, Таны ариун гэгээн нэр алдрыг давтан хэлж байгаа хүн доод гэр бүлээс (нохойгоор хооллогчийн) гаралтай байсан байлаа ч өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн дээдийн дээд түвшинд оршин байдаг билээ. Ийм хүн өнгөрсөн цаг үедээ бүхий л төрлийн гэвчил, наманчлал болон тахилга өргөлийг ведийн зан үйлийн дагуу үйлдсэн байдаг ба ведийн судруудыг олонтаа судалж, бүх ариун мөргөлийн газруудад угаал үйлдсэн байдаг. Ийм хүнийг *ария-чуудын* дундаас хамгийн шилдэг нь гэж үзэх хэрэгтэй.”

Иймээс, хүн зөвхөн зан үйлийн ёслолд дурлан татагдаж авталгүйгээр илүү оюунлаг байж Ведийн жинхэнэ зорилгыг ойлгох ёстой бөгөөд мэдрэхүйн таашаал ханамжийг илүү дээд хэлбэр байдлаар эдлэхээр тэнгэрийн гаригуудад хүрэхээр тэмүүлэхийн хэрэггүй. Энэ цаг үеийн эгэл жирийн хүмүүс ведийн зан үйл, ёслолын бүхий л журам дүрмийг даган мөрдөх эсвэл бүх Веданта болон Упанишадудыг бүрэн дүүрэн нарийн судалж мэдэх чадваргүй юм. Ведийн янз бүрийн зорилго, дүрэм журмуудыг биелүүлэхэд үлэмж хэмжээний цаг хугацаа, эрч хүч, мэдлэг болон зардал шаардагдана. Энэ бол одоо цаг үед арай л боломжгүй хэрэг юм. Харин бүх унасан сүнснүүдэд аврал хайрлагч Шри Чайтаньягийн зөвлөсөнчлөн, Бурханы ариун гэгээн нэр алдруудыг давтан хэлснээр ведийн соёлын дээдийн дээд зорилгод хүрч болно. Ведийн аугаа их номч мэргэн Пракашананда Сарасвати, Шри Чайтаньягаас Веданта философийг судлахын оронд сентименталист дүрслэн бодогч аятай яагаад Бурханы ариун гэгээн нэр алдруудыг давтан хэлээд байдгийн учрыг асуухад Тэр, номын багш нь Түүнийг ихээхэн тэнэг хэмээн үзсэн учраас Шри Кришнагийн ариун гэгээн нэр алдруудыг давтан хэлж бай хэмээн сургасан гэж хариулжээ. Тэр багшийнхаа зааж сургасны дагуу Бурханы ариун гэгээн нэр алдруудыг давтан хэлсээр галзуурсан мэт онгод хөөрөлд (экстаз) ордог байжээ. Энэхүү Калийн цаг үеийн ихэнх хүмүүс мунхаг бөгөөд Веданта философийг ойлгох хэмжээний хангалттай мэдлэг боловсролгүй. Гэсэн ч Бурханы ариун гэгээн нэр алдруудыг ямар ч алдас хийлгүйгээр давтан хэлснээр Веданта философийн дээдийн дээд зорилгод хүрч болно. Веданта нь Ведийн цэцэн мэргэн мэдлэгийн охь дээж бөгөөд түүнийг бүтээгч хийгээд нэвтэрхий сайн мэдэгч нь Шри Кришна Өөрөө билээ. Ведантаг төгс төгөлдөр мэдэгч бол Бурханы ариун гэгээн нэр алдруудыг давтан хэлэхдээ жаргал цэнгэлийг эдлэх аугаа их сүнс бөлгөө. Үүнд л Ведийн бүхий л ид шидийн дээдийн дээд зорилго оршдог билээ.

ШҮҮЛЭГ 47

*карманй эвадхикарас те ма пхалешу кадачана
ма карма-пхала-хетур бхур ма те санго `ств акармани*

кармани- оноогдсон үүргүүд, *эва-* гарцаагүй, *адхикарах-* эрх, *те-* чамайг, *ма-* хэзээ ч үгүй, *пхалешу-* үр дүнд, *кадачана-* ямар ч цаг үед, *ма-* хэзээ ч үгүй, *карма-пхала-* үйлийн үр дагавар, *хетух-* учир шалтгаан, *бхих-* болох, *ма-* хэзээ ч үгүй, *те-* чамайг, *сангах-* дурлан татагдал, *асту-* ёстой байх, *акармани-* оноогдсон үүргээ биелүүлэхгүй.

Чи өөрт оноогдсон үүргийг л биелүүлэх ёстой бөгөөд харин үйлийнхээ үр дагаварт санаархах эрх байхгүй. Хэзээ ч өөрийгөө үйлийнхээ үр дагаврын учир шалтгаан гэж бүү үзэж бай, мөн үүргээ биелүүлэхээс зайлсхийх гэж бүү оролдож бай.

ТАЙЛБАР: Энд, оноогдсон үүрэг, өөрийн дур зоргоор үйлдсэн үйл, үйл үл үйлдэх гэсэн гурван зүйлийн тухай яригдаж байна. Өөрт оноогдсон үүрэг гэдэг бол бидний бие махбодид нөлөөлж буй материаллаг мөн чанарын гунуудын дагуу үйлдэх ёстой үйл юм. Дээд эх сурвалжийн шахалт шаардлагагүйгээр үйлдсэн үйлийг өөрийн дур зоргоор үйлдсэн үйл гэдэг. Өөрт оноогдсон үүргээ үл биелүүлэхийг үйл бус буюу үйл үл үйлдэх гэнэ. Бурхан Аржунад үйл бусыг бүү үйлдэж, харин өөрт оноогдсон үүргээ үр дүнд нь татагдалгүй биелүүлэхийг сургаж байна. Хүн үйлийнхээ үр дагаварт татагдах аваас тэр өөрөө уг үйлийнхээ учир шалтгаан болдог. Иймээс тэр өөрийн үйлийн үр дагавраас хамааран нэг бол таашаал ханамж эдэлж үгүй бол зовон шаналж байдаг.

Оноогдсон үүргийг дотор нь гурван хэсэг болгон ангилдаг ба үүнд: өдөр тутмын үйл, онцгой нөхцөл байдлын доор үйлдэгдэх үйл болон өөрийн хүсэл эрмэлзлийн дагуу үйлдэх үйл багтдаг. Үр дагаварт нь дурлан татагдалгүйгээр судруудад заасны дагуу үйлдэж буй өдөр тутмын үйл нь цэвэр ариуны гуна дахь үйл болно. Үр дүнг нь хүртэхийн төлөө үйлдэж буй үйл нь уг хүнийг энэ материаллаг ертөнцөд уягдан хүлэгдэхийн учир шалтгаан болдог учир ийм үйл үйлдэх нь ач тустай бус байдаг. Хүн бүр өөрт оноогдсон үүргээ биелүүлэх эрхтэй байдаг боловч түүний үр дүнд нь татагдалгүй биелүүлэх ёстой. Өөрт оноогдсон заавал биелүүлэх ёстой үүргээ ийнхүү үр дүнд нь дурлан татагдалгүйгээр биелүүлж байгаа хүн ангижралд хүргэх зам мөрөөр замнаж яваа нь эргэлзээгүй.

Иймээс Шри Кришна Аржунад үр дагаварт нь татагдалгүйгээр цэвэр өөрт оноогдсон үүргээ биелүүлэх үүднээс л тулалдахыг уриалж байна. Тулалдаанд оролцохоос зайлсхийж байна гэдэг бол үр дагаварт нь татагдан байгаагийн нэг хэлбэр билээ. Ийнхүү татагдах нь хүнийг ангижралын зам мөрт хэзээ ч хүргэхгүй. Аливаа үйлийн үр дагаварт эерэг эсвэл сөрөг байдлаар автах, татагдах явдал нь бидний материаллаг боолчлолд уягдан байхын учир шалтгаан болж байдаг. Үйл бус байна гэдэг нь нүгэлтэй учраас цэвэр өөрт нь оноогдсон үүргийг биелүүлэх үүднээс тулалдах нь Аржунагийн хувьд ангижралд хүрэх цорын ганц ач тустай зам юм.

ШҮҮЛЭГ 48

*йога-стхах куру кармани сангам тьяктва дхананьжяя
сиддхй-асиддхьох само бхутва саматвам йога учьяте*

йога-стхах- ажралгүй, *куру-* биелүүл, *кармани-* өөрийн үүргийг, *сангам-* дурлан татагдал, *тьяктва-* орхин, *дхананьжяя-* Аржуна минь, *сиддхй-асиддхьох-* ялалт болон ялагдлын үед, *самах-* тогтвортой тайван, *бхутва-* байж, *саматвам-* үл ажирсан, *йогах-* иог, *учьяте-* гэж нэрлэгддэг.

Ай Аржуна минь ээ, ялах болон ялагдахыг ажралгүйгээр өөрт оноогдсон үүргээ тайван байж биелүүл. Ингэж үл ажирсан байдалтай, тогтвортой тайван байхыг йога гэж нэрлэдэг юм.

ТАЙЛБАР: Кришна Аржунаг *йогын* байдалд байж үүргээ биелүүлэх ёстойг зөвлөж байна. *Йога* гэж юу вэ? *Йога* гэж байнгад тайван бус байх мэдрэхүйгээ эзэмдэн захирснаар ухаанаа Дээдийн Дээдэд төвлөрүүлэхийг хэлдэг. Энэхүү Дээдийн Дээд гэж хэн бэ? Дээдийн Дээд бол Кришна. Бурхан энд Өөрөө Аржунад тулалдахыг зарлиг болгож байгаа учраас энэ тулалдааны үр дагавар нь Аржунад ямар ч холбогдолгүй. Ялах эсвэл ялагдах нь бол зөвхөн Кришнад хамааралтай асуудал. Аржуна зөвхөн, Түүний сургаал айлдварыг л дагах хэрэгтэй. Кришнагийн сургаал зааврыг дагаж мөрдөх нь жинхэнэ *йога* бөгөөд энэ нь Кришнагийн ухамсарын үйл явцад хэрэгжиж биелдэг. Энэ ертөнцөд ямар нэгэн зүйл өмчлөх эзэмших гэсэн ойлголт, бодлоо хүн зөвхөн Кришнагийн ухамсарт л орхиж чадах болно. Кришнагийн албат үйлчлэгч, эсвэл Кришнагийн албатын албат үйлчлэгч болж тэдэнд үйлчлэн зүтгэх хэрэгтэй. Энэ бол өөрийн үүргээ Кришнагийн ухамсарт биелүүлж болох зөв зам бөгөөд ганц энэ зам л хүнийг *йогын* байдалд үйлээ үйлдэхэд тусладаг.

Аржуна нь *киатрия* болохын хувьд *варнашрама-дхармын* системд хамаарагдана. Вишну Пуранад *варнашрама-дхарма* системийн бүхий л зорилго нь зөвхөн Вишнуг цэнгүүлэхэд чиглэгдсэн байдаг гэж өгүүлсэн байдаг. Энэхүү материаллаг ертөнцөд дадал заншил болсон шиг зөвхөн өөрийн мэдрэхүйн таашаал ханамжийг хангахын төлөө бус, харин Кришнагийн таалалд нийцүүлэн Түүнийг цэнгүүлэхийн төлөө ажиллахыг эрмэлзэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, Кришнагийн таалалд нийцүүлэлгүйгээр *варнашрама-дхармын* зарчмуудыг зөв дагаж мөрдөж чадахгүй юм. Кришна Өөрийн айлдварыг биелүүлэх хэрэгтэй гэдгийг Аржунад ийнхүү шууд бус байдлаар ойлгуулж байна.

ШҮҮЛЭГ 49

*дурена хй аварам карма буддхи-йогад дхананьжяя
буддхау шаранам авиччха крипанах пхала-хетавах*

дурена- хол хая, *хи-* тодорхой, *аварам-* жигшүүрт бузар, *карма-* үйл, *буддхи-йогат-* Кришнагийн ухамсарын хүч чадал дээр тулгуурлан, *дхананьжяя-* баялгийг эзлэгч минь, *буддхау-* ийм ухамсарт, *шаранам-* бүрэн даатга, *авиччха-* хойноос тэмүүл, *крипанах-* харамч нарийн, *пхала-хетавах-* өөрийн үйлийн үр дагаврын хойноос хөөцөлдөгч

Ай Дхананьжяя минь ээ, Бурханы чин бишрэлийн албанд зүтгэснээр бүхий л жигшүүрт бузар үйлүүдээс өөрийгөө ангид байлга. Ийм ухамсартайгаар Түүнд өөрийгөө даатга. Өөрсдийн ажил үйлийн үрээр цэнгэн жаргахыг хүсэгчдийг харамч нарийн хүн хэмээн нэрлэдэг билээ.

ТАЙЛБАР: Өөрийн жинхэнэ байр суурийг Кришнагийн мөнхийн албат зарц мөн хэмээн үнэхээр ойлгож чадсан хүн л Кришнагийн ухамсарын үйлээ бусад бүх үйлээ орхидог. Урьд өмнө өгүүлсэнчлэн, *буддхи-йога* нь Бурханд трансценденталь хайраар үйлчлэн зүтгэх алба гэсэн утгатай билээ. Ийм чин бишрэлийн албанд зүтгэх нь амьд оршинолуудын хувьд үйлийн зөв арга зам байдаг. Зөвхөн харамч нарийн, шунаг сувдагчууд л өөрсдийн үйлийн үр дүнгээр таашаал ханамж эдлэж байдаг бөгөөд ингэснээрээ тэд материаллаг боолчлолд улам лав баригдан орооцолддог. Кришнагийн ухамсар дахь үйлээ бусад бүх төрлийн үйлүүд нь тэдгээрийг үйлдэх хүнийг төрөлт үхлийн хүрдэнд үргэлжлүүлэн уяж хүлдэг учраас жигшин зэвүүцвээс сохилтгой. Иймээс хүн өөрөө үйлийнхээ учир шалтгаан байхыг хэзээ ч хүсэхийн хэрэггүй. Кришнаг цэнгүүлэхийн тулд бүхнийг Кришнагийн ухамсарт үйлдэх хэрэгтэй. Харамч нарийн хүмүүс нь хувь тавилангийн эрхээр аяндаа орж ирж байгаа эсвэл хөлс хүчээ шавхан байж олсон эд баялгаа хэрхэн яаж хэрэглэхээ ч мэддэггүй. Кришнагийн төлөө зүтгэхийн тулд хүн бүхий л эрч хүчээ ашиглах хэрэгтэй, тэгснээр л бидний амьдрал урагштай амжилттай болно. Гэсэн ч харамлан нарийлагчид шиг хувь заяа муутайчууд хүмүүний эрч хүчээ Бурханы алба үйлэнд зориулдаггүй.

ШҮҮЛЭГ 50

буддхи-юкто жсахатиха убхе сукрита-душкрите

тасмад йогая южъясва йогах кармасу каушалам

буддхи-юктах- чин бишрэл дүүрэн алба үйлэнд зүтгэн байгаа хүн, *жахати-* -аас ангижрах болно, *иха-* энэ амьдралдаа, *убхе-* хоёул, *сукрита-душкрите-* сайн болон муу үр дагавар, *тасмат-* ниймээс, *йогая-* чин бишрэлийн алба үйлийн төлөө, *южъясва-* ийм байдлаар үйлд, *йогах-* Кришнагийн ухамсар, *кармасу-* бүхий л үйлэндээ, *каушалам-*урлаг.

Бурханы чин бишрэлийн албанд зүтгэж байгаа хүн одоогийн энэ амьдралдаа л үйлийн сайн болон муу үр дагавруудаасаа ангижрана. Иймд аливаа үйл үйлдэхийн урлаг болсон йогад тэмүүл.

ТАЙЛБАР: Амьд оршнол бүрт өнө эртийн цагаас эхлэн үйлдсэн сайн болоод муу үйлүүдтэй нь холбогдон гарах үр дагаврууд хуримтлагдсан байдаг. Ийм нөхцөлд орсноороо тэд өөрсдийн жинхэнэ, жам ёсны байр суурийн талаар үл мэдэх харанхуй мунхаг байдалд оршин байдаг. Харин бид, Шри Кришнад өөрсдийгөө бүрэн даатгаснаар, биднийг амьдралаас амьдралд үйл болон үр дагавартай уяж холбох уяа хүлээснээс ангижирч болохыг сургах Бхагавад Гитагийн номлолыг дагаж мөрдөн энэхүү харанхуй мунхаг байдлыг арилган зайлуулж болно. Иймээс л Аржунад өнгөрсөн цагийн үйлүүдийнхээ бүхий л үр дагавруудаас ариусгах үйл явц болох Кришнагийн ухамсарт үйлээ үйлдэхийг зөвлөж байна.

ШҮҮЛЭГ 51

*карма-жам буддхи-юкта хи пхалам тьяктава манишинах
жанма-бандха-винирмуктах падам гаччхантй анамаям*

карма-жам- үр дагавар дагуулагч үйлийн улмаас, *буддхи-юктах-* чин бишрэлийн албанд зүтгэх, *хи-* тодорхой, *пхалам-* үр дагаврууд, *тьяктава-* орхин, *манишинах-* аугаа мэргэд болон чин бишрэлтэнгүүд, *жанма-бандха-* үхэл төрөлтийн уяа хүлээснээс, *винирмуктах-* ангижирсан, *падам-* байр суурь, *гаччхантй-* тэд хүрдэг, *анамаям-* зовлон шаналалгүйгээр,

Аугаа их цэцэд мэргэд болон чин бишрэлтэнгүүд нь Бурханы чин бишрэлийн алба үйлэнд ийнхүү зүтгэснээр материаллаг ертөнц дэх үйлийн үрээсээ ангижирдаг. Ийм байдлаар л тэд үхэл төрөлт давтагдан үргэлжлэх хүрднээс мултран гарч бүхий л зовлон шаналлын чанадад орших Бурханы залран байх оронд буцаж хүрдэг.

ТАЙЛБАР: Ангижралд хүрсэн амьд оршнолууд нь материаллаг зовлон шаналлын чанадад байх оронд хамаарагддаг. Шримад Бхагаватамын (10.14.58)-д өгүүлсэнчлэн:

*самашрита е пада-паллава-плавам
махат-падам пунья-яшо мурарех
бхавамбудхир ватса-падам парам падам
парам падам яд випадам на тешам*

“Мукунда (*мукти-г* хайрлагч) нэрээр алдаршсан хийгээд сансар огторгуйн бүх илрэлүүдэд аврал ивээлийг хайрладаг Бурханы бадамлянхуа өлмийн завин дээр гарч чадсан хэн бүхний хувьд материаллаг ертөнцийн далай нь тугалын турууны мөрийн хонхорхойд тунасан ус мэт. *Парам падам* буюу материаллаг зовлон байдаггүй орон –Вайкунтха- бол түүний хүрэх зорилго болохоос алхам тутам аюул отон нүүрлэх орон биш билээ.”

Амьд оршнол нь харанхуй мунхгийнхаа харгайгаар энэхүү материаллаг ертөнц нь алхам тутамд аюул занал учруулж байдаг орон гэдгийг мэддэггүй. Оюунлаг бус хүмүүс нь зөвхөн харанхуй мунхаг байдлын улмаасаа болж үр дагавар дагуулах үйл үйлдсэнээр материаллаг ертөнц дэх өөрсдийн байр байдлаа сайжруулахыг оролдох бөгөөд иймэрхүү үйлийн үр нь тэднийг аз жаргалтай болгоно хэмээн итгэж найдаж байдаг. Материаллаг бие махбодийн ямар ч хэлбэрийг авсан орчлонгийн хаана ч тэр зовлон шаналалгүй амьдрах боломжгүй гэдгийг тэд огтхон ч мэддэггүй. Амьдралын зовлон шаналал буюу төрөлт, үхэл, хөгшрөлт болон өвчлөл нь материаллаг ертөнцөд хаа сайгүй байдаг. Харин Бурханы мөнхийн албат гэсэн өөрийн жинхэнэ жам ёсны байр суурийг ойлгож ухаарсан ба тэгснээрээ мөн Бурханы Бодьгалын байр суурийг таньж мэдсэн хэн бүхэн Бурханы трансценденталь хайрын алба үйлэнд зүтгэхэд өөрийгөө зориулдаг. Үүний үрээр тэр материаллаг зовлон шаналал дүүрэн амьдрал болон цаг хугацааны нөлөөлөл хийгээд үхлийн аль аль нь ч үгүй байдаг Вайкунтийн гаригуудад хүрч очих чадвартай болно. Өөрийн жинхэнэ байр суурийг таньж мэднэ гэдэг нь Бурханы эрхэм дээд байр суурийг мөн таньж мэднэ гэсэн үг. Амьд оршнолын байр суурь болон Бурханы байр суурь нь нэг ижил түвшинд оршдог хэмээн андуу ташаагаар бодож итгэх хүн нь харанхуйд төөрөлдөн самуурч байгаа хэрэг бөгөөд тиймээс ч Бурханы чин бишрэл дүүрэн албанд зүтгэх чадваргүй байдаг. Тэр өөрийгөө нэгэн “Бурхан” болгох бөгөөд тэгснээрээ тэр үхэл төрөлтийн хүрдэнд дахин давтагдан эргэх өөрийн зам мөрөө засаж шулуутгасан хэрэг болдог. Харин албат болох байр сууриа ойлгож Бурханы алба үйлэнд зүтгэхэд өөрийгөө зориулсан хүн л Вайкунтхалокад мөдхөн хүрэхэд зохистой болдог. Бурханы төлөө зүтгэх албыг *карма-йога* буюу *буддхи-йога* эсвэл зүгээр л Бурханд чин бишрэлээр зүтгэх алба гэж нэрлэдэг.

ШҮҮЛЭГ 52

*яда те моха-калилам буддхир вьятитаришьяти
тада гантаси нирведам шротавьясья шрутасья ча*

яда- хэрвээ, *те-* чиний, *моха-* хий хуурмагийн, *калилам-* өтгөн, *буддхих-* оюун ухаан бүхий трансценденталь алба, *вьятитаришьяти-* гэтлэн гарах, *тада-* тэр цагт, *ганта-аси-* чи явах болно, *нирведам-* үл ажрах, хамаагүй байх, *шротавьясья-* сонсох ёстой бүхнийхээ өмнө, *шрутасья-* урьд нь сонссон бүхэн, *ча-* мөн.

Оюун ухаан чинь төөрөгдлийн өтгөн шигүү ойгоос гарч чадсан үед л чи урьд өмнө нь сонсож байсан болоод ирээдүй хойшид сонсох бүхнийг огтхон ч үл ажрах болно.

ТАЙЛБАР: Бурханы чин бишрэлний алба үйлэнд зүтгэж байгаа учир Ведийн зан үйлүүд түүний хувьд хамаагүй мэт болох Бурханы аугаа их чин бишрэлтэнгүүдийн амьдралаас олон гайхамшигтай жишээнүүд дурьдаж болно. Кришнаг болон Түүнтэй холбогдсон өөрийн харьцаа холбоог үнэхээрийн ойлгосон хүнд, хэдийгээр тэр туршлагатай *брахмана* байсан ч ялгаагүй, үр дагавар дагуулах үйлүүдтэй холбоотой янз бүрийн зан үйлүүд аяндаа огтхон ч хамаагүй мэт болдог. Чин бишрэлтэнгүүдийн хэлхээ сүлжээн дэх *ачарья* бөгөөд аугаа чин бишрэлтэн Шри Мадхавендра Пури хэлэхдээ:

*сандхья-вандана бхадрам асту
бхавато бхох снана тубхьям намо
бхо девах питараиш ча тарпана-
видхау нахам кишамах кишамьятам
ятра квапи нишадыя ядава-
кулоттамасья камса-двипах
смарам смарам агхам харам
тад алам манье ким аньена ме*

“Ай миний өдөр бүр гурван удаа үйлддэг залбирал мөргөл минь ээ, та бүхэнд хүндэтгэлээ илэрхийлье! Ай угаал минь ээ, Би чамд хүндэтгэлээ илэрхийлье! Ай сахиулсан тэнгэрүүд минь ээ, ай өвөг дээдэс минь ээ, Та бүхэнд хүндэтгэлээ илэрхийлэх чадваргүй байгаад минь намайг бүү буруутгаарай. Би хаана ч байсан, Камсагийн дайсан, Ядугийн аугаа их үр удам Кришнаг дурсан бодох юм. Ингэж байж л би нүглийнхээ тушаа хүлээснээс ангижирч чадах билээ. Энэ л надад хангалттай гэж би бодож байна.”

Ведийн зан үйл болон ёслолууд нь шинээр эхэлж буй хүмүүст зайлшгүй шаардлагатай. Өдөр бүр гурван удаа боломжит бүхий л залбиралаа хэлэх, өглөө эрт бүрэн угаал үйлдэх, өвөг дээдэстээ хүндэтгэл үзүүлэх ... гэх мэт. Харин Кришнагийн ухамсарт бүрнээ автаж Бурханы трансценденталь хайрын албанд зүтгэн байгаа хэн бүхэн төгс төгөлдөрт хэдийнээ хүрсэн байх тул түүний хувьд энэ бүх зохицуулах зарчмууд огтхон ч чухал биш хийгээд хамааралгүй мэт болдог. Бүхний Дээд Бурхан Кришнад зүтгэснээр бурханлаг мэдлэгийн түвшинд хүрсэн хүн ариун гэгээн судруудад зөвлөсөн байдаг янз бүрийн хэлбэрийн тахилга өргөл болон тэвчил, наманчлалуудыг цаашид үйлдэх хэрэггүй болдог. Нөгөө талаас Ведийн зорилго нь Шри Кришнад хүрэхэд оршдог гэдгийг ойлголгүйгээр зан үйл болон ёслолуудыг зүгээр л үйлдэж байгаа хүмүүс нь цагаа хий дэмий хоосон үрж байгаа хэрэг. Кришнаг ухамсарласан хүн *шабда-брахма-ын* буюу Ведүүд болон Упанишадудын хүрээний чанадад гарсан байдаг.

ШҮҮЛЭГ 53

*шрути-випратипанна те яда стхасьяти нишчала
самадхав ачала буддхис тада йогам авасьяси*

шрути- ведийг хүртэхүй, *випратипанна-* үр дагавар дагуулагч үйлийн үр дүнд нөлөөлөгдөлгүйгээр, *те-* чиний, *яда-* хэрвээ, *стхасьяти-* үлддэг, *нишчала-* үл хөдлөн, *самадхау-* Кришнагийн ухамсарт буюу трансценденталь ухамсарт, *ачала-* хэлбэрэлт гуйвалтгүй, *буддхих-* оюун ухаан, *тада-* тэр цагт, *йогам-* өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүй, *авасьяси-* чи хүрнэ.

Чиний ухаан Ведийн цэцэг мэт үг хэллэгэнд төөрөлдөн самуурахгүй болох үед болон өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн транс-д гүн бат автах цагт л бурханлаг ухамсарт хүрнэ.

ТАЙЛБАР: Хэн нэгнийг *самадхи-д* автан байна гэж ярьж байх аваас тэр Кришнагийн ухамсарт бүрэн хүрсэн гэсэн үг. Өөрөөр хэлбэл, *самадхи-д* бүрнээ автан умбаж байгаа хүн Брахман, Параматма болон Бхагаваныг таньж мэдсэн байдаг. Өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн дээдийн дээд төгс төгөлдөр нь хүн өөрийгөө Кришнагийн мөнхийн албат үйлчлэгч бөгөөд үүргээ Кришнагийн ухамсарт биелүүлэх ганцхан даалгавартай байдаг гэдгээ танин мэдэх явдал юм. Кришнаг ухамсарласан хүн буюу өөрөөр хэлбэл гуйвалтгүй чин бишрэлтэн нь Ведийн цэцэг мэт үгэнд төөрөлдөж самуурах ёсгүй, мөн тэнгэрийн гаригуудад хүрэх гэж материаллаг үйлүүдийн хойноос хөөцөлдөх ч хэрэггүй. Кришнагийн ухамсарт хүрснээр хүн Кришнаатай шууд холбогддог бөгөөд энэхүү трансценденталь түвшинд Кришнагийн бүхий л сургаал зааврыг ойлгох чадвартай болдог. Хэрвээ хүн ийхүү зүтгэн байх аваас тодорхой үр дүнд болон шийдвэрлэх мэдлэгт хүрэх нь эргэлзээгүй. Иймээс хүн зөвхөн Кришнагийн буюу Түүний элч төлөөлөгчийн сургаал зааврыг л даган биелүүлэх хэрэгтэй.

ШҮҮЛЭГ 54

*аржуна увача
стхита-прагьясья ка бхашиа самадхи-стхасья кешава
стхита-дхих ким прабхашета ким асита вражета ким*

аржуна увача- Аржуна хэлсэн, *стхита-прагьясья-* Кришнагийн ухамсарт гүнээ автан байгаа хэн нэгнийг, *ка-* юу, *бхашиа-* хэл, *яриа,* *самадхи-стхасья-* транед оршин байгаа хэн нэгнийг, *кешава-* Кришнагийн тухай, *стхита-дхих-* Кришнагийн ухамсарт батжсан хэн нэгэн, *ким-* юу, *прабхашета-* ярьдаг, *ким-* яаж, *асита-* суудаг, *вражета-* явдаг, *ким-* яаж.

Аржуна айлтгасан нь: Ай Кришна минь ээ, ухамсар нь ийнхүү трансценденталь байдалд автан байгаа хүнийг яаж таньж мэдэх вэ? Тэр юуны тухай ярьж, санаа бодлоо хэрхэн илэрхийлдэг вэ? Ямархуу байдалтай сууж, яаж явдаг вэ?

ТАЙЛБАР: Өөрийн эзэлж буй байр сууриасаа хамааран хүн бүр тодорхой өвөрмөц шинж төрхийг үзүүлж байдгийн адил Кришнагийн ухамсарт оршин байгаа хүний үг яриа, алхаа гишгээ, бодол санаа, байгаа байдлаар нь илрэх өөрийн гэсэн онцлог шинж байдаг. Баян хүн хүмүүс баян гэдгийг нь таньж мэдэхээр тодорхой шинжүүд, өвчтэй хүн өөрийнх нь туссан өвчнийг илэрхийлсэн, мөн эрдэм мэдлэгтэй хүн түүнийг мэдлэгтэй гэдгийг нь илтгэн харуулах тодорхой шинж тэмдгүүдийг

агуулж байдгийн адил Кришнаг ухамсарласан хүний өөрийгөө авч явах байдалд онцгой шинж чанарууд илэрдэг. Энэхүү онцлог шинжүүдийн талаар Бхагавад Гитад тодорхойлон өгүүлдэг. Үг яриа бол хүний хамгийн гол шинж чанар байдаг учир Кришнаг ухамсарласан хүн хэрхэн ярьж байгаа нь хамгийн чухал. Тэнэг хүн үг үл дуугаран байгаа үедээ тэнэг гэдэг мэдэгддэггүй гэж ярьдгийн адил сайн хувцасласан тэнэг хүн ам нээн үг яриа эхэлсэн үедээ л өөрийн үнэн нүүр царайгаа харуулдаг. Кришнаг ухамсарласан хүний хамгийн гол шинж тэмдэг нь тэрээр зөвхөн Кришнагийн тухай хийгээд Түүнтэй холбоотой сэдвээр л ярьж байдагт оршдог. Бусад шинж тэмдгүүд нь аяндаа өөрөө бий болдог нь дараагийн шүлгүүдээс тодорхой болно.

ШҮҮЛЭГ 55

*ири бхагаван увача
пражахати яда каман сарван партха мано-гатаман
атманй эватмана туштах стхита-прагьяс тадочьяте*

ири бхагаван увача- Бурханы Дээд Бодгаль айлдсан, *пражахати-* татгалзан орхих, *яда-* хэрвээ, *каман-* мэдрэхүйн таашаал ханамж эдлэх хүсэл, *сарван-* бүхий л хэлбэрийн, *партха-* Притхын хүү минь, *манах-гатаман-* ухаан бодлын хүслийн төсөөлөл дүрслэлээс, *атмани-* сүнсний ариун байдалд, *эва-* гарцаагүй, *атмана-* ариуссан ухаанаар, *туштах-* ханамжтай, *стхита-прагьях-* трансцендент байдалд автан, *тада-* тэр цагт, *учьяте-* гэж нэрлэгддэг.

Бурханы Дээд Бодгаль айлдсан нь: Ай Партха минь ээ, ухааны хүслийн төсөөлөл дүрслэлээс үүсэн бий болох мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн хүслийн бүхий л хэлбэрийг орхин, чингэснээрээ ухаан санаа нь ариуссан, зөвхөн өөрийн “би”-д ханамжтай байх хүнийг цэвэр трансценденталь ухамсарт автан умбаж байна гэж ярьдаг.

ТАЙЛБАР: Шримад Бхагаватамд батлан өгүүлснээр Кришнагийн ухамсарт, өөрөөр хэлбэл Бурханы чин бишрэлийн албанд бүрнээ автах хүн аугаа их мэргэдийн бүхий л сайн шинжүүдийг агуулдаг байхад ийм трансценденталь байдалд эс оршигч нь бүхий л зүйлд өөрийн ухаан бодлын ойлголт төсөөллөө удирдлага болгож байдаг гэдэг нь тодорхой учир түүнд ийм сайн шинжүүд байдаггүй. Иймээс энд ухаан бодлын түвшин дэх хүслийн ойлголт төсөөллөөс үүсэн бий болох бүхий л мэдрэхүйн шунаг хүсэл эрмэлзлийг орхих нь чухал гэж хамгийн зөвөөр хэлж байна. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн энэхүү шавдалт шаардлагаас зохиомол байдлаар салах аргагүй. Харин Кришнагийн ухамсрын үйлэнд зүтгэн байх хүний хувьд энэхүү эрмэлзэл нь ямар нэгэн онцгой нэмэлт хүчин чармайлт гаргалгүйгээр аяндаа өөрөө дарагдан үгүй болдог. Иймээс огтхон ч алгуурлалгүйгээр Кришнагийн ухамсарт үйл ажиллагаагаа явуулах нь чухал. Учир нь энэхүү чин бишрэл дүүрэн бялхал алба үйл нь трансценденталь ухамсарын түвшинд хоромхон зуурт хүрэх боломжийг өгдөг. Хөгжил дэвшлийн өндөр түвшинд хүрсэн сүнс Бурханы мөнхийн албат үйлчлэгч мөн гэдгээ ойлгож мэдсэн байдаг учир өөртөө үргэлж ханамжтай байдаг. Энэхүү трансценденталь түвшинд хүрсэн хэн бүхэн явцуу материаллаг үзэл бодлоос үүсэн бий болох мэдрэхүйн хүсэл эрмэлзлийг агуулдаггүй билээ. Харин түүний оронд тэр Бүхний Дээд Бурханд мөнхөд үйлчлэн зүтгэх өөрийн жам ёсны байр сууриндаа үргэлжид аз жаргалтай байдаг.

ШҮҮЛЭГ 56

*духхешв анудвигна-манах сукхешу вигата-сприхах
вита-рага-бхая-кродхах стхита-дхир мунир учьяте*

духхешу- зовлонгийн гурван хэлбэрт, *анудвигна-манах-* тайван ухаантай, *сукхешу-* аз жаргалд, *вигата-сприхах-* сонирхолгүй байх, *вита-* ангид, *рага-* дурлан татагдал, *бхая-* айдас хүйдэс, *кродхах-* уур хилэн, *стхита-дхих-* ухаан нь тогтвортой байх тэр, *муних-* мэргэн, *учьяте-* гэж нэрлэгддэг.

Гурвалсан зовлонгийн дунд ч ухаан самууралгүй тогтвортой байж, жаргалд үл ташуурах, мөн аливаад автан татагдах болон айдас хүйдэс, уур хилэнгээс ангид байж чадах хүнийг тогтворжин батажсан ухаантай мэргэн гэж нэрлэдэг.

ТАЙЛБАР: Жинхэнэ дүгнэлтэнд хүрэлгүйгээр олон янзын бодол санаа цэцэрхийлэлд өөрийгөө даатгасан ухаанаа ятган сэнхрүүлж чадах хүнийг *муни* гэж нэрлэдэг. *Муни* бүр нь өөрийн гэсэн санаа бодол, арга барилтай байдаг бөгөөд нэг *муни* нь нөгөөгөөс ялгагдахгүй байвал чухамдаа түүнийг *муни* гэж нэрлэх хэрэггүй гэж ярьдаг. *На часав ришир ясья матам на бхиннам* (Махабхарата, Вана-парва, 313.117). Гэхдээ энд Бурханы тодорхойлон айлдсанчлан, *стхита-дхир муни* жирийн *мунигаас* ялгаатай. *Стхита-дхир муни* өөрийн ухаан бодлын цэцэрхийллэйн бүхий л нөөцөө бүрэн шавхсан байдаг учир тэрээр Кришнагийн ухамсарт үргэлж автаж байдаг. Түүнийг *прашантанихшеша-мано-ратхантара* (Стотра-ратна,43) гэж нэрлэдэг нь тэр ухаан бодлын цэцэрхийллийн үе шатыг туулж өнгөрөөн ардаа орхисон ба Шри Кришна буюу Васудева бол бүх зүйл юм (*васудевах сарвам ити са махатма су-дурлабхах*) гэсэн дүгнэлтэнд хүрсэн гэдгийг зааж байна. Ийм хүнийг тогтворжиж батажсан ухаантай *муни* гэж нэрлэдэг. Тэрээр Кришнагийн ухамсарт бүрнээ оршин байдаг бөгөөд бүхий л зовлон бэрхшээлийг Бурханы өршөөл нигүүлсэл хэмээн хүлээн авч өөрийн өнгөрсөн үеийн нүглийн төлөө үүнээс хавьгүй их шийтгэл эдлэх ёстой байсан ч Бурханы өршөөлөөр л хамгийн бага хэмжээгээр амсаж байна хэмээн үздэг учир бүхий л гурван төрлийн зовлон зүдгүүрийн шахалт дарамтанд огтхон ч бэрхшээдэггүй буюу тэдгээрт үл ажирдаг. Тэр аз жаргалтай үедээ чухамдаа өөрийгөө ийм аз жаргалыг эдлэх гавьяагүй гэж үздэг ба энэ бүхний төлөө зөвхөн Бурханд л баярлаж талархаж байдаг. Тэр зөвхөн Бурханы өршөөл нигүүлсэлээр л Түүнд илүү сайн үйлчлэн зүтгэх боломж олгож буй ийм тааламжтай нөхцөл байдалд байна гэдгээ ойлгож мэддэг. Тэрээр Бурханы албанд үйлчлэн зүтгэж байхдаа үргэлж аймшиггүй зоригтой бөгөөд идэвхтэй байдаг ба дурлан татагдахуй болон эс дурлан татагдахуйн нөлөөлөлд ордоггүй. Дурлан татагдана гэж аливаа зүйлийг өөрийн мэдрэхүйд таашаал ханамж эдлүүлэх үүднээс хүлээн авч хэрэглэхийг хэлдэг бөгөөд эс дурлан татагдахуй гэдэг нь мэдрэхүйн ийм дурлан татагдахуйд автахгүй байхыг хэлдэг. Кришнагийн ухамсартавтан умбаж байгаа хэн бүхэн нь өөрийн амьдралыг Бурханд зүтгэхэд зориулж байдаг учир тэрээр дурлан татагдахуй болон эс дурлан татагдахуйн аль алиныг нь ч мэддэггүй. Тиймээс Кришнаг ухамсарласан хүн хэзээ ч уурлаж хилэгнэдэггүй. Ажил үйл нь амжилт муутай байсан ч мөн адил. Ялалт ч тэр ялагдал ч тэр Бурханд үйлчлэн зүтгэх гэсэн түүний шийдвэрийг ганхуулж чаддаггүй.

ШҮҮЛЭГ 57

*ях сарватранабхиснехас тат тат прапья шубхашубхам
набхинандати на дवेशти тасья прагья пратиштхита*

ях-тэр, хэн нэгэн, *сарватра*- хаа сайгүй, *анабхиснехах*- дур сонирхолгүй, *тат*- түүнийг, *прапья*- хүрэн, *шубха*- сайн, *ашубхам*- муу, *на*- хэзээ ч үгүй, *абхинандати*- магтах, *на*- хэзээ ч үгүй, *дवेशти*- атаархах, *тасья*- түүний, *прагья*-төгс төгөлдөр мэдлэг, *пратиштхита*- батгжсан.

Материаллаг ертөнцийн сайн болоод муу ямар ч зүйл тохиолдсон магтаал сайшаал хийгээд муучлал доромжлолын алинд ч үл автах хүн төгс төгөлдөр мэдлэгийг гүн бат хүртсэн байдаг.

ТАЙЛБАР: Материаллаг ертөнцөд зарим үед сайн, зарим үед муу болох өөрчлөлт хувиралтууд байнга явагдаж байдаг. Иймэрхүү материаллаг өөрчлөлтүүдийн улмаас амгалан тайван байдлаа алдахгүй, өөрөөр хэлбэл сайн муу алины ч нөлөөлд орж автахгүй байгаа хүнийг Кришнагийн ухамсарт батажсан гэж үздэг. Материаллаг ертөнц нь хоёрдмол байдлаар дүүрэн байдаг учир энэхүү ертөнцөд оршин байх хэн бүхэнд сайн болоод муу зүйл байнгад тохиолдох нь зүйн хэрэг. Кришнагийн ухамсарт автан байгаа хүний бүхий л ухаан бодол нь зөвхөн, үнэмлэхүй бөгөөд хамгийн сайн нь болох Кришнад төвлөрч н байдаг учир сайн муугийн алины нь ч нөлөөнд ордоггүй. Кришнад ийнхүү татагдан автаж амар амгаланг олсон ухамсар нь хүнийг мэргэжлийн хэллэгээр бол *самадхи* гэж нэрлэгддэг төгс төгөлдөр, трансценденталь түвшинд дээшлүүлэн хүргэдэг.

ШҮҮЛЭГ 58

*яда самхарате чаям курмо `нганива сарваиах
индрияниндрияртхебхьяс тасья прагья пратиштхита*

яда- хэрвээ, *самхарате*- хойш татах, *ча*- мөн, *аям*- тэр, *курмах*- яст мэлхий, *ангани*- мөчнүүд, *ива*- яаж, *сарваиах*-бүгд хамт, *индрияни*- мэдрэхүй, *индрия-артхебхьяс*- мэдрэхүйн объектоос, *тасья*- түүний, *прагья*- ухамсар, *пратиштхита*- батгжсан.

Яст мэлхий мөчүүдээ хуяг дотроо татан оруулдагтай адил мэдрэхүйгээ мэдрэхүйн объектуудаас хөндийрүүлэн холдуулах чадвартай хүн төгс төгөлдөр ухамсарт хөдөлбөргүй автсан байдаг.

ТАЙЛБАР: Иогч, чин бишрэлтэн эсвэл өөрийгөө бүрэн нээж танин мэдсэн сүнс мөн болохын шалгуур нь өөрийн мэдрэхүйгээ ухамсартайгаар эзэмдэн захирч чадаж байгаа чадвар байдаг. Гэхдээ ихэнхи хүмүүс өөрсдийн мэдрэхүйн боол болон тэдний тушаал зааварт хөтлөгдөж байдаг. Энэ нь иогч хүний шинж чанарын талаар асуусан асуултын хариулт болно. Мэдрэхүйнүүдийг хортой могойтой зүйрлэдэг бөгөөд тэд ямар ч жолоодлогогүй зоргоороо болоод ямар ч хязгаарлалтгүй үйлдэж, хийж байхыг хүсэж байдаг. Иймээс иогч буюу чин бишрэлтэн нь могойг эрхэндээ оруулах сургагч адил эдгээр могойнуудыг захирч байхын тулд маш их хүчтэй байх хэрэгтэй. Тэр тэдгээрийг өөрөөс нь хамааралгүйгээр үйл үйлдэхийг хэзээ ч зөвшөөрдөггүй. Ариун гэгээн судруудад энэ талын олон тооны сургаал зааврууд байдаг. Тэдгээрийн зарим нь хорио цээрийн шинжтэй байхад нөгөө хэсэг нь бүр эсрэгээр буюу хийж үйлдэхийг шаардсан байдаг. Энэ хоёр хэлбэрийн сургаал заавруудыг даган мөрдөх болон өөрийгөө мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйлээс хойш татах чадваргүй байгаа нөхцөлд хүн Кришнагийн ухамсарт байнга тогтвортой оршиж чадахгүй. Үүнтэй холбогдуулан татаж болох хамгийн сайн жишээ бол яст мэлхий юм. Яст мэлхий мөчүүдээ агшин зуурт татан хуяг доогуураа оруулахын зэрэгцээ тодорхой зорилгоор ямар ч цаг үед гадагш гаргаж чаддаг. Үүний нэгэн адил Кришнагийн ухамсарт оршин байгаа хүн өөрийн мэдрэхүйг зөвхөн Бурханд үйлчлэн зүтгэх тодорхой зорилгоор л ашигладаг ба энэхүү алба үйлээс гадуур бол тэр мэдрэхүйгээ хойш татсан байдалд байлгадаг. Энд, мэдрэхүйгээ өөрийн хувийн таашаал ханамжийн төлөө бус харин Бурханы алба үйлэнд зүтгэхэд ашиглахыг Аржунад сургаж байна. Мөчөө хойш нь татах яст мэлхийтэй зүйрлүүлсэн зүйрлэл нь хүн мэдрэхүйгээ Бурханы алба үйлэнд үргэлж зүтгүүлж байх ёстой гэдгийг тодорхой болгож байна.

ШҮҮЛЭГ 59

*вишая винивартанте нирахарасья дехинах
раса-варжам расо `ни асья парам дриштва нивартате*

вишаях- мэдрэхүйн таашаал ханамжийн объектууд, *винивартанте*- хойш татахад суралцах, *нирахарасья*- сөрөг хязгаар цээрүүдээр, *дехинах*- бие махбодийг олон төрсөн сүнсний хувьд, *раса-варжам*- амт дуршилыг орхин, *расах*- таашаал ханамжийн мэдрэхүй, *ати*- байдаг хэдий ч, *асья*- энд, *парам*- хавьгүй илүү зүйлс, *дриштва*- мэдэрсэнээ, *нивартате*-буурдаг.

Бие махбодид төрсөн сүнс нь мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйлээс татгалзан холдож болох боловч мэдрэхүйн объектуудын амт түүнд урьдын адил хадгалагдан үлдсэн хэвээр байдаг. Гэвч тэрээр дээд матыг мэдэрдэгц иймэрхүү дур хүслээ орхин ухамсартаа батжих болно.

ТАЙЛБАР: Трансценденталь түвшинд хүрээгүй цагт хүн мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйлээ бүрэн зогсооно гэдэг боломжгүй хэрэг. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийг тодорхой журам зааврын дагуу хязгаарлах нь өвчтэй хүнд хоолны дэглэм сахиулж зарим төрлийн хоол ундыг хэрэглэхийг хорьдогтой адил юм. Эдгээр хоол ундыг идэх дуршил алдагдаагүй байгаа өвчтөн иймэрхүү хязгаарлалт дэглэмд дуртай биш. Үүнтэй төстэйгөөр, мэдрэхүйн хязгаарлалтыг *аштанга-йога*-түүний үе шатууд болох: *яма*, *нияма*, *асана*, *пранаяма*, *пратьяхара*, *дхарана*, *дхьяна* гэх мэтчилэн ямар нэгэн бурханлаг арга замаар хийж болохыг илүү сайн мэдлэгийг үл хүртсэн байх оюунлаг бус хүмүүст зөвлөдөг. Харин Кришна ухамсарт ахиц дэвшил гаргах явцдаа Бурханы гайхамшигт сайхныг таньж мэдсэн хүн л үхмэл материаллаг зүйлүүдээс ямар ч амтыг

цаашид олохгүй. Иймэрхүү хязгаарлалтууд нь иймээс бурханлаг амьдралын зам мөрт шинээр орж байгаа, төдийлөн оюунлаг бус хүмүүст зориулагдсан байдаг бөгөөд харин Кришна ухамсрын амтыг үнэхээрийн хөгжүүлсэн хүний хувьд тэдгээр нь цаашдаа чухал бус болдог. Кришнаг үнэхээрийн ухамсарласан хүний хувьд уйтгартай заваан зүйлийн амт аяндаа үгүй болно.

ШҮҮЛЭГ 60

*ятато хй апи каунтея пурушасья випашичитак
индрияни праматхини харанти прасабхам манах*

ятатх- хичээснээр, *хи-* тодорхой, *апи-* ч, *каунтея-* Кунтийн хүү минь, *пурушасья-* хүний, *випашичитак-* бүрэн хэрсүү, *индрияни-* мэдрэхүй, *праматхини-* өдөөн, *харанти-* хаяж чулуулах, *прасабхам-* хүчээр, *манах-* ухааныг.

Ай Аржуна минь ээ, мэдрэхүй бол маш хүчтэй хийгээд эрчтэй бөлгөө. Тиймээс ч тэд өөрсдийг нь эзэмдэн захирахыг хичээн байгаа хийгээд ялган салгах чадвар бүхий хэрсүү хүний ухаант хүмүүнийг ч аваад явчих хүчтэй байдаг.

ТАЙЛБАР: Гүн гүнзгий мэдлэг бүхий олон мэргэд, гүн ухаантнууд болон трансценденталистууд мэдрэхүйгээ эзэмдэхийг хичээн их чармайлт гаргах боловч, заримдаа тэдний хамгийн аугаа нь ч ухаан нь өдөөгдсөний улмаас материаллаг мэдрэхүйн таашаал ханамжийн золиос болдог. Аугаа их мэргэн, төгс иогч Вишвамрита хүнд хэцүү *танасья* болон *йогын* дасгалуудаар мэдрэхүйгээ эзэмдэн захирахыг хичээж байсан ч түүнийг Менака бэлгийн харилцаанд татан оруулсан. Дэлхийн түүхэнд иймэрхүү жишээ баримт маш олон байдаг. Иймд, Кришнаг бүрэн ухамсарлаагүй хүний хувьд ухаан болон мэдрэхүйгээ эзэмдэн захирах гэдэг маш хүнд бэрх. Ухаан бодлоо Кришнад чиглүүлэлгүйгээр материаллаг үйлүүдээс болих боломжгүй юм. Аугаа их гэгээнтэн, чин бишрэлтэн Шри Ямуначарья бидэнд бодит жишээ болгон доорхийг өгүүлсэн:

*яд-авадхи мама четах кришна-падаравинда
нава-нава-раса-дхаманй удьятам рантум асит
тад-авадхи бата нари-сангаме смарьямане
бхавати мукха-викарах суитху ниитхиванам ча*

“Миний ухаан Шри Кришнагийн бадамлянхуа өлмийд үйлчлэн зүтгэсэн болон энэхүү зүтгэлээсээ байнгад улам шинэ шинэ бурханлаг баяр баясгалан, жаргал цэнгэлийг эдлэх болсон цагаас эхлэн, хэрвээ эмэгтэй хүнтэй бэлгийн харьцаатай болох талаар ямар нэгэн бодол ухаанд минь орж ирмэгц би тэр даруйхан өөрчилж тэр бодлоо нулиман хаядаг.”

Кришнагийн ухамсар бол материаллаг таашаал цэнгэл өөрөө жигшигдэх болдог тийм бурханлаг бөгөөд гайхамшигтай. Энэ нь өлсгөлөн хүн өлсгөлөнгөө тэжээллэг чанартай, хангалттай хэмжээний хоолоор дарахтай адил. Өөр нэг жишээ бол Махаража Амбариша ухаанаа Шри Кришнагийн ухамсарт гүнээ автуулж чадсанаар аугаа их иогч Дурваса Мунниг ялж дийлсэн түүх юм (*са вай манах кришна-падаравиндъор вачамси вайкунтха-гунануварнана*).

ШҮҮЛЭГ 61

*тани сарвани самьямья юкта асита мат-парах
ваше хи ясьяндрияни тасья прагья пратиитхита*

тани- аливаа мэдрэхүйгээ, *сарвани-* бүгд, *самьямья-* эзэмдэн захирсанаар, *юктах-* үйлдэх, *асита-* автах ёстой, *мат-парах-* Надтай холбон, *ваше-* бүрэн захиргаанд, *хи-* тодорхой, *ясья-* хэн нэгэн, *индрияни-* мэдрэхүй, *тасья-* түүний, *прагья-* ухамсар, *пратиитхита-* батжсан.

Мэдрэхүйгээ хойш татан бүрэн төгс эзэмдэн захирахын зэрэгцээ ухамсраа Надад төвлөрүүлж чадсан хүнийг тогтвортой оюун ухаантай хүн гэдэг.

ТАЙЛБАР: Энэ шүлэгт Кришнагийн ухамсар бол иогийн төгс төгөлдрийн дээдийн дээд түвшин гэдгийг тод томруунаар хэлж байна. Кришнаг ухамсарлаагүй л бол мэдрэхүйгээ эзэмдэн захирна гэдэг огт бүтэшгүй хэрэг. Дээр дурьдсанчлан, аугаа их мэргэн Дурваса Мунни Махаража Амбаришатай муудалцахдаа бардам сайрхуу зангаасаа болж уур хилэнгээ хий дэмий бадраасан тул мэдрэхүйгээ захирч хянаж чадахаа больсон. Харин тэгэхэд хаан хэдийгээр мэргэн лугаа сүрхий иогч биш ч Бурханы чин бишрэлтэн тул мэргэний зөв бус байдлыг тэвчин дуугүй өнгөрөөснөөрөө эцсийн дүндээ ялагч болж гарсан. Хаан, Шримад Бхагаватамын (9.4.18-20)-д өгүүлсэнчлэн, дараахь шинжүүдийг агуулж байсан учир мэдрэхүйгээ эзэмдэн захирч чадсан:

*са вай манах кришна-падаравиндайор
вачамси вайкунтха-гунануварнана
карау харер мандира-маржананишу
шрутим чакарачьота-сат-катходае*

*мукунда-лингалая-даршане дришау
тад-бхитья-гатра-спарше нга-сангамам
гхранам ча тат-пада-сарожжа-саурабхе
шримат-туласья расанам тад-арпите*

*падау харех кшетра-паданусарпана
широ хришикеша-падабхивандане
камам ча дасье на ту кама-камьяя*

“Амбариша хаан ухаанаа Шри Кришнагийн бадамлянхуа өлмийд төвлөрүүлэн, үг яриагаа Бурханы орныг тодорхойлон хэлэхэд зориулан, гараараа Бурханы сүмийг цэвэрлэн, чихээрээ Бурханы зугаа наадмын тухай сонсон, нүдээрээ Бурханы дүрийг ажиглан, биеэрээ чин бишрэлтэнгийн биеийг шүргэн, хамраараа Бурханы бадамлянхуа өлмийд өргөсөн цэцгийн үнэрийг үнэрлэн, хэлээрээ Бурханд өргөсөн *туласийн* навчийг амтлан, хөлөөрөө Бурханын сүмүүд орших ариун газруудаар яван, тэргүүнээрээ Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлж мөргөн, өөрийн хүслээ Бурханы тааллыг биелүүлэхэд зориулан... гэх зэргээр энэ бүхнийг үйлдэж байсаар Бурханы *мат-пара*-чин бишрэлтэн болсон.”

Мат-пара гэдэг үг нь үүнтэй холбогдон маш гүн утга агуулгатай. Хэрхэн *мат-пара* болж болохыг Махаража Амбаришагийн амьдрал тодорхой харуулж байна. *Мат-пара* сүлжээний *ачарья* хийгээд их номч Шрила Баладева Видьябхушана: *мад-бхакти-прабхавена сарвендрия-вижяя-пурвика сватма дриштитх сулабхети бхавах* буюу Кришнад чин бишрэлээр зүтгэсний хүчээр л мэдрэхүйгээ бүрэн эзэмдэн захирч болно гэж хэлсэн байдаг. Үүнтэй холбогдуулан зарим үед галаар жишээ татдаг: “Дүрэлзэн асаж байгаа гал өрөөн дотор байгаа бүхнийг шатаадаг шиг иогчийн зүрхнээ залрах Шри Вишну ариун бус бүхнийг тэгж шатаадаг.” Иогийн сударт Вишнуг бясалгах талаар зааварласан байдаг болохоос хоосныг биш. Вишнугийн түвшинд үл орших зүйлийг бясалгах иогч гэж өөрсдийгөө нэрлэх хүмүүс нь хуурмаг зүйлийн хойноос эрэлд хатаж цагаа хий дэмий үрж байгаа хэрэг. Бид Кришнагийн ухамсрыг хөгжүүлэн, Бурханы Бодгальд чин бишрэлээр зүтгэх хэрэгтэй. Энэ бол жинхэнэ иогийн зорилго.

ШҮЛЭГ 62

*дхьяято вишаян пумсах сангас тешупажаяте
сангат саньжаяте камах камат кродхо `бхижяяте*

дхьяятах- ажиглах явцдаа, *вишаян*- мэдрэхүйн объект, *пумсах*- хүний, *сангах*- дурлан татагдахуй, *тешу*- мэдрэхүйн объектод, *упажаяте*- хөгждөг, *сангат*- дурлан татагдлаас, *саньжаяте*- өөрөө хөгждөг, *камах*- шунал тачаал, *камат*- шунал тачаалаас, *кродхах*- уур хилэн, *абхижяяте*- үүсэн бий болдог.

Мэдрэхүйн объектыг ажиглаж харснаар хүн тэдгээрт дурлан татагддаг. Энэхүү дурлан татагдлаас шунал тачаал, харин шунал тачаалаас уур хилэн үүсэн бий болдог.

ТАЙЛБАР: Мэдрэхүйн объектуудыг харж ажиглах Кришнаг ухамсарлаагүй хүнд материаллаг хүсэл хөгжин бий болдог. Мэдрэхүйг зөв үйл ажиллагаанд чиглүүлэн хандуулах хэрэгтэй байдаг бөгөөд хэрвээ тэднийг Бурханы трансценденталь хайрын алба үйлэнд зүтгүүлэхгүй бол материализмын албан дахь үйлийн хойноос эрэл хайгуул хийн хөөцөлдөх нь гарцаагүй юм. Материаллаг ертөнц дэх амьд оршнол бүр, тэнгэрийн гаригуудын сахиулсан тэнгэрүүд бүү хэл Шива болон Брахма хүртэл мэдрэхүйн объектуудын нөлөөнд автсан байдаг бөгөөд материаллаг оршнолын энэхүү төөрөгдөл самуурлаас салан хагацах цорын ганц боломж бол Кришнаг ухамсарлах явдал юм. Гүн бясалгалд автан байсан Шива мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн Парватид хөтлөгдөн уруу татагдсаны улмаас Картикея төрсөн. Харидаса Тхакураг залуухан чин бишрэлтэн байхад Майа-девагийн хувилгаан дүр нь дээрхтэй адил оролдлого хийсэн ч тэрээр Шри Кришнад үнэнхүү чин бишрэлээр зүтгэдгийн ач тусаар энэхүү шалгалт сорилтыг амархан давсан билээ. Шри Ямуначарьягийн дээр дурьдсан шүлгээс үзэхэд Бурханы жинхэнэ чин бишрэлтэн нь Бурхантай харьцсанаар бурханлаг цэнгэл жаргалын илүү дээд амтыг мэдэрдэг учраас материаллаг мэдрэхүйн аливаа таашаал ханамжийг эдлэхээс зайлсхийдэг. Үүнд л амжилтын нууц оршдог. Өөрөөр хэлбэл, Кришнаг ухамсарлаагүй хүн мэдрэхүйгээ зохиомлоор шахалт үзүүлэх байдлаар хичнээн сайн эзэмдэн захирсан ч бай ялгаагүй мэдрэхүйн таашаал ханамжийн талаарх өчүүхэн төдий бодол санаа түүнийг хүслээ хангахад өдөөн хөтлөх учир эцсийн эцэст уналтанд орох нь эргэлзээгүй.

ШҮЛЭГ 63

*кродхад бхавати саммохах саммохат смрти-вибхрамаха
смрити-бхрамишад буддхи-нашо буддхи-нашат пранашьяти*

кродхат- уур хилэнгээс, *бхавати*- үүсдэг, *саммохах*- бүрэн хий хуурмаг, *саммохат*- хий хуурмагаас, *смрти*- ой санамж, *вибхрамах*- төөрөлдөл самуурал, *смрити- бхрамишат*- ой санамж төөрөлдөн самуурсаны дараагаар, *буддхи-нашах*- оюун ухаан алдагдана, *буддхи-нашат*- оюун ухаан алдагдсанаар, *пранашьяти*- хүн уналт доройтолд орно.

Уур хилэнгээс төөрөгдөл самуурал үүсэн бий болох ба төөрөгдөл нь ой санамжийг бүрхэгдүүлдэг. Ой санамж харанхуйлах аваас оюун ухаан алдагдана. Хүн оюун ухаанаа гэвээс материаллаг намагт буцан унадаг.

ТАЙЛБАР: Шрила Рупа Госвами бидэнд дараахь сургаалыг хайрласан:

*прапаньчикатая буддхяя хари-самбандхи-вастунах
мумукиубхих паритьяго вайрагьям пхалгу катхьяте
(Бхакти-расамрита-синдху, 1.2.258)*

Кришнагийн ухамсрыг хөгжүүлснээр хүн, бүхнийг Бурханы албанд ашиглаж хэрэглэж болно гэдгийг таньж мэддэг. Кришнагийн ухамсрын талаар ямар ч мэдлэггүй хүмүүс материаллаг зүйлсээс зохиомол байдлаар зайлсхийхийг оролддог. Иймээс ч тэд материаллаг боолчлолын уяа хүлэснээс ангижрахыг хичээн чармайсан ч огоорохуйн төгс төгөлдөр түвшинд хүрч чадаагүй. Тэдний огоорохуй хэмээх энэ үйл явцыг *пхалгу* буюу дутуу дулзмаг гэж нэрлэдэг. Харин тэгэхэд, Кришнаг ухамсарласан хүн бүх зүйлсийг Кришнагийн албанд хэрэглэж ашиглаж болно гэдгийг мэддэг учраас хэзээ ч материаллаг

ухамсарын золиос болж унадаггүй. Бодгаль бусыг баримтлагч нь жишээлбэл, Бурхан буюу Үнэмлэхүй бол бодгаль бус, тиймээс Тэр зоогийг таалан болгоож чаддаггүй гэж боддог. Бодгаль бусыг баримтлагч нь ийнхүү амт чанартай зоогоос зайлсхийж байхад, чин бишрэлтэн Кришна бол дээдийн дээд Таашаагч, Түүнд хайр чин бишрэлээр өргөсөн бүхнийг таалан болгоодог гэдгийг мэддэг. Чин бишрэлтэнгүүд Бурханд амтат зоогийг өргөсний дараагаар *прасадам* гэж нэрлэгдэх, илүү гарч үлдсэнийг нь хүртэцгээдэг билээ. Ийнхүү бүх зүйлс бурханлаг шинж чанартай болох бөгөөд уналтанд өртөх аюул учрахгүй. Чин бишрэлтэн Кришнагийн ухамсарт *прасадамаа* хүртэж байхад бодгаль бусыг даган баримтлагчид нь энэ бол материаллаг зүйл хэмээн үзэж түүнээс татгалздаг. Иймээс бодгаль бусыг баримтлагчид нь өөрсдийн зохиомол огоорохуйгаас болж амьдралын таашаал ханамжийг эдэлж чаддаггүй учраас ухаан нь өчүүхэн төдий өдөөлтөнд өртөн тэднийг материаллаг оршнолын намагт дахин унагадаг. Ийм сүнс нь ангижралын түвшинд мацан хүрсэн байж болох ч чин бишрэлийн алба үйлэнд үл тулгуурлах учир дахин унадаг гэж үздэг.

ШҮҮЛЭГ 64

*рага-двеша-вимуктайс ту вишаян индрияйш чаран
атма-вашьяйр видхейатма прасадам адхигаччхати*

рага- дурлан татагдахуй, *двеша-* салан хөндийрөхүй, *вимуктайх-* аас ангижирсан тэр, *ту-* харин, *вишаян-* мэдрэхүйн объектууд, *индрияйх-* мэдрэхүйгээр, *чаран-* чиглэж хандан, *атма-вашьяйх-* түүний захиргаан доор, *видхей-атма-* зохицуулагдсан ангижралын зарчмуудыг даган байгаа тэр, *прасадам-* Бурханы өршөөл нигүүлслийг, *адхигаччхати-* хүртэнэ.

Дурлан татагдахуй болон жигшил зэвүүцлээс ангид байж мэдрэхүйгээ ангижрахуйн зохицуулах зарчмуудаар эзэмдэн захирч чадаж байгаа хүн л Бурханы өршөөл нийгүүлслийг бүрэн хүртдэг.

ТАЙЛБАР: Урьд өмнө тайлбарсанчлан, хүн мэдрэхүйгээ зохиомол арга замаар өнгөцхөн төдий эзэмдэн захирч чадаж байж болох ч тэдгээрийг Бурханы трансценденталь алба үйлэнд зүтгэхэд хамруулан оролцуулахгүй л бол уналтанд өртөх аюул байнга нүүрлэсээр байх болно. Мөн Кришнаг бүрэн ухамсарласан хүн мэдрэхүйн түвшинд л үйл ажиллагаа явуулж буй мэт харагдаж байж ч магадгүй. Гэхдээ үнэн хэрэг дээрээ, тэр Кришнагийн ухамсарын ач тусаар мэдрэхүйн үйлэнд огтхон ч татагддаггүй. Кришнаг ухамсарласан хүн Кришнаг цэнгүүлэхээс өөр юуны ч тухай боддоггүй. Тийм учраас тэрээр аливаа дурлан татагдахуй болон эс дурлан татагдахуйгаас ангид дээгүүр трансценденталь түвшинд оршдог. Хэрвээ Кришна л таалан хүсэх аваас чин бишрэлтэн тухайн үйлийг ерөнхийдөө таатай биш байсан ч хийж гүйцэтгэдэг. Хэрвээ Кришна таалан хүсээгүй л бол тухайн үйл нь жирийн нөхцөл байдалд түүний хувийн ханамжинд хичнээн таашаалтай байх байсан ч хийдэггүй. Тэрээр зөвхөн Кришнагийн сургаал зааврыг удирдлага болгодог учраас аливаа үйлийг үйлдэх болоод эс үйлдэх нь түүний хяналтанд байдаг. Энэхүү ухамсар нь чин бишрэлтэнгийн хүртэх Бурханы учир шалтгаангүй өршөөл нигүүлсэл бөгөөд тэрээр үүнийг мөн мэдрэхүйн түвшний үйлүүдэд татагдан байсан ч хүртэх болно.

ШҮҮЛЭГ 65

*прасаде сарва-духкханам ханир асьопажяате
прасанна-четасо хй ашу буддхих парьяватиштхате*

прасаде- Бурханы учир шалтгаангүй өршөөл нигүүлслийг хүртсэнээр, *сарва-* бүхий л, *духкханам-* материаллаг зовлон, *ханых-* устал сүйрэл, *асья-* түүний, *упажяате-* явагдах болно, *прасанна-четах-* аз жаргалтайгаар бодогчийн, *хи-* тодорхой, *ашу-* мөдхөн, *буддхих-* оюун ухаан, *пари-* хангалттай, *аватиштхате-* батжин бэхждэг.

Ийм байдлаар (Кришнагийн ухамсарт) ханамжтай байх хэн бүхний хувьд материаллаг оршнолын гурвалсан зовлон цаашид эс орших бөгөөд ийм ханамжтай байх түвшинд хүрснээр түүний оюун ухаан мөдхөн батжин бэхждэг.

ШҮҮЛЭГ 66

*насти буддхир аюктасья на чаюктасья бхавана
на чабхаваятах шантир ашантасья кутах сукхам*

на асти- байж болохгүй, *буддхих-* трансценденталь оюун ухаан, *аюктасья-* (Кришнагийн ухамсартай) холбогдоогүй хэн бүхний, *на-* үгүй, *ча-* мөн, *аюктасья-* Кришнагийн ухамсаргүй хэн бүхний, *бхавана-* аз жаргалд автан умбасан ухаан, *на-* үгүй, *ча-* мөн, *абхаваятах-* батжан бэхжээгүй хэн бүхний, *шантих-* амар амгалан, *ашантасья-* тайван бус байгчийн, *кутах-* хаана, *сукхам-* аз жаргал.

Бүхний Дээдтэй (Кришнагийн ухамсарт) холбогдоогүй хэн бүхэн нь тайван амгаланд хүргэдэг трансценденталь оюун ухаан болон тогтвортой ухаантай байж чаддаггүй. Тэдэнгүйгээр тайван амгалан байх боломжгүй ба тайван амгалангүйгээр аз жаргал гэж яаж байх билээ дээ.

ТАЙЛБАР: Кришнаг ухамсарлаагүй байсан цагт хүн амар амгаланд хүрнэ гэдэг боломжгүй хэрэг. Тав дугаар бүлгийн (5.29)-д: Кришна бол тахилга өргөлийн болоод тэвчил, огоорлын бүхний л сайн үр дагавруудын цорын ганц таашаагч, орчлонгийн бүх илрэлүүдийг эзэмшигч эзэн бөгөөд бүх амьд оршнолуудын жинхэнэ найз нөхөр нь мөн гэдгийг ойлгосон хүн л жинхэнэ тайван амгаланг олно гэж өгүүлдэг. Иймд Кришнаг ухамсарлаагүй хэн бүхний ухаанд дээдийн дээд зорилго байдаггүй. Амгалан бус байна гэдэг нь дээдийн дээд зорилго байдаггүйтэй холбоотой бөгөөд Кришнаг бүхнээр жарган цэнгэгч, бүгдийг эзэмшигч, бүгдийн найз нөхөр гэдэгт итгэж үнэмшсэн хүн л тогтвортой ухаанаараа тайван амгаланг олно. Иймээс Кришнаатай холбогдсон холбоо харьцаагаа үл анхаарах хэн бүхэн бурханлаг хөгжил дэвшилд болон тайван амгаланд хүрсэн дүр үзүүлэхийг хичээн чармайж байсан ч байнгад зовж шаналахын зэрэгцээ тайван амгалан байдлыг огтхон ч үздэггүй. Кришнагийн ухамсар бол өөрөө амар амгалан бөгөөд түүнд гагцхүү Кришнаатай холбоо харилцаатай байж л хүрч болно.

ШҮҮЛЭГ 67

*индриянам хи чаратам ян mano `нувидхияте
тад асья харати прагьям ваюр навам ивамбхаси*

индриянам- мэдрэхүйн, **хи-** тодорхой, **чаратам-** угзрах үед, **ят-** юу, **манах-** ухаан, **анувидхияте-** байнгад татагдана, **тат-** түүнийг, **асья-** түүний, **харати-** холдуулан одно, **прагьям-** оюун ухаан, **ваюх-** салхи, **навам-** завь, **ива-** яаж, **амбхаси-** усан дээр.

Хүчит салхи усны мандал дээрх завийг хэрхэн хөөн авч оддогийн адил жолоодлогогүй байх мэдрэхүйнүүдээс, ухааны чиглэн хандсан зөвхөн нэг нь л хүний оюун ухааныг угз татан цааш авч оддог.

ТАЙЛБАР: Бүх мэдрэхүйгээ Бурханы алба үйлэнд хамруулан зүтгүүлээгүй л бол өөрийн таашаал ханамж эдлэх эрмэлзэлдээ хөтлөгдсөн тэдний зөвхөн нэг нь л чин бишрэлтэнг бурханлаг хөгжлийн зам мөрөөс татан гаргачихаж чадна. Махаража Амбаришагийн амьдралаар тодорхой болсончлон, бүх мэдрэхүйгээ Бурханы алба үйлэнд татан оролцуулж зүтгүүлэх хэрэгтэй. Учир нь энэ бол ухаанаа эзэмдэн захирах зөв арга болой.

ШҮҮЛЭГ 68

*тасмад ясья маха-бахо нигрихитани сарваиах
индрияниндрияртхебхьяс тасья прагья пратиштхита*

тасмат- иймээс, **ясья-** хэний, **маха-бахо-** хүчит гарт минь, **нигрихитани-** ийнхүү эзэмдэн захирсан, **сарваиах-** бүгд хамтдаа, **индрияни-** мэдрэхүй, **индрия-артхебхьях-** мэдрэхүйн объектоос, **тасья-** түүний, **прагья-** оюун ухаан, **пратиштхита-** батжсан.

Иймээс ай хүчит гарт минь ээ, мэдрэхүйгээ тэдний дурлан татагддаг зүйлүүдээс холдуулан барьж чаддаг хүний оюун ухаан нь батжин бэхжсэн байдаг гэдэг нь эргэлзээгүй.

ТАЙЛБАР: Мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн шавдалт шаардлагыг зөвхөн Кришнагийн ухамсрын тусламжтайгаар буюу бүх мэдрэхүйгээ Бурханы трансценденталь хайрын алба үйлд хамруулж оролцуулсан цагт л дарж чадна. Дайснаа илүү хүчтэй байж ялж дийлдэгийн адилаар мэдрэхүйг мөн тэгж байж л ялах болно. Гэхдээ тэднийг хүний хүчин чармайлтаар биш, зөвхөн Бурханд зүтгэх үйлэнд байнга хамруулж оролцуулснаар л эзэмдэн захирч болно. Зөвхөн Кришнагийн ухамсрын тусламжтайгаар л оюун ухааны түвшинд үнэхээрийн батжин бэхжиж болохыг хийгээд энэ урлагийг зөвхөн жинхэнэ номын багшийн удирдлага доор суралцах ёстойг ойлгосон хүнийг *садхака* буюу ангижралыг олж чадах хүн гэдэг.

ШҮҮЛЭГ 69

*я ниша сарва-бхутанам тасьям жагартти самьями
ясьям жаграти бхутани са ниша пашьято мунех*

я- юу, **ниша-** шөнө, **сарва-** бүгд, **бхутанам-** амьд оршнолын, **тасьям-** түүнд, **жагартти-** сэрүүн, **самьями-** өөрийгөө эзэмдэн захирагч, **ясьям-** үед, **жаграти-** сэрүүн, **бхутани-** бүх оршнолууд, **са-** энэ бол, **ниша-** шөнө, **пашьятах-** дотоод руугаа хандсан, **мунех-** мэргэд.

Бүх оршнолуудын хувьд шөнө эхлэхэд өөрийгөө эзэмдэн захирагчийн хувьд сэрэх цаг нь болдог. Бүх оршнолуудын сэрэх цаг болоход дотооддоо хандсан мэргэдийн хувьд шөнө эхэлдэг.

ТАЙЛБАР: Оюунлаг хүмүүсийн хоёр төрөл байдаг. Нэг нь мэдрэхүйн таашаалаа хангах материаллаг үйлийн хойноос хөөцөлдөхөд оюун ухаанаа ашигладаг байхад нөгөө нь өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн шаардлагатайг ухааран дотоод руугаа хандаж байдаг. Дотоод руугаа хандах мэргэн буюу эргэцүүлэн бодох хүний үйл нь зөвхөн материаллаг зүйлсийн тухай боддог хүмүүсийн хувьд шөнө байдаг. Материалист хүмүүс нь өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн талаар юу ч үл мэдэх учир тэд өөрсдийнхөө шөнө эхлэхэд унтацгаадаг. Дотоод руугаа хандах мэргэн нь материалист хүмүүсийн “шөнө” сэрүүн байдаг. Дотоод руугаа хандсан мэргэд нь бурханлаг зам мөр дэх аажим аажмаар урагшлан дэвших хөгжлийн явцдаа трансценденталь цэнгэл жаргалыг мэдэрч байхад материаллаг үйлийн хойноос хөөцөлддөг хийгээд өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйгээ нам унтуулж байгаа хүмүүс гүн нойрондоо дугжран мэдрэхүйн янз бүрийн таашаал ханамжийн тухай зарим үед баяр хөөртэй, зарим үед зовлон шаналалтай зүйлийг зүүдлэнэ. Дотооддоо хандах хүний хувьд материаллаг жаргал зовлонг үргэлж ч үл ажрана. Тэр материаллаг үр дагаварт амгалан тайван байдлаа алдагдуулалгүйгээр өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн үйлээ цаашид үргэлжлүүлж байдаг.

ШҮҮЛЭГ 70

*апурьяманам ачала-пратиштхам
самудрам апах правишанти ядват
тадват кама ям правишанти сарве
са шантим апноти на кама-ками*

апурьяманам- байнгад дүүргэгддэг, *ачала-прапиштхам*- үргэлж дөлгөөн, *самудрам*- далайн, *анах*- ус, *правишанти*- цутгах, *ядват*- яаж, *тадват*- тэгж, *камах*- хүсэл, *ям*- түүнд, *правишанти*- цутган, *сарве*- бүх, *сах*- хүний, *шантим*- тайван амгалан, *апноти*- хүрнэ, *на*- үгүй, *кама-ками*-өөрийн хүслээ биелүүлэхийг хүсэгч тэр.

Гол мөрний ус зогсолтгүй цуггах боловч далай урьдын адил дөлгөөн хэвээр, эргээсээ үл халин гардгийн адил тасралтгүй үргэлжлэх хүслийнхээ урсгалд өдөөгдөн авталгүй байх хүн л тайван амгаланд хүрдэг. Харин иймэрхүү хүслүүдээ хангахын хойноос тэмүүлэх хэн бүхэн түүнд хүршгүй билээ.

ТАЙЛБАР: Өргөн их далай нь усаар байнга дүүрэн байдаг ч борооны улиралд бүр их усаар дүүргэгддэг. Тэгсэн ч далай урьдын адил дөлгөөн хэвээр, давалгаа нь тогтуун, эргээсээ үл халин гарна. Кришнагийн ухамсарт батжин бэхжсэн хүн энэхүү далайтай адил билээ. Амьд оршнол бие махбодид оршин байгаа цагт түүний мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн шаардлага хэвээр байдаг. Тэгсэн ч чин бишрэлтэн нь бүхнээр хангагдсан байдаг учраас ийм хүсэлд автан хөтлөгддөггүй. Бурхан материаллаг бүх хэрэгцээг нь хангаж өгдөг тул Кришнагийн ухамсарт оршин буй хүн дутагдаж гачигдахыг үл мэднэ. Иймээс тэрээр далай мэт байнга өөрөө өөртөө дүүрэн байдаг. Далайд цутгах голын ус адил янз бүрийн хүсэл орж ирж байсан ч тэрээр мэдрэхүйн таашаал ханамж эдлэх хүсэлд өчүүхэн төдий ч өдөөгдөн хөтлөгдөлгүй өөрийн үйлээ тогтвортой үргэлжлүүлдэг. Энэ бол Кришнаг ухамсарласан хүн мөн гэдгийн баталгаа. Хэдийгээр хүсэл оршин байх боловч түүнд материаллаг мэдрэхүйн таашаал ханамж эдлэх дур сонирхол байдаггүй. Тэрээр Бурханы трансценденталь хайрын албанд зүтгэх үйлэндээ ханамжтай байх тул далай мэт дөлгөөн байдаг. Иймээс ч тэр бүрэн дүүрэн тайван амгаланд оршиж байдаг.

Материаллаг амжилтын хойноос хөөцөлдөгчид бүү хэл ангижралд хүрэхийг хүсэгч бусад хүмүүс хүртэл хэзээ ч тайван амгаланд хүрч чаддаггүй. Үр дагавар дагуулагч үйлийн хойноос хөөцөлдөгч *карми*, чөлөөлөгдөл ангижралыг эрэлхийлэгч *гьяни* болон ид шидийн хүч хүсэгч *йогчид* нь өөрсдийн нь хүсэл биелэхгүй байгаагийн улмаас бүгд л аз жаргалтай бус байдаг. Харин тэгэхэд Кришнагийн ухамсарт оршигч хүн бүхэн Бурханы албанд үйлчлэн зүтгэж байгаадаа аз жаргалтай байдаг бөгөөд түүнд биелэгдэх ёстой өөр хүсэл байдаггүй. Үнэн хэрэгтээ, тэд материаллаг боолчлогдол хэмээгдэх зүйлээс ч ангижрахыг эрмэлздэггүй. Кришнагийн чин бишрэлтэнд материаллаг хүсэл сонирхол байдаггүй учир тэд бүгд байнгад төгс төгөлдөр амар амгалан байдалд амьдардаг.

ШҮҮЛЭГ 71

вихая каман ях сарван пумами чарати нихсприхах
нирмамо нираханкарах са шантим адхигаччхати

вихая- орхин, *каман*- мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн материаллаг хүсэл, *ях*- түүнийг, *сарван*- бүх, *пумам*- хүн, *чарати*- амьдардаг, *нихсприхах*- хүсэл үгүй, *нирмамах*- эд баялаг эзэмших гэсэн эрмэлзлэлийгээр, *нираханкарах*- хуурамч эго-гүйгээр, *сах*- тэр, *шантим*- төгс төгөлдөр амар амгалан, *адхигаччхати*-хүрдэг.

Мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн бүхий л хүсэл эрмэлзлээ орхиж, хүслийн нөлөөнд үл автан амьдарч, эд баялаг өмчлөх эзэмших гэсэн санаархал болон хуурамч эго-гоос ангид байх хүн л жинхэнэ амар амгаланд хүрдэг.

ТАЙЛБАР: Хүсэл эрмэлзлээс ангид байна гэж мэдрэхүүдээ таашаал ханамж эдлүүлэхийн төлөө юунд ч шавдан тэмүүлэхгүй байхыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, Кришнаг ухамсарлах хүсэл бол хүслээс жинхэнэ ангид байгаа хэрэг. Өөрийгөө материаллаг бие махбодь хэмээн андуу ташаагаар адилтган үзэхгүйн зэрэгцээ энэхүү ертөнцөд аливаа зүйлийг өмчлөх, эзэмших гэсэн хуурмаг санаархлаа огоорон өөрийн жинхэнэ байр сууриа Кришнагийн мөнхийн албат зарц гэж хэмээн ойлгох нь Кришнагийн ухамсарын төгс төгөлдөр түвшин билээ. Энэхүү төгс төгөлдөр түвшинд оршин байгаа хүн Кришна бол бүх зүйлсийг өмчлөгч, эзэмшигч эзэн учраас Түүнийг цэнгүүлэхийн тулд бүхнийг ашиглах хэрэгтэй гэдгийг мэддэг. Аржуна өөрийн мэдрэхүйн таашаал ханамжийн төлөөнөөс болж тулалдахыг хүсэхгүй байсан ч, Кришнаг бүрэн ухамсарласнаар Түүний шаардсаны дагуу тулалдаанд орсон билээ. Өөрийнхөө төлөө тулалдах шаардлагагүй байсан ч Кришнагийн төлөөнөө тэр л Аржуна бүх хүч чадлаараа тулалдсан билээ. Хүслээс жинхэнээр огоорох буюу хүсэлгүй байна гэдэг бол Кришнаг цэнгүүлэхийг хүсэхийг хэлэхээс биш ямар нэгэн зохиомол аргаар хүслээ дарахыг оролдоно гэсэн үг биш. Амьд оршнол нь хүсэх болоод мэдрэхээс ангид байж чаддаггүй. Харин хүслийнхээ шинж чанарыг л өөрчлөх хэрэгтэй. Материаллаг хүсэл үл агуулах хүн бүх зүйлс Кришнад хамааран Түүний соёрхолд байдаг (*шиавасьям идам сарвам*) гэдгийг тодорхой мэдэх учир аливаа зүйлийг өөртөө эзэмших гэсэн хуурмаг санаархалд автдаггүй билээ. Энэхүү трансценденталь мэдлэг нь өөрийгөө танин мэдэхүйд буюу амьд оршнол нь Кришнагийн салшгүй өчүүхэн жижиг хэсэг мөн болохын хувьд бурханлаг мөн чанартай, иймээс ч тэрээр Кришнаатай хэзээ ч эн зэрэгцэхгүй бөгөөд Түүнээс даван илүү гарч чадахгүй юм гэдгийг ойлгож мэдсэн байдагт үндэслэгддэг. Кришнагийн ухамсарын энэхүү ойлголт нь жинхэнэ амар амгалангийн үндсэн зарчим билээ.

ШҮҮЛЭГ 72

эша брахми стхитих партха найнам пранья вимухьяти
стхитивасьям анта-кале `ни брахма-нирванам риччхати

эша- энэ, *брахми*- бурханлаг, *стхитих*- байр суурь, *партха*- Притхын хүү минь, *на*- үгүй, *энам*- үүнд, *пранья*- хүрсэнээр, *вимухьяти*- төөрөлддөг, *стхитива*- оршноор, *асьям*- энэ байдалд, *анта-кале*- амьдралынхаа төгсгөлд, *ани*- мөн, *брахма-нирванам*- Бурханы бурханлаг орон, *риччхати*-хүрдэг.

Энэ бол сүнслэг буюу бурханлаг амьдралын зам мөр юм. Энэхүү зам мөрд хүрсэнээр хүн цаашдаа төөрөлдөж самуурахгүй. Үхэх цаг мөчдөө ч энэ ухамсартаа автан байгаа хүн Бурханы оронд очих болно.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсарын буюу бурханлаг амьдралын түвшинд хүн агшин зуурт, нэг секундын дотор ч хүрч болно. Эсвэл сая сая төрөлтийн дараа ч хүрэхгүй байж болно. Энэ бүхэн, хүн үүнийг ойлгож хүлээж авч байна уу үгүй юу гэдгээс хамаардаг. Кхатванга Махаража энэ түвшинд үхэхийнхээ өмнөхөн хэдхэн минутын дотор Кришнад өөрийгөө даатгаж

чадсанаар хүрсэн билээ. *Нирвана* гэж материаллаг амьдрал оршнолоо төгсгөл болгохыг хэлдэг. Буддизмын философийн онолоор бол материаллаг амьдрал төгссөний дараагаар зөвхөн хоосон л байдаг. Харин Бхагавад Гитад энэ талаар өөрөөр номлодог. Материаллаг амьдрал буюу оршнол төгссөний дараагаар жинхэнэ амьдрал, оршнол эхэлдэг. Бүдүүн баараг материалистуудын хувьд материаллаг амьдрал, оршнолоо төгсгөл тавих хэрэгтэй гэж мэдэх нь л хангалттай байдаг бол бурханлаг хөгжил дэвшилд хүрсэн хүмүүс материаллаг амьдралын дараагаар өөр амьдрал эхлэнэ гэдгийг мэддэг. Өөрийн амьдралаа төгсгөл болохоос өмнө Кришнаг ухамсарлах аз завшаан тохиосон хүн *брахма-нирвана* түвшинд шуудхан хүрдэг. Бурханы залран байх орон болон Бурханы чин бишрэл дүүрэн алба хоёрын хооронд ялгаа байдаггүй. Энэ хоёр нь хоёул үнэмлэхүй түвшинд байдаг учир Бурхан Кришнагийн трансценденталь хайрын албанд бишрэн зүтгэж байгаа хүн бурханлаг ертөнцөд хэдийнээ хүрсэн гэсэн үг. Материаллаг ертөнцөд хүн өөрийн мэдрэхүйд таашаал ханамж эдлүүлэхийн төлөө үйл үйлдэж байдаг бол бурханлаг ертөнцийн бүхий л үйл нь Кришнагийн ухамсартай байдаг. Кришнагийн ухамсарт хүрсэн хүн нь Брахманы түвшинд хүрсэн байдаг бөгөөд үүнд энэ амьдралдаа ч хүрч болно. Кришнагийн ухамсарт оршин байх хэн бүхэн бурханлаг ертөнцөд хэдийнээ хүрсэн гэдэг нь эргэлзээгүй хэрэг юм.

Брахман бол материйн эсрэг тал юм. Иймээс ч *брахми-стхити* нь “материаллаг үйлийн түвшинд биш” гэсэн утгатай үг болно. Бурханы чин бишрэлийн алба бол ангижралын түвшин юм (*са гунан саматитьяйтан брахма-бхуя калпате*) гэж Бхагавад Гитагийн (14.26)-д өгүүлдэг. Иймээс *брахма-стхити* нь материаллаг боолчлогдлоос ангижрахуй гэсэн утгыг илэрхийлэх юм.

Шрила Бхактивинода Тхакура, Бхагавад Гитагийн хоёр дугаар бүлэг нь энэ номын хураангуйлал юм гэж тайлбарласан байдаг. Бхагавад гитад *карма-йога*, *гьяна-йога* болон *бхакти-йогын* талаар авч үздэг. Энэ хоёр дугаар бүлэгт *карма-йога* болон *гьяна-йогын* тухай дэлгэрэнгүй өгүүлэхийн сацуу энэ номын хураангуйлал болгон мөн *бхакти-йогын* талаар товч дурдсан.

Шримад Бхагавад Гитагийн “Бхагавад Гитагийн хураангуй тойм нэртэй” хоёр дугаар бүлэгт Бхактиведантын хийсэн тайлбар ийнхүү өндөрлөлөө.

ГУРАВ ДУГААР БҮЛЭГ Карма-йога

ШҮЛЭГ 1

*аржуна увача
жьяяси чет караманас те мата буддхир жанардана
тат ким кармани гхоре мам нийожаяси кешава*

аржунах увача- Аржуна айлтгасан нь, *жьяяси*- илүү сайн, *чет*- хэрвээ, *карманас*- үр дагавар дагуулах үйл, *те*- Таны хувьд, *мата*- тооцогддог, *буддхир*- оюун ухаан, *жанардана*- ай Кришна минь ээ, *тат*- ийм учраас, *ким*- яагаад, *кармани*- ажил үйлд, *гхоре*- аймшигт, *мам*- намайг, *нийожаяси*- оролцуулах, *кешава*-ай Кришна минь.

Аржуна айлтгасан нь: Ай Жанардана, ай Кешава минь ээ, оюун ухаан нь үр дагавар дагуулах үйлээс илүү дээр гэж үзэж байгаа юм бол намайг юунд энэ аймшигт дайн тулаанд оролцуулахыг хүсээд байгаа юм бэ?

ТАЙЛБАР: Бурханы Дээд Бодгаль, Шри Кришна Өөрийн дотнын сайн нөхөр Аржунаг материаллаг зовлонгийн далайгаас аврахын тулд сүнсний мөн чанарын талаар өмнөх бүлэгт маш нарийн тодорхой айлдсан билээ. Тэр түүнд танин мэдэхүйн зам мөр болгон Кришнагийн ухамсар, *буддхи-йога-г* зөвлөсөн бөлгөө. Заримдаа, хүмүүс Кришнагийн ухамсрыг үйл үл үйлдэх, идэвхигүй байдал хэмээн буруу ойлгодог тул ийм андуу ташаа ойлголт авсан хүмүүс ихэнхидээ Кришнаг бүрэн ухамсарлахын тулд Шри Кришнагийн ариун гэгээн нэр алдрыг давтан хэлэхээр хүнгүй аглаг эзлүүд газарт ганцаараа очдог. Гэхдээ Кришнагийн ухамсрын философид гүн суралцалгүйгээр Бурханы ариун гэгээн нэр алдрыг эзгүй аглаг газар очин давтан хэлэхийг зөвлөдөггүй. Ингэх нь зөвхөн юм мэдэхгүй хүмүүсийн гайхшрал, хачирхалыг төрүүлэхээс цаашгүй. Аржуна мөн Кришнагийн ухамсар, *буддхи-йога* буюу бурханлаг мэдлэгийн хөгжил дэвшилд оюун ухаанаа ашиглах замаар хүрэхийн тулд идэвхитэй амьдралаас холдон аглаг эзлүүд газарт очиж тэвчил наминчлал үйлдэх юм шиг бодож байв. Өөрөөр хэлбэл тэрээр Кришнагийн ухамсраар шалтаглан тулалдаанаас эвтэйхнээр зайлсхийхийг хүсэж байв. Гэхдээ тэр буурь суурьтай хэрсүү шавийн ёсоор үйл хэргийн учир байдлыг өөрийн багш Кришнад илээр гарган тавьж, түүний хувьд хэрхэх нь хамгийн сайн болохыг Түүнээс асууж байна. Шри Кришна энэ асуултын нь хариу болгон түүнд энэхүү гурав дугаар бүлэгт *карма-йога* буюу Кришнагийн ухамсар дахь үйлийн талаар дэлгэрэнгүй тайлбарлана.

ШҮЛЭГ 2

*вьямишренева вакьена буддхим мохаясива ме
тад экам вада нишчитья ена шрейо `хам апнуйам*

вьямишрена-хоёр утгатай, *ива*- тодорхой, *вакьена*- үгнүүд, *буддхим*- оюун ухаан, *мохаяси*- төөрөлдүүлж байна, *ива-ме*- миний, *тат*- иймээс, *экам*- зөвхөн ганц, *вада*- хэлээч, *нишчитья*- тодорхойлсноор, *ена*- түүгээр, *шреяx*- жинхэнэ ач тус, *ахам*- би, *апнуям*- хүлээн авна.

Миний оюун ухаан Таны айлдах хоёрдмол утгатай айлдварт бүр төөрөлдөж орхилоо. Иймд миний хувьд хэрхэх нь хамгийн үр дүнтэй болохыг тодорхой айлдана уу?

ТАЙЛБАР: Өмнөх бүлэгт, Бхагавад Гитагийн удиртгал болгон янз бүрийн зам мөрүүдийн талаар, жишээлбэл: *санкхья-йога*, *буддхи-йога*, оюун ухаанаараа мэдрэхүйгээ эзэмдэн захирах, дагалдах үр дүнд нь татагдалгүйгээр үйл үйлдэх болон шинээр эхлэгчийн байр суурийн талаар тайлбарласан. Гэхдээ энэ бүхнийг нарийн дэс дараалалтайгаар тайлбарлаагүй тул эдгээр зам мөрийг зөв ойлгож даган баримтлахын тулд бүр эмх цэгцтэй тайлбар хэрэгтэй. Иймээс Аржуна будлиулж төөрөлдүүлэх мэт санагдах энэхүү сургаалыг эгэл жирийн хүн хүртэл ямар ч алдаа мадаггүйгээр ойлгож чадахаар тодруулахыг хүсэж байна. Хэдийгээр Кришна олон утгат айлдвараараа Аржунаг төөрөлдүүлж самууруулах гэсэн санааг агуулаагүй ч Аржуна Кришнагийн ухамсрын арга замыг үйл үл үйлдсэнээр ч тэр, мөн идэвхитэйгээр үйлчлэн зүтгэсэнээр ч тэр дагаж мөрдөж чадахааргүй байв. Өөрөөр хэлбэл, тэр ингэж асууж тодруулснаар Бхагавад Гитагийн нууцыг ойлгохыг үнэхээрийн чармайх бүх шавь нарт Кришнагийн ухамсарт хүрэх зам мөрийг гэрэлтүүлэн гийгүүлж гэгээн саруул болгож байна.

ШҮЛЭГ 3

шри бхагаван увача
локе `смин дви-видха ништха пура прокта маянагха
гьяна-йогена санкхьянам карма-йогена йогинам

шри бхагаван увача- Бурханы Дээд Бодгаль айлдсан нь, *локе*- гаригт, *асмин*- энэ, *дви-видха*- хоёр төрөл, *ништха*- итгэл, *пура*- урьд өмнө, *прокта*- хэлсэн, *майа*- Надаар, *анагха*- ай нүгэл үгүй минь ээ, *гьяна-йогена*- мэдлэгийн холбох үйл явцаар, *санкхьянам*- эмпирик философчдоор, *карма-йогена*- чин бишрэлийн холбох үйл явцаар, *йогинам*- чин бишрэлтэнгээр.

Бурханы Дээд Бодгаль айлдсан нь: Ай нүгэл үгүй Аржуна минь ээ, өөрийн “Би”-г танин мэдэхийг чармайх хоёр төрлийн хүмүүс байдаг тухай Би урьд нь айлдсан билээ. Тэдний зарим нь туршилтат, гүн ухааны цэцэрхийллээр, нөгөө хэсэг нь Бурханы чин бишрэлийн албанд зүтгэсэнээр ойлгохыг хичээдэг.

ТАЙЛБАР: Бурхан хоёр дугаар бүлгийн 39 дүгээр шүлэгт *санкхья-йога* болон *карма-йога* буюу *буддхи-йога* гэсэн хоёр өөр арга замуудын талаар тайлбарласан. Харин энэ шүлэгт Бурхан тэр талаар илүү тодорхой тайлбарлаж байна. *Санкхья-йога* буюу сүнсний болон материйн мөн чанарыг задлан шинжилж судлах замаар цэцэрхийлэлд дуртай, бүхнийг туршилтын дүнд гарсан мэдлэг хийгээд гүн ухааны аргаар ойлгохыг оролдогч хүмүүс замнадаг. Харин нөгөө бүлгийн хүмүүс нь хоёр дугаар бүлгийн 61 дүгээр шүлэгт тайлбарласанчлан, Кришнагийн ухамсарт үйл ажиллагаагаа явуулж байдаг. Бурхан мөн 39 дүгээр шүлэгт Кришнагийн ухамсрын буюу *буддхи-йогын* зам мөрийн үндсэн зарчмуудыг даган баримталснаар хүн үйлийнхээ уяа хүлээснээс ангижирдаг тухай болон энэ арга зам нь аливаа алдаа дутагдлаас ангид байдаг тухай тайлбарласан билээ. Мөн цааш нь энэ талаар 61 дүгээр шүлэгт тайлбарласан ба тэнд, *буддхи-йога* гэдэг нь Бүхний Дээдээс (бүр тодорхой хэлбэл Кришнагаас) бүрэн хамааралтай байхыг хэлэх бөгөөд ингэснээр бүхий л мэдрэхүйгээ маш хялбархан хянаж чадах болно гэж өгүүлсэн. Иймээс иогийн энэ хоёр хэлбэр нь шашин болоод гүн ухааны нэгэн адил бие биенээсээ харилцан хамааралтай байдаг. Гүн ухаан дээр үндэслэж тулгуурлаагүй шашин бол сентименталь, заримдаа бүр фанатизм (дэврүүн туйлшрал) байдаг бол шашингүй гүн ухаан нь ухаан бодлын цэцэрхийллээс өөр юу ч биш юм. Үнэмлэхүй Үнэний эрэлд үнэнхүү шамдагч философичид нь эцсийн эцэст Кришнагийн ухамсарт ирэх тул дээдийн дээд зорилго бол Кришна юм. Үүнийг мөн Бхагавад Гитагийн (7.19)-д батлан өгүүлдэг. Дээд Сүнстэй холбогдсон өөрийн сүнсний жинхэнэ байр суурийг ойлгоход бүхий л үйл явц чиглэдэг. Философийн цэцэрхийллийн буюу шууд бус арга зам нь хүнийг Кришнагийн ухамсарт аажим аажмаар, удаанаар хүргэдэг бол нөгөө замаар замнагч нь бүхнийг шууд Кришнагийн ухамсарт үйлдэж байдаг. Энэ хоёр арга замуудаас Кришнагийн ухамсрын арга зам нь илүү төгс юм. Учир нь энэ арга зам нь мэдрэхүйгээ философийн эрэгцүүлэн бодох, шүүн тунгаах үйл явцын тусламжтайгаар ариусгахаас үл хамаардаг. Кришнагийн ухамсар нь өөрөө хүнийг материаллаг бузраас ариусгадаг арга зам. Бурханы чин бишрэлийн алба үйлэнд зүтгэх шууд арга болохын хувьд энэ нь хялбар байдгийн зэрэгцээ эрхэм дээд ариун бөлгөө.

ШҮЛЭГ 4

на карманам анарамбхан найшкармьям пурушо `шнуте
на ча санньясанад эва сиддхим самадхигаччхати

на- үгүй, *карманам*- оноогдсон үүргүүд, *анарамбхат*- үйлдээгүйгээр, *найшкармьям*- үр дагавраас ангид, *пурушах*- хүн, *ашнуте*- хүрдэг, *на*- үгүй, *ча*- мөн, *санньясанат*- огоорсноор, *эва*- үнэндээ, *сиддхим*- төгс төгөлдөр, *самадхигаччхати*- хүртэх.

Хүн ажил үйлээсээ зүгээр л татгалзан хойш сууснаар үйлийнхээ үр дагавраас ангижирдаггүй бөгөөд мөн дан ганц огоорохуйгаар ч төгс төгөлдөрт хүрдэггүй.

ТАЙЛБАР: Материалист хүний зүрхийг бүхий л бузраас нь ариусгах дан ганц зорилго бүхий өөрт оноогдсон үүргүүдээ биелүүлснээр ариуссан хүн л огоорохуйн амьдралын түвшинд орж болно. Ариусаагүй хүн амьдралын дөрөв дэх үе шатанд (*санньяса*) шууд орсноор ямар ч амжилтанд хүрэхгүй. Эмпирик философчдын бодлоор бол хүн шууд *санньяси*

болон үр дагавар дагуулагч үйлүүдээс татгалзан хойш суун холдож хөндийрснөөр Нараяна лугаа төгс төгөлдөр болох ажээ. Шри Кришна энэ үзэл бодолтой санал нэгдэхгүй байна. Зүрхээ ариусгалгүйгээр *санньяси* болно гэдэг нь нийгмийн байгууллын тогтолцоонд зөвхөн саад гажуудал болох юм. Харин нөгөө талаас, Бурханы трансценденталь алба үйлэнд (*буддхи-йога*) хандан зүтгэх хүний энэ зам мөрдөө гаргасан ахиц дэвшил бүрийг тэр өөрт оноогдсон үүргээ биелүүлээгүй байсан ч Бурхан хүлээн зөвшөөрдөг. *Св-аллам апй асья дхармасья траяте махато бхаят*: энэ зам мөрөөр өчүүхэн төдий ч урагшлах явдал нь хүнийг маш их хүндрэл бэрхшээлийг гэтлэн туулах чадвартай болгодог.

ШҮЛЭГ 5

*на хи кашчит кшанам апи
жату тиштхатй акарма-крит
карьяте хй авашах карма
сарвах пракрити-жайр гунайх*

на- үгүй, *хи*-тодорхой, *кашчит*- хэн нэгэн, *кшанам*-хоромхон зуур, *апи*- мөн, *жату*- хэзээ нэгэн цагт, *тиштхати*-үлддэг, *акарма-крит*- үйл хөдлөлгүйгээр, *карьяте*- хийхээр тулгагдан шахагдах, *хи*- зайлшгүй, *авашах*- арчаагүй, *карма*- үйл, *сарвах*- бүгд, *пракрити-жайх*- материаллаг байгалийн гунуудаас үүсэн гарсан, *гунайх*- шинж чанараар.

Амьд оршнол бүр нь материаллаг байгалийн гунуудын нөлөөллөөс төрөн гарах дарамт шахалтын дагуу үйл үйлдэхээр тулгагдсан ямар ч арчаагүй байдалтай байдаг. Иймээс хэн ч, хоромхон зуур ч үйл үл үйлдэн зүгээр байна гэж байдаггүй билээ.

ТАЙЛБАР: Зөвхөн бие махбодид орших амьд оршнолууд л идэвхтэй байж үйл хөдлөл хийдэг юм биш. Байнгын идэвхтэй байх нь сүнсний мөн чанар юм. Сүнсний оршин байхгүйд материаллаг бие махбодь нь хөдөлж ч чадахгүй. Бие махбодь нь агшин зуурч амс үл хийн байнгын идэвхтэй байх сүнсээр л хөдөлгөөнд орж байдаг амьгүй механизм юм. Ийм учраас л бурханлаг сүнс нь Кришнагийн ухамсрын эерэг үйл үйлдэж байх хэрэгтэй бөгөөд эс тэгэх аваас хий хуурмагийн эрчмээс түүнд тулгах үйлүүдийг үйлдэх болно. Материаллаг эрчимтэй хутгалдсаны улмаас бурханлаг сүнс материаллаг гунуудын нөлөөнд орж унан бузартдаг. Сүнсээ энэхүү материаллаг холбогдлоос ариусгахын тулд шастирт заасан үүргүүдийг биелүүлэх хэрэгтэй. Харин сүнс Кришнагийн ухамсрын өөрийн жам ёсны үйлээ үйлдэн байх аваас үйлдэн байгаа бүхэн нь түүнд ач тустай. Энэ тухай Шримад Бхагаватамын (1.5.17)-д дараах байдлаар батлан өгүүлсэн байдаг:

*тьяктва сва-дхармам чаранамбхужам харер
бхажанн апакво `тха патет тато яди
ятра ква вабхадрам абхуд амушья ким
ко вартха апто `бхажатам сва-дхарматах*

“Кришнагийн ухамсарт хандан байгаа хүн шастирт заасан үүргүүдийг үл даган биелүүлсэн ч, чин бишрэлийн алба үйлээ зохих ёсоор нь зөв үйлдэхгүй байсан ч, тэр ч бүү хэл тухайн түвшингөөсөө доошлон унасан байсан ч түүнд ямар ч гарз зохирол, муу зүйл учрахгүй. Харин тэр Кришнаг ухамсарлаагүй л бол шастирт заасан ариуслын журам дүрмүүдийг бүгдийг нь хичээнгүйлэн биелүүлээд ч ямар ач тусыг олох билээ дээ.”

Иймд Кришнагийн ухамсрын түвшинд хүрэхийн тулд ариусах үйл явц зайлшгүй шаардлагатай. Тиймээс *санньяса* нь бусад ариусах үйл явцуудын нэгэн адил хүнийг дээдийн дээд зорилгодоо буюу Кришнагийн ухамсарт хүрэхэд зориулагдсан байдаг. Эс тэгвээс бидний бүхий л амьдрал ямар ч утгагүй болно.

ШҮЛЭГ 6

*кармендрияни самьямья я асте манаса смаран
индрияртхан вимудхатма митхьячарах са учьяте*

карма- индрияни- үйлийн таван мэдрэхүй, *самьямья*- эзэмдэн захирсанаар, *ях*- тэр, *асте*-үлддэг, *манаса*- ухаанаараа, *смаран*- дурсан боддог, *индрия-артхан*- мэдрэхүйн объектууд, *вимудха*- мангуу, *атма*- сүнс, *митхья-ачарах* – дүр эсгэгч, *сах*- тэр, *учьяте*- нэрлэгддэг.

Мэдрэхүйн эрхтэнгүүдээ үйлээс холдуулан хойш татавч бодол санаа нь мэдрэхүйн объектуудад эргэлдэн байгаа хүн мэдээж хэрэг өөрийгөө л хуурч байгаа хэрэг бөгөөд тийм хүнийг хуурамч дүр эсгэгч гэж нэрлэдэг.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсрын үйлээс татгалзахын зэрэгцээ гаднаа бясалгал үйлдэж буй дүр эсгэх боловч дотооддоо зөвхөн мэдрэхүйн таашаал ханамж эдлэх тухай бодолд автагсад олон байдаг. Иймэрхүү хоёр нүүртэнгүүд нь өөрт нь автсан даган бишрэгчдэдээ хүнзгий сэтгэгдэл төрүүлэхийн тулд мөн философийн хуурай яриа өрнүүлж чаддаг ч энэ шүлэгт өгүүлснээр бол тэд хамгийн том хууран мэхлэгчид. Зөвхөн мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийг сонирхон байгаа хүн нийгмийн журам дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах хэрэгтэй бөгөөд гэхдээ тэр өөрийн байр сууринд оноогдсон журам дүрмүүдийг дагаж мөрдөж байх аваас түүний оршихуй аажим аажмаар ариусах болно. Гадна өнгөндөө иогчийн дүр эсгэх боловч үнэн хэрэгтээ мэдрэхүйн таашаал цэнгэл эдлэх зүйлсийн хойноос эрэлхийлэгч нь заримдаа философийн сэдвээр ярьдаг байсан ч тэр бол хамгийн аймшигт их хууран мэхлэгч болно. Ийм нүгэлт хүний мэдлэг Бурханы хий хуурмагийн эрчимд автагдсан байдаг учир ямар ч үнэ цэнэгүй. Иймэрхүү хоёр нүүртний ухаан байнгад бузарт нэрвэгдсэн байдгаас түүний үзүүлбэр болгож буй бясалгал хийгээд иог нь өчүүхэн төдий ч үнэ цэнэгүй.

ШҮЛЭГ 7

*яс тв индрияни манаса ниямьярабхате `ржуна
кармендрияйх карма-йогам асактах са вишишьяте*

ях- тэр, ту- харин, индрияни- мэдрэхүй, манаса- ухаанаар, ниямья- зохицуулснаар, арабхате- эхэлдэг, аржуна- Аржуна минь, карма-индрияйх- идэвхтэй мэдрэхүйгээрээ, карма-йогам- чин бишрэлээр, асактах- дурлан татагдалгүйгээр, сах- тэр, вишишьяте- хавьгүй сайн.

Харин тэгэхэд, өөрийн идэвхитэй мэдрэхүйгээ ухаанаараа хянан, эзэмдэн захирахыг үнэнчээр чармайн материаллаг зүйлд дурлан татагдалгүй карма-йога-ын (Кришнагийн ухамсарт) зам мөрөөр замнаж эхэлж буй хүн хавьгүй дээгүүрт тавигдана.

ТАЙЛБАР: Трансценденталист болж хуурамч дүр эсгэх хийгээд мэдрэхүйн таашаал ханамж эдлэхээр садар самуун амьдралд тэмүүлж байснаас өөрт оноогдсон үүрэг даалгаврын хүрээнд байж, материаллаг боолчлолын хүлээснээс ангижран Бурханы оронд буцан очиход оршиж байдаг амьдралынхаа учир утгыг биелүүлэх нь хавьгүй илүү. Хүн бүрийн дээдийн дээд зорилго буюу *свартха-гати* нь Вишнуд хүрэх явдал юм. *Варна* болон *ашрамын* нийт тогтолцоо нь биднийг амьдралын энэхүү зорилгодоо хүрэхэд тус дөхөм болохоор зохион байгуулагдсан байдаг. Мөн *грихастха* ч Кришнагийн ухамсар дахь зохицуулалт бүхий алба үйлэнд зүтгэснээр энэхүү зорилгодоо хүрч болно. Өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн түвшинд хүрэхийн тулд хүн шастирт заасны дагуу амьдралаа жолоодлоготой, зөв зохион явуулах ёстой бөгөөд өөрийн үйлийг ямар ч материаллаг дурлан татагдалгүйгээр цаашид үргэлжлүүлэх хэрэгтэй. Ингэж байж л бурханлаг хөгжил дэвшилд хүрнэ. Энэ арга замыг чин үнэнээсээ даган мөрдөх хүн нь бурханлаг байдлын хөөрхийлөлтэй үзүүлбэр эзэмшин гэмгүй олныг хууран мэхлэгч хоёр нүүртэнгүүдээс хамаагүй илүү дээр. Өөрийн ажилдаа чин үнэнчээр хандах гудамж цэвэрлэгч нь зөвхөн өөрийн амин зуулгаа олохын тулд бясалгах хуурамч амьтнаас хавьгүй илүү.

ШҮЛЭГ 8

*ниятм куру карма твам карма жьяйо хй акарманах
шарира-ятрапи ча те на прасиддхьед акарманах*

ниятм- оноогдсон, *куру*- хий, үйлд *карма*- үүргүүд, *твам*- чи, *карма*- үйл, *жьяях*- илүү дээр, *хи*- зайлшгүй, *акарманах*- үйл бус байдлаар, *шарира*- бие махбодь, *ятра*- тогтоон барих, *апи*- тэр ч бүү хэл, *ча*- мөн, *те*- чиний, *на*- хэзээ ч үгүй, *прасиддхьет*- хүрэх болно, *акарманах*-ажил үйлгүйгээр.

Өөрт оноогдсон үүргээ биелүүл. Ингэх нь юу ч үл үйлдэхээс дээр. Юу ч хийхгүй байх аваас хүн өөрийн материаллаг бие махбодио ч тэжээн тэтгэж чадахгүй болно шүү дээ.

ТАЙЛБАР: Өөрсдийгөө дээд язгуур гарал удамтай хэмээн батлахыг оролдох хуурамч бясалгагчид болон ариун гэгээн судруудаас уран чадамгай уншин олны хүндэтгэлийг хүлээн өндөр байр сууринд хүрсэн байх мэргэжлийн гэмээр олон хүмүүс нь бүхнийг шашин номын амьдралын хөгжил дэвшлийн төлөө зориулан өргөж байдаг хэмээн хуурмаг дүр гаргах явдал ч байдаг. Шри Кришна Аржунаг хууран мэхлэгч байхыг биш, харин өөрийн үүргээ *кшатрия* хүнд оноогдсон байдаг тэр л байдлаар биелүүлэхийг хүссэн. Аржуна бол *грихастха* хийгээд цэргийн том жанжин байсан учир тэрээр энэхүү байр сууриндаа байж, *грихастха-кшатрия* хүний хувьд өөрт нь оноогдсон шашин номын үүргүүдээ биелүүлэх нь илүү сайн байх байсан билээ. Ийм үйл нь материаллаг хүний зүрхийг аажим аажмаар ариусган улмаар материаллаг бузраас ангижруулдаг. Зөвхөн өөрийн амьжиргааны орлогод санаа тавих зорилго бүхий огоорохуй гэж нэрлэгдэх зүйлийг Бурхан ч тэр, мөн шашны судруудад ч тэр сайшаадаггүй. Бие махбодь болон сүнсээ тогтоон барьж, тэжээн тэтгэж байхын тулд хүн эцсийн эцэст ямар нэгэн ажил хийх л хэрэгтэй. Материаллаг дур хүслээсээ ариусаагүй байж ажил үйлээ өөрийн дур зоргоор орших ёсгүй. Материаллаг ертөнцөд орших хэн бүхэн материаллаг байгалийг ноёрхох гэсэн ариун бус дур сонирхолтой байдаг нь маргашгүй хэрэг. Энэхүү ариун бус дур сонирхлоос ариусах ёстой. Гэхдээ өөрт оноогдсон үүргээ биелүүлснээр л. Үүнийг үл хайхрах хэн бүхэн трансценденталист болохыг хийгээд өөрийн ажил үйлийг огоорон зөвхөн бусдын мөнгөөр амьдрах гэж оролдохын хэрэггүй.

ШҮЛЭГ 9

*ягьяртхам карmano `ньятра локо `ям карма-бандханах
тад-артхам карма каунтея мукта-сангах самачара*

ягья-артхат- зөвхөн Ягья (Вишну)-д зориулж үйлдэх, *карманах*- үйл байдлаар, *аньятра*- өөрөөр, *локах*- ертөнц, *аям*- энэхүү, *карма-бандханах*- ажил үйлээрээ уягддаг, *тат*- түүнийг, *артхам*- зорилгоор, *карма*-үйл, *каунтея*- Кунтийн хүү минь, *мукта-сангах*- хүрээллээс ангижирдаг, *самачара*- төгс төгөлдөр байдлаар гүйцэтгэ.

Хүн өөрийн ажил үйлээ Вишнуд өргөл болгон зориулах хэрэгтэй. Эс тэгэх аваас тэр ажил үйл нь түүнийг материаллаг ертөнцөд уяж хүлэх болно. Ай Кунтийн хүү минь ээ, иймд өөрт оноогдсон үүргээ Түүний тааллыг хангахын тулд биелүүл. Ингэж байж л чи материаллаг боолчлолын уяа хүлээснээс үргэлж ангид байх болно.

ТАЙЛБАР: Бие махбодио зөвхөн тэжээн тэтгэхийн тулд ч гэсэн хүн ажиллах шаардлагатай байдаг учраас хүний шинж чанар, нийгмийн байр сууринд харгалзан оноогдсон үүргүүд ч энэхүү зорилго, шаардлага биелэгдсэн байхаар зохицуулагдсан байдаг. *Ягья* нь Бурхан Вишнуд ч мөн тахилга өргөлд ч хамааралтай үг юм. Учир нь өргөлийн бүхий л хэлбэрүүд нь Шри Вишнуг цэнгүүлэхэд л зориулагдсан байдаг. Ведэд *ягьявай вишнух* гэж өгүүлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, хүн Бурхан Вишнуд шууд үйлчлэн зүтгэж байсан ч, эсвэл оноогдсон тахилга өргөлүүдийг үйлдэж байсан ч энэ л зорилгод хүрэхээр зорьж байдаг. Иймээс Кришна ухамсар нь энэ шүлэгт өгүүлснээр бол *ягья* үйлдэх явдал юм.

Варнашрама тогтолцоо нь мөн Бурхан Вишнуг цэнгүүлэх л зорилготой: *Варнашрама-чара вата пурушена парах пуман/вишнур арадхьяте...*(Вишну Пурана, 3.8.8).

Иймээс хүн бүр Вишнуг цэнгүүлэх зорилгоор л ажиллах ёстой. Сайн болоод муу аль ч үйл нь өөрийн үр дагавартай байдаг ба энэ үр дагавар нь тухайн үйлийг үйлдэгчийг уяж хүлж байдаг учраас энэхүү материаллаг ертөнц дэх бусад аливаа үйл нь боолчлогдон хүлэгдэхийн учир шалтгаан болж байдаг. Иймээс Кришна буюу Вишнуг цэнгүүлэхийн тулд Кришнагийн ухамсарт үйл хэргээ явуулах хэрэгтэй бөгөөд үйлээ ийнхүү үйлдэн байх хүн ангижралын түвшинд оршиж байдаг. Энэ бол үйл үйлдэх аугаа урлаг бөгөөд энэ үйл явцын эхэн үед маш их туршлага бүхий удирдан залагч шаардлагатай байдаг. Иймээс хүн бүр үйлээ маш хянуур няхуур, гэхдээ Шри Кришнагийн шууд сургаал, зааврын дор (Аржуна лугаа) эсвэл Шри Кришнагийн туршлагатай чин бишрэлтэнгийн удирдлага дор үйлдэж байх хэрэгтэй. Ямар ч үйлийг өөрийн мэдрэхүйд таашаал ханамж эдлүүлэх үүднээс бус харин Кришнаг цэнгүүлэх зорилгоор л үйлдэх хэрэгтэй. Үйлээ ийнхүү үйлдэх нь хүнийг зөвхөн үйлдсэн үйлийн нь үр дагавраас хамгаалаад зогсохгүй, Бурханы трансценденталь хайрын алба үйлэнд зүтгэх түвшинд аажим аажмаар дээшлүүлэн хүргэдэг. Дан ганц энэ албанд зүтгэснээр л хүн Бурханы оронд дээшлэн хүрч очих чадвартай болно.

ШҮЛЭГ 10

*саха-ягьях пражах сриштва пуровача пражапатих
анена прасавишьядхвам еша во ств ишта-кама-дхук*

саха- хамт, ягьях- тахилга өргөлтэй, пражах- үе удам, сриштва- бүтээснээр, пура- урьд нэгэн цагт, увача- айлдсан, пража-патих- бүхнийг бүтээн захирагч, анена- тэгснээр, прасавишьядхвам- үргэлж сайн сайхан байх болтугай, эшах- энэ, вах- та нарын, асту- болтугай, ишта- хүсэж болох бүхий л зүйл, кама-дхук- хүртээгч.

Бүтээлийн эхэнд, бүхнийг бүтээгч Бурхан хүн төрөлхтний болон сахиулсан тэнгэрүүдийн үе удмыг Вишнуд зориулан өргөх тахилга өргөлийн хамт бүтээсэн бөгөөд “Та бүхэн энэхүү ягьяг үйлдэн аз жаргалд хүрэх болтугай. Учир нь та бүхэн аз жаргалтай амьдрах хийгээд ангижралыг олохын тулд хүссэн бүхэндээ түүнийг үйлдсэнээр л хүрэх болно.” хэмээн айлдаж тэдэнд адислалаа хүртээсэн.

ТАЙЛБАР: Бүх бүтээлийн эзэн Бурхан (Вишну) материаллаг бүтээлээрээ болзолт сүнснүүдэд гэр лүүгээ, Бурханы зүг буцан очих боломжийг олгож байгаа юм. Материаллаг ертөнц дэх бүх амьд оршнолууд нь Вишну буюу Бурханы Дээд Бодгаль Кришнаатай холбогдсон харьцаа холбоогоо мартсан байдаг учир материаллаг байгалиар болзолдож нөхцөлддөг. Ведийн зарчмууд нь энэхүү мөнхийн холбоогоо ухаарахад бидэнд туслах ёстой байдаг бөгөөд Бхагавад Гитад мөн энэ тухай өгүүлсэнчлэн: *ведайш ча сарвайр ахам эва ведьях*. Ведийн зорилго бол түүнийг ойлгох явдал юм гэж Бурхан айлдсан. Ведийн дууллуудад: *патим вишвасьятмеш-варам* гэж өгүүлдэг. Амьд оршнолуудын эзэн нь Бурханы Дээд Бодгаль Вишну байдаг гэдгийг энэ шүлэгт батлан өгүүлж байна. Шрила Шукадева Госвами Шримад Бхагаватамын (2.4.20)-д Бурханыг *пати* гэж олон янзаар тодорхойлсон байдаг:

*шриях-патир ягья-патих пража патир
дхиям патир лока-патир дхара-патих
патир гатиш чандхака-вришни-сатеватам
прасидатам ме бхагаван сатам патих*

Шри Вишну бол *пража-пати*, Тэр бол бүх амьд бүтээлүүдийн Эзэн, бүхий л ертөнцийн Эзэн, бүхий л гоо сайхны Эзэн бөгөөд Тэр бүгдийг хамгаалагч юм. Бурхан материаллаг ертөнцийг бүтээснээрээ болзолт сүнснүүдэд, Вишнуг цэнгүүлэхийн тулд *ягья* буюу тахилга өргөлүүдийг хэрхэн үйлддэгийг суралцан, тэгснээрээ материаллаг ертөнцөд оршин байхдаа санаа зовох байдлаас ангид байж, аятай тухтай амьдарцгаан, энэхүү материаллаг бие махбодио орхисны дараа Бурханы оронд хүрч чадах бололцоог олгож байгаа юм. Болзолт сүнснүүдэд зориулан соёрхож байгаа Бурханы таалал ийм байдаг бөлгөө. *Ягья* өргөснөөр болзолт сүнснүүд Кришнаг аажим аажмаар ухаарах ба бүхий л талаараа бурханлаг шинжтэй болж ирнэ. Энэ цаг үе Кали-д *санкиртана-ягья* (Бурханы ариун гэгээн нэр алдруудыг давтан хэлэх) үйлдэхийг ведийн судруудад зөвлөсөн байдаг бөгөөд Бурхан Чайтанья энэхүү трансценденталь арга замыг манай энэ цаг үеийн бүх хүмүүсийг ангижралд хүргэхийн тулд номлосон. *Санкиртана-ягья* болон Кришнагийн ухамсар хоёр нь хоорондоо маш сайн зохицон хосолдог. Шримад Бхагаватамын (11.5.32)-д Өөрийн чин бишрэлийн албаны дүрд (Шри Чайтанья дүрээр) хувирсан Шри Кришнагийн талаар *санкиртана-ягьятай* холбогдуулан нэгэн зүйлийг онцгойлон дурьдсан байдаг:

*кришна-варнам твишакришнам сангопангастра-паршадам
ягьяйх санкиртана-праййр яжанти хи су-медхасах*

“Калийн цаг үед хангалттай оюун ухаан бүхий хүмүүс нь Өөрийн бараа бологчдоо дагуулан залрах Бурханд *санкиртана-ягьяг* үйлдэн бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх болно.”

Ведийн судруудад заасан бусад *ягья-уудыг* энэ цаг үед үйлдэх нь тийм ч амар хэрэг биш. Харин *санкиртана-ягья* нь үйлдэхэд бүхий л талаараа амар хялбарын зэрэгцээ эрхэм дээд бөлгөө. Түүнийг мөн Бхагавад Гитагийн (9.14)-д зөвлөсөн байдаг.

ШҮЛЭГ 11

*деван бхаваятанена те дева бхаваянту
параспарам бхаваянтах шреях парам авапсьятха*

деван- сахиулсан тэнгэрүүд, *бхаваята*- ханамж эдэлсэнээр, *анена*- энэ өргөлөөр, *те*- тэд, *девах*- сахиулсан тэнгэрүүд, *бхаваянту*- ханамж эдлэнэ, *вах*- та нар, *параспарам*- харилцан, *бхаваянтах*- харилцан ханамж эдэлсэнээр, *шреях*- адислал, *парам*- дээдийн дээд, *авапсьятха*- хүртэнэ.

Тахилга өргөлд тань сэтгэл ханасан сахиулсан тэнгэрүүд нь мөн та та нарыг баясгах болно. Ийнхүү хүмүүс хийгээд сахиулсан тэнгэрүүд нь харилцан хамтарсны ачаар бүх нийтээрээ түвшин жаргалтай амьдрах болно.

ТАЙЛБАР: Сахиулсан тэнгэрүүд нь материаллаг үйл хэргийг хариуцан зохицуулах онцгой эрх бүхий захирагчид юм. Бүхний Дээд Бурханы биеийн янз бүрийн хэсгүүд дэх туслагчид болох тоо томшгүй олон сахиулсан тэнгэрүүдэд амьд оршнол бүрийн сүнс болон бие махбодийг тогтоон барьж тэжээн тэтгэхэд шаардлагатай агаар, гэрэл, усаар хангаж байхыг болон бусад бүх адислалуудыг итгэмжлэн даатгасан байдаг. Тэдний ханамжтай байх эсэх нь хүмүүсийн тахилга өргөл үйлдэж байгаа эсэхээс хамаардаг. Тахилга өргөлүүдийн зарим нь тодорхой сахиулсан тэнгэрүүдэд таашаал ханамж эдлүүлж тэднийг цэнгүүлэхэд зориулагдсан байдаг боловч бүхий л тахилга өргөлүүдэд Шри Вишнуг дээдийн дээд таашаан болгоогч гэж бишрэн хүндэтгэж байдаг. Бүхий л тахилга өргөлийн дээдийн дээд зорилго нь Бурхан Вишну байдаг. Бхагавад Гитад ч мөн, Шри Кришна бол бүх тахилга өргөлүүдийн таашаан болгоогч гэж өгүүлдэг: *бхоктарам ягья-тапасам*. Иймээс эцсийн эцэст, *ягья-пати*г цэнгүүлэх нь бүхий л *ягья-уудын* гол зорилго болж байдаг. Энэхүү *ягья-уудыг* зөв зүйтэй үйлдэх аваас хангамжийн янз бүрийн салбар хэсгүүдийг хариуцсан сахиулсан тэнгэрүүд баясан цэнгэх учраас байгалийн бүтээгдэхүүнүүдийн хангамжинд дутагдал гачигдал огтхон ч гарахгүй.

Тахилга өргөл үйлдэх нь олон төрлийн ач тусыг давхар агуулж байдаг бөгөөд тэдгээр нь эцсийн дүндээ материаллаг боолчлолын хүлээнэс ангижрахад хүргэдэг. Ведэд өгүүлсэнчлэн, *ягья-э* үйлдсэнээр хүн өөрийн бүхий л үйлээ ариусгаж байдаг: *ахара-шудхау саттва-шуддхих саттва-шуддхау дхрува смритих смрити-ламбхе сарва-грантхинам випрамокшах*. *Ягья* үйлдсэнээр хоол хүнс ариусна, ариуссан хоол хүнс хэрэглэсэнээр хүний өөрийн нь оршихуй ариусна, оршихуй нь ариуссанаар түүний ой санамжийн эргэн санах чадвар бүхий нарийн эд эс нь ариусан гэгээрнэ, эргээн саруул ой санамжтай хүн ангижралыг олох зам мөрийн талаар бодох чадвартай болно. Энэ бүхэн цогцолсноор энэ цаг үеийн нийгэмд маш чухал шаардлагатай байгаа Кришнагийн ухамсарт хүргэнэ.

ШҮЛЭГ 12

иштан бхоган хи во дева дасьянте ягья-бхавитах таир даттан апрадаяибхьо ио бхункте стена эва сах

иштан- хүсэж байгаа, *бхогат*- амьдралын шаардлагатай зүйл, *хи*- зайлшгүй, *вах*- та нарт, *девах*- сахиулсан тэнгэрүүд, *дасьянте*- хүртэнэ, *ягья-бхавитах*- өргөл өргөснөөр ханамж эдэлсэнээр, *тайх*- тэд нараар, *даттан*- өгөгдсөн зүйл, *апрадая*- өргөл өргөлгүйгээр, *эбхьях*- энэхүү сахиулсан тэнгэрүүдэд, *ях*-тэр, *бхункте*-ханамж эдэлдэг, *стенах*- хулгайч, *эва*- гарцаагүй, *сах*-тэр.

Амьдралын шаардлагатай бүхнийг хариуцсан сахиулсан тэнгэрүүд нь тахилга өргөлөөс ханамж авснаар та бүхнийг хэрэгцээтэй бүхнээр хангах болно. Харин урьд нь сахиулсан тэнгэрүүдэд өргөл өргөлгүйгээр энэхүү өглөгөөс хуваалцан таашаал ханамж эдлэх хэн бүхэн мэдээжийн хэрэг гэдэг нь эргэлзээгүй хэрэг.

ТАЙЛБАР: Бурханы Дээд Бодгаль Вишнугийн, энэ орчлонгийн бүх амьд оршнолуудад санаа тавих үүргийг гардан хариуцагч бүрэн эрхт элч төлөөлөгчид нь сахиулсан тэнгэрүүд юм. Иймээс Ведэд заасан янз бүрийн тахилга өргөлүүдийг үйлдэн тэднийг цэнгүүлэх хэрэгтэй. Ведэд янз бүрийн сахиулсан тэнгэрүүдэд зориулсан төрөл бүрийн хэлбэрийн тахилга өргөлүүдийн талаар заасан байдаг ч эцсийн дүндээ тэр бүгдийг Бурханы Дээд Бодгальд л зориулан өргөдөг. Бурханы Бодгаль гэж хэн болохыг ойлгож мэддэггүй хүмүүсийг сахиулсан тэнгэрүүдэд зориулан тахилга өргөл үйлдэж байхыг зөвлөдөг. Хүмүүст үйлчлэл нөлөөллөө үзүүлж байдаг материаллаг байгалийн янз бүрийн гунуудад харгалзан *ягья-ын* янз бүрийн хэлбэрүүдийн талаар Ведэд зөвлөсөн байдаг. Янз бүрийн сахиулсан тэнгэрүүдийг шүтэн бишрэх явдал нь мөн энэхүү учир шалтгаан буюу хүмүүсийн агуулан байх янз бүрийн шинж чанарууд дээр тулгуурладаг. Жишээлбэл, мах идэгч хүмүүсийг материаллаг байгалийн айдас хүйдэс төрүүлэм дүр бүхий Кали гэдэг охин тэнгэрийг шүтэн биширч түүнд амьтнаар өргөл өргөхийг зөвлөдөг. Харин цэвэр ариуны гунад орших хүнд Бурхан Вишнуд трансценденталь бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхийг зөвлөдөг. Эцсийн дүндээ бүх *ягья* нь хүнийг аажим аажмаар трансценденталь түвшинд дээшлэн хүрэхэд зориулагдсан байдаг. Эгэл жирийн хүмүүс наад зах нь *панча-маха-ягья* гэж нэрлэгдэх таван тахилга өргөлийг үйлдэх шаардлагатай байдаг.

Хүний нийгмийг амьдралын шаардлагатай бүхнээр хангаж байдаг сахиулсан тэнгэрүүд нь бол Бүхний Дээд Бурханы элч төлөөлөгчид юм гэдгийг хүн бүр ойлгож ухаарах хэрэгтэй. Хэн ч, ямар ч зүйлийг өөрөө бүтээж үл чадна. Хүн төрөлхтөний хэрэглэдэг хүнсний зүйлийг жишээ болгон авч үзье: үр тариа, жимс, ногоо, сүү, элсэн чихэр зэрэг олон зүйлс нь цэвэр ариуны гунад байх хүмүүст зориулагдсан байдаг бол мах зэрэг зүйлсийг цагаан хоолтон бус хүмүүс хүнсэндээ хэрэглэдэг. Энэ бүгдийн алиныг нь ч хүмүүс өөрсдөө бүтээж бий болгож эс чадна. Эсвэл дахин өөр нэг жишээ авья: дулаан, гэрэл, ус, агаар нь бүгд л амьдралын зайлшгүй хэрэгцээтэй зүйлс. Мөн эдгээрийн алиныг нь ч хүн бүтээж чадахгүй. Бүхний Дээд Бурхангүйгээр нарны гэрэл, сарны гэрэл, бороо, салхи гэж байхгүй байсан. Энэ бүгд үгүй бол хэн ч амьд байж чадахгүй. Эндээс үзэхэд бидний амьдрал Бурханаас үзүүлж буй халамж хангамжаас хамаарч байна. Тэр бүү хэл манай үйлдвэрүүдэд хэрэглэгддэг маш их хэмжээний түүхий эд болох металл, хүхэр, мөнгөн ус, мангани болон бусад олон олон хэрэгтэй зүйлүүдийг Бурханы элч төлөөлөгчид биднийг энэ бүхнийг зөв зохистой хэрэглэн аль ч талаараа эрүүл саруул байж материаллаг оршнолын төлөөх тэмцлээс ангижрах дээдийн дээд зорилгод хүргэдэг өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйд хүрэх чадвартай болгох үүднээс л хангаж байдаг. Амьдралын энэхүү зорилгод *ягья* үйлдсэнээр л хүрнэ. Хэрвээ бид хүний амьдралын учир утгыг мартаж умартахын зэрэгцээ Бурханы элч төлөөлөгч нараар зөвхөн өөрсдийн мэдрэхүйн таашаалыг хангуулж байх аваас материаллаг оршнолдоо улам бүр татагдан автаж орооцолдох болно. Гэхдээ ингэх нь бүтээлийн зорилго биш байдаг учраас бид бүхэн хулгайч мөн болох нь ямар ч эргэлзээ мадаггүй хэрэг. Иймээс бид материаллаг байгалийн хуулиудын дагуу шийтгэгдэх болно. Хулгайчдын нийгэм нь амьдралын ямар

ч зорилгогүй байдаг тул хэзээ ч аз жаргалтай байж чадахгүй. Материалист хулгайч нарт амьдралын дээд зорилго гэж байдаггүй. Тэд зөвхөн дан ганц өөрсдийн мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийг хүсэж сонирхохоос биш хүн ягья-э хэрхэн яаж үйлддэгийг ч мэддэггүй. Харин Шри Чайтанья бидэнд хамгийн хялбар ягья болох *санкиртана-ягья-ын* тухай мэдлэгийг хүртээсэн билээ. Энэхүү *санкиртана-ягья* Кришнагийн ухамсрын зарчмуудыг хүлээн зөвшөөрсөн хэн бүхэн үйлдэж болно.

ШҮЛЭГ 13

*ягья-шишта*нах санто мучьянте сарва-килбишайх
бхуньжате те тв аехам папа е пачантй атма-каранат

ягья-шишта- ягья- өргөсний дараагаар хүртэж байгаа зоог, *ашинах*- зооглогчид, *сантах*- чин бишрэлтэнгүүд, *мучьянте*- ангижирдаг, *сарва*- бүхий л хэлбэрээс, *килбишайх*- нүглийн, *бхуньжате*- таашаал ханамж эдлэх, *те*- тэд нар, *ту*- харин, *аехам*- хүнд нүгэл, *папах*- нүгэлтэнгүүд, *е*- тэд, *пачантй*- хоол хүнсээ бэлтгэдэг, *атма-каранат*- мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн тулд.

Бурханы чин бишрэлтэнгүүд нь эхлээд Бурханд өргөсөн хоол хүнсийг хэрэглэдэг тул нүглийн бүхий л хэлбэрээс ангижирдаг. Харин бусад нь буюу зөвхөн өөрсдийн мэдрэхүйн таашаалыг хангах зорилгоор хоол хүнсээ бэлтгэгчид нь үнэн хэрэгтээ зөвхөн нүгэл л идэж байдаг.

ТАЙЛБАР: Бурханы чин бишрэлтэн буюу Кришнаг ухамсарласан хүнийг *санта* гэж нэрлэдэг бөгөөд Брахма самхитагийн (5.38)-д өгүүлсэнчлэн, тэд Бурхантай байнгад хайраар холбогдож байдаг: *преманьжана-ччхурита-бхакти-вилочанена сантах садайва хридаешу вилочаянти*. Бурханы Дээд Бодгаль Говинда (цэнгэл жаргалын эх булаг), Мукунда (ангижралыг хүртээгч) эсвэл Кришна (бүхний татагч)-тай байнгад хайраар холбогдох *санта* нь эхлээд Бурханд өргөөгүй л бол юу ч байсан хүрдэггүй. Иймээс ийм чин бишрэлтэнгүүд нь чин бишрэлийн албаны янз бүрийн, тухайлбал *киртанам*, *смаранам*, *арчанам* болон бусад үйлүүдэд зүтгэснээр байнгад *ягья* үйлдэж байдаг. Ийнхүү *ягья* үйлдсэнээрээ тэд материаллаг ертөнц дэх нүгэлт харьцааны улмаас үүсэх бүхий л бузраас байнгад ангид байдаг. Хоол хүнсээ өөрөө өөртөө зориулах буюу өөрөө мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн төлөө бэлтгэх бусад хүмүүс нь зөвхөн хулгайч байгаад зогсохгүй байж болох бүхий л нүглийг идэж байгаа хэрэг. Зөвхөн хулгайч байгаад зогсохгүй мөн түүний хажуугаар нүгэлтэн байх хүн яаж аз жаргалтай байж чадах билээ дээ? Энэ бол байж болшгүй зүйл. Иймээс хүмүүс аль ч байдлаараа аз жаргалтай байхын тулд Кришнагийн бүрэн ухамсарт *санкиртан-ягья-ын* хүнд хэцүү биш үйлийг үйлдэж сурах хэрэгтэй. Эс тэгэх аваас энэ дэлхий дээр тайван амгалан хийгээд аз жаргалтай байж чадахгүй.

ШҮЛЭГ 14

аннад бхаванти бхутани паржаньяд анна-самбхавах
ягьяд бхавати паржаньо ягьях карма-самудбхавах

аннат- үр тарианаас, *бхаванти*- ургадаг, *бхутани*- материаллаг бие махбодиуд, *паржаньят*- бороо орсноор, *анна*- үр тарианаас, *самбхавах*- үүсэл гарал, *ягьят*- тахилга өргөл өргөснөөр, *бхавати*- болно, *паржаньях*- бороо, *ягьях*- тахилга үйлдэж өргөл өргөх, *карма*- оноогдсон үүргүүд, *самудбхавах*- төрөн гардаг.

Бүхий л амьд бие махбодиуд нь өөрсдийгөө үр тариагаар тэжээн тэтгэж байдаг. Харин үр тариа нь бороо орж чийг өгсөн газрын хөрснөөс ургана. Бороо нь ягья үйлдсэнээр ордог. Харин ягья нь өөрт оноогдсон үүргээ биелүүлэх үйлээс л төрөн гардаг.

ТАЙЛБАР: Бхагавад Гитад гайхамшигтай тайлбар хийсэн Шрила Баладева Видьябхушена бичихдээ: *е индрадй-ангатаявастхитам ягьям сарвешварам вишнум абхьярчья тач-чхешам ашнанти тена тад деха-ятрам сампадаянти, те сантах сарвешварасья ягья-пурушасья бхактах сарва-килбишайр анадй-кала-виериддайр атманубхава-пратибандхакайр никхилайх папайр вимучьянте*. *Ягья-пуруша* буюу бүхий л тахилга өргөлийг таалан болгогч Бүхний Дээд Бурхан бол бүх сахиулсан тэнгэрүүдийн эзэн. Биеийн эрхтэн хэсгүүд бүхэл бүтэн биедээ хэрхэн үйлчилж байдагтай адилаар сахиулсан тэнгэрүүд нь Түүнд үйлчлэн зүтгэж байдаг. Индра, Чандра, Варуна болон бусад сахиулсан тэнгэрүүд нь материаллаг үйл хэргийг удирдан зохицуулахаар Бурханаас томилогдсон захирагчид бөгөөд эдгээр сахиулсан тэнгэрүүдийг цэнгүүлэх тахилга өргөл үйлдэхийг Ведэд зөвлөсөн байдаг. Ийнхүү тахилга үйлдэж өргөл өргөн сахиулсан тэнгэрүүдийг цэнгүүлснээр тэд үр тариа ургахад хангалттай агаар, гэрэл, дулаанаар хангана. Хүмүүс Шри Кришнаг дээдлэн шүтэж Түүнд бишрэл хүндэтгэлээ үзүүлэх аваас энэ нь Түүний биеийн янз бүрийн хэсгүүд болох сахиулсан тэнгэрүүдэд ч мөн бишрэл хүндэтгэлээ давхар илэрхийлсэн хэрэг болдог учир Бүхний Дээд Бурханы зэрэгцээ сахиулсан тэнгэрүүдийг тусгайд нь онцлон шүтэн бишрэх шаардлагагүй. Энэ учраас Кришнагийн ухамсарт оршин байх Бурханы чин бишрэлтэнгүүд нь зөвхөн, эхлээд Кришнад өргөсөн зоогноос л хүртдэг. Энэ үйл явц нь тэдний бие махбодийг бурханлаг эрчмээр ханган тэтгэж байдаг. Ингэснээр тэд өнгөрсөн үеийн үйлүүдийнхээ үр дагаврыг устгаад зогсохгүй бие махбодио материаллаг мөн чанарын ямар ч бузардалтанд үл эрсдэхээр сэргийлэн хамгаалдаг. Халдварт өвчин дэгдэн тархах үед хүн тэр өвчний эсрэг үйлчилгээтэй вакциныг хэрэглэснээр өөрийгөө халдварт өртөхөөс сэргийлэн хамгаалж дархлаажуулдаг. Үүний нэгэн адил эхлээд Бурхан Вишнуд өргөсөн хоол хүнс биднийг бүхий л материаллаг үйлчлэл нөлөөллөөс хангалттай хэмжээгээр хамгаалан дархлаажуулдаг бөгөөд энэхүү үйлийг байнга үйлдэж заншсан хүнийг Бурханы чин бишрэлтэн хэмээн нэрлэдэг билээ. Иймээс Кришнагийн ухамсарт оршин, зөвхөн, Бурханд өргөсөн зоогноос хүртэн байх хүний өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн үйлд саад тотгор болох өнгөрсөн цаг үеийн материаллаг халдварын бүхий л үр дагавар саармагжин үгүй болдог. Ийнхүү эс үйлдэх хэн бүхний хувьд түүний үйлдсэн нүгэлт үйлийн тоо нь нэмэгдэн улмаар дараагийн амьдралдаа нохой эсвэл гахайны бие махбодийг аван төрж өөрийн бүх үйлийн үрийг эдэлж зовж шаналахаар тулгагдах болно. Материаллаг ертөнц бузар булай бүхнээр дүүрэн байх

бөгөөд зөвхөн Вишнуд өргөсөн зоог буюу Бурханы *прасадамыг* хүртэн дархлаажуулагдсан хүн л тэдгээрийн халдварт үл өртөнө. Харин *прасадам* үл хүртэгч хэн бүхэн энэхүү бузар булайн золиос болдог.

Хүн янз бүрийн үр тариа, жимс, ногоо зэргийг хоол хүнсэндээ хэрэглэдэг байхад адгуус амьтад нь үр тарианы хаягдал болоод төрөл бүрийн өвс, ургамал зэргийг идэж байдаг учир чухамдаа үр тариа, ногоо нь л хүнс тэжээлийн бүтээгдхүүн юм. Амьтад нь мөн л өвс ургамлаар хооллох учир мах идэж заншсан хүмүүс ч гэсэн амьтан идэхийн тулд угтаа мөн л ургамлын ургацаас хамааралтай байдаг. Иймд эцсийн дүндээ хүмүүс бид талбайгаас хураах ургацаас л хамаарахаас биш том том үйлдвэрүүдэд үйлдвэрлэгдэх бүтээгдэхүүнүүдээс хамаардаггүй. Ургац нь бороо хангалттай орох эсэхээс хамаарах бөгөөд харин энэхүү бороо нь Бурханы албатууд болох нарны, сарны сахиулсан тэнгэрүүд болон Индра зэрэг сахиулсан тэнгэрүүдийн эрх мэдэлд байдаг. Өргөл өргөснөөр Бурханыг цэнгүүлж болох учир хэн өргөл эс өргөнөм тэр гачигдаж дутагдах нь байгалийн хууль. Ийм учраас тахилга өргөл, ялангуяа энэ цаг үед зориулагдсан *санкитана-ягьяг* үйлдсэнээр бид бүхэн наад зах нь хүнсний хангамжийн гачигдал хомсдолд орж өлсгөлөнд нэрвэгдэхээс аврагдах болно.

ШҮЛЭГ 15

*карма брахмодбхавам виддхи брахмакшара-самудбхавам
тасмат сарва-гатам брахма нитьям ягья пратиштхитам*

карма- үйл, *брахма*- Ведээс, *удбхавам*- төрсөн, *виддхи*- мэдэх ёстой, *брахма*- Вед, *акшара*- дээдийн дээд Брахманаас (Бурханы Бодгаль), *самудбхавам*- илэрч тодордог, *тасмат*- иймээс, *сарва-гатам*- бүхэнд нэвчсэнээр, *брахма*- трансцендент, *нитьям*- мөнхийн, *ягье*- тахилга өргөлд, *пратиштхитам*- оршдог.

Зохицуулагдсан үйлийн талаар Ведэд өгүүлсэн байдаг бөгөөд Вед нь Бурханы Дээд Бодгалиас шууд гаралтай. Иймд бүхэнд нэвтрэн түгэх Трансцендент нь тахилга өргөлийн үйлүүдэд мөнхөд заларч байдаг.

ТАЙЛБАР: Гагцхүү Кришнаг цэнгүүлэхэд чиглэгдсэн ажил үйлийн зайлшгүй шаардлага буюу *ягьяртха-карма* нь энэ шүлэгт бүр тодорхой илэрч байна. *Ягья-пуруша*, Вишнуг цэнгүүлэхийн төлөө ажиллахын тулд бид эхлээд Брахманаас буюу трансценденталь “Вед”-ээс энэ үйлд зориулагдсан байх заавар журмуудыг даган баримтлах хэрэгтэй. Ведүүд нь иймд, хүн үйлийг хэрхэн яаж үйлдэх ёстойг тодорхойлсон хууль юм. Ведийн сургаалаас ангид гадуур үйлдэж буй бүхнийг *викарма* буюу эх сурвалж бус, нүгэлт үйлүүд гэдэг. Өөрийн үйлдэж буй үйлийн үр дагавраас хамгаалагдахын тулд хүн бүр ямар ч нөхцөл байдалд байсан Ведийг үргэлж удирдлага чиглэлээ болгож байх нь чухал. Ердийн амьдралдаа хүн бүр төрийн хуулийг мөрдөн баримталдагтай адил дээдийн дээд төр болох Бурханы хуулийг мөн дагаж мөрдөх ёстой. Ведийн сургаал нь Бурханы Дээд Бодгалийн амьсгалаас шууд гаралтай билээ. *Асья махато бхутасья нишваситам этад яд риг-ведо яжур-ведах сама-ведо тхарвангирасах*: “Дөрвөн Вед буюу Риг-веда, Яжур-веда, Сама-веда болон Атхарва-веда нь Бурханы эрхэм дээд Бодгалын амьсгалын цацрал юм.” (Брихад-араньяка Упанишад, 4.5.11) Бурхан бол хамгаас хүчирхэг бүхнийг чадагч учраас Тэр өөрийн амьсгалаар ярьж чаддаг. Брахма-самхитад батлан өгүүлсэнчлэн, Түүний мэдрэхүй бүр нь бусад бүх мэдрэхүйн үүрэг, үйл ажиллагааг биелүүлж чаддаг. Өөрөөр хэлбэл Бурхан амьсгалаараа ярьж, мэлмийн харцаараа үр тогтоож чаддаг. Тэрээр материаллаг мөн чанарын зүг харцаа хоромхон зуур илгээх төдийд л бүхий л амьд оршолуудыг төрүүлсэн гэж судруудад үнэхээр өгүүлдэг. Энэхүү бүтээх үйл буюу материаллаг мөн чанарын хэвлийд болзолт сүнснүүдээр үр тогтоосны дараа, тэдэнд буцаад гэр лүүгээ, Бурханы зүг хэрхэн харихыг харуулахын тулд Өөрийн сургаалаа Ведийн цэцэн мэргэн номлол хэлбэрээр нээн хүртээсэн. Материаллаг ертөнц дэх болзолдож нөхцөлдсөн сүнснүүд нь бүгд л материаллаг таашаал ханамж эдлэхийн хойноос тэмүүлж байдаг гэдгийг бид бүхэн байнгад санаж явах ёстой. Харин Ведийн сургаал нь түүнийг баримтлан дагагч хүн таашаал ханамж хэмээн нэрлэгдэх зүйлээ эцэслэсний дараагаар Бурханы зүг буцаж харихын тулд өөрийн гажуудаж гуйвсан хүсэл эрмэлзлээ хангаж болохуйц тийм байдалтайгаар бүтээгдсэн байдаг. Ведийн мэдлэг ухаан нь болзолт сүнсэнд ангижралыг олох боломж олгодог тул хүн өөртөө Кришнагийн ухамсрыг хөгжүүлэн *ягья-ын* зам мөрийг даган замнахыг хичээх хэрэгтэй. Ведийн сургаалыг урьд нь дагаж мөрдөж байгаагүй хүмүүс ч гэсэн Кришнагийн ухамсрын зарчмуудыг даган баримтлах зам мөрд орж болох бөгөөд энэ нь ведийн *ягья* эсвэл *карма-г* орлоно.

ШҮЛЭГ 16

*эвам правартитам чакрам нанувартаятиха ях
агхяур индриярамо могохам партха са живати*

эвам- ингэж, *правартитам*- Ведээр тогтоогдсон, *чакрам*- тойрог, *на*- үгүй, *анувартаяти*- хүлээж авдаг, *иха*- энэ амьдралдаа, *ях*- тэр, *агха-аюх*- түүний амьдрал нүгэл дүүрэн байдаг, *индрия-арамах*- мэдрэхүйн таашаал ханамж эдлэгч, *могохам*- дэмий хоосон, *партха*- Притхын хүү минь, *сах*- тэр, *живати*- амьдардаг.

Ай Аржуна минь ээ, хүний бие махбодийг аван төрчихөөд тахилга өргөлүүдийг Ведэд заасны дагуу үл үйлдэх хэн бүхэн нүгэл дүүрэн амьдралаар амьдарч байгаа гэдэг нь эргэлзээгүй юм. Тэр зөвхөн мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн төлөө л амьдарч байдаг учраас өөрийн амьдралаа хий дэмий хоосон өнгөрөөж байдаг.

ТАЙЛБАР: “Сайн ажиллаж, мэдрэхүйн таашаал ханамж эдэл.” гэдэг маммонизмын буюу эд баялгийг дээдлэн шүтэхийн гүн ухааныг Бурхан энд буруушааж байна. Иймээс материаллаг ертөнцийн таашаал ханамжийг эдлэхийг хүсэгч хүмүүс дээр өгүүлсэн *ягья-ын* үйлүүдийг үйлдэж байх нь туйлын чухал. Энэ сургаал зааврыг эс дагаж мөрдөх хэн бүхэн өөрийгөө мөхөл сүйрлийн аюул руу улам бүр түлхэж байдаг учраас маш аюултай амьдралыг зохиож байдаг. Байгалийн хуулийн дагуу бол хүний амьдралын хэлбэр нь *карма-йога*, *гьяна-йога* эсвэл *бхакти-йогын* замуудын аль нэгийг нь даган

замнаснаар өөрийгөө бүрэн нээж танин мэдэхэд зориулагдсан байдаг. Муу болоод сайн үйлээс дээгүүр түвшинд орших трансценденталистууд нь зөвлөмж болгосон *ягья-уудыг* нарийн чанд үйлдэх шаардлагагүй байдаг. Харин мэдрэхүйн таашаал ханамж эдлэхийн хойноос хөөцөлдөгчид нь эдгээр *ягья-уудыг* үйлдэн өөрсдийгөө ариусгах хэрэгтэй. Үйлийн маш олон төрөл хэлбэр байдаг. Кришнаг ухамсарлаагүй хүмүүс нь мэдрэхүйн түвшингийн ухамсартай байдаг нь эргэлзээгүй хэрэг тул тэдний хувьд зөв шудрага үйлүүд үйлдэж байх нь чухал. *Ягья-ын* систем нь мэдрэхүйн түвшний ухамсартай хүмүүсийг мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйлүүдийнхээ үр дагаварт татагдан орооцолдолгүйгээр өөрсдийн хүсэл эрмэлзлээ хангах боломжийг олгодог. Энэ дэлхийн чинээлэг сайхан амьдрал нь бидний хичээл чармайлтаас биш харин Бүхний Дээд Бурханы урьдчилан таалж зохицуулсан, сахиулсан тэнгэрүүдээр шууд гүйцэтгэгдэн далд цаагуур явагдах үйлүүдээс хамаардаг. Ийм учраас, *ягья* нь Ведэд дурьдагдсан тодорхой сахиулсан тэнгэрүүдэд шууд зориулагдсан байдаг. Энэ нь шууд бус утгаараа мөн л Кришнагийн ухамсар. Учир нь *ягьяг* үйлдэж сурч дадсанаар хүн Кришнаг ухаарах нь эргэлзээгүй. Харин *ягья-г* үйлдэн байх боловч Кришнаг үл ухаарах аваас түүний дагаж мөрдөж буй зарчмууд нь ёс суртахууны зүгээр л нэг сургаал болохоос өөр юу ч биш болох юм. Иймээс өөрийн бурханлаг хөгжил дэвшлийг хязгаарлан ёс суртахууны журам дүрмийн түвшний зогсонги байдалд үлдэж болохгүй. Харин Кришнагийн ухамсарт хүрэхийн тулд тэдгээрийн чанад дахь трансценденталь түвшинд хүрэх ёстой.

ШҮЛЭГ 17

*яс тв атма-ратир эва сьяд атма-трипташ ча манавах
атманй эва ча сантуштас тасья карьям на видьяте*

яx- тэр, ту- гэхдээ, атма-ратих- өөрийн дотоодоос баяр цэнгэлийг олсноор, эва-гарцаагүй, сьят- байдаг, атма-трипташ- өөрөө өөртөө ханамжтай байдаг, ча- мөн, манавах- хүн, атмани- өөрөө өөртөө, эва- зөвхөн, ча- мөн, сантуштах- бүрэн ханамжтай, тасья- түүний, карьям- үүрэг, на- үгүй, видьяте- оршдог.

Гэвч өөрөө өөртөө дүүрэн ханамжтай байж хүний амьдралаа өөрийгөө бүрэн нээж танин мэдэхэд зориулсан, зөвхөн өөрийн дотооддоо ханамжтай байж, бүрэн хангалуун байх хэн бүхний хувьд ямар ч үүрэг байдаггүй.

ТАЙЛБАР: Кришнаг бүрэн ухамсарлаж Кришнагийн ухамсар дахь өөрийн үйлэндээ бүрэн ханамжтай байгаа хүнд биелүүлэх ёстой өөр үүрэг байдаггүй. Кришнаг ухамсарласны ачаар түүний дотоод дахь бүхий л цэвэр ариун бус зүйл нь хоромхон зуурт л үгүй болно. Ийм байдалд олон олон мянган тахилга өргөлийн дүнд л хүрч болох билээ. Ухамсар нь ийнхүү ариуссаны ач тусаар хүн Бүхний Дээдтэй холбогдсон өөрийн мөнхийн байр сууриа бүрэн ухаарч мэднэ. Ийнхүү Бурханы өршөөлөөр түүний гүйцэтгэх үүрэг, үйл нь өөрөө нээгдэх учир тэрээр Ведийн сургаал зааврыг цаашид заавал биелүүлж байх үүрэггүй. Кришнаг ийнхүү ухамсарласан хүн материаллаг үйлүүдийг цаашид үл сонирхох бөгөөд архи дарс, авгай хүүхэн болон үүнтэй адил төстэй зүйлүүдэд татагдсан материаллаг таашаал ханамжаас баяр баясгаланг үл олно.

ШҮЛЭГ 18

*найва тасья критенартхо накритенеха кашчана
на часья сарва-бхутешу кашчид артха-вьяпашраях*

на- хэзээ ч үгүй, эва- гарцаагүй, тасья- түүний, критена- үүргээ биелүүлснээр, артхах- санаа бодол, на- мөн үгүй, акритена- үүргээ биелүүлээгүйгээр, иха- энэ ертөнцөд, кашчана- ямар нэгэн, на-хэзээ ч үгүй, ча- мөн, асья- түүний, сарва-бхутешу – бүх амьд оршнолуудын дунд, кашчит- хэн нэгэн, артха- бодол санаа, вяпашраях- аврал ивээл хүртсэнээр,

Өөрийгөө бүрэн нээж танин мэдсэн хүн өөрт оногдсон үүргээ биелүүлэхдээ ямар ч санаа зорилго агуулдаггүй ба түүнд тэдгээр үйлүүдийг үйлдэхгүй байх учир шалтгаан байдаггүй. Мөн түүний хувьд өөр бусад амьд оршнолуудаас хамааралтай байх шаардлага байдаггүй.

ТАЙЛБАР: Өөрийгөө бүрэн нээж танин мэдсэн хүн Кришнагийн ухамсрын үйлээс бусад, өөрт оногдсон аливаа үйл, үүргүүдийг үйлдэх, биелүүлэх шаардлагагүй болдог. Кришнагийн ухамсар нь огт юу ч хийхгүй байна гэсэн үг биш гэдгийг дараагийн шүлгүүдэд тодорхой тайлбарлана. Кришнаг ухамсарласан хүн өөр хэн нэгэн хүн эсвэл сахиулсан тэнгэр, эсвэл ямар нэгэн амьд оршнолоос аврал, ивээл эрж хайдаггүй. Кришнагийн ухамсарт үйлдэж буй бүхэн нь өөрийн үүргээ биелүүлэхэд хангалттай байдаг.

ШҮЛЭГ 19

*тасмад асактах сататам карьям карма самачара
асакто хй ачаран карма парам апноти пурушах*

тасмат- ийм учраас, асактах- дурлан татагдлаас ангид, сататам- байнга, карьям- үүрэг байдлаар, карма- үйл, самачара- үйлдэх, асактах- үл дурлан татагдах, хи- гарцаагүй, ачаран- үйлдсэнээр, карма- үйл, парам- Бүхний Дээд, апноти- хүрдэг, пурушах- хүн.

Иймээс хүн үйлийн үр дүндээ дурлан татагдалгүйгээр өөрийн үүргээ биелүүлэх хэрэгтэй. Ийнхүү дурлан татагдалгүйгээр үйлдсэнээр л тэр Бүхний Дээдэд хүрнэ.

ТАЙЛБАР: Чин бишрэлтэнгүүдийн хувьд Бүхний Дээд нь Бурханы Бодгаль байдаг. Харин бодгаль бусыг баримтлагчдын хувьд ангижрал. Зөв удирдлагын доор хийгээд Кришнад зориулсан өөрийн үйлийн үр дүнд дурлан татагдалгүйгээр буюу өөрөөр хэлбэл Кришнагийн ухамсарт оршин байж үйл үйлдэх хэн бүхэн амьдралын дээдийн дээд зорилгодоо хүрэх зам мөртөө ахиц дэвшил гаргах нь ямар ч эргэлзээгүй. Бурхан Кришна, Өөрийн нь тааллын дагуу Түүний төлөө Курукшетрын тулалдаанд оролцох хэрэгтэй гэж Аржунад айлдсан билээ. Сайн хүн байх буюу хүч үл хэрэглэн энэрч нигүүлсэнэ гэдэг нь хүний хувийн аминчхан дурлан татагдалтын нэгэн хэлбэр бөгөөд Дээдийн Дээд Бурханы таалан болгоож даалгасны дагуу үйл үйлдэнэ гэдэг бол үйлийн үр дүндээ дурлан татагдахгүй байна гэсэн үг. Энэ бол Бурханы Дээд Бодгаль, Шри Кришнагийн бидэнд зөвлөж байгаа дээдийн дээд түвшин дэхь төгс төгөлдөр үйл юм.

Тахилга өргөл өргөх зэрэг ведийн зан үйлүүдийг мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үүднээс үйлдсэн нүгэлт үйлүүдээс ариусахын тулд үйлддэг. Харин Кришнагийн ухамсар дахь үйл нь аливаа сайн болоод муу үйлүүдийн үр дагаварт трансценденталь байдаг. Кришнагийн ухамсарт оршин буй хүн үйлийг үр дүнд нь дурлан татагдсанаас биш, харин зөвхөн Кришнагийн таалалд нийцүүлэн үйлдэж байдаг. Тэрээр янз бүрийн үйлүүд үйлдэж байдаг ч тэдгээрийн үр дагаварт огтхон ч татагддаггүй.

ШҮЛЭГ 20

*карманайва хи самсиддхим астхита жанакадаях
лока-санграхам эвапи сампашьян картум архаси*

кармана- ажил үйлээр, эва- тэр ч бүү хэл, хи- эргэлзээгүй, самсиддхим- төгс төгөлдөрт астхитах- хүрсэн, жанака- адаях- Жанака болон бусад хаадууд, лока-санграхам- нийт олон, эва апи- мөн, сампашьян- анхааралдаа авснаар, картум- үйлдэх, архаси- гавьятай.

Жанака мэт хаад зөвхөн оноогдсон үүргээ биелүүлснээр л төгс төгөлдөрт хүрсэн. Тиймээс чи ч гэсэн өөрт оноогдсон үүргээ биелүүлэхийн сацуу бусад нийт олныг сурган хүмүүжүүлэхэд үлгэр жишээ бол.

ТАЙЛБАР: Жанака зэрэг хаадууд нь өөрийгөө бүрэн нээж танин мэдсэн сүнснүүд байсан учраас тэдний хувьд Ведэд заасан үүргүүдийг биелүүлэх шаардлагагүй байсан ч тэд бусад хүмүүст үлгэр дууриал үзүүлэх үүднээс л оноогдсон бүх үүргүүдээ биелүүлж байв. Жанака бол Ситагийн эцэг, Шри Рамагийн хадам эцэг байв. Бурханы аугаа их чин бишрэлтэн мөн болохын хувьд тэрээр трансценденталь түвшинд оршин байсан ч Митхилагийн (Энэтхэгийн Бихар мужийн нэгэн хэсэг) эзэн хааны хувьд өөрийн харьяат албат иргэддээ өөрт ноогдсон үүргүүдээ хэрхэн биелүүлэхийн үлгэр дууриалыг үзүүлэх хэрэгтэй байсан. Шри Кришна болон Түүний мөнхийн анд нөхөр Аржуна хоёрын хувьд Курукшетрын тулалдаанд хамтран оролцох шаардлага үгүй байсан боловч үг хэлээр, тайван замаар зохицуулах боломжгүй үед хүч хэрэглэх шаардлага мөн гардаг гэдгийг хүмүүст харуулах үүднээс хамтран тулалдсан билээ. Курукшетрын энэхүү тулааны өмнө тулалдан дайтахаас зайлсхийхийн тулд бүхий л хүчин чармайлтыг, тэрч бүү хэл Бурхан Кришна Өөрөө хүртэл гаргасан боловч эсрэг тал тулалдахаар эрс шийдвэрлэсэн байв. Үүн лугаа зөв үйл хэргийн төлөө дайтан тулалдах шаардлагатай байсан. Кришнагийн ухамсарт орших хүн материаллаг ертөнцөд үл дурлан татагдаж байдаг ч яаж амьдрах, үйлээ хэрхэн үйлдэхийг нийт олонд харуулж, үлгэр дууриал болохын тулд ажил үйлээ явуулж байдаг. Кришнагийн ухамсарт дадлагажиж туршлагажсан хүн, бусад хүмүүс өөрөөс нь үлгэр жишээ авахуйцаар үйл хэргээ ийнхүү явуулах чадвартай байдаг талаар дараагийн шүлэгт өгүүлнэ.

ШҮЛЭГ 21

*яд яд ачарати шрештхас тат тад эветаро жанах
са ят праманам куруте локас тад анувартате*

ят ят- тэр бүгд, ачарати- хийдэг, шрештхах- алдар нэртэй хүн, тат- түүнд, тат- мөн зөвхөн түүнд, эва- гарцаагүй, итарах- эгэл жирийн, жанах- хүн, сах- тэр, ят- тэр, праманам- үлгэр жишээ, куруте- үзүүлдэг, локах- дэлхий даяар, тат- түүнд, анувартате- дагадаг.

Алдартай, нэр нөлөө бүхий хүн юу л хийнэ эгэл жирийн хүмүүс түүнийг дагаж байдаг. Тэр өөрийн үлгэр жишээгээр ямар хэм хэмжээ тогтооно түүнийг нь бүхий л дэлхий нийт даган мөрддөг.

ТАЙЛБАР: Өөрийн бодит үлгэр жишээгээр бусдыг сургах чадвар бүхий удирдан манлайлагч нийт олонд байнгад хэрэгтэй шаардлагатай байдаг билээ. Өөрөө тамхи татдаг хүн бусдыг тамхинаас гаргах талаар номлож сургах нь утгагүй, дэмий хэрэг. Бурхан Чайтанья, багш хүн бусдыг сургахын өмнө өөрийгөө зөв авч явж сурах хэрэгтэй гэж айлдсан. Ийм байдлаар сургаж номлож байгаа хүнийг ачарья буюу үлгэр жишээч багш гэж нэрлэдэг. Иймээс багш хүн бусдыг сургахын тулд судруудад заасан зарчмуудыг дагаж мөрдөх хэрэгтэй. Мөн тэрээр ариун гэгээн судруудад заасан зарчмуудад зөрчилдсөн огт өөр журам дүрэм сэдэж гаргах хийгээд тогтоож болохгүй. Ману-самхита болон бусад ариун гэгээн судрууд нь хүн төрөлхтний дагаж мөрдөх ёстой үлгэр жишээ болох номууд юм. Иймээс удирдан манлайлагч хүний заавар сургаж нь ийм үлгэр жишээ шастируудад үндэслэгдэж тулгуурлагдсан байх ёстой. Хөгжил дэвшилд хүрэхийг хүсч буй хүн аугаа их номын багш нарын өөрсдийнх нь хэрэгжүүлж тогтоосон стандарт журам дүрмийг дагаж мөрдөх ёстой. Бурханлаг танин мэдэхүйн зам мөр дээр ахиц дэвшил гаргахын тулд аугаа их чин бишрэлтэнгүүдийн мөрийг даган замнах хэрэгтэй гэж Шримад Бхагаватамд мөн батлан өгүүлдэг. Улс гүрний эзэн хаан эсвэл төрийн тэргүүн, эцэг, мөн сургуулийн багш нарыг эгэл жирийн хүмүүсийн жам ёсны удирдан залагчид гэж үздэг. Энэхүү жам ёсны удирдан залагч бүр нь өөрийн захирагдагсдын өмнө өндөр хариуцлага хүлээдэг учраас тэрээр ёс суртахууны болоод бурханлаг амьдралын хуулиудын үлгэр жишээ болохуйц ном судруудтай танилцан, тэдгээрийг сайн судалж мэдэх хэрэгтэй.

ШҮЛЭГ 22

*на ме партхаста картавьям тришу локешу киньчана
нанавалтам авалтавьям варта эва ча кармани*

на- үгүй, ме- миний, партха- Притхын хүү минь, асти- байдаг, картавьям- оноогдсон үүрэг, тришу- гурван, локешу- гаригуудын системд, киньчана- ямар нэгэн, на-үгүй, авалтам- хэрэгтэй байгаа, авалтавьям- хүрэхээр, варте - үйлддэг, эва- гарцаагүй, ча- мөн, кармани- оноогдсон үүрэг.

Ай Притхын хүү минь ээ, Бүхий л гурван гаригсын систем дотор Надад заавал үйлдэх ёстой үйл гэж байдаггүй. Би юуг ч үл хүсэх ба Надад хэрэгтэй шаардлагатай зүйл гэж үгүй. Гэхдээ л Би өөрт оноогдсон үүргүүдээ биелүүлж байдаг.

ТАЙЛБАР: Бурханы Дээд Бодгалийг ведийн судруудад дараах байдлаар тодорхойлон өгүүлсэн байдаг:

*там ишваранам паранам махешварам
там деватанам парамам ча дайватам
патим патинам парамам парастад
видама девам бхуванешам идьям
на тасья карьям каранам ча видьяте
на тат-самаш чабхьядхикаш ча дришьяте
парасья шактир вивидхайва шруяте
свабхавики гьяна-бала-крия ча*

“Бүхний Дээд Бурхан бол бусад бүх удирдан захирагч нарын Захирагч. Тэр бол янз бүрийн гаригуудыг захиран байх бүх сахиулсан тэнгэрүүдээс ч аугаа билээ. Бүгд Түүний захиргаанд оршдог. Гагцхүү Бүхний Дээд Бурхан л бүх амьд оршнолуудад тодорхой эрх мэдэл, хүч чадлыг хайрлан хүртээж байдаг ба тэд өөрсдөө бол Дээдийн Дээд биш юм. Сахиулсан тэнгэрүүд ч мөн бүгдээрээ Түүнийг бишрэн шүтдэг бөгөөд Тэр бүх удирдан залагчдын дээд удирдан залагч. Иймээс Тэр бүхий л хэлбэрийн материаллаг удирдан залагчид хийгээд захирагчдын хувьд трансценденталь түвшинд орших бөгөөд тэд бүгдийн хувьд Түүнийг шүтэн бишрээс зохистой билээ. Түүнээс аугаа хэн ч байдаггүй бөгөөд Тэрээр бүх учир шалтгаануудын хамгийн дээд учир шалтгаан бөлгөө.

Түүний бие нь эгэл жирийн амьд оршнолуудынхаас өөр билээ. Түүний бие болон сүнсний хооронд ялгаа байдаггүй. Тэр бол үнэмлэхүй. Түүний бүх мэдрэхүй нь трансценденталь. Түүний мэдрэхүй бүр нь бусад мэдрэхүй бүрийн үүргийг гүйцэтгэж чадна. Иймээс Түүнээс аугаа болон Түүнтэй эн зэрэгцэх хэн ч байдаггүй. Түүний хүч чадал олон янз төрөл байдаг учраас Түүний бүх үйл жам ёсны байдлаараа, өөрөө л биелдэг.” (Шветашватара Упанишад, 6.7-8).

Бурханы Дээд Бодгаль бүх зүйлсийг бүрэн дүүрэн агуулж эзэмшдэг ба бүгд бүрэн үнэнээр оршин байдаг учраас Түүний хувьд заавал биелүүлэх ёстой үүрэг гэж байдаггүй. Өөрийн үйлийн үр дүнд дурлан татагдаж буй хүн ямар нэгэн тодорхой үүргийг биелүүлэх шаардлагатай байдаг бол бүхий л гаригуудын гурван системд хүрэхээр эрмэлзэн тэмүүлэх зүйл огт байдаггүй хэн нэгний хувьд биелүүлэх ёстой ямар ч үүрэг байхгүй гэдэг нь ойлгомжтой хэрэг юм. Гэсэн хэдий ч Шри Кришна Курукшетрын тулалдаанд *кшатриянуудыг* удирдан жолоодогчоор оролцож байна. Учир нь *кшатрия* хүний үүрэг бол зовж шаналж байгаа бүхнийг хамгаалах явдал байдаг. Хэдийгээр Шри Кришна ариун гэгээн судруудад заасан бүхий л дүрэм журмуудаас дээгүүр түвшинд залрах боловч Тэр тэдгээрийг зөрчин гажуудуулсан ямар ч үйл үйлддэггүй.

ШҮЛЭГ 23

*яди хй ахам на вартеям жату карманй атандритах
мама вартманувартанте манушьях партха сарвашах*

яди- хэрвээ, хи- гарцаагүй, ахам- Би, на- үгүй, вартеям- Би ийм байдлаар үйлддэг, жату- хэзээ нэгэн цагт, кармани- оноогдсон үүргүүдэд, атандритах- эрчимтэй, мама- Миний, вартма- зам, анувартанте- дагах, манушьях- хүмүүс, партха- Притхын хүү минь, сарвашах- бүхий л талаар.

Би Өөрийн биелүүлэх ёстой үүрэгтээ хэзээ нэгэн цагт хайхрамжгүй хандах аваас, ай Притхийн хүү минь ээ, бүх хүмүүс Миний жишээг л дагах нь тодорхой шүү дээ.

ТАЙЛБАР: Хүмүүсийг бурханлаг амьдралдаа хөгжил дэвшил гаргахад шаардлагатай байдаг нийгмийн амгалан тайван байдал болон түүний тэнцвэртэй байдлыг сахин хамгаалж хадгалахад зориулагдсан, соёл иргэншилт хүн бүрийн дагаж мөрдөн баримталж байх ёстой гэр бүлийн уламжлалт зан заншлууд байдаг. Гэхдээ иймэрхүү дүрэм журам нь Шри Кришнад биш харин зөвхөн болзолт сүнснүүдэд зориулагдсан байдаг боловч Тэр энэ дэлхий дээр шашин номын зарчмуудыг тогтоохоор залран байсан учраас тэдгээрийг даган мөрдөж байсан. Эс тэгвээс, Тэр Өөрөө дээдийн дээд эх сурвалж мөн болох учраас эгэл жирийн хүмүүс Түүний жишээг дагах байсан билээ. Шри Кришна өргөөндөө залран байхдаа ч тэр, гадуур саатан морилохдоо ч тэр, гэр бүлтэй хүний дагаж мөрдөх ёстой шашин номын бүхий л үүрэг, ёс журмуудыг биелүүлдэг байсныг бид Шримад Бхагаватамаас мэдэж болно.

ШҮЛЭГ 24

*утсидеюр име лока на курьям карма чед ахам
санкарасья ча карта сьям упаханьям имах пражах*

утсидеюх- мөхөх байсан, име- энэ бүхэн, локах- гаригууд, на- үгүй, курьям- Би биелүүлээгүй байсан бол, карма- оноогдсон үүрэг, чет- хэрвээ, ахам- Би, санкарасья- хүсээгүй хүн ам, ча- мөн, карта- бүтээгч, сьям- болох байсан, упаханьям- устгах байсан, имах- энэ бүх, пражах- амьд оршнол.

Хэрвээ Би Өөрт оноогдсон үүргүүдээ эс биелүүлэх аваас энэ бүх дэлхий ертөнц сөнөн үгүй болох билээ. Тийнхүү Би хүсээгүй оршин суугчид төрөхийн шалтгаан болох байсан хийгээд чингэснээрээ Би бүх амьд оршнолуудын амар амгаланг бусниулан сүйтгэх байсан билээ.

ТАЙЛБАР: *Варна-санкара* гэдэг үг нь олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулагч хүсээгүй оршин суугчид буюу хүмүүс гэсэн утгатай юм. Нийгмийн амгалан тайван байдлыг алдагдуулахаас сэргийлэн, хэв журмыг сахиулахад чиглэгдсэн зохих журам зааврууд байдгийн ачаар хүн ам амар амгалан байж бурханлаг хөгжил дэвшилд хүрэх боломжтой болдог. Шри Кришна энэ газар дэлхийд морилон буун ирж залрах үедээ эдгээр дүрэм журмуудын нэр хүндийг өргөх хийгээд биелүүлэх нь ямар чухал, чухал ач холбогдол шаардлагатай болохыг харуулах үүднээс тэдгээрийг ягштал баримталдаг нь ойлгомжтой хэрэг. Бурхан бүх амьд оршнолуудын эцэг болох тул хэрвээ тэд буруу замаар орж төөрөлдөж будилах аваас үүний хариуцлага Түүнд шууд бусаар оногдоно. Иймээс зохицуулах зарчмуудыг нийтээрээ хайхрахаа больсон цагт Бурхан Өөрөө морилон буун ирж нийгмийг зүгшрүүлэн зөв замд нь оруулдаг. Иймээс бид бүхэн Бурханы үлгэр дууриалыг л дагах ёстой бөгөөд гэхдээ үүний сацуу Түүнийг дуурайж чадашгүй гэдгээ хатуу ойлгох хэрэгтэй. Дагах болон дуурайх гэдэг хоёр нь өөр зүйл юм. Бид, Бурхан хүүхэд байхдаа Говардхана уулыг хэрхэн өргөж байсныг дуурин түүнийг өргөж чадахгүй нь мэдээж хэрэг билээ. Хүний хувьд энэ бол бүтэшгүй, боломжгүй хэрэг. Бид Бурханы сургаалыг дагахаас биш Түүнийг дуурайж хэзээ ч болохгүй. Шримад Бхагаватамын (10.33.30-31)-д энэ тухай батлан өгүүлсэн:

*найтад самачареж жату манасапй хи анишварах
винашьятй ачаран маудхьяд ятха 'рудро 'бдхи-жам вишам
ишваранам вачах сатьям татхайвачаритам кваचित
тешам ят сва-юктам буддхимамс тат самачарет*

“Хүн Бурханы болоод Түүний онцгой эрх чадал бүхий албатын сургаалыг зөвхөн энгийнээр л дагаж мөрдөх хэрэгтэй. Тэдний бүх сургаал нь бидэнд ач тусаа хүртээх болно. Оюунлаг хүн бүр тэдгээрийг нарийн чанд ягштал дагаж биелүүлдэг билээ. Гэхдээ тэдний үйлүүдийг дуурайх оролдлого хийхээс сэрэмжлэн зайлсхийх хэрэгтэй. Шива сахиулсан тэнгэр хорон далайг шавхтал ууж байсныг дуурайх хэрэггүй.”

Сар болон нарны хөдөлгөөнийг үнэхээрийн хянан, удирдан залж чадах *ишвар-уудын* байр суурь бидний байр суурьтай зүйрлэхийн аргагүй илүү дээд түвшинд байдаг гэдгийг сайн ойлгож, байнгад санаж байх хэрэгтэй. Бид өөрсдөө ийм чадваргүй байж хүний хирээс давсан дээд хүч чадал, эрх мэдэл бүхий *ишвар-уудыг* дуурайх хэрэггүй. Шива сахиулсан тэнгэр хороос бүрдсэн бүхэл бүтэн далайг уучихаж байхад, ердийн хүмүүс бид энэ хорноос өчүүхэн бага хэмжээгээр уухад л үхэх билээ. Шива сахиулсан тэнгэрийн хуурамч чин бишрэлтэнгүүд олон байдаг бөгөөд тэд түүнийг дуурайснаар, өөрсдийгөө үхэлд амархан хүргэнэ гэдгийг умартан, ганжи (марихуан) болон түүнтэй төстэй мансууруулах бодисуудыг татаж, хэрэглэж байдаг. Үүнтэй мөн нэгэн адил, Шри Кришнагийн чин бишрэлтэнгүүд хэмээн өөрсдийгөө хуурамчаар нэрийдэх хүмүүс Говардхана уулыг өргөх чадал чадваргүй гэдгээ умартан, Түүний *раса-лила* буюу хайрын бүжгийг дуурайхыг оролддог. Ийм учраас хамгийн чухал нь хүчирхэг бодгалиудыг дуурайх биш, харин тэдний сургаал номлолыг зүгээр л дагах явдал юм. Мөн ямар ч боловсрол гэгээрлийг олоогүй байж тэдний байр суурийг эзлэх гэж оролдохын хэрэггүй. Бурханы хүч чадал эрх мэдлийг агуулаагүй байж өөрсдийгөө Түүний хувилгаан хэмээн нэрийддэг хүмүүс олон байдаг.

ШҮЛЭГ 25

*сактах карманй авидвамсо ятха курванти бхарата
курьяд видвамс татхасакташ чикиршур лока-санграхам*

сактах- дурлан татагдаж байдаг, *кармани-* оноогдсон үүрэгт, *авидвамсах-* харанхуй мунхаг хүмүүс, *ятха-* шиг, *курванти-* хийдэг, *бхарата-* Бхаратын үр удам минь, *курьят-* хийх хэрэгтэй, *видван-* мэдлэг бүхий хүн, *татха-* ийм байдлаар, *асактах-* дурлан татагдалгүй, *чикиршух-* оруулах хүсэлтэй, *лока-санграхам-* нийт олон.

Харанхуй мунхаг хүмүүс өөрсдийн үүргийг үр дүнд нь дурлаж татагдан биелүүлдэг бол, ай Бхаратын үр удам минь ээ, цэцэд мэргэд нь мөн л тийн үйлдэх авч өөрсдийн үүргээ тэдгээрийн үр дагаварт татагдалгүйгээр зөвхөн хүмүүсийг зөв замдаа ороход нь үлгэр дууриал болохын үүднээс биелүүлдэг билээ.

ТАЙЛБАР: Кришнаг ухамсарласан болон Түүнийг ухамсарлаагүй хүмүүсийн ялгаа нь тэдний ялгаатай байх хүсэл эрмэлзлээр илэрдэг. Кришнаг ухамсарласан хүн нь Кришнагийн ухамсрыг хөгжүүлэхэд ач тустай бус зүйлийг огтхон ч хийдэггүй. Зарим үед тэд материаллаг үйлдээ маш ихээр дурлан татагдаж байгаа харанхуй мунхаг хүмүүстэй адил харагдах ч тохиолдол байдаг. Гэхдээ тэдний нэг нь өөрийн мэдрэхүйн таашаалыг хангахын тулд ажиллаж байхад нөгөө нь Кришнаг цэнгүүлэхээр ажиллаж байдаг билээ. Ийм учраас Кришнаг ухамсарласан хүн бүхэн үйлээ хэрхэн үйлдэх ёстой болон өөрийн үйлийн үр дүнг Кришнагийн ухамсрын зорилгод хэрхэн ашиглаж болохыг бусдад харуулах нь чухал.

ШҮЛЭГ 26

*на буддхи-бхедам жанаед агьянам карма-сангинам
жошаает сарва-кармани видван юктах самачаран*

на- үгүй, буддхи-бхедам- оюун ухааны төөрөгдөл, жанаёт- өдөөх ёстой, агьянам- мунхаг хүмүүст, карма-сангидам- үр дагавар дагуулах үйлэнд татагдсан, жошаёт- үйлдэхийг өдөөж байг, сарва-бүгд, кармани- үйлүүд, видван- мэдлэг бүхий хүн, юктах- үйлдэж байгаа, самачаран- хэрэгжүүлж байгаа.

Өөрт оноогдсон үүргийнхээ үр дагаварт дурлан татагдах харанхуй мунхаг хүмүүсийн ухааныг үймээн сандраах хэрэггүй байдаг шиг цэцэн мэргэн хүмүүсийг ажил үйлээ зогсоохыг албадан ятгаж болохгүй. Харин чин бишрэхүйн сэтгэлээр үйлдэн байж тэр хүн бүхий л хэлбэрийн үйлийг үйлдэх хэрэгтэй(Кришнагийн ухамсарт аажмаар хүргэх үйлүүдийг).

ТАЙЛБАР: *Ведайш ча сарваир ахам эва ведьях.* Энэ бол Ведийн бүхий л зан үйлүүдийн зорилго. Ведэд заасан бүхий л зан үйлүүд, бүхий л тахилга өргөлүүд болон Ведийн бусад бүхий л агуулгууд, түүний дотор мөн материаллаг үйлтэй холбоотой бүхий л сургаал зааврууд нь хүмүүсийг амьдралынхаа дээдийн дээд зорилго болох Кришнаг ойлгоход хүргэх ёстой байдаг. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэхээс өөрийг үл мэдэх болзолт сүнснүүд нь Ведийг зөвхөн энэ л зорилгоороо үзэж судалдаг. Харин үр дагавар дагуулах болон мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйлээ Ведийн журам заавар, зан үйлийн дагуу үйлдэх хүн Кришнагийн ухамсрын түвшинд аажим аажмаар дээшлэн хүрэх болно. Тийм учраас Кришнагийн ухамсарт оршин буй өөрийгөө бүрэн нээж танин мэдсэн сүнснүүд нь бусдын үйл хийгээд үнэмшилд саад тотгор учруулах ёсгүй бөгөөд харин тэдэнд аливаа үйлийн үрийг Кришнагийн албанд хэрхэн зориулж болдгийг өөрийн биеэр үлгэр дууриал болгон үзүүлэх хэрэгтэй. Кришнаг ухамсарласан туршлага бүхий хүмүүс, өөрсдийн мэдрэхүйн таашаал ханамжийн төлөө ажиллаж буй харанхуй мунхаг хүмүүст үйлээ хэрхэн үйлдэх болон өөрсдийгөө хэрхэн авч явахыг даган суралцаж чадахуйц байдлаар үйл ажиллагаагаа явуулж байх ёстой. Ажил үйлд нь саад тотгор болохын хэрэггүй харанхуй мунхаг хүмүүсийг бодоход өөртөө Кришнагийн ухамсарыг бага зэрэг ч хөгжүүлж чадсан хүн Ведэд заасан байх өөр бусад арга замуудыг эрж хайлгүйгээр Бурханд шууд үйлчлэн зүтгэх нь зүйтэй. Шууд Кришнагийн ухамсарт үйлчлэн зүтгэж байгаа хэн бүхэн нь өөрт оноогдсон үүргээ биелүүлснээр хүрч болох бүхий л үр дүнд хүрэх тул ийнхүү аз завшаан тохиосон хүн Ведийн зан үйлүүдийг дагаж мөрдөх шаардлагагүй юм.

ШҮЛЭГ 27

пракритех крияманани гунайх кармани сарвашах аханкара-вимудхатма картахам ити маньяте

пракритех-материаллаг байгалийн, крияманани- үйлдэгддэг, гунайх- гунаар, кармани- үйлүүд, сарвашах- олон янзаар, аханкара-вимудха- хуурамч эгод төөрөлддөг, атма- мөнхийн сүнс, карта- үйл үйлдэгч, ахам- би, ити- тэгж, маньяте- боддог.

Хуурамч эго-ны нөлөөллөөр төөрөлдөж самуурсан болзолт сүнс нь өөрийгөө үйл үйлдэгч гэж үздэг. Үнэн хэрэгтээ үйл нь материаллаг байгалийн гурван гунуудаар үйлдэгдэж байдаг.

ТАЙЛБАР: Нэг ижил үйлийг үйлдэж байгаа ч нэг нь Кришнагийн ухамсарт, нөгөө нь материаллаг ухамсарт оршин байх хоёр хүн нэг түвшинд байгаа мэт харагдах боловч үнэн хэрэгтээ тэр хоёрын хооронд асар их ялгаа байдаг. Материаллаг ухамсарт байх хүн өөрийн хуурамч эгодоо хөтлөгдсөнөөс болж үйлийг өөрөө үйлдэж байна хэмээн бодож итгэж байдаг. Бие махбодийн механизм нь Бүхний Дээд Бурханы хараа хяналтын доор үйл хөдлөлөө хийх материаллаг мөн чанарын бүтээгдхүүн мөн гэдгийг тэр үл мэднэ. Материалист хүн өөрөө эцсийн дүндээ Кришнагийн хараа хяналтан доор байдаг гэдгээ мэддэггүй. Хуурамч эгоны нөлөөнөөс болж хүн өөрийн хийж үйлдэж байгаа бүхнээ бие даан, хэнээс ч хамааралгүйгээр үйлддэг хэмээн үзэж байдаг нь түүний харанхуй мунхагийн шинж юм. Түүний бүдүүн болоод нарийн бие махбодь нь Бурханы Дээд Бодгалийн таалал, зарлигийн дагуу материаллаг байгалийн бүтээгдэхүүн хийгээд иймээс өөрийн бие махбодь болон ухааныг Кришнагийн ухамсарт, Кришнагийн алба үйлэнд үйлчлэн зүтгэхэд зориулах ёстой гэдгийг тэр мэддэггүй. Харанхуй мунхагт орших хүн Бурханы Дээд Бодгаль нь материаллаг бие махбодийн мэдрэхүйн эзэн, Хришикеша гэж нэрлэгддэгийг мартсан байдаг. Учир нь өөрийн мэдрэхүйгээ мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйлийн хойноос хөөцөлдөхөд удаан хугацааны туршид буруугаар ашигласнаас болж тэр Бурхан Кришнатай холбогдсон өөрийнх нь мөнхийн холбоо харьцааг мартагдуулсан хуурамч эго-ны нөлөөллөөр бүрэн төөрөлдсөн байдаг.

ШҮЛЭГ 28

маттва-вип ту маха-бахо гуна-карма-вибхагайох гуна гунешу вартанта ити маттва на сажжате

маттва-вип- Үнэмлэхүй Үнэнийг танин мэдэгч, ту- гэхдээ, маха-бахо- хүчит гарт минь, гуна-карма- материаллаг эрчмийн нөлөөллийн доорх үйлүүд, вибхагайох- ялгаа, гунах- мэдрэхүй, гунешу- мэдрэхүйн таашаал ханамжтай, вартанта- үйлддэг, ити- ингэж, маттва- бодсоноор, на- үгүй, сажжате- татагддаг.

Ай хүчит гарт минь ээ, Үнэмлэхүй Үнэний мэдлэг бүхий хэн бүхэн чин бишрэлийн үйл болон үр дагавар дагуулагч үйлийн хоорондын ялгааг сайн ойлгосон байх учир өөрийн мэдрэхүйтэй болон мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйлтэй үл зууралдана.

ТАЙЛБАР: Үнэмлэхүй Үнэнийг таньж мэдсэн хэн бүхэнд материаллаг ертөнцөд эзлэн байх таагүй байр суурь нь түүний хувьд жам ёсны заягдмал бус гэдэг нь ойлгомжтой болдог. Тэрээр өөрийгөө Бурханы Дээд Бодгаль Кришнагийн салшгүй өчүүхэн жижиг хэсэг мөн болох хийгээд чухамдаа энэхүү материаллаг ертөнцөд оршин байх ёсгүй гэдгээ ойлгоно. Тэрээр, өөрийгөө мөнхийн мэдлэг хийгээд мөнхийн цэнгэл жаргал болох Бүхний Дээдийн бүрэлдхүүн хэсэг гэсэн өөрийн жинхэнэ байр суурийг таньж мэдэх бөгөөд ямар нэгэн байдлаар материаллаг амьдралын үзэл бодлын урхи торонд оржээ гэдгээ ойлгодог. Цэвэр ариун байдалдаа амьд оршнол Бурханы Дээд Бодгаль Кришнад чин бишрэлээр зүтгэх ёстой

гэдгийг тэр ойлгодог. Иймээс тэр Кришнагийн ухамсрын үйлэнд зүтгэдэг ба материаллаг мэдрэхүйн нөхцөл байдалд болзолдсон цаг зуурын үйлэнд дурлан татагдахаас жам ёсоороо салан холддог. Түүний материаллаг амьдралын нөхцөл байдал нь Бурханы дээдийн дээд хараа хяналтын доор байдаг гэдгийг мэдэх учир тэр өөрийн амсаж эдэлж буй материаллаг үр дагавар нь ямар ч хэлбэртэй байсан зөвхөн Бурханы өршөөл нигүүлсэл гэж үзэх учраас тэр тэдгээрт огтхон ч үл түүртэнэ. Шримад Бхагаватамд өгүүлсэнчлэн, Үнэмлэхүй Үнэнийг Брахман, Параматма болон Бурханы Дээд Бодгаль гэсэн гурван төлөвт нь таньж мэдсэн хэн бүхэн Бүхний Дээдтэй холбогдсон өөрийн жинхэнэ байр суурийг мөн таньж мэдсэн байх учир түүнийг *таттва-вит* гэж нэрлэдэг.

ШҮЛЭГ 29

*пракритер гуна саммудхах сажжанте гуна-кармасу
тан акритсна-видо мандан критсна-вин на вичалает*

пракритех- материаллаг байгалийн, *гуна-* гунуудаар, *саммудхах-* материтай адилтган үзсэнээр хууртдаг, *сажжанте-* будилдаг, *гуна-кармасу-* материаллаг үйлд, *тан-* тэр, *акритсна-видах-* мэдлэгээ алдаж гэсэн хүмүүс, *мандан-* өөрийн бурханлаг мөн чанарт хүрэхээс хойргошдог, *критсна-вит-* жинхэнэ мэдлэгийг агуулсан байх хүн, *на-* үгүй, *вичалает-* тайван байлгахгүй байх ёстой.

Материаллаг байгалийн гунуудад төөрөлдсөн харанхуй мунхаг хүмүүс зөвхөн материаллаг үйлтэй зууралдан түүндээ улам татагдана. Мэдлэг хомсын харгайгаар тэдний биелүүлэх энэ бүх үүргүүд нь доод мөн чанартай байдаг хэдий ч цэцэд мэргэд тэднийг тайван байдлыг алдагдуулж, будлиулж самууруулахын хэрэгтгүй.

ТАЙЛБАР: Мунхагаасаа болж харалган болсон хүмүүс ухамсраа бүдүүн баараг материд буруу ташаагаар чиглүүлэн хандуулахын зэрэгцээ өөрсдөдөө янз бүрийн материаллаг нэр алдар өгдөг. Бие махбодь нь материаллаг байгалийн өглөг бөгөөд бие махбодийн ухамсарт хэт татагдан автсан хүнийг *манда* буюу бурханлаг сүнсний оршнолын талаар ойлгохыг үл хичээн хашин хойрго хандагч гэж нэрлэдэг. Мунхаг хүмүүс бие махбодио өөрсдийн нь жинхэнэ “Би” гэж үзэн өөртэй нь бие махбодийн холбоогоор холбогдсон бусдыгаа өөрийн төрөл төрөгсөд гэж тооцон, бие махбодь нь төрсөн нутаг орноо тахиж шүтэн, шашны хэлбэр төдий зан үйлийг өөрсдийн зорилгоо хэмээн үзэцгээдэг. Иймэрхүү материаллаг нэр алдар, томъёололд автсан хүмүүс заримдаа нийгмийн тустай ажил, үндсэрхэг үзэл болон энэрэнгүйн үйлд татагдаж байдаг. Иймэрхүү нэр алдар, томъёоллын эрхшээлд орсон байдаг тэд зөвхөн материаллаг түвшний үйлүүдтэй байнгад орооцолдон зууралддаг. Тэд бурханлаг танин мэдэхүй бол хий хоосон хийсвэр зүйл хэмээн үзэхээс цаашгүй учир энэ талаар огтхон ч сонирхдоггүй. Харин бурханлаг амьдралд гэгээрсэн хүн материаллаг ахуйд ийнхүү гүнээ живсэн хүмүүсийг ухааруулах гэж дэмий өдөөн оролдохын хэрэггүй. Түүний оронд өөрийн бурханлаг хөгжил дэвшлийг улам бүр ахиулахыг чармайх нь илүү дээр. Харин иймэрхүү төөрөлдсөн хүмүүсийг хүч үл хэрэглэн энэрэн нигүүлсэх зэрэг ёс суртахууны үндсэн зарчмуудыг дагах болон түүнтэй төстэй материаллаг ач буянтай чанаруудыг хөгжүүлэхэд л сургах нь зүйтэй.

Мунхаг хүмүүс Кришнагийн ухамсар дахь үйлийг үнэлж цэгнэж үл чадах учир тэдгээртэй зууралдан үнэт цагаа хий дэмий хоосон үрэхийн хэрэггүй гэж Шри Кришна бидэнд зөвлөж байна. Харин Бурханы чин бишрэлтэнгүүд нь Түүнээс Өөрөөс нь ч илүү нигүүлсэнгүй бөлгөө. Тэд Бурханы таалал буюу санаа бодлыг ойлгож мэдэх учир өөрсдийгөө учирч болох бүхий л аюул заналд эрсдүүлэн хүн төрөлхтөнд үнэхээрийн чухал шаардлагатай Кришнагийн ухамсрын үйлд харанхуй мунхаг хүмүүсийг татан оролцуулахыг хичээн, тэр ч бүү хэл тэдэнд ойртон нүүр тулан харьцаж байдаг билээ.

ШҮЛЭГ 30

*майи сарвани кармани санньясьядхьятта-четаса
нирашир нирмамо бхутва юдхьясва вигата-жварах*

*майи-*Надад, *сарвани-* бүхий л төрөл, *кармани-* үйлүүд, *санньясья-* бүрэн орхисноор, *адхьятта-* сүнсний тухай төгс төгөлдөр мэдлэгтэйгээр, *четаса-* ухамсараар, *нираших-* ашиг хонжоо олох гэсэн эрмэлзэл тэмүүлэлгүйгээр, *нирмамах-* өмчилж эзэмших гэсэн санаархалгүйгээр *бхутва-* байснаар, *юдхьясва-* тулалд, *вигата-жварах-* ажралгүйгээр.

Иймээс Аржуна минь ээ, Миний тухай дүүрэн мэдлэгийг хүртэн ямар ч ашиг хонжоо харалгүйгээр хувийн сонирхол болон сул дорой байдлаа орхин, өөрийн бүхий л үйлээ Надад зориул, тулалд.

ТАЙЛБАР: Энэ шүлэг нь Бхагавад Гитагийн зорилгыг тод томруунаар илэрхийлж байна. Бурхан, цэргийн хүн даргынхаа тушаалыг хэрхэн гүйцэтгэдэг шиг хүн өөрт оноогдсон үүргээ биелүүлэхдээ Кришнаг бүрэн ухамсарласан байх хэрэгтэй гэж тайлбарлаж байна. Ийм сургаал зааврыг даган биелүүлэх нь тийм ч амар бус боловч өөрт ноогдсон үүргээ биелүүлэх л хэрэгтэй, гэхдээ бүр Кришнагаас хамааралтайгаар биелүүлэх хэрэгтэй. Учир нь үүнд л амьд оршнолын жинхэнэ байр суурь оршдог билээ. Амьд оршнолын Бурханы таалалд нийцүүлэн үйлчлэн зүтгэх явдал нь түүний мөнхийн жам ёсны байр суурь байдаг тул тэрээр Бүхний Дээд Бурханаас хамааралгүйгээр аз жаргалтай байж чадахгүй юм. Иймээс Аржуна Шри Кришнагаас, Тэр өөрийг нь жанжин мэтээр тулалдах тушаал авч байна. Бүхний Дээд Бурханы таалалд нийцүүлэхийн тулд хүн бүхнээ зориулах хийгээд өргөхийн зэрэгцээ хувийн эрмэлзэл санаархлаа урьтал үл болгон өөрт оноогдсон үүргээ л биелүүлэх хэрэгтэй. Аржунагийн хувьд Бурханаас соёрхож буй айлдвар зарлигийн талаар бодлого болохын хэрэггүй, түүнийг зөвхөн биелүүлэх л хэрэгтэй байсан. Бүхний Дээд Бурхан бол бүх сүнснүүдийн сүнс билээ. Иймээс өөрийн амин хувийн болзол нөхцлийг эрхэмлэлгүй, Бүхний Дээд Бурханаас бүрнээ хамаарах буюу өөрөөр хэлбэл Кришнаг бүрнээ ухамсарласан хүнийг *адьятта-четаса* гэж нэрлэдэг. *Нирашихи* гэдэг үг нь ямар ч үр дагавар дагуулах үр дүн харалгүйгээр өөрийн эзний тушаалыг гүйцэтгэх хэрэгтэй гэсэн утгатай. Кассчин хүн өөрийн ажил олгогч эзний сая сая долларыг тоолж байдаг боловч өөртөө нэг ч цент авахыг санаархдаггүй. Үүний нэгэн адил энэхүү ертөнцийн юу ч хэн нэгэн хүнд хамаарагддаггүй, харин бүгд Бүхний Дээд Бурханы өмч юм гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ

бол *майи* буюу “Миний” гэдэг үгийн жинхэнэ утга болно. Кришнагийн ийм ухамсарт оршин байгаа хүн ямар нэгэн зүйл өмчлөхийг эрмэлзэж санаархдаггүй гэдэг нь эргэлзээгүй хэрэг. Ийм ухамсрыг *нирмама* буюу “надад юу ч хамаарагддаггүй” гэж нэрлэдэг. Хэрвээ өөрийн төрөл төрөгсөд гэж нэрлэгдэгчид буюу бие махбодийн холбоотонгуудаа огтхон ч хайхардаггүй энэхүү хатуу чанга тушаалыг гүйцэтгэхийн эсрэг ямар нэгэн дургүйцэл төрөх аваас энэхүү цааргаллыг өөрөөсөө зайлуулах хэрэгтэй. Ингэж байж л бид *вигата-жвара* буюу тайван бус байдал болон ухамсрын нойрмог ноомой гөлгөр байдлаасаа ангижрана. Хүн бүр өөрийн шинж чанар хийгээд байр сууриндаа зохицож нийцсэн тодорхой үйл ажиллагааг эрхэлж байх ёстой бөгөөд энэхүү бүх үүргээ дээр өгүүлсэнчлэнээр буюу Кришнагийн ухамсарт үйлдэх хэрэгтэй. Энэ нь л хүнийг ангижралын зам мөрд хүргэнэ.

ШҮЛЭГ 31

*е ме матам идам нитьям анутиштханти манавах
шраддхаванто `насуянто мучьянте те `пи кармабхих*

е- тэд, ме- Миний, *матам*- сургаалууд, *идам*- энэ, *нитьям*- мөнхийн үйл, үүрэг байдлаар, *анутиштханти*- байнгад биелүүлэх, *манавах*- хүн, *шраддха-вантах*- итгэл чин бишрэлтэйгээр, *анасуянтах*- атаархалгүйгээр, *мучьянте*- ангид байх, *те*- тэд бүгд, *апи*- тэр ч бүү хэл, *кармабхих*- үр дагавар дагуулах үйлийн уяа хүлээснээс.

Өөрт оноогдсон үүргээ Миний сургаалын дагуу биелүүлж байгаа болоод энэхүү номлол сургаалыг итгэл бишрэлтэйгээр, атаархаж жөтөөрхөлгүйгээр даган мөрдөж байгаа хүмүүс л үр дагавар дагуулах үйлийн уяа хүлээснээс салан ангижрана.

ТАЙЛБАР: Бурханы Дээд Бодгалийн сургаалууд нь бүхий л ведийн цэцэн мэргэн ухааны охь болох учир мөнхийн хөдөлбөргүй үнэн юм. Вед нь мөнхийн байдагтай адил Кришнагийн ухамсрын энэхүү үнэн нь мөн л мөнх. Хүмүүс Бурханд атаархалгүйгээр, энэхүү сургаал номлолд хатуу итгэх ёстой. Кришнад итгэдэггүй мөртөө Бхагавад Гитад тайлбар бичдэг олон философичид байдаг. Тэд үр дагавар дагуулах үйлийн гинж тушаа, уяа хүлээснээс хэзээ ч үл ангижрах болно. Харин Бурханы мөнхийн сургаал номлолд хатуу итгэл бишрэлтэй байх эгэл жирийн хүн энэхүү сургаалыг бүрэн гүйцэд даган биелүүлэх чадваргүй байсан ч кармын хуулийн хүлээснээс чөлөөлөгдөн ангижрах болно. Кришнагийн ухамсрын зам мөрөөр замнаж эхэлж буй хүмүүс эхэндээ Бурханы сургаал зааврыг бүрэн гүйцэд биелүүлж чаддаггүй ч энэхүү зарчмуудыг эсэргүүцэлгүйгээр, ялагдах цөхрөлөө үл хайхран үнэнчээр дагах аваас Кришнагийн цэвэр ариун ухамсрын түвшинд дээшлэн хүрэх нь эргэлзээгүй юм.

ШҮЛЭГ 32

*е тв этад абхьясуянто нанутиштханти ме матам
сарва-гьяна-вимудхамс тан виддхи наштан ачетасах*

е- тэд, *ту*- гэхдээ, *элат*- энэ, *абхьясуянтах*- атаархалын улмаас, *на*- үгүй, *анутиштханти*- журам дүрмийн дагуу дагаж мөрдөх, *ме*- Миний, *матам*- заавар, *сарва-гьяна*- мэдлэгийн бүхий л төрөлд, *вимудхан*- бүрэн хууртсан, *тан*- тэд бол, *виддхи*- сайн мэдэж ав, *наштан*- амжилтанд хүрэхгүй, *ачетасах*- Кришнагийн ухамсаргүйгээр.

Атаархлын улмаас энэхүү сургаал номлолыг үл хайхран, эс дагаж мөрдөх хүн мэдлэг ухаанаа гэж толгой нь эргэн төөрөлдөх бөгөөд төгс төгөлдөрт хүрэх гэсэн түүний бүхий л оролдлого нь ямар ч амжилтанд хүрэхгүй.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсаргүй байх нь ямар сөрөг муу талтай болохыг энэ шүлэгт тодорхой өгүүлж байна. Төр засгийн тэргүүний тушаал зааврыг эс дагаж мөрдөх хүн хэрхэн шийтгэгддэгийн адил Бурханы Дээд Бодгалийн айлдварыг эс хайхрагч нь мөн шийтгэл хүлээх нь тодорхой хэрэг. Түүний айлдварыг үл тоомсорлогч нь ямар ч аугаа бодьгал байсан ялгаагүй зүрх нь хоосон байх учир, өөрийн жинхэнэ байр суурь хийгээд Дээд Брахман, Параматма болон Бурханы Бодгалийн талаар юу ч мэддэггүй. Иймээс түүний хувьд амьдралын төгс төгөлдөрт хүрэх ямар ч горьдлого найдвар байхгүй.

ШҮЛЭГ 33

*садришам чештате свасьях пракритер гьянаван апи
пракритим янти бхутани ниграхах ким каришьяти*

садришам- харгалзсанаар, *чештате*- оролдох, *свасьях*- өөрийн хувийн, *пракритех*- байгалийн гунууд, *гьяна-ван*- мэдлэгтэй хүн, *апи*- хэдий ч, *пракритим*- байгаль, *янти*- эрсдүүлэх, *бхутани*- бүх амьд оршнол, *ниграхах*- шахалт, *ким*- юу, *каришьяти*- биелүүлж чадах.

Мэдлэг ухаанд гаргуун хүн ч гэсэн өөрийн мөн чанарын дагуу л үйлээ үйлдэж байдаг учраас хүн бүр л гурван гунагаас тулган шаардаж буй мөн чанарыг шингээсэн байдаг. Өөрийн мөн чанарыг шахан зайлуулах гээд юунд хүрэх билээ дээ?

ТАЙЛБАР: Долоо дугаар бүлэгт (7.14) Бурханы айлдсанчлан, хүн Кришнагийн ухамсрын трансценденталь түвшинд хүрээгүй л бол материаллаг байгалийн гунуудын нөлөөллөөс ангижирч чаддаггүй. Иймд, материаллаг үүднээс авч үзэхэд хамгийн өндөр боловсролтой хүн ч гэсэн зөвхөн онолын мэдлэгээр буюу сүнсийг бие махбодиос ялгаатай гэдгийг ойлгосноор *майа-гийн* урхинаас чөлөөлөгдөж чадахгүй. Өөрсдийгөө бурханлаг зам мөрөөр замнагчид хэмээн нэрийдэх олон хүмүүс гаднаа энэ талын мэдлэг ухааны ихэд өндөр түвшинд хүрсэн дүр үзүүлдэг боловч дотооддоо буюу

хувийн амьдралын хүрээндээ материаллаг байгалийн гунуудын нөлөөн доор бүрнээ оршин байдаг бөгөөд тэдгээрийг даван туулах чадваргүй байдаг. Хүн материаллаг шинжлэх ухааны маш өндөр түвшинд хүрсэн байсан ч материаллаг байгальтай удаан хугацааны туршид зууралдсан байдгаас шалтгаалан түүний эрхшээлд орсон байдаг. Кришнагийн ухамсар нь материаллаг амьдралын хүрээнд өөрт оноогдсон үүргээ үргэлжлүүлэн биелүүлж байгаа хүнд ч энэхүү материаллаг ертөнцийн урхинаас ангижрахад нь туслана. Иймээс Кришнаг бүрэн ухамсарлаагүй байж өөрт оноогдсон үүргээ гэнэт орхин өөрийгөө иогч буюу трансцендентальч хэмээн зохиомлоор нэрлэж болохгүй. Өөрийн байр сууриндаа байж эх сурвалж удирдлагын доор Кришнагийн ухамсарт хүрэхийг хичээн чармайх нь илүү дээр. Ингэж байж л Кришнагийн хий хуурмагийн эрчим *майа-гийн* хурц савраас чөлөөлөгдөн ангижрах болно.

ШҮЛЭГ 34

индриясьендриясьартхе рага-двешау вьявастхитау тайор на вашам агачхет тау хй асья парипантхинау

индриясья- мэдрэхүйн, *индриясья артхе*- мэдрэхүйн объектуудад, *рага*- дурлан татагдахуй, *двешау*- мөн салан хөндийрэхүй, *вьявастхитау*- зохицуулалтанд оруулсан, *тайох*- тэднээр, *на*- хэзээ ч үгүй, *вашам*- ноёрхол, *агачхет*- ирэх ёстой, *тау*- тэд, *хи*- зайлшгүй, *асья*- түүний, *парипантхинау*- саад тотгор.

Мэдрэхүйнүүд болон мэдрэхүйн объектуудад дурлан татагдах, тэдгээрийг жигшин зэвүүцэх явдлыг тохируулах зарчмууд байдаг. Ийн дурлан татагдах болон жигшин зэвүүцэх явдал нь өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн зам мөрт саад тотгор болох учир тэдгээрийн эрхшээлд орж болохгүй.

ТАЙЛБАР: Кришнагийн ухамсарт оршин байх хүн бүхэн жам ёсоороо, материаллаг мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйлтэй хутгалдан зууралддаггүй. Харин энэхүү ухамсарт үл амьдрагсад нь ариун гэгээн судруудад заасан дүрэм журмуудыг даган баримтлах нь зүйтэй. Ямар ч хязгаарлалт цээрлэл, жолоодлогогүй мэдрэхүйн таашаал ханамж нь бид бүхний материаллаг ертөнцөд хадагдан уягдаж байхын учир шалтгаан болдог. Харин ариун гэгээн судруудад заасан журам дүрмүүдийг баримтлагчид нь мэдрэхүйн объектын урхинд орж орооцолдохгүй. Жишээлбэл: бэлгийн харьцаа нь болзолт сүнснүүдийн хувьд нэгэн хэрэгцээ нь болж байдаг бөгөөд энэ нь зөвхөн тухайн гэр бүлийн эхнэр нөхрийн хооронд л зөвшөөрөгддөг. Судруудад зааснаар бол гэр бүлээс гадуур буюу өөрийн эхнэрээс өөр бусад хүнтэй бэлгийн харьцаатай байх нь хориотой. Бусад бүх эмэгтэйчүүдэд өөрийн эх мэтээр хандаж харж байх ёстой. Ийм сургаал заавар байсаар байтал эрэгтэй хүн өөр эмэгтэйчүүдтэй бэлгийн харьцаа холбоотой байх дур хүсэлтэй байдаг. Иймэрхүү дур сонирхлыг тас цохиж байхгүй бол өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйн зам мөрт саад тотгор болно. Хүн бие махбодид оршин байх үедээ түүний хэрэгцээг хангаж байж болох боловч зохих журам дүрмийг баримтлах ёстой. Гэхдээ эдгээр хязгаарлалт цээрүүд нь шууд л амжилтанд хүргэнэ гэж бодож болохгүй. Дээрх журам дүрмийг даган биелүүлэхдээ тэдгээрт татагдан автаж болохгүй. Учир нь, хэдийгээр хязгаарлалт зохицуулалт байгаа ч мэдрэхүйн таашаал ханамж эдлэх явдал нь өргөн засмал зам дээр осол гарахыг үгүйсгэж болохгүйн адил хүнийг зөв замаас нь гажуудуулан гаргачихаж болох юм. Зам нь харахад өргөн, хөдөлгөөн багатай, хамгийн сайн чанартай байлаа ч аюул осол тохиолдохгүй гэж хэн ч баталгаа гаргаж чадахгүй билээ. Урт удаан хугацааны туршид материтай холбогдон зууралдсанаас болж мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн бидний дур хүсэл маш хүчтэй байдаг. Үүний улмаас мэдрэхүйн таашаал эдлэхийг хичнээн тохируулж байсан ч жолоодлого алдагдаж уналтанд эрсдэх явдал байсаар байх учир мэдрэхүйн энэхүү хязгаарлагдаж зохицуулагдсан таашаал ханамж эдлэх явдалд татагдахаас ямар ч нөхцөлд байсан мөн л зайлсхийх хэрэгтэй юм. Харин Кришнагийн ухамсарт татагдах буюу өөрөөр хэлбэл Кришнагийн хайр дүүрэн бялхал алба үйлэнд зүтгэх нь хүнийг мэдрэхүйн үйлийн бүхий л төрөл хэлбэрээс салган ангижруулдаг. Иймээс амьдралын ямар ч түвшинд байсан Кришнагийн ухамсраас холдохыг хэн ч оролдохын хэрэггүй. Мэдрэхүйн дурлан татагдахуйн бүхий л хэлбэрээс огоорохын хамаг учир утга зорилго нь эцсийн дүндээ Кришнагийн ухамсрын түвшинд дээшлэн хүрэх явдал байдаг.

ШҮЛЭГ 35

шреян сва-дхармо вигунах пара-дхармат св-ануштхитат сва-дхарме нидханам шреях пара-дхармо бхаявахах

шреян-хавьгүй дээр, *сва-дхармах*- түүний оноогдсон үүргүүд, *вигунах*- алдаатай байсан ч, *пара-дхармат*- бусдад зориулагдсан үүргүүдээс, *су-ануштхитат*- төгс төгөлдөр биелүүлсэн, *сва-дхарме*- өөрт оноогдсон үүргүүдэд, *нидханам*- устал сүйрэл, *шреях*- илүү дээр, *пара-дхармах*- бусдад оноогдсон үүргүүд, *бхая-авахах*- аюултай.

Бусдад оноогдсон үүргийг төгс сайн биелүүлснээс өөрт оноогдсон үүргийг алдаа мадагтай, дутуу дулимаг ч гэсэн биелүүлэх нь хавьгүй дээр. Бусдын зам мөрийг дагах нь аюултай байдаг учир өөр бусдын үүргийг биелүүлснээс, өөрийн үүргийг биелүүлэх явцад хохирох нь илүү дээр.

ТАЙЛБАР: Иймд бусдад оноогдсон үүргийн хойноос хөөцөлдөж явснаас өөрт оноогдсон үүргийг Кришнагийн бүрэн ухамсарт биелүүлэхийг илүү чухалчлах хэрэгтэй. Материаллаг талын оноогдсон үүргүүд нь материаллаг байгалийн гунуудын үзүүлэх нөлөөллийн доор авсан психологийн болон физиологийн шинж чанарт харгалзсан үүргүүд байдаг. Харин бурханлаг үүргүүд нь Шри Кришнагийн трансценденталь алба үйлэнд зүтгэхэд зориулан номын багшийн зүгээс өгсөн сургаал зааврууд байдаг. Бусдад оноогдсон үүргийг дуурайн хийж байснаас өөрт оноогдсон үүргээ материаллаг ч байна уу, бурханлаг ч байна уу ялгаагүй, биелүүлэх үйлд амьдралынхаа төгсгөл хүртэл үнэнчээр зүтгэх нь илүү чухал. Бурханлаг болоод материаллаг түвшний үүргүүд нь өөр хоорондоо ялгаатай байж болох ч эх сурвалжийн сургаал зааврыг даган баримтлах зарчим нь түүнийг биелүүлэгчдэд ач тусаа үргэлж хайрлана. Хэрвээ хүн материаллаг байгалийн гунуудын нөлөөн доор оршин байгаа л бол тэр өөрийн тодорхой байр сууринд оноогдсон дүрэм журам үүргүүдийг сахин биелүүлэх ёстой болохоос бусдыг дуурайх гэж оролдох хэрэггүй. Жишээлбэл: цэвэр ариуны гунад оршдог *брахмана* нь хүч үл

хэрэглэн энэрэн нигүүлсэнгүй байдаг байхад хүсэл тачаалын гунад оршдог *кшатрияд* хүч хэрэглэхийг зөвшөөрдөг. Иймээс *кшатрия* хүний хувьд хүч үл хэрэглэн энэрэн нигүүлсэхүйн зарчмыг баримтлагч *брахманаг* дуурайж байснаас хүч хэрэглэж яваад амь эрсдэх нь илүү дээр. Хүн бүр өөрийн зүрхээ ариусгах ёстой бөгөөд гэхдээ энэ үйл явцыг гэнэт огцом биш, харин аажим аажмаар хийх хэрэгтэй. Харин хүн материаллаг байгалийн гунуудын нөлөөллийг даван гарч Кришнагийн ухамсарт бүрнээ оршин байх аваас жинхэнэ номын багшийн удирдлага зааврын доор ямар ч ажил үйлийг хийж үйлдэж болно. Кришнаг ухамсарласан энэхүү төгс төгөлдөр түвшинд *кшатрия* нь *брахманын* адил эсвэл *брахмана* нь *кшатрийн* адил үйл үйлдэж болно. Материаллаг ертөнцөд орших ялгаатай байдлууд нь трансценденталь түвшинд байдаггүй. Жишээлбэл: Вишвамित्रа нь анх эхлээд *брахмана* байснаа хожим нь *кшатрия* байдлаар үйлдэл хийж байсан бол Парашурама нь *кшатрия* байснаа дараа нь *брахмана* байдлаар үйл үйлдэх болсон. Тэд трансценденталь түвшинд оршин байсан учир ийнхүү үйлдэж чадаж байлаа. Хүн материаллаг түвшинд оршин байгаа нөхцөлд материаллаг байгалийн гунуудаас түүнд үзүүлэх нөлөөлийн дагуу өөрт нь оноогдсон үүргээ биелүүлэхийн зэрэгцээ Кришнагийн ухамсрын нарийн тодорхой ойлголттой байх хэрэгтэй.

ШҮЛЭГ 36

аржуна увача

*атха кена праюкто ям папам чарати пурушах
аниччханн апи варшнея балад ива нийожитах*

аржунах увача- Аржуна айлтгасан нь, *атха*- тэгвэл, *кена*- юугаар, *праюктах*- шахагдсан тулгагдсан, *аям*- энэ, *папам*- нүгэл, *чарати*- үйлддэг, *пурушах*- хүн, *аниччхан*- хүсэлгүйгээр, *апи*- хэдий ч, *варшнея*- Вришнигийн үр удам минь, *балат*- албадан шахалт доор, *ива*- шиг, *нийожитах*- үйлдэж байдаг.

Аржуна айлтгасан нь: Ай Вришнигийн үр удам минь ээ, дургүйцэж татгалзсаар байхад албадан тулгаж байгаа мэт, юу ингэж нүгэлт үйл үйл рүү түлхэнэ вэ?

ТАЙЛБАР: Бүхний Дээдийн өчүүхэн жижиг хэсэг болохын хувьд амьд оршнол нь анхандаа бурханлаг, ариун бөгөөд бүхий л материаллаг бузраас ангид байдаг. Иймээс жам ёсны мөн чанараараа бол тэр материаллаг ертөнцийн нүгэлтэй учрахгүй ёстой юм. Гэвч материаллаг байгальтай хавьтан холбогдсоны улмаас тэр ямар ч тээнгэлзээгүйгээр олон тооны, тэр ч бүү хэл зарим үед өөрийн хүсэл сонирхлын эсрэг нүгэлт үйлүүд үйлддэг. Тиймээс амьд оршнолын гажуудсан мөн чанартай холбогдуулан Аржунагаас Кришнад хандан тавьсан энэхүү асуулт онцгой сонирхолтой билээ. Зарим үед амьд оршнол нь нүгэлт үйл үйлдэхийг хүсэхгүй байсан ч түүнийг үйлдэхээр тулгагддаг. Гэхдээ энэхүү нүгэлт үйлүүдийг тэдний дотоодод залран байх Дээд Сүнс хийлгэхээр өдөөдөггүй. Үүний шалтгаан нь огт өөр зүйл байдаг бөгөөд Бурхан энэ тухай дараагийн шүлэгт айлдах болно.

ШҮЛЭГ 37

шри бхагаван увача

*кама эша кродха эша ражо-гуна-самудбхавах
маха шано маха-папма виддхй знам иха вайринам*

шри бхагаван увача- Бурханы Дээд Бодгаль айлдсан, *камах*- шунал тачаал, *эшах*- энэхүү, *кродхах*- уур хилэн, *эшах*- энэхүү, *ражо-гуна*- хүсэл тачаалын гуна, *самудбхавах*- төрөн гарсан, *маха-ашанах*- бүхнийг залгигч, *маха-папма*- маш нүгэлт, *виддхи*- мэдэж ав, *знам*- энэхүү, *иха*- материаллаг ертөнцөд, *вайринам*—хамгийн аюултай дайсан.

Бурханы Дээд Бодгаль айлдсан нь: Ай Аржуна минь ээ, энэ бол гагцхүү шунал тачаал юм. Шунал тачаал нь хүсэл тачаалын гунын нөлөөллөөр л бий болох бөгөөд дараа нь уур хилэн болон хувирдаг. Тэр бол энэ ертөнцийн, бүхнийг залгигч, нүгэлт дайсан бөлгөө.

ТАЙЛБАР: Амьд оршнол нь материаллаг байгальтай шүргэлцэн хутгалдсанаас болж Кришнаг хайрлах түүний мөнхийн хайр нь хүсэл тачаалын гунатай холбогдож улмаар шунал тачаал болон хувирдаг. Өөрөөр хэлбэл, Бурханыг хайрлах хайрын мэдрэмж нь сүүг хүчиллэг тамаринд (хасарваань)-тай хольж хутгахад тараг болдогтой адил шунал болон хувирдаг. Шунал тачаал үл хангагдах аваас уур хилэн болж хувирах ба уур хилэнгээс хий хуурмаг байдал үүсэн бий болно. Хий хуурмагийн улмаас хүн материаллаг ахуйд цаашид үргэлжлэн оршин байхаар тулгагддаг. Иймээс шунал тачаал нь амьд оршнолын хамгийн аюулт дайсан бөгөөд зөвхөн тэр ганцаараа л цэвэр ариун амьд оршнолын материаллаг ертөнцийн урхинд орооцолдон үлдэхийн учир шалтгаан болдог. Уур хилэн болон болон түүний үр дагаврууд нь харанхуй мунхагийн гунын илрэл юм. Хүн хүсэл тачаалын гунаас харанхуй мунхгийн гуна руу доройтон доошлохын оронд оноогдсон дүрэм, журмын дагуу амьдрал үйлээ зохион явуулах аваас хүсэл тачаалын гунаас цэвэр ариуны гуна руу өгсөн дээшлэнэ. Ийнхүү хүн бурханлаг амьдралын амтанд дурлан татагдсанаар уур хилэнгийн улмаас уруудан доройтохоос аврагдах болно.

Бурханы Дээд Бодгаль нь Өөрийн мөнхийн хөгжин дэлгэрэх бурханлаг жаргал цэнгэлээр баясахаар Өөрийгөө олон дүрээр илрүүлж тодруулдаг бөгөөд амьд оршнолууд нь энэ бурханлаг жаргал цэнгэлийн нь салшгүй жижиг хэсгүүд байдаг. Тэд мөн өчүүхэн төдий үл хамаарах шинж байдлыг агуулан байдагч, энэхүү үл хамаарах байдлаа буруугаар ашигласны улмаас буюу Бурханд үйлчлэн зүтгэх байдлаа өөрийн мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн дур сонирхол болгон хувиргаснаар шунал тачаалын эрхшээлд ордог. Энэ материаллаг ертөнцийг Бурхан болзолт сүнснүүдэд өөрсдийнхөө шунал тачаалын дур хүслээ гүйцэлдүүлэх боломж олгохын тулд бүтээсэн бөгөөд өөрсдийн шунал тачаалаа хангах гэсэн байнгын хичээл чармайлт нь үргэлжид мухардалд орох тэр цагт л тэд өөрсдийн жинхэнэ байр суурийн талаар сонирхож асууж эхлэх болно.

Энэхүү асуултаар Веданта судар эхэлдэг бөгөөд тэнд: *атхато брахма-жигьяса* гэж өгүүлсэн байдаг нь “Хүн Бүхний Дээдийн талаар асуух ёстой.” гэсэн утгыг агуулдаг. Мөн Бүхний Дээдийг Шримад Бхагаватамд тодорхойлохдоо:

жанмадй асья ято `нваяд итараташ ча буюу “Бүх зүйлийн анхдагч эх булаг нь Бүхний Дээд Брахман.” гэжээ. Иймээс шунал нь мөн л Бүхний Дээдээс эхлэлтэй болно. Харин энэхүү шунал тачаалыг Бүхний Дээдийг хайрлахад буюу Кришнагийн ухамсарт, өөрөөр хэлбэл бүхнийг зөвхөн Кришнад зориулан үйлдэх хүсэлд хувиргах аваас шунал тачаал хийгээд уур хилэн нь бурханлаг мөн чанартай болон хувирна. Рама Бурханы аугаа албат үйлчлэгч Хануманы уур хилэн бадарч Равана демоны алтан хотыг түймэрдсэнээр Бурханы аугаа их чин бишрэлтэн болохоо харуулжээ. Мөн энд, Бхагавад Гитад, Бурхан Аржунаг өөрийн уур хилэнгээ Түүний таалалд нийцүүлэн өөрийн дайсны эсрэг чиглүүлэн хандуулах хэрэгтэй гэж айлдаж байна. Өөрөөр хэлбэл шунал тачаал болон уур хилэнг Кришнагийн ухамсарт зориулан ашиглах аваас тэд бидний дайсан болох биш харин ч бидний нөхөд болон хувирна.

ШҮЛЭГ 38

*дхуменаврияте вахнир ятхадаршо малена ча
ятхолбенаврито гарбхас татха тенедам авритам*

дхумена- утаагаар, аврияте- бүрхэгдсэн, вахних- гал, ятха- яг адил, адаршах- толь, малена- тоосонд, ча- мөн, ятха- яг адил, улбена- эхийн хэвлийгээр (саваар), авритах- хучигдсан, гарбхах- үр хөврөл, татха- тэгж, тена- энэхүү шунал тачаалаар, идам- энэхүү, авритам- хучигддаг.

Гал утаанд халхлагдах, толь тоосонд дарагдах болон үр хөврөл эхийн хэвлийгээр хучигдан бүрхэгдэж байдгийн адил амьд оршнолууд энэхүү шунал тачаалд янз бүрийн хэмжээгээр хучигдсан байдаг.

ТАЙЛБАР: Амьд оршнолын цэвэр ариун ухамсар нь гурван янзын хэмжээ байдлаар халхлагдан далдлагдсан байдаг. Энэ бүрхүүлүүд нь янз бүрийн байдлаар илэрч буй шунал тачаал мөн бөгөөд тэдгээрийг галын дөлийг халхлах утаа, толин дээр хуралдсан тоос болон үр хөврөлийн гадуур бүрхэх эхийн хэвлийтэй зүйрлүүлсэн байна. Хэрвээ шуналыг утаатай адилтгах аваас энэ нь амьд очны галын дөл нь бага сул байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл амьд оршнол нь өөртөө Кришнагийн ухамсрыг бага зэрэг хөгжүүлсэн байх аваас түүнийг утаанд бүрхэгдсэн галтай адилтган зүйрлүүлж болно. Хаана утаа байна тэнд мөн гал байх учиртай ч эхэндээ гал нь сайн ноцож дүрэлзээгүй байдаг тул тод сайн харагддаггүй. Энэ үе шат нь Кришнагийн ухамсрын эхлэлийн байдалтай зүйрлэж болно. Тоосонд хучигдан дарагдсан толийг бурханлаг янз бүрийн аргуудаар цэвэрлэгдэн ариусгагдах ёстой ухааны тольтой зүйрлүүлж болно. Эдгээрээс хамгийн сайн нь Бурханы ариун гэгээн нэр алдрыг давтан хэлэх арга юм. Эхийн хэвлийд байх үр хөврөл буюу хүүхэд нь хаашаа ч хөдлөх аргагүй байдалд байдаг учир түүгээр яах ч аргагүй, арчаагүй байдлыг илэрхийлэн үзүүлж болох юм. Энэ үе шатны амьдралын нөхцөл байдлыг модтой адилтган үзэж болно. Ургаа мод нь мөн л амьд оршнол бөгөөд өөрийгөө олны өмнө үзүүлбэр болгох гэсэн хэт их шунал тачаалын улмаас тэр бараг ухамсаргүй гэмээр амьдралын иймэрхүү нөхцөл байдалд орсон хэрэг. Тоосонд дарагдсан толийг шувууд хийгээд хөхтөн амьтадтай, харин утаанд бүрхэгдсэн галыг хүнтэй адилтгаж болно. Амьд оршнол нь хүний биеийг аван төрснөөр өөртөө Кришнагийн ухамсрыг бага зэрэг ч гэсэн сэргээж чаддаг бөгөөд хэрвээ тэр түүнийг цаашид улам бүр хөгжүүлэх аваас түүний бурханлаг амьдралын галын дөл бадран дүрэлзэх болно. Утаа баагисан галыг зөв арчлах аваас улам бүр дүрэлзэн асдаг. Ийм учраас хүний амьдралын хэлбэр нь амьд оршнолд материаллаг ахуй оршнолын уяа хүлээснээс мултран гарах боломжийг олгодог. Хүний амьдралын хэлбэрт хашир туршлагатай удирдлагын доор Кришнагийн ухамсрыг хөгжүүлэх замаар дайсан болох шунал тачаалыг ялан дийлж чадах боломжтой юм.

ШҮЛЭГ 39

*авритам гьянам этена гьянино нитья-вайрина
кама-рупена каунтея душпуренаналена ча*

авритам- бүрхэгдсэн, гьянам- ариун ухамсар, этена- энүүгээр, гьянилах- мэдлэг бүхий хүний, нитья-вайрина- мөнхийн дайснаар, кама-рупена- шунал тачаалын хэлбэрт, каунтея- Кунтийн хүү минь, душпурена- хэзээ ч хангагдахгүй, аналена- галаар, ча- мөн.

Цэцэн мэргэн амьд оршнолын ухамсар нь, хэзээ ч ханаж цаддаггүй, гал мэт дүрэлзэн бадарч байх, түүний мөнхийн дайсан - шунал тачаалд ингэж л бүрхэгдэн байдаг.

ТАЙЛБАР: Дүрэлзэн буй гал руу түлш байнга нэмж хийснээр түүнийг унтрааж болдоггүйтэй нэгэн адил мэдрэхүйн таашаал ханамжийг хичнээн ч эдэлсэн шунал тачаал хэзээ ч ханаж цаддаггүй гэж Ману-смритид өгүүлсэн байдаг. Бэлгийн таашаал ханамж нь материаллаг ертөнцийн бүх үйлийн төв нь болж байдаг учраас материаллаг ертөнцийг *майтхунья-агара* буюу бэлгийн амьдралын гав гинж гэж нэрлэдэг. Гэмт хэрэг үйлдсэн ялтанг шоронд торны цаана хорьдогийн адил Бурханы хуулийг зөрчсөн гэм нүгэлтэнг бэлгийн амьдралын гав гинжээр гинжилдэг. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэх үйлд үндэслэж тулгуурласан материаллаг соёл иргэншлийн хөгжил нь амьд оршнолын материаллаг оршнолын үргэлжлэх хугацааг улам сунган уртасгадаг. Иймээс шунал тачаал нь амьд оршнолыг материаллаг ертөнцөд уян барьж байх харанхуй мунхагийн илрэл тэмдэг юм. Мэдрэхүйн таашаал ханамж эдлэх явцад аз жаргалтай байгаа мэт зарим нэгэн мэдрэмж төрж болох ч үнэн хэрэгтээ энэхүү хуурмаг аз жаргал нь түүнийг амтлан таашаагчийн хамгийн гол дайсан нь байдаг.

ШҮЛЭГ 40

*индрияни мано буддхир асьядхитханам учьяте
этаир вимохятей эша гьянам авритья дехинам*

индрияни- мэдрэхүй, *манах*- ухаан, *буддхих*- оюун ухаан, *асья*- энэхүү шунал тачаалаар, *адхиштханам*- байрлах газар, *учьяте*- гэж нэрлэгддэг, *этайх*- энэ бүхнээр, *вимохаяти*- төөрөлдөж будилдаг, *эшах*- энэхүү шунал тачаал, *гьянам*- мэдлэг, *авритья*- бүрхэгдсэнээр, *дехинам*- бие махбодид төрөгсдийн.

Мэдрэхүй, ухаан болон оюун ухаан нь шунал тачаалын хоргодон байх байр юм. Шунал тачаалаар дамжин амьд оршнолын жинхэнэ мэдлэг бүрхэгдэн хучигдаж улмаар төөрөгдөлдүүлэн самууруулдаг.

ТАЙЛБАР: Дайсан этгээд нь болзолт сүнсний бие махбодийн стратегийн хамгийн чухал байрлалуудыг эзэлсэн байдаг учраас Шри Кришна түүнийг хаана байгааг илрүүлэн олж болохыг дайснаа нухчин дарахыг хүсэгчдэд заан өгч байна. Ухаан нь мэдрэхүйн аливаа үйлийн төв болж байдаг тул бид мэдрэхүйн объектын тухай сонсмогч чухамдаа ухаан л мэдрэхүйн таашаал ханамж эдлэх талын янз бүрийн төлөвлөгөө боловсруулж эхлэх ба үүний үр дүнд мэдрэхүй болон ухаан нь шунал тачаалын цугларах байр болдог. Үүний дараагаар, оюун ухааны хэсэг нь энэхүү шунал тачаалаар дүүрэн байх дур сонирхлын төв нь болдог. Оюун ухаан нь сүнсний шууд зэргэлдээ орших хөрш юм. Шунал тачаалаар дүүрсэн оюун ухаан нь сүнсийг хуурамч эго-г хүлээн авч өөрийгөө материтай, тэгснээрээ ухаан болон мэдрэхүйнүүдтэй адилтган үзэхэд нөлөөлдөг. Мөнхийн сүнс нь ийнхүү материаллаг таашаал ханамжинд автан доройтох боловч үүнийгээ жинхэнэ аз жаргал эдэлж байна хэмээн андуу ташаагаар үздэг. Материтай өөрийгөө ийнхүү андуу ташуу, хуурамчаар адилтган үзэх сүнсийг Шримад Бхагаватамын (10.84.13)-д маш оновчтойгоор тодорхойлон өгүүлсэн байдаг:

*ясыатма-буддхих кунале три-дхатуке
сва-дхих калатрадишу бхаума ижъя-дхих
ят-тиртха-буддхих салиле на кархичиж
жанешв абхигьешу са зва го-кхарах*

“Гурван махбодиос бүрэлдэн тогтсон бүтээгдэхүүн болох бие махбодтойгоо өөрийгөө адилтган, бие махбодийн дагалдах бүтээгдэхүүнүүдээ өөрийн төрөл төрөгсөд хэмээн үзэж, төрсөн газар орноо тахин шүтэж, трансценденталь мэдлэг ухаан хүртэн эзэмшсэн мэргэдтэй уулзаж учрахын тулд бус зөвхөн угаал үйлдэх зорилгоор л мөргөлийн газарт очиж байдаг хүн нь илжиг эсвэл үхрээс дээрдэх юмгүй байдаг.”

ШҮЛЭГ 41

*тасмат твам индрияни адау ниямья бхаратаршабха
папманам пражахи хй знам гьяна-вигьяна-нашанам*

тасмат- иймээс, *твам*- чи, *индрияни*- мэдрэхүйгээ, *адау*- эхлээд, *ниямья*- тохируулснаар, *бхарата*- Бхаратын удмынхны шилдэг минь, *папманам*- нүглийн аугаа билэг тэмдэг, *пражахи*- ялан дийл, *хи*- гарцаагүй, *энам*- энэхүү, *гьяна*- мэдлэгийн, *вигьяна*- цэвэр сүнсний тухай эрдэм ухааны мэдлэгийн, *нашанам*- устгагч.

Иймээс, ай Бхаратын шилдэг нь болох Аржуна минь ээ, юуны түрүүнд зохицуулан захирсан мэдрэхүйнүүдээрээ энэхүү аугаа их нүглийн бэлэг тэмдгийг(шунал тачаал) хазаарлан барь. Ингэж өөрийгөө танин ухамсарлахуй болон эрдэм мэдлэгийн устган сөнөөгчийг дарагтун.

ТАЙЛБАР: Бурхан, юуны өмнө өөрийн мэдрэхүйг эзэмдэн захирч хянан жолоодох хэрэгтэйг, ингэснээр л тэр сүнсний жинхэнэ оршнолын тухай мэдлэг болон өөрийгөө бүрэн нээж танин мэдэхүйд хүрэх гэсэн эрмэлзэл тэмүүллийг хөнөөн сүйрүүлдэг шунал тачаал буюу хамгийн том заналт, нүгэлт дайсанг ялан дийлж чадна гэдгийг зөвлөж байна. *Гьяна* нь “жинхэнэ Би”-г “хуурамч Би”-гээс ялгаж салгах мэдлэг ухаан гэсэн утгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, бурханлаг сүнс бол материаллаг бие махбодь биш гэдэг тухай мэдлэг гэсэн утгатай юм. *Вигьяна* нь “сүнсний жинхэнэ байр суурины тухай болон түүний Дээд Сүнс, Параматматай холбогдсон холбоо харьцааны талаарх нарийн мэдлэг” гэсэн утгыг илэрхийлдэг. Энэ тухай Шримад Бхагаватамын (2.9.31)-д дараах байдлаар тайлбарласан байдаг:

*гьянам парама-гухьям ме яд-вигьяна-саманвитам
са-рахасьям тад ангам ча грихана гадитам майя*

“Сүнсний болон Дээд Сүнсний тухай ийм мэдлэг нь маш чухал эрхэм нандин бөгөөд нууцлаг юм. Харин Бурхан Өөрөө түүний янз бүрийн төлвийн талаар бидэнд нээн хүртээх аваас бид энэхүү мэдлэг ухааныг болон түүнийг хэрхэн бүрэн танин мэдэж болохыг ойлгож болно.”

Бхагавад Гита нь бидэнд сүнсний тухай энэхүү ерөнхий болоод нарийн мэдлэгийг өгдөг. Амьд оршнол нь Бурханы салшгүй өчүүхэн жижиг хэсэг мөн болох учир түүний цорын ганц үүрэг нь Бурханд үйлчлэн зүтгэх явдал байдаг. Энэ ухамсрыг Кришнагийн ухамсар гэж нэрлэдэг. Амьдралынхаа бүр эхнээс л энэхүү Кришнагийн ухамсарт суралцах хэрэгтэй бөгөөд ингэснээрээ хүн Түүнийг бүрэн ухамсарлаж улмаар энэ ухамсрын дагуу амьдрал үйлээ явуулж чадна.

Шунал бол амьд оршнол бүрт жам ёсоор заяагдсан байдаг Бурханыг хайрлах хайрын зөвхөн гажуудсан тусгал юм. Харин хүнийг бүр багаас нь эхлэн Кришнагийн ухамсарт хүмүүжүүлэх аваас түүний Бурханыг хайрлах энэхүү жам ёсны хайр нь шунал тачаал болон гажуудан хувирахгүй. Бурханыг хайрлах хайр шунал тачаал болон хувирч өөрчлөгдсөн нөхцөлд түүнийг буцаан хэвийн байдалд оруулах нь нэн ярвигтай хүнд. Гэсэн ч Кришнагийн ухамсар аугаа хүчирхэг учир хүн хэдийгээр энэ зам мөрд оройтон орж, хожуу эхэлж байгаа ч чин бишрэл дүүрэн бялах албаны зохицуулах зарчмуудыг баримтлан дагаж мөрдөх аваас Бурханыг хайрлах хайрын түвшинд хүрч чадна. Иймээс хүн амьдралын ямар ч үе шатанд байсан, үүнийг хойшлуулалгүй чухал шаардлагатайг мэдсэн цагаасаа л Бурханы чин бишрэлийн албанд буюу Кришнагийн ухамсарт хандах хэрэгтэй. Ингэснээр мэдрэхүйгээ эзэмдэн захирч, шунал тачаалаа аажим аажмаар Бурханыг хайрлах хайр болгон хувиргаж хүний амьдралын дээдийн дээд зорилгодоо хүрнэ.

ШҮЛЭГ 42

*индрияни паранй ахур индриебхьях парам манах
манасас ту пара буддхир йо буддхех паратас ту сах*

индрияни- мэдрэхүй, парани- илүү дээд, ахух- хэлдэг, индриебхьях- мэдрэхүйгээс илүү, парам- илүү дээр, манах- ухаан, манасах- ухаанаас илүү, ту- мөн, пара- илүү дээр, буддхих- оюун ухаан, ях- тэр, буддхех- оюун ухаанаас илүү, паратах- бүр илүү дээр, ту- харин, сах- тэр (сүнс).

Мэдрэхүй нь үхмэл материас дээгүүр ба ухаан нь мэдрэхүйгээс дээгүүр, оюун ухаан нь ухаанаас дээгүүр, харин тэр (сүнс) оюун ухаанаас ч дээгүүр байр сууринд оршдог.

ТАЙЛБАР: Мэдрэхүйнүүд нь шунал тачаалын хувьд үйлийнх нь талбар болж байдаг. Шунал тачаал нь бие махбодид хуримтлагдсаар мэдрэхүйгээр дамжин гадагш илрэн гардаг. Иймээс, бие махбодийг бүхэлд нь авч үзвэл мэдрэхүйнүүд нь түүнээс дээд түвшинд оршдог байна. Гэхдээ мэдрэхүй нь илүү дээд ухамсарт, өөрөөр хэлбэл Кришнагийн ухамсарт дээрхийн адил гарц байдлаар ашиглагддаггүй. Кришнагийн ухамсарт сүнс нь Бурханы Дээд Бодгальтай шууд холбоо тогтоодог. Иймээс бие махбодийн энд тодорхойлон өгүүлсэн үүргүүдийн шатлан захирагдах тогтолцооны дээд оргил нь Параматма байдаг. Бие махбодийн үйл ажиллагаа гэж мэдрэхүйн үйл ажиллагааг хэлэх бөгөөд мэдрэхүйн үйлийг зогсооно гэдэг нь бие махбодийн бүхий л үйлүүдийг зогсооно гэсэн үг юм. Харин ухаан байнга идэвхтэй байх учир бие махбодь амарч байсан ч идэвтэй байдлаа хадгалан байдаг бөгөөд үүний нэг жишээ бол унтаж байхдаа зүүдлэх явдал юм. Ухааны дээр шийдвэрлэгч оюун ухаан байх ба түүний дээр сүнс оршино. Иймээс, хэрвээ сүнс нь Бүхний Дээдэд шууд үйлчлэн зүтгэж байх аваас түүнээс доош оршин түүнд захирагдан байх оюун ухаан, ухаан болон мэдрэхүй нь аяндаа өөрсдөө тэр дагуу үйлчлэн зүтгэх болно. Катха Упанишадад үүнтэй адил төстэй нэгэн хэсэг байдаг бөгөөд тэнд өгүүлсэнчлэн, мэдрэхүйн таашаал ханамж эдлэхтэй холбогдсон объектууд нь мэдрэхүйгээс дээш, харин ухаан нь мэдрэхүйн энэ объектуудаас дээгүүр оршдог. Иймд, ухаан нь байнга болоод шууд Бүхний Дээд Бурханд үйлчлэн зүтгэж байх аваас мэдрэхүйд өөр ямар нэгэн зүйл оролдох хийгээд үйлдэх боломж олдохгүй. Ухааны энэхүү үйл ажиллагааны талаар урьд нь тайлбарласан билээ. *Парам дриштва нивартате*. Хэрвээ ухаан нь Бурханы трансценденталь алба үйлэнд үйлчлэн зүтгэж байх аваас тэрээр аливаа доод дур сонирхолд татагдан хөтлөгдөхгүй. Сүнс нь бүгдийн буюу мэдрэхүйн объектууд, мэдрэхүйнүүд, ухаан мөн оюун ухааны дээр орших тул түүнийг Катха Упанишадад *махан* буюу аугаа гэж нэрлэсэн байдаг. Иймээс сүнсний жинхэнэ байр суурийг ойлгосноор бүх асуудал шийдвэрлэгдэх болно.

Хүн бүр өөрийн оюун ухааныг сүнсний жинхэнэ байр суурийг олж тогтооход ашиглах хэрэгтэй бөгөөд үүнийг ухаарч ойлгосноор ухааныг үргэлжид Кришнагийн ухамсарт үйлчлэн зүтгэх хэрэгтэй. Ингэснээр бүх асуудал шийдвэрлэгдэнэ. Бурханлаг амьдралын зам мөрд шинээр орж буй мэдлэг туршлага багатай хүмүүст ерөнхийдөө мэдрэхүйн объектуудаас аль болох хол хөндий байхыг зөвлөдөг. Түүнээс гадна тэд өөрсдийн оюун ухааныг ашиглан ухаанаа батжуулан бэхжүүлэх хэрэгтэй. Хүн өөрийгөө Бурханы Дээд Бодгальд бүрнээ зориулан оюун ухааныхаа хүчийг ашиглан ухаанаа Кришнагийн ухамсрын үйлэнд автуулах аваас ухаан нь аяндаа өөрөө батжин бэхжихийн зэрэгцээ могой мэт хүчтэй мэдрэхүй нь хортой шүдийг нь сугалж хаясан могой шиг ямар ч хор хөнөөлгүй болно. Хэдийгээр сүнс нь оюун ухаан, ухаан болон мэдрэхүйг захирах боловч Кришнаатай холбогдон Кришнагийн ухамсарт батжин бэхжээгүй тохиолдолд ухааны өдөөлтөнд амархан өртөмтгий мөн чанараас болж уналт доройтолд эрсдэж болзошгүй байдаг.

ШҮЛЭГ 43

*эвам буддхех парам буддхва самстабхьятманам атмана
жахи шатрум маха-бахо кама-рупам дурасадам*

эвам- ийм байдлаар, буддхех- оюун ухаанд, парам- илүү дээр байх тэр, буддхва- мэдсэнээр, самстабхья- батжин бэхжсэнээр, атманам- ухааныг, атмана- цэвэр ариун оюун ухаанаар, жахи- ялж дийл, шатрум- дайснаа, маха-бахо- ай хүчит гарт минь, кама-рупам- шунал тачаалын хэлбэрт, дурасадам- аюултай.

Ийнхүү материаллаг мэдрэхүй, ухаан болон оюун ухаанд трансценденталь байх өөрийгөө таньж мэдсэнээр, ай хүчит гарт Аржуна минь ээ, хүн өөрийн ухаанаа цэвэр ариун бурханлаг оюун ухааны (Кришнагийн ухамсрын) тусламжтайгаар батжуулан бэхжүүлэх хэрэгтэй бөгөөд энэхүү бурханлаг хүчээр л, хэзээ ч үл ханаж цадах дайсан шунал тачаалыг дарж авах ёстой.

ТАЙЛБАР: Бхагавад Гитагийн гурав дугаар бүлэг нь өөрийн энэхүү дүгнэлтээрээ, хүн бодгаль бус хооныг эцсийн зорилго гэж үзэлгүй, өөрийгөө Бурханы Дээд Бодгалийн мөнхийн албат зарц мөн гэдгийг таньж мэдсэнээрээ Кришнагийн ухамсарт хүрэх замыг зааж байна. Материаллаг амьдралдаа хүн шунал тачаал дүүрэн байх дур сонирхол болон материаллаг байгалийн баялгийг эзэмшин захирах гэсэн хүсэлд автагдан байдаг нь ямар ч эргэлзээгүй билээ. Ноёлон захирах хийгээд мэдрэхүйн таашаал ханамж эдлэх гэсэн эрмэлзэл нь болзолт сүнсний хамгийн аюултай дайснууд мөн боловч тэрээр Кришнагийн ухамсрын хүчээр өөрийн материаллаг мэдрэхүй, ухаан болон оюун ухаанаа эзэмдэн захирч чадах болно. Хүн өөрийн ажил болон өөрт оноогдсон үүргээ гэнэт огцом, шууд хаяж болохгүй. Харин түүний оронд Кришнагийн ухамсрыг аажим аажмаар хөгжүүлэн трансценденталь байр сууринд хүрэх ёстой бөгөөд оюун ухаанаа өөрийн жинхэнэ “Би”-д хандуулан чиглүүлсний ач тусаар материаллаг мэдрэхүйн болон ухааны нөлөөллөөс ангижрах хэрэгтэй. Энэ бол уг гурав дугаар бүлгийн гол утга учир нь билээ. Философийн цэцэрхийлэл болон иог хэмээн нэрлэгдэх дасгалаар мэдрэхүйгээ эзэмдэн захирах гэсэн зохиомол оролдлогын аль аль нь материаллаг оршнолын гүйцэд боловсорч нээгдээгүй түвшинд байгаа хүнийг бурханлаг амьдралд хүрэхэд нь тусалж чадахгүй. Тэр, бүр илүү дээд оюун ухааны тус дэмжлэгтэйгээр Кришнагийн ухамсрыг өөртөө хөгжүүлэх хэрэгтэй.

Шримад Бхагавад Гитагийн “Карма-йога буюу өөрт оноогдсон үүргээ Кришнагийн ухамсарт биелүүлэх нь” гэсэн нэртэй гурав дугаар бүлэгт Бхактиведантын өгсөн тайлбар ийнхүү өндөрлөлөө.

